



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199 I оны II
сарын 18 өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

Ардын Их Хурлын II хуралдааны 7 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9⁰⁰ цагт Ардын Их Хурлын танхимд эхлэв. Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан даргалав. Хуралдааны ирц 92/393/ хувь байв.

Депутат Г.Чингэл, Т.Батмөнх, Ц.Охинтогтох, Н.Сампилноров нар өвчтэй, Г.Сүрэнжаргал гадаадад ажлаар явсан байв. /Ирцийн байдлыг хавсаргав/

9⁰² цагт байгууллага, хамт олон, иргэдээс хуралдааны нэр дээр ирсэн захидал, утас, цахилгааны тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Ц.Лоохууз уншиж танилцуулав. Эцэст нь нэр бүхий 51 депутатаас их хурлын дарга, орлогч нарын нэр дээр болон мөн Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасангийн нэр дээр академич Л.Тойвгоо тэргүүтэй хэсэг эрдэмтдээс ирүүлсэн саналыг тус тус уншиж танилцуулав.

Ж.Уртнасан 103 депутат бичгээр саналаа ирүүлсэн, 94 депутат үг хэлээд байна, одоо 200 гаруй депутат үг хэлэхээр нэрээ өгсөн байгаа тул ерөнхий санал, шүүмжлэлээ үргэлжлүүлье гэв. Ингээд 290-р тойргийн депутат С.Цэвээндорж, 164-р тойргийн депутат Ц.Дэмжид, 85-р тойргийн депутат К.Сайраан, 321-р тойргийн депутат С.Батхуяг, 213-р тойргийн депутат В.Даваа, 310-р тойргийн депутат Л.Хад саналаа хэлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан ерөнхий шүүмжлэлээ таслая гэсэн саналыг 132 депутат ирүүлсэн тул цөөнхийн саналыг хүндэтгэн санал хураалт явуулав. Зөвшөөрсөн 191/73%, татгалзсан 58/22%, түдгэлзсэн 12/5%, бүгд 261/61%. Зөвшөөрсөн депутатуудын тоо, хувьтайгаа тохирохгүй, санал хураалтанд нийт депутатуудын зөвхөн 61% нь оролцсон тул дахин санал хураалт явуулав. Зөвшөөрсөн 283/72%, татгалзсан 94/24%, түдгэлзсэн 16/4%, бүгд 393/92%.

Ерөнхий санал, шүүмжлэлийг тасалж цөөнхийн саналыг соноох болов.

94-р тойргийн депутат Б.Сандуйжав, 274-р тойргийн депутат Л.Цог-очир нар цөөнхийг сонсъя гэв. 298-р тойргийн депутат Д.Тангад, 390-р тойргийн депутат Ү.Аварзэд нар цөөнх болж үг хэлсний дараа 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж үг хэлэх зөвшөөрөл авч, 2-3 өдөр санал, шүүмжлэл явагдлаа. Ихэнх нь давхардлаа. Өөр саналтай депутатууд үгээ хэлж чадсангүй. Иймд зүйл, бүлэг дээр хэлжэ гэв.

332-р тойргийн депутат А.Бааст, 80-р тойргийн депутат Д.Зарьжкан, 244-р тойргийн депутат Б.Доржхорлоо, 89-р тойргийн депутат Л.Пүрэвгял, 19-р тойргийн депутат Б.Батсайхан, 50-р тойргийн депутат А.Далхжав нар үг хэлсний дараа, цөөнхийн саналыг хүндэтгэн ерөнхий санал, шүүмжлэлийг таслая гэдгээр санал хураав зөвшөөрсөн 289/75%, татгалзсан 84/22%, түдгэлзсэн 11/3%, бүгд 384/90% болж ерөнхий санал, шүүмжлэлийг тасалсаны дараа үг хэлж чадаагүй депутатуудын нэрийг "ирц" товчлуураар нэрээр нь авав. 269 депутатуудын нэр ирсэн байв.

10³⁴ цагаас Их цаазын төслийг зүйлчлэн хэлэлцэж эхлэв.

72-р тойргийн депутат А.Болат, 184-р тойргийн депутат С.Билэгсайхан, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 301-р тойргийн депутат М.Жамсран, 393-р тойргийн депутат Д.Баасанжав нар үг хэлсний дараа депутатуудын бүлгийн зөвлөлгөөн болох тул 12 минутын өмнө буюу 10⁴⁸ цагт завсарлав.

Хуралдаан 11²⁴ цагаас үргэлжилж 296-р тойргийн депутат Л.Батжаргал, 157-р тойргийн депутат Л.Одончимэд, Л.Батжаргал, 26-р тойргийн депутат Д.Сүрэнхорлоо, 263-р тойргийн депутат З.Адъяа, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 284-р тойргийн депутат Ш.Бадам нар үг хэлсний дараа Үндсэн хууль оноосон нэртэй байна гэдгээр санал хураав. зөвшөөрсөн 157/45%, татгалзсан 181/51%, түдгэлзсэн 14/4%, бүгд 352/82%.

Санал хураалтын агуулгыг депутатууд бүрэн сайн ойлгоогүй гэж үзэн 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 393-р тойргийн депутат Д.Баасанжав, 297-р тойргийн депутат Д.Тангад, 132-р тойргийн депутат С.Чулуунбаатар, 22-р тойргийн депутат Л.Дашням нар үг хэлсний дараа Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан оноосон нэрийн талаар товч тайлбар өгөхийг

Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдоржоос хүсэж тэрээр энэ талаар товч тайлбар депутатуудад өгөв. Мөн Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Б.Чимид нэмэлт тайлбар хийв.

Оноосон нэрийн төлөө цөөнх болж 274-р тойргийн депутат Н.Жанцан, 143-р тойргийн депутат Г.Зуунай, 264-р тойргийн депутата Б.Баньди, 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 271-р тойргийн депутат Ж.Даргахүү, 44-р тойргийн депутат Ш.Сүрэнжав, 160-р тойргийн депутат Д.Содном, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан, 141-р тойргийн депутат Ж.Авхиа /оноосон нэрийн эсрэг, цөөнхийн эсрэг, Үндсэн хууль гэдгийн төлөө үг хэлэв/, 236-р тойргийн депутат Д.Дэмбэрал, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 247-р тойргийн депутат Ж.Шоовдор, 285-р тойргийн депутат С.Батсүх, 63-р тойргийн депутат Х.Лүрэндагва, 157-р тойргийн депутат Л.Одончимэд, 90-р тойргийн депутат О.Нямдаваа, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 301-р тойргийн депутат М.Жамсран, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 191-р тойргийн депутат Б.Лханаа сүрэн, 21-р тойргийн депутат П.Мөнхдорж, 153-р тойргийн депутат Д.Чойжамц, 103-р тойргийн депутат Л.Дүйсэсанги нар үг хэлж хуралдаан 12⁵⁴ цагт завсарлав.

Хуралдаан 15⁰⁰ цагаас ажлаа үргэлжлүүлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хуулийн нэр "Их цааз" гэж төсөлд байгааг "Их засаг" гэдэг үгээр сольё гэсэн томъёолол дээр санал хураав. зөвшөөрсөн 160/40% /татгалзсан 218/54%/, түдгэлзсэн 23/6%/, бүгд 401/94%/

Хуулийн нэрийг "Үндсэн хууль" гэж нэрэлье гэдэг дээр санал хураав. зөвшөөрсөн 270/68%/, татгалзсан 110/28%/, түдгэлзсэн 18/5% бүгд 398/93%/

"Их цааз" гэдэг нэрийг хуулийн нэр болгож үлдээх талаар санал хураав. зөвшөөрсөн 60/15%/, татгалзсан 332/82%/, түдгэлзсэн 13/3%/, бүгд 405/95%/.

Санал хураалтын дүнтэй холбогдуулан цөөнхийн саналыг сонсов.

56-р тойргийн депутат Р.Гончигдорж, 148-р тойргийн депутат Д.Баттулга, 297-р тойргийн депутат Д.Тангад, 427-р тойргийн

депутат Ц.Элбэгдорж, 9-р тойргийн депутат С.Зориг, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 167-р тойргийн депутат Ш.Гүрбазар, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 22-р тойргийн депутат Л.Дашням, 143-р тойргийн депутат Г.Зуунай, 7-р тойргийн депутат Ц.Балдорж, 272-р тойргийн депутат С.Лунаа, 219-р тойргийн депутат Х.Чойжилжав, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 11-р тойргийн депутат Ж.Бямбаа, 396-р тойргийн депутат Б.Чимид, 6-р тойргийн депутат Б.Нямбуу, 414-р тойргийн депутат Д.Цэрэн, 355-р тойргийн депутат Х.Баянмөнх, 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, 184-р тойргийн депутат С.Билэгсайхан, 101-р тойргийн депутат Р.Доржбат, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 18-р тойргийн депутат Г.Ганболд, 63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 393-р тойргийн депутат Д.Баасанжав нар цөөнхийн санал гаргав. 184-р тойргийн депутат С.Билэгсайхан, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж 20-30-аад оны үед хэлмэгдсэн олон зуун эгэл жирийн ард түмний гэгээн дурсгалыг хүндэтгэж нэг минут босч зогсоё гэсэн санал гаргацгаав.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хурлаа дэгийнхээ дагуу явуулах зорилгын үүднээс цөөнхийн саналаа үргэлжлүүлэн сонсьё гэв.

283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 118-р тойргийн депутат Ж.Жамбалдорж, 19-р тойргийн депутат Б.Батсайхан, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 429-р тойргийн депутат Р.Рэнцэн-нацаг санал хэлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан цөөнхийн саналыг үндэслэн зарим асуудлыг эргэн харж "Үндсэн хууль оноосон нэртэй байна" гэдэг дээр эхлээд санал хураая гэхэд 231-р тойргийн депутат Г.Амабаян, 72-р тойргийн депутат А.Болат, 17-р тойргийн депутат Т.Очирхүү, 244-р тойргийн депутат Б.Доржхорлоо нар оноосон нэртэй холбогдуулан үг хэлэв. Мөн 13-р тойргийн депутат Л.Цог, 38-р тойргийн депутат Д.Чойжамц нар хууль гэдэг үгийг мэргэжлийн үүднээс тайлбарласан тодотгол хэлэв. Ингээд "Үндсэн хууль оноосон нэртэй байна" гэдэг дээр санал хураав. Зөвшөөрсөн 231 /58%/, татгалзсан 146 /36%/, түдгэлзсэн 23 /6%/, бүгд 400 /94%/.

Хуулийн оноосон нэрийг "Их засаг" гэж нэрлэе гэсэн санал гаргахад нэр, тойргоо хэлээгүй депутат, 274-р тойргийн депутат Л.Цог-очир, 298-р тойргийн депутат Д.Тангад, 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн, 183-р тойргийн депутат Ч.Намсрай, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 227-р тойргийн депутат Б.Баасанхүү, 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэ 9-р тойргийн депутат С.Зориг, 424-р тойргийн депутат Х.Бадамсүрэн, 32-р тойргийн депутат Д.Мандах, 404-р тойргийн депутат Л.Хээшиг, 257-р тойргийн депутат Ч.Цэрэндагва, 260-р тойргийн депутат Ж.Буд, 84-р тойргийн депутат Н.Самат нар горимын санал хэлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан 5 үндсэн санал дээр шалгаруулах журмаар санал хураая гээд: "Их засаг", "Их хууль", "Эх хууль", "Их цааз", "Үндсэн хууль" гэсэн томъёолуудыг хэлэв.

197-р тойргийн депутат Н.Шуурай, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 32-р тойргийн депутат Д.Мандах, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, 360-р тойргийн депутат Д.Найдан, 22-р тойргийн депутат Л.Дашням нар нэмж санал гаргав.

Хуулийн нэр "Их засаг"

зөвшөөрсөн 198/47%/

татгалзсан 170/42%/

түдгэлзсэн 43/11%/

бүгд 401/94%/

Хуулийн нэр "Их хууль"

зөвшөөрсөн 31/8%/

татгалзсан 332/84%/

түдгэлзсэн 31/8%/

бүгд 394/92%/

Хуулийн нэр "Эх хууль"

зөвшөөрсөн 17/4%/

татгалзсан 352/80%/

түдгэлзсэн 21/5%/

бүгд 400/94%/

Хуулийн нэр "Үндсэн хууль"

зөвшөөрсөн 221/56%/

татгалзсан 145/36%/

түдгэлзсэн 32/8%/

бүгд 398/93%/

Хуулийн нэр "Их цааз"

зөвшөөрсөн	49/12%/
татгалзсан	322/81%/
түдгэлзсэн	26/7%/
бүгд	397/93%/

Шалгаруулалтаар хамгийн олон санал авсан 2 төсөл дээр хоёрдахь шатны санал кураалт явуулъя. "Үндсэн хууль", "Их засаг"

"Их засаг"

зөвшөөрсөн	206/51%/
татгалзсан	173/43%/
түдгэлзсэн	21/5%/
Бүгд	400/94%/

"Үндсэн хууль"

зөвшөөрсөн	196/49%/
татгалзсан	182/45%/
түдгэлзсэн	24/6%/
Бүгд	402/94%/

Хуулийн нэрийг депутатуудын олонхийн саналаар "Их Засаг" гэж тогтов. "Их засаг" гэсэн нэрийг баталъя гэсэн саналыг Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан гаргасан боловч депутатууд саналаа хэлье гэж хүссэнээр санал гаргах ажиллагаа үргэлжлэв.

10-р тойргийн депутат О.Дашбалбар, 104-р тойргийн депутат Д.Жагварал, 234-р тойргийн депутат Д.Дэмбэрэл, 273-р тойргийн депутат Н.Жанцан, 426-р тойргийн депутат Ж.Барамсай, 406-р тойргийн депутат Ч.Тэрвил, 228-р тойргийн депутат Н.Адъяажав, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн, 297-р тойргийн депутат И.Бадарч, 296-р тойргийн депутат Л.Батжаргал, 141-р тойргийн депутат Ж.Авхиа, 415-р тойргийн депутат Н.Ганбямба, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 58-р тойргийн депутат С.Рэнцэбал, 302-р тойргийн депутат Ц.Шагдарпүрэв, 360-р тойргийн депутат Д.Найдан, 340-р тойргийн депутат В.Сумьяа, 95-р тойргийн депутат Т.Төмөрбаатар, 86-р тойргийн депутат С.Харжаубай, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 109-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 332-р тойргийн депутат А.Бааст, 389-р тойргийн депутат Н.Бат-очир

344-р тойргийн депутат Х.Сүхбаатар, 396-р тойргийн депутат Б.Чимид нар үг хэлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан цөөнхийн саналыг сонслоо. Түрүүчийн хэлсэн томъёололын дагуу санал хураая.

Хуулийн төслөө "Үндсэн хууль" гэж нэрлэе гэсэн томъёололыг

эвшөөрсөн	238/60%/
татгалзсан	145/37%/
түдгэлзсэн	14/4%/
бүгд	397/93%/

Улсын Бага Хурлын гишүүн П.Улаанхүү, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 137-р тойргийн депутат Г.Бааран, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 297-р тойргийн депутат Д.Тангад, 157-р тойргийн депутат Л.Одончимэд, нэр тойргоо хэлээгүй депутат, 9-р тойргийн депутат С.Зориг, 2-р тойргийн депутат С.Батмөнх, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам, 1-р тойргийн депутат С.Баяр, Улсын Бага Хурлын гишүүн Гү.Лхагважав, 66-р тойргийн депутат Го.Лхагважав үг хэлэв. Цөөнхийн саналыг сонссоны дараа хуулийн нэр дээр гуравдахь удаагаа саналаа хураа "Их засаг" нэрийг

эвшөөрсөн	190/47%/
татгалзсан	189/47%/
түдгэлзсэн	25/6%/
бүгд	404/95%/

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан, депутат С.Билэгсайхан, Ц.Элбэгдорж нарын гаргасан саналын дагуу 20-30-аад онд хэлмэг-дэгсэдийн дурсгалыг хүндэтгэх асуудлыг санал хураалтаар шийдвэрлэх үү? гэхэд олонхи депутат энэ асуудлыг маргааш өглөө ярилцъя гэсэн санал хэлэв.

Хуралдаан 19³⁶ цагт дуусав.

Танилцсан: АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

ОРЛОГЧ ДАРГА

Тэмдэглэсэн:

Ж. УРТНАСАН
 Н. БАТБАЯР
 Г. ЖАГАЙ
 Ц. ЛООХУУЗ
 Д. МООНДОЙ
 А. ЮНДЭНДОРЖ
 Г. ХҮРЭЛБААТАР

8

АРЛЫН ИХ ХУРЛЫН 1991 ОНЫ 11 ДҮГЭЭР
САРЫН 18-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ИРЦИЙН
Б А И Д А Л

Ирвэл зохих: 427

Хуралдаанд ирээгүй / шалтгааныг дурдана/: Депутат

Г.Чингэл /339/, Т.Батмөнх /376/, Ц.Охинтогтох/254/, Н.Сампил-
норов /199/

Депутат Р.Сүрэнжаргал гадаадад яваа.

Хуралдаанд хоцорч ирсэн:

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Уртнасан: -Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая. Та бүгдийг ням гаригт сайхан тав тухтай амарсан гэдэгт найдаж байна. Ингээд хуралдааныхаа ажиллагааг эхэлье. Уламжлал ёсоор хуралдааныхаа ирцийг бүртгэе. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү. За ирц бүртгэж эхэллээ. Ирвэл зохих 427 депутатаас 393 буюу 92 % нь ирсэн байна. Хурал эхлэхэд хүчин төгөлдөр байна. Баярлалаа.

За одоо эр өнгөрсөн хоногуудад манай хуралдааны нэр дээр хөдөлмөрчид, хөдөө орон нутгаас болон төв хотуудаас олон захидал, мэдээлэл, санал ирсэн байна. Үүний тоог орлогч дарга Лоохууз гуай уншиж сонсоно.

Лоохууз:

-Тус хуралдааны нэр дээр 2 өдрийн дотор асар олон тооны талархал, мэдэгдэл, захидал ирсэн байна. Энэ хугацаанд олон нийт, хувь хүмүүсээс бичгээр 79, цахилгаанаар 5, утсаар 31 ширхэг, хүлээн авах байраар 31 хүн ирж санал хүсэлтээ тавьсан байна. Энүүнийг УБХ, Засгийн газартай холбогдсон нь бүр их олон байна. Эднүүдийг тухайлан тоймлож, Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланд оруулахаар тохиролцож үлдээсэн байна. Тус хурлын нэр дээр ирсэн цахилгаан бичиг бол үндсэндээ 45 хуудас ийм зүйл ирсэн байна. Тэгээд энийг нэг бүрчлэн унших хэрэгцээ байна уу, утга нь ерөнхийдөө түрүүчийнхтэй төстэй, хуулийг гол нь хуулийн талаар хуулийн нэрийг зарим нь өөрчилнө, зарим нь өөрчлөхгүй гэсэн ийм зүйлүүд ихэнх нь байна. Энэ хүмүүсийн нэрсийг унших хэрэгцээ байна уу, үгүй юу нөхдүүдээс санал асууя. За Октябрийн районы 35 дугаар хорооны иргэн Дашзэвэг утсаар ярихдаа би ардчилал динчлэлийг дэмждэг, гэтэл зарим нөхдүүд ардчиллаар далимдуулаад болох бүтэхгүй юмаар хөөцөлдөж байна, гэсэн ийм юм сануулсан байна. Мөн Октябрийн районы 25 дугаар хорооны иргэн Гунгаажав утсаар ярихдаа, депутатууд гол зүйлдээ анхааралаа чиглүүлмээр байна. Гуйваж, дайваад байх хэрэг байхгүй. Ирээдүйтэй, урт настай, ард түмний сэтгэлд нийцсэн хууль гаргахыг хүсье гэсэн байна.

Мөн Сүхбаатарын районы I дүгээр хорооны иргэн Лодойсамбуу утсаар хэлэхдээ, АИХ-ын депутат генерал Пүрэвдорж, зохиолч Бямбаа нар хот, хөдөө гэж депутатуудын дотор ялгаа гаргаж хөдөөгийн депутатуудыг мэдлэг муутай, асуулт ойлгохгүй байна гэж дайрч доромжилж байна, телевизийн тоймч Мянмар иймэрхүү сэтгэлгээтэй хүмүүсийг нэгтгэн ярилцлага авсан нь таашаагдсангүй гэнэ. За мөн Сүхбаатарын районы III хорооны иргэн Амар бичгээр ирүүлэхдээ хуралдаанд унтаж байгаа депутат телевизээр багагүй харагдаж харагдах юм, тэр зүгт телевизийн дуранг чиглүүлмээр байна гэнэ. За Сүхбаатарын районы ардын шүүхийн шүүгч Гэрэл хүлээн авах байраар УБХ-ын гишүүд, комисс маань Их цаг хүч зарцуулж, тал бүрээс нь нягтлан боловсруулсан Их цаазын төслийг хөдөөгийн депутатууд хуучнаараа сэтгэж, зүтгэж байгаад сэтгэл дундуур байгаагаа илэрхийлжээ гэсэн байна. Мөн Октябрийн дүүргийн 25-р хорооны өндөр настан Ханджав хүлээн авах байраар хөдөөнөөс ^{сонгогдсон} депутатууд аа, хотоос сонгогдсон депутатууд, УБХ-ын гишүүд, төр, засгийн удирдлагадаа итгэж, энэ тэр нам гэхгүйгээр эв эеэ олж, ард түмнээрээ хэлэлцүүлсэн Их цаазын төслөө хэлэлцэн батлахыг та нөхдөөс хүсч байна. Та нарын дотөр хуучинсаг үзлээсээ салж чадаагүй хэсэг депутат байгааг ухаарч, биенээ хардаж сөрдөхөө болих хэрэгтэй, хөдөлмөр гаргаж боловсруулсан төслөө тэр чигээрэнгий нь батлахад буруутах юу байх вэ гэж бичсэн байна. Мөн Октябрийн дүүргийн орон сууц гудамжны 37-р хорооны иргэн Банзрагч хүлээн авах байраар Их цаазын төслийг бүх шатанд хэлэлцсэн учраас сонгогч бүрийн захиасыг биш, түүнээс хамгийн оновчтой зөв саналыг нь авах замаар ухаалаг бодож батлах хэрэгтэй байна. Засгийн газар ганцхан жил ажилласан учир тайланг нь хэлэлцэх хэрэг байгаа юм уу. Бас ч Засгийн газар маань их л арга хэмжээ авсан байна шүү дээ. Сүхбаатарын дүүргийн 32-р хорооны өндөр настан Доржгочоо хүлээн авах байраар хуралдаан асуудал шийдвэрлэхдээ битгий хэт туйлшраад байгааг чээ. 70 жилийн туршид бий болсон бүх л юмыг өөрчлөх, үгүй хийх юм ярьж байна. Тэр үеийн бүх хүн чинь хэрэггүй болж байна уу, тэгвэл тэр үед босоон бүх үйлдвэр барилга, оюуны бүтээл устах уу, ингэж болохгүй шүү дээ. Тэр үеийн сайн бүхнийг нь авч, хуулинд тусгах хэрэгтэй байна гэнээ. Мөн Баруунурт хотын III хорооны өндөр настан Цэвэлмаа бичгээр ирүүлэхдээ

Цэен-Ойдовын АИХ-ын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлж болохгүй, депутатгүй сонгогчид байх учиргүй, энэ тойргийн сонгуулийн комисс сонгууль явуулах журмыг зөрчсөн байхад энэ хуралдааны өмнө дахин сонгууль явуулах байжээ. Тогтоолдоо эргэж хянахыг хүсье гэжээ. Октябрийн дүүргийн ҮШ хорооны иргэн Даваасамбуу бичгээр ирүүлэхдээ улсын нэр, төрийн сүлд, тамга, тэмдэг, соёмбо, 5 хошуут хэвээр нь байлгая гэнээ. Улсын болон хуулийн нэр, сүлд, далбааны талаар улсын бага хурлаас оруулсан саналыг дэмжиж байна гэж ирүүлсэн байна. Хуулиа Их хууль гэж нэрлэе гэж санал ирүүлсэн байна. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал дэд эрдэмтэн Минжигдорж бичгээр ирүүлэхдээ төслийн I дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн I-д ус, ой, гэсний дараагаар мал, сүрэг гэж нэмж оруулъя гэдэг санал ирүүлсэн байна. Октябрийн районы 32 дугаар хорооны иргэн Лхагвасүрэн бичгээр ирүүлэхдээ төрийн тугийг цэнхэр өнгөтэй болгох нь зүйтэй, улсын нэрийг Монгол улс гэх нь зхйтэй. Хуулийн нэрийг Их цааз гэх нь зүйтэй гэж хэлсэн байна. УБ хотын МАХН-ын хорооны ажилтан Норовсамбуу, улс, хуулийн нэрийг хэвээр үлдээх, морьтой, алтан нартай, эх орны минь байгальтай сүлд байх, гадаадын иргэдэд ямар нэг хэлбэрээр газар эзэмшүүлэхийг хориглох, ийм санал ирүүлсэн байна. Ер нь гол утга санаа нь иймэрхүү янзэн км явж байна. 40 хэдэн хуудас байна. Тэгээд энийг бүгдий нь унш гэвэл унших байна, их л дульдрах байх даа л гэж бодож байна, тэгээд гол санаа нь ийм байна, хууль зүйн талаар, засгийн газрын тайлангийн талын холбогдсон саналууд тэртэй тэргүй цөмөөрөө анхааралд авагдана, ийм км байна. Энийг л сонордуулъя. Цаашлаад нэг хэсэг депутатуудаас ирсэн нэг ийм хурлын дарга нарт ирсэн бичиг байна, энийг сонордуулъя. БНМАУ-ын АИХ-ын дарга Уртнасан, орлогч дарга нарт, АИХ-ын 2 дугаар хуралдааны 6 өдрийн явцаас дүгнэлт хийвээс цаашид хуралдаан улам сунжирч, төлөвлөсөн 21 хоногтоо багтахгүй нь ойлгомжтой боллоо. Хөдөлмөрчдийн дунд дээрээс эхлээд хурал дэглэм муутай, хэрүүл маргаантай, цаг хөрөнгө их үрж, удаан үр дүн муутай болдог гэсэн ийм яриа байгааг бид мэдэрлээ. Энэ бодит байдлыг та нартаа танилцуулъя. Ингээд дор дурдсан саналыг хуралдааны эхний цагт хэлэлцүүлж өгөхийг эрхэмлэн хүсье гэсэн байна. Энэ нь I-рт, уг хэлсэн депутатууд гол санаагаа илэрхийлж чадсан тул Их цаазын

ерөнхий хэлэлцүүлгийг тасалж, өнөөдрөөс эхлэн улсын болон хуулийн нэр, засаглалын хэлбэр, засаг захиргааны нэгж, төрийн сүлд, туг зэрэг зарчмын гол асуудлуудаа хэлэлцэж шийдэж эхэлье. Эдгээр асуудлыг шийдвэл ард олны бүхимдал намдах байх аа гэнэ. I-рт, 2-рт ерөнхий хэлэлцүүлэгт оролцохоор нэрээ бүртгүүлсэн депутатууд саналаа бичгээр өгцгөөе. Хамгийн гол нь бичгээр өгсөн саналуудыг нэгтгэн цэгцэлж, хэвлэлд тавьж нийтлүүлэх юм уу, радио телевизээр нэвтрүүлэхээр тогтвол депутатууд таслах саналаа дэмжинэ байхаа гэсэн ийм ийм зүйлийг ирүүлсэн байна. Энд бол 58 депутатууд тойргийнхоо дугаарыг тавьж ирүүлсэн байна. Энүүнийг депутатуудын сонорт хүргье.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

1991.XI.18.

Кассет №28

9.15-9.30

Ардын Их Хурлын орлогч дарга Ц.Лоохууз:

-Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасангийн нэр дээр хэсэг эрдэмтдээс бичиг ирүүлсэн байна.Энүүнийг уншиж өгөхөөр боллоо.

ЫНМАУ-ын шинжлэх ухааны академийн дор үсэг ^{зурсан} бүхий нэр бүхий эрдэмтдээс.Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн өдгөө, ирээдүйн хувь заяаг шийдвэрлэх хүндтэй бөгөөд түүхэн хариуцлагатай үйлс бүтээхийн тулд улсынхаа шинэ Үндсэн хуулийг батлан гаргахаар хуран цуглаж байгаа эрхэм хүндэт депутат Та бүгдийн мэргэн өмүнд толилуулах нь:

Ард нийтээрээ хэлэлцэж олон шатанд боловсруулсан Монгол улсын Их цааз нэртэй шинэ Үндсэн хуулийг ерөнхийд нь дэмжиж байгаа боловч түүнийг улам боловсронгуй болгох олон зүйл байгааг та бүгд бүрэн төгөлдөржүүлж чадна гэдэгт итгэл төгс байгаагаа юуны өмнө илэрхийлж байна.Бид эрдэм судалгааны ажил эрхэлж эрт, урьдын уламжлалаас эхлээд одоо цагийн бодлыг эргэцүүлэн бодож ирээдүйг таамаглах дадал зуршилтай болсны хувьд олон нийтийн анхаарлыг татаж байгаа улс орны төрийн удирдлагын засаглалын хэлбэрийн талаар саналаа та бүгдэд өргөн айлтгаж байгааг минь соёрхон хянаж болгоон тунгаана уу.

Монголын төрт ёсны түүхэн уламжлалаас үзэхэд бидний монголчууд төр, засгийн тэргүүнээ гүнээ хүндэтгэж, эх орон, ард түмнийхээ хувь заяаг түүндээ даатгаж ирсэн түүхтэй билээ. 1991 онд манай улсын анхны Ерөнхийлөгчийг Ардын Их Хуралд тангараг өргөж бүрэн эрхээ өргөмжлүүлсэн ёслолын ажиллагаа бол ёстой л монгол хун бүрийн үндэсний бахархал түрүүлсэн баярт мөч байсныг маргах хун байхгүй биз ээ.Энэ бол ард түмний уламжлалт, төрт ёсны сэтгэлгээний тодорхой жишээ болсон билээ.Ийм учраас монгол улсын Их цааз нэртэй Үндсэн хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг Монгол улс бол Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс мөн.Төслийн 30 дугаар зүй-

лийн I дэх хэсгийг Монгол улсын Ерөнхийлөгч бол монголын ард түмнийг төлөөлсөн төр, засгийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн бэлгэдэл мөн гэж өөрчлөн найруулахын хамт төслийн 31 дүгээр зүйлийг зөвхөн уг зүйлийн 3 дугаар хэсэгт нь заасан агуулгад зохицуулан өөрчилж энэ гурван зүйлийн заалттай зохицох бусад өөрчлөлтүүдийг оруулан шийдвэрлэхийг хүсч байна.

Байдлыг судлан үзэхэд төрийн удирдлагын засаглалын Ерөнхийлөгчийн хэлбэрийг эсэргүүцэж байгаа талынхны гол үндэслэл, аймшиг нь нэгдүгээрт, хэмжээгүй эрхтэй нэг хүний дарангуйлал тогтож мэднэ. Чойбалсан, Цэдэнбал нарын дэглэмээс үзэхэд ийм аймшиг байж болох юм. Гэхдээ хоёрдугаарт, улс төрийн тогтолцоо тогтворгүй болж төрийн эргэлт гаргахад хялбар болж мэднэ. Гуравдугаарт, улсын эдийн засаг нэг хүний гарт хэт төвлөрнө. дөрөвдүгээрт, төрийн аппаратын орон тоо зардал хэт өснө гэдгээр тайлбар тавьж байгаагийн зэрэгцээгээр Ерөнхийлөгчийн ачаалал үүрэг хэт өсөж, хариуцлага өндөржсөнөөс сүрдэх тал ч байх шиг байна гэнэ ээ. Бидний үзэж байгаагаар нэгдүгээрт, Ерөнхийлөгчийг нийт сонгогчид шууд сонгохдоо улс төрийн намуудаас урьдчилан шалгаруулж нэр дэвшүүлсэн хүмүүсийн дотроос дахин дахин шалгаруулалт хийх учраас ард түмэн хэн нэг овилгогүй этгээдийг гаргахгүй байх баталгаа болж чадах юм.

Чойбалсан, Цэдэнбал нарыг ард түмэн сонгож байгаагүй, зөвхөн ганц намын тойрон хүрээлэгчид л дэвшүүлж тухайн үедээ үйлчилж байсан парламент сонгож байсан шүү дээ.

Хоёрдугаарт, улс төрийн олон намын тогтолцоо бодитой бүрдсэн бөгөөд тэдгээр нь цаашид эрх барих сөрөг болон хөндлөнгийн намууд болж улс төрийн нэр хүнд бүхий хүчнүүд болох явдал эргэлзээгүй учраас төр, засгийн тэргүүнийг дарангуйлагч болохыг хазаарлан барих улс төрийн баталгаа болох юм. Үүнээс гадна Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэр нь хууль тогтоох, төрийн дээд эрх барих, парламентыг үгүйсгэхгүй бөгөөд түүний эрх хэмжээг ч хязгаарлахгүйгээс гадна Ерөнхийлөгч, Засгийн газрын хоёрын үйл ажиллагаанд парламентаас тавих хяналтын журманд Ерөнхийлөгч дарангуйлагч болохгүй байх ардчиллын баталгаа болж чадах юм.

Гуравдугаарт, Ерөнхийлөгчийн сонгогдох бүрэн эрхийн хувьд заасан тодорхой хугацаагаар хязгаарлагдаж байгаа бөгөөд Ерөнхийлөгчийн үйл ажиллагаа хуульд хэрхэн нийцэж байгаад хяналт тавих эрх хэмжээтэй, хараат биш Үндсэн хуулийн цэц бий болж байна. Энэ нь Ерөнхийлөгчийг хугацаагүй дарангуйлагч болох нөхцөлийг хааж байгаа бөгөөд түүнийг үйл ажиллагааг Парламентын болон олон түмний хяналтад оруулж байгаа баталгаа болж байгаа юм.

дөрөвдүгээрт, Өмнөд Америкийн болон Африк тивийн зарим жижиг орнуудын туршлагатай харьцуулсан ч улс төрийн эргэлт гаргахад хялбар байж магадгүй гэж үзэж болохгүй ээ. Төрт ёсоо хүндэтгэн үзэх, Монголын ард түмний уламжлалт сэтгэлгээ, монгол хуулийн онцлогоос үзэхэд ард түмний дундаас шалгаруулсан улс орны удирдагч бол төр, засгийн тогтвортой байдлын тулгуур, эв нэгдлийн бэлгэдэл болох учиртай.

Тавдугаарт, манай оронд эдийн засгийн социалист харилцаа задарч, өмчийн олон хэлбэр хууль ёсоор зөвшөөрөгдөн хөгжиж байгаа нөхцөлд улсын эдийн засаг яасан ч нэг хүний гарт төвлөрүүлэхгүй болно. Түүнээс гадна зарим нэг хүний нотолгоогоор Ерөнхийлөгчид 5 төгрөгийн ч мэдэл өгч болохгүй гэдэг бол улсыг бүхэлд нь болон түүний удирдагчийн статусыг доромжилсон хэрэг гэж үзэж байна аа.

Зургадугаарт, Ерөнхийлөгчийн засаглал тогтсоноороо төрийн аппаратын орон тоо өснө гэж таван муж улстай 30 шахам сая хүн амтай эдийн засаг, цэрэг, улс төрийн хүч боломжоороо дэлхийд хэт их гүрэн АНУ-ын Ерөнхийлөгчийн аппарат, захиргааны зардал, орон тоотой Монголын Ерөнхийлөгчийн аппарат, орон тоог адилтган үзсэн нь хэтэрхий гэнэн бөгөөд төөрөгдөлтэй хэрэг болно. Харин одоо байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын аппаратад давхардаж байгаа ихээхэн орон тоо, зардлыг хэмнэх боломж гарна.

долдугаарт, улс эх орон, ард түмний өмнө Ерөнхийлөгчийн хүлээх үүрэг хариуцлагыг улам их болгох ёстой. Тэгсэн нөхцөлд улс орны удирдлага төвлөрч, удирдагч, олон түмэн хоёрын харьцаа хүндэтгэл, хариуцлага нэмэгдэнэ. Му ч шийдэж, хийж чаддаг-

гүй гар, хөл нь хүлээстэй юм шиг зөвхөн харагдаж, ёслол гүйцэтгэхийн тулд Ерөнхийлөгч байх ёстой гэж үзэж болохгүй ээ. Үүний тулд айлтган барилаа. II дүгээр сарын 15.

Гарын үсэг зурсан эрдэмтнүүдийн нэрсийг дурдах уу. Академич Тойвгоо, Цунцаг, Шагдарсүрэн, Жанчив, Лодой, Гомбо, Уртнасан, Түмэн, Намхайдорж, Шягмарсүрэн, Цэрэнбалжид, Лигху, Өлзийхутаг, даариймаа, дугаржав, Цогт /докторууд байна зарим нь/, Буян-Орших, Цодлой, Адъяа, Хандсүрэн, Шүрөв, Ганболд, Гарамбазар, Сүхбаатар, Кндон, Сэржээ, Маньбазар /дэд эрдэмтэнгүүд/, Цэрэвсамбуу, Мандах, Шамъянсүрэн, Цэвээн, Лхагвасүрэн, Гончиг /академич/. Ийм 34 хүн нэр тавьж гарын үсэг зурсан байна.

М. Уртнасан: -Та бүгдийн сонорт байдлыг танилцуулаад хуралдаанаа дэгийн дагуу үргэлжлүүлье. Одоогийн байдлаар 103 хүн саналаа бичгээр бидэнд ирүүлжээ. Манай орлогч дарга нар ажлын групптэй хамтран нэгтгэж байна. 91 хүн үг хэлсэн. Анх 168 хүн үг хэлье гэж саналаа ирүүлсэн дээр 39 хүн нэмэгдээд одоо бидэнд байгаа нэр бол 207 депутатын нэр байна. Одоо үг хэлээгүй хүн 116 үлдэж байна. Хэрвээ 116 хүн 7 минутаар үг хэлье гэвэл 812 минут буюу 13 цаг зарцуулах төлөвтэй байна. Таслах саналыг 74 депутат ирүүлсэн байсан. Өнөөдөр 58 хүн, сая 3 хүн нэмэгдээд ингээд 132 хүн ер нь санал давхардаж байна. Цаг бага байна, үлдсэн нь бичгээр өгье. Цеен хэдэн зүйл дээр яригдаж байна гэсэн санал ирүүлж байна.

Гэхдээ байдлыг шүүгээд үзэхэд таслах санал гаргаж байгаа депутатууд голдуу үг хэлсэн улсууд байгаад бид бас мэдрэмжтэй байна. Ингээд хуралдаанаа дэгийн дагуу үргэлжлүүлье. I дүгээр микрофон дээр 290 дүгээр тойргийн депутат Цэвээндорж.

290 дүгээр тойргийн депутат С. Цэвээндорж: -Үндсэн хуульд манай орны ирээдүйн хөгжил, амьдралын түвшин, баталгааны хувьд онцгой их нөлөөлөх олон асуудлууд хөндөгджээ. Хэлбэрийн хувьд дахин дахин ярих шаардлага алга байна. Харин агуулгад онц

анхаармаар байна. Ардчилал, зах зээлийн нөхцөлд манай орны нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарч, бүтэц өөрчлөгдөж байна. Малчин, тариаланчид, хөдөлмөрчид, ялангуяа хөдөөгийн ард түмний дунд бүрэн бэлтгэл хангагдаагүй байж хувьчлалыг эхэлж гэрээ, түрээсэнд хамруулснаас ардчиллын дор эрх чөлөө олгосноор сүүлийн хоёр жилийн дотор ажлын хариуцлага, сахилга бат, ажил хөдөлмөрийн эрч далайц, амьжиргааны түвшин буурлаа. Энэ талаар яриад байвал ярих зүйл их байна. Өнгөрсөн онуудад гаргасан хууль, тогтоол, засаг, төрөөс авсан арга хэмжээнүүд зарим талаасаа амьдралаас хөндий хийсвэр, хуулбарласан гарч биелэлт муу байна.

Шинэ Үндсэн хуулийн төсөлд ийм зүйл нэлээд оржээ. Энэ тухай зүйл бүлэг дээр нь ярилцъя. Би хоёр, гурван зүйл дээр анхаарал төвлөрүүлж ярьж гэж бодож байна. Өөрчлөх, зохион байгуулах гэж байгаа зүйлийн мөн чанар, зорилго яаж хэрэгжүүлэхийг ард түмэндээ эхлээд сайн ойлгуулах хэрэгтэй байна. Ойлгуулахгүйгээр, санал авахгүйгээр шууд шийдвэр гаргачихаар их, бага хэмжээгээр алдаатай шийдвэр гарч, гарсан шийдвэр нь буруу хэрэгжүүлээд завхралд хүрч байна. Үүнээс эцсийн эцэст сахилга, дэг журам зөрчигдөж, улсын өмч үрэгдэж, хүний аманд хийх, өмсөж эдлэх зүйл маань хомсдож байна.

Мөн дэвшүүлж өөрчилж байгаа зүйлээ яаж хэрэгжүүлэх, ямар аргаар хүргэх, хэрэгжүүлээд юу болох гэдгийг маш сайн төлөвлөхгүйгээр ингэх ёстой, тэгэх ёстой гээд хууль гаргачихсан байна. Манай монголын хууль өвөрмөц онцлогтой. Бид хэтэрхий нэг тийшээ туйлшраад хуулбарлаад байна гэж бодогдож байна. Мөн Үндсэн хуулийн нэлээд заалтыг ард түмэн хүлээж авах бэлтгэл хангагдаагүй байна.


Онолын хувьд зөв, ард түмэндээ бэлтгэлээ хангаагүй. Нэг амьсгаагаар бүх кмыг хийж болохгүй ээ. Ард түмэн голлон олон зүйлд өөрсдийнхөө саналыг өгчихөөд байна шүү дээ. Үүнийг анхаарах хэрэгтэй. Байж болмооргүй юм байна. Төрийн тогтолцоог маш зөв тогтоосноос бидний ирээдүй шалтгаална шүү дээ.

Надад горимын холбогдолтой санал, гомдол байна. Би энэ танхимд тэгш эрхтэй баймаар байна. Тэгш эрх алдагдаж байна. Сэтгэ-

лийн хөөрлөөр зарим нь, зарим нь өөрийн үзэл бодол, баримтлалаа хэт хамгаалах гээд, зарим нь үсэрч босоод, дэгээ зөрчөөд яриад, уриалаад, залгаад байх юм. Хэн ийм илүү эрх эдлэх юм бэ? Бүгд ижилхэн эрх эдэлнэ. Өчөр дугаар аваад ярина. дундуур нь үсэрч босч ирээд юм ярьж байхад хажуугаар яриад байх юм. Тэр нэг хэдэн хэтэрхий хүмүүст эрх мэдэл илүү өгч болохгүй.

Хувийн болоод нам, эвслийн үзэл бодлыг хэтэрхий явцуу хамгаалаад байх юм. Нэг нэгийгээ доромжлоод байна, үүнийг болимоор байна. Би хэвлэл, мэдээллийн ажилтнуудад шударга биш байна гэж бас хэлэх гэж байна. Радио, телевиз, сонинд танил тал, монгол хувцастай, нэр төртэй хэдэн нэрийн, хэлбэр харж их сурталчилж байх шиг байна. Энийг анхаарах хэрэгтэй. Сурталчилгаа бол хэлбэрээсээ биш агуулгандаа байх хэрэгтэй.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУУЯ

Бичээч

Ө.Оюунчимэг

Хоёрдугаарт би энд гол асуудал хэлэх гэж байна. Төрийн эрх барих дээд байгууллагын хуралдаан болж байна гэж яриад байдаг боловч сурталчилгаа хангалтгүй байна гэж үзэж байна. Би бодохдоо Монголын радио, Монголын телевиз, Ардын эрх сонин болон бусад сонингууд ихэнх нэвтрүүлэг, хэвлэлээ энэ хуралдаанд зориулмаар юм шиг бодогдох юм. Ардын эрх сонин хуралдааны үеэр янз бүрийн зохиол, шүлэг ч юм уу тийм юм тавьж байхын оронд бүх хуудсаа юм уу ихэнх хуудсаа хуралдаанд зориулах хэрэгтэй. Ардын эрх сонин бол энэ хуралдааны үед одоо гарч байгаагаас хоёр дахин юм уу гурав дахин нэмж гарах хэрэгтэй. Зөвхөн мэдээ төдий гарч байна. Телевиз радио программаа өөрчилмөөр байна. Энэ хуралдааны ажиллагаа, хуралдаанд шийдэх гэж байгаа ажиллагааг олон эрдэмтдээр тал талаас нь яриулж өгмөөр байна. Ард түмэнд энэнийг сурталчилмаар байна. Ийм учраас хуралдааны сурталчилгааг Ардын Их Хурлын дарга Уртнасан анхааралдаа авч энэ сурталчилгааны талаар бүр нэлээд их арга хэмжээ авах хэрэгтэй. Түрүүчийн тэр хүний ирүүлсэн аргагүй шүү дээ. Ерөөсөө ингээд эогсоогоод ярьдаг нэг хэлбэрийн яриа нэг 20 минут өдөрт телевизээр явж байна. Энэ бол бага байна гэж байна. Ийм учраас энэ сурталчилгааны ажил дээр их анхаарал тавиачээ. Их баярлалаа.

Ардын Их Хурлын I64 дүгээр тойргийн депутат Ц. Дэмий: - За саян уг хэлсэн депутатын суулийн санал, гомдолтой санаа нэг байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт төрийн сүлд, далбаа, бэлгэцлийн хувьд бол түрүүчийн олонхийн санал хэлээд байсан саналтай нэг байгаа учраас давхардуулах шаардлагагүй гэж үзэж байна. Ингээд энэ ерөнхий саналтай холбогдуулж хоёр гуравхан саналыг товчхон та бүхэнд толилуулъя гэж бодож байна.

Нэгдүгээрт юу гэхлээр бид энэ Үндсэн хуулийг ард түмнээр

хэлэлцүүлж , бүсийн зөвлөлгөөн хийж багагүй зардал чирэгдэл гаргасан.Энэ дээр манай энэ бүх депутатууд, 420 гаруй депутатууд маань нэлээн олон хүн амьтантай уулзаж олон сонгогчидтойгоо уулзаж тодорхой санал бодлыг ирүүлсэн.Тэр санал өнөөдрийн манай Бага Хурлаас Их Хуралд өргөн барьж байгаа төсөлд төдийлэн сайн сэтгэл ханамжтай орж чадаагүй байна гэцгийг хэлж байна.Үүнтэй холбогдуулж шүүмжлэлтэй хандаж хэлэхэд энэ төслийг боловсруулсан хүмүүс өөрсдийнхөө боловсруулсан төслийн зүйл, бүлэг тус бүр дээр өөрсдийнхөө бодлыг тулган хүлээлгэх гэсэн тийм хандлага байна.Тийм учраас энэ эрхэм Бага Хурлын гишүүдийг энэ тал дээрээ нэг жаахан хүлээцтэй, тэвчээртэй , бид нарын үгийг гайгүй сайн сонсоод дараа нь дүгнэж эрх тэгшээр яривал яасан юм бэ гэсэн ийм санаа байна.

Энэ нь ийм байдлаар тэр өөрийнхөө гаргасан хувилбарыг хэт хамгаалж туйлшрах явдал бол танхим дотор ч ялгаагүй, гадна ч ялгаагүй, ард түмэн бидэнд ч ялгаагүй бас нэг эвгүй сэтгэгдэл төрүүлээд байгааг анзаарахгүй байж болохгүй байна.

Хоёрдугаар асуудал гаэрыг өмчлүүлэх тухай асуудал байгаа. Энэ дээр яах вэ тоон үзүүлэлтээр хувиар авч үзвэл 03 хувь гэж яригдсан.Энэнийг хувиар аваад үзэхэд хэдийгээр бага хувь гэж харагдсан ч гэсэн яг энэнийг авч үзэх юм бол 46Г700 кв/км тийм нутаг байна.За яах вэ зүгээр өөрийн уугуул иргэндээ эзэмшүүлэх тэр нь зүйн хэрэг юм биз.Гаднын элчин,өшөө тэр зам,харилцаатай холбогдсон гаэраа түрээсээр эзэмшүүлэх нь зүйтэй байх.Гэсэн ч энэ хувь маань хэтэрхий өндөр юм биш үү. Энэ хот суурин газар, хувь хүнд эзэмшүүлэх, тэр одоо бусад түрээсээр эзэмшүүлэх газар маань одоо чухам хэдий хэмжээний юм байгаа юм бэ? Миний сонссоноор бол дорнод талын бүсэд тэр Тамсагбулагорчимд Японд баахан газар эзэмшүүлэх юм гэж дуулсан.Энэнд хүмүүс их дургүйцээд байх шиг байгаа шүү. Энэнийг бодохгүй бол болхгүй байх аа.

Засаглалын хувьд яах вэ ер нь нэлээн яригдах байх.Энэ дээр

бол яах вэ миний хувьд бол парламентын бүгд найрамдах улс гэсэн тийм засаглалтай байх нь одоо, тэр талыг дэмждэг. Тийм хүн. Хүмүүс ч ярьж байсан зарим депутатууд. Ер нь хоёр танхимтай байх нь зүйтэй гэсэн. Тэрийг бол дэмжиж байна. Тооны хувьд бол санал хураалт явах байх. Хоёулаа нийлээд л 200 цотор багтсан хэмжээний хоёр танхимтай байх нь зүйтэй гэсэн тийм санал байгаа.

Засаг захиргааны нэгжийн хувьд тун их анхааралтай болохгүй бол болохгүй. Засаг захиргааны нэгжийн хуваарь. Энэ дээр бол миний санаа бол ерөөсөө аймаг, сум, баг гэсэн чиглэлтэй байвал яасан км бэ гэсэн саналтай байгаа. Ер нь энэ дээр бол яг өнөөдөр бид нар нэг хувилбар гаргаад батлуулчих нэг хэрэг. Үүнийг хэрэгжүүлэхэд мэдээж Засгийн газраас бас нэг заавар чиглэл, шийдвэр гарах байх. Тэрийг хэрэгжүүлэх нөхцөлд маш их хүндрэл учирна. Тэгэхлээр энэ дээр нэлээн болохгүй бол болохгүй. Одоогийн манайхны төслөөр бол бидэнд дараа нь танилцуулах км гэж Их Хурлын дарга ярьсан. Хоёр хувилбар яригдаад байгаа км байна лээ. Нэг нь долоон хошуу, 76 баг. Нөгөөдөх нь 7 аймаг, 76 хошуу, нэг нь 8 аймаг, 105 хошуу гэсэн ийм чиглэлтэй байгаа. Тэгэхлээр өнөөдөр манай орон нутгийн ард түмэн маань өөрийнхөө сумыг тараахыг хүсч байгаа нэг ч иргэн байхгүй, ийш тийшээ нэгцээд томорчих, нааш, цааш суурьшлын хөдөлгөөнд их дургүйцэж байгаа ийм км байна.

Хамгийн эцэст хэлэхэд Улсын прокурорын функцэд нэлээн анхаарч өгөхгүй бол болохгүй нь ээ. Энд одоо хяналтын байгууллагыг нэлээн татаж буулгасан, тэрийг нэлээн ад үзсэнээс шалтгаалж өнөөдөр улс орон ямар янзтай байгааг анхаарахгүй байж болохгүй. Ийм учраас энэ Улсын прокурорын функцийг жаахан нэмэгцүүлэх, түүн дээр ерөнхий хяналтын талыг тодруулж өгөх талаас нь анхаарч үзвэл ямар байсан км бэ гэсэн ийм санал байна.

Ардын Их Хурлын 85 дугаар тойргийн депутат К. Сайраан: -Эрхэм хүндэт депутат нөхдийн анхаарлыг би дараахь хэдэн зүйлд

4.

ерөнхий санал шүүмжлэлтэй холбогтуулан хандуулмаар байна аа. Бид Үндсэн хуулиа батлах гэж байна. Энд бол цаг үе, цаг хугацаа, орон зайны хүчин зүйлийг заавал анхаарч үзэх ёстой билээ. Дэлхийн хүн төрөлхтөний хөгжил дэвшил, соёл иргэншлийн их нүүдэл хаана хүрээд байгаа билээ, бид тэдний хаана нь явж байгаа билээ, энэ нүүцлийн гэгдгийг юүний өмнө бодмоор. Яагаад бид энэ Үндсэн хуулийг өөрчлөх шалтгаан, өөрчлөх болсон гэдэг энэ шалтгааныг та бүхэн сайн ойлгож байгаа. Өнгөрсөн 70 жилийн бидний явж ирсэн систем маань явахгүй болж, өөрчлөх шаардлагатай гэгдгийг ард түмэнд нэгэнтээ хэлсэн шүү дээ. Ийм энэ сонголт бол эргэлт буцалтгүй, энэ шийшвэр бол эргэлт буцалтгүй гэдэг нь тодорхой. Бид өнөөдөр ард түмний энэ сонголтыг Үндсэн хуульд хуульчлан батлахын тулд энд цуглараад байгаа биш үү. Гэтэл тэр хуучин системийг маань ямар нэг хэмжээгээр заавал хадгалан үлдэх гэсэн ийм эрмэлзэлтэй, ийм зүйлийг элдэв аргаар оролдож байгааг би сайн ойлгохгүй байна. Арлаараа овоглосон ард түмний маань нэг хэсэг 20-30-аад онд амьд үлдээд, овоглож чадаагүй нөгөө хэсэг нь устгагдсан шүү дээ. Феодал нэр зүүгээд. Үүнээс үзсэн ч гэсэн монгол улсын Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нэрийг заавал өөрчлөх шаардлагатай гэгдгийг би дэмжиж байгаа.

Орон зайн хувьд бол түрүүн Монгол улсын тусгаар тогтнолын талаар санал гаргасан зарим депутатын саналыг би бүрэн дэмжиж байна. Тухайлбал эрхэм гишүүн Энхсайханы хэлсэн санаандта бүхний анхаарлыг хандуулмаар байна. Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал өнөөгийн дэлхий нийтийн олон улсын харилцааны тогтолцооноос, тэр дундаа манай хоёр их хөршийн харилцаанаас их шалтгаалж ирсэн, цаашдаа ч шалтгаалах болно. Энэнийг бид ямагт анхаарч байх ёстой. Үүний тулд юүний өмнө ард түмэн маань эрх чөлөөтэй, төр маань тогтвортой, эдийн засаг маань хүчирхэг байх шаардлагатай, үүнийг бид энэ Үндсэн хуульдаа тусгаж өгөх ёстой гэж үзэж байгаа. Ерөнхийлөгчийн засаглалтай байх уу, парламентын засаглалтай байх уу гэж их маргаж байна. Ерөнхийлөгчийн засаглалтай байхад төрийг яаж амархан эргүүлж болох вэ, яаж амархан төрийн тэргүүнийг өөрчилж болох вэ гэдгийг саяхны өнгөрсөн 8 дугаар сард Зөв-

лөлтөд гарсан төрийн эргэлт бэлхнээ харуулсан шүү дээ. Энэнийг бас депутатууд маань анхааралдаа авах хэрэгтэй гэж үзэж байна. Эцсийн эцэст бидний батлан гаргах гэж байгаа шинэ Үндсэн хууль маань хүн төрөлхтөний соёл иргэншлийн их санд оруулж буй та бидний хувь нэмэр гэдгийг эрхэм депутат минь анхааралдаа аваасай гэдгийг сануулмаар байна.

Ардын Их Хурлын 321 дүгээр тойргийн депутат С.Батхуяг:—Ард түмнийхээ олонхийн саналд нийцсэн тийм Үндсэн хууль гаргах нь зүйтэй гэж бодож байна. Тэгэхээр би энд хүмүүсийн сонирхлыг татаж байгаа цөөн асуудлаар саналаа товч хэлье. Улсын нэр, хуулийн нэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж бодож байна. Төрийн сүлд, далбаанд ямар нэг хэмжээний өөрчлөлт оруулж болох юм. Гэхдээ шувуужхэрэггүй байх аа гэж бодож байна.

Гаэрыг монголын хот суурин газрын иргэдэд олон арван жилээр эзэмшүүлж, бусдад шилжүүлэхгүйгээр эзэмшүүлж болох юм гэж бодож байна. Тэгэхдээ өмчлүүлэх биш, эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ардын Их Хурлыг дээд, доод гэсэн хоёр танхимтай, дээд танхим нь, танхим гэх юм уу, үндсэндээ өнөөгийн энэ Их, Бага Хурал гэсэн системтэй байх нь зүйтэй юм. Дээд танхим 160-200 гишүүдтэй, бүх ард түмнээр сонгогцдог, Ардын Их Хурлын дарга буюу төрийн тэргүүн гэж энэнийгээ ахалцаг, Засгийн газрын гишүүд нь бүгдээрээ юм уу нэлээд хэсэг нь энэ дээд танхимтай суудалтай, доод танхим буюу Улсын Бага Хурал 25-30 гишүүнтэй байхаар ингэж байж болох юм гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл би энд парламентын засаглалтай байя, өнөөдрийнх шиг эрх мэдэл багатай, ийм бэлгэдлийн ерөнхийлөгчгүй, ерөнхийлөгч буюу төрийн тэргүүн нь Их Хурлаа даргалж байя гэсэн ийм санал оруулж байна.

Энд Их Хурал, Бага Хурлын хоорондын ажлын уялдааг яаж сайжруулах вэ гэдэг талаар бодож үзэх юм бий. Энэ талаар бид ярилцах учиртай. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд сонгуультай

үүргээ биелүүлэх бололцоо муутай, Их Хурлын депутатууд нь ажил ихтэй. Бага Хурлынхаа депутатуудыг шүүмжилж байдаг ийм системээсээ гарах уу гэдэг талаар бид бодох учиртай. Ардын Их Хуралд олонхийн суудал, санал суудал авсан намын дарга нь Улсын Ерөнхий сайцаар томилогдож, төрийн тэргүүнтэй зөвшилцөж Засгийн газраа бүрцүүлж байдаг ийм журамтай байвал яасан юм бэ гэж бодож байна. Нутаг цэвсгэр, эсвэл захиргааны хуваарийн хувьц одоогийн энэ хуваарийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэж байна.

Ардын Их Хурлын 213 дугаар тойргийн депутат В. Даваа:- Энэ Их цаазын төслийг боловсруулах талаар комисс, Бага Хурлын гишүүд ихээхэн нэр хөдөлмөрөө шингээж боловсруулсан байна гэдгийг сайшаан тэмдэглэхийг хүсч байна. Ингээд Их цаазын төсөлд төлөвлөгдсөн энэ улс, улсын нэр, хуулийн нэр, төрийн далбаа, сүлдний тухайд бол түрүүчийн депутатуудын хэлсэн саналтай нэг байна. Хуучнаар нь батлах ийм саналтай байна. Энэ дээр хамгийн гол, Их цаазын төслийн гол тулгуур асуудал бол энэ газрын талаар энэ газрыг өмчлүүлэх, түрээслүүлэх талаар орсон энэ саналыг бол хасах саналтай байна. Энэ дээр бол бид хамгийн гол нь өнөөдрийн тухайд бид газраа худалдаж идэхэд арай ч тулаагүй байх аа гэж ингэж бодож байна. Газрыг өмчлүүлж, газрыг түрээслүүлснээр өвөг, дээдэс, ураг удмаа бас бодох хэрэгтэй болов уу гэж энэ дээр бодож байна.

Засаглалын хувьд Ерөнхийлөгчийн засаглалыг ихээхэн дэмжиж байна. Ерөнхийлөгчийн засаглал дээр бол их бодож үзэх нь зүйтэй байх аа гэж. Энэ дээр Ерөнхийлөгчийн засаглал дээр энэ Монгол төрийнхөө ухаанаар бүтээсэн ийм засаглал бидэнд шаардлагатай болох байх. Монголын засаглалын түүхэн уламжлалыг нэлээд би авч хэрэглэх ёстой гэж ингэж бодож байна. Их цаазын төслийг өнөөдрийн эдийн засаг, нийгмийн бодит бололцоонд тулгуурласан Их цаазын төсөл биш, өнөөдөр биш, алсын хараатай ийм Их цаазын төсөл бол бидэнд хэрэгтэй болж таарах байх гэж ингэж бодож байна.

Газрыг түрээслэх буюу өмчлүүлснээр нүүдлийн мал аж ахуйн

систем устах вий гэдгээс ихээхэн эмзэглэж байна. Монгол малын генетонд устах вий гэдгээс ихээхэн эмзэглэж байна. Энэ тал дээр бас бодох тал бий байх аа гэж ингэж бодож байна. Монголын нүүдлийн мал аж ахуйн систем бол хамгийн өвс ургамал, бэлчээр нутаг сайтай газраа мал нь бэлчээрээ мал дагадаг, малаа малчин нь дагадаг, малчнаа хойно нь сургууль, цэцэрлэг, бусад үйлчилгээний асуудал дагаж одоо ингэж явдаг ийм системтэй шүү дээ. Энэнийгээ бас боцолцох хэрэгтэй болов уу гэж ингэж бодож байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ

НИЙЛСЭН

Д. Баяндүүрэн

Д. БАЯНДҮҮРЭН

Бичээч Л. Хорлоо

1991.11.18
Кассет III-30
9.46-10.02

213-р тойргийн депутат Лаваа:

Ингээд эцэст нь засаг захиргааны нэгжийн тухайд аймаг, сум, баг гэсэн ийм нэгжтэй байх саналтай байна.

Энэ дээр өнөөдрийн байдлаар энэ хөдөө орон нутагт ийм зүйлүүд ажиглагдаж байна. Өмч хувьчлал буку аж ахуйн зарим засаг, захиргааны аппаратууд цомхотгогдсоноос болж, өнөөдөр бэлхнээ бидний нүдэн дээр бригадуудаа ^{балгас} болгож байгаа ийм тохиолдлын кмнууд ихээхэн харагдаж байна. Тийм учраас хүнийг ихээхэн цомхотгож эхэлбэл, сум устаж үгүй болох, байхгүй болох өнөөдрийн энэ барилга байгууламж үгүй болох байхгүй байхаа, ийм тохиолдол гарч болох кмаа гэж ингэж үзэж байна.

Ерөнхийлөгчийн насны тухайд бол 45 наснаас дээш, монгол 3 үеийн, монгол улсын уугуул иргэн байна гэсэн энэ заалт хамгийн тохиромжтой хэлбэр болох байхаа гэж бодож байна.

Сонгуульд ялсан нам Засгийн газраа бүрдүүлнэ гэсэн ийм зарчмыг энд авч хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ж.Уртнасан: Депутатууд аа, хэвлэл мэдээллийн нөхдүүд бидэнд ийм гомдол ирүүлж байна. Депутатууд уг тавихгүй байна гэж гомдоллоод байгаа хэрнээ, тойргийн дугаар нэрээ хэлэхгүй, хэвлэл мэдээллийнхэнд хүндрэл учруулж байна.

Ийм учраас үгийнхээ эхэнд тойргийн дугаар, нэрээ тод хэлж байна уу гэж бидэнд анхааруулж байна.

310 дугаар тойргийн депутат Хад: Би өөрийнхөө саналыг бичгээр өгсөн.

Ж.Уртнасан: Бид цөөнхийг сонсч, цөөнхийг хүндэтгэж, олонхийн шийдлээр шийддэг, ийм учраас эрх биш бидэнд 132 хүн санал хураалгаж өгөөч гэж хүсээд байна. Нэмээд 7 хүн уг давхардаж байна.

Гол асуудлууд ер нь яригдлаа гэж байгаа учраас нэг удаа санал хураалт явуулж, танхимын олонхийн саналыг шийдмээр байна.

Тангад:

Даргаа энэ чинь яаж болдог юм бэ? Ганцхан нэг чиглэлийн үзэл баримтлалыг яриад байна шүү дээ. Бид чинь ерөнхий санал шүүмжлэл дээрээ, ямар ямар үзэл баримтлал байна вэ гэдгийг сонсох хэрэгтэй шүү дээ. Ганц нэг ижил юмыг яриулсаар байгаад дуусгачихаад, өөр юм сонсохгүй, аль эсвэл Хурлын дарга болоод зарим хүмүүсүүдэд ганцхан юм хэрэгтэй байгаа юм уу? ганцхан нэг хэвэнд цутгасан юм. Энэ чинь яаж болдог юм бэ? Бусдыгаа сонсох хэрэгтэй шүү дээ. Цөөнх нь ч бай, юу нь ч бай.

Ж.Уртнасан: Танхимыг хүндэтгэж байна, санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Тангад:

Би саналаа бичиж өгөхгүй ээ. Би энэ депутатуудад л хандаж хэлэх үгээ хэлнэ.

Ж.Уртнасан: Баярлалаа. Санал хураалтанд бэлтгэнэ үү. Бидэнд цөөнхийг хүндлэх горим бий шүү. 132 хүн байна.

Танхимаас:

Ерөөсөө давхардуулахгүй хэлэх юм байна шүү дээ. Хэвлэл, мэдээлэл дээр тавиулах гэж би сонирхохгүй байна.

Танхимаас:

Санал хураахаар олонхийн саналаар л таслаад хаячихна шүү дээ. Энэ чинь ямар хэрэг байгаа юм бэ?

Ж.Уртнасан: Таны нэр байгаа. Энд бидэнд жагсаачихсан нэр байна.

Танхимаас:

Үгээ хэдэн хүн хэлье гэж байгаа юм бэ? гарыг нь өргүүлээд барагцаагийг нь харчихгүй юу?

Ж.Уртнасан: Санал хураалтанд бэлтгэнэ үү.Ерөнхий санал шүүмжлэлийг тасалъя гэсэн томъёоллоор санал хурааж байна.

Танхимаас:

Хурлын даргаа заавал хэлүүлэхгүй гэсэн хүн байхад , заавал хэлье гэсэн депутатыг яаж болж байна вэ?

Ж.Уртнасан: Цөөнх болж саналаа хэлнэ биз дээ.

Бичих хамаагүй, хэлье гэсэн хүн байна шүү дээ.

94-р тойргийн депутат Санджав:

Хурлын даргаа, энэ дээр ийм юм байна.Энэ үг хэлэх гэж байгаа улсууд бол зүйтэй байх.Гэхдээ энд нэг юм байна . Бид нар ерөнхий санал шүүмжлэл нэртэй - 2 өдөр ерөөсөө морь магтаж, шувуу муулсан ийм л юм боллоо.Заавал ингэж бие-биенийхээ ярьсныг давтаад байхын шаардлага юу байна вэ? Би энэ дээр депутатуудыг доромжилж байгаа юм биш, уучлаарай. Уржигдар Жумдаанбаатар асуусан, энэ үг хэлж байгаа нөхдүүдийн хэлсэн үгийг хэвлэл дээр нийтлэх үү? ном болгох уу гэсэн.Болгоноо гэсэн.Үүнээс хойш л тэр хэвлэл дээр гарах гээд байгаа юм уу? үг хэлэх улсуудын тоо эрс нэмэгдээд, энэ сонирхол жигтэйхэн нэмэгдлээ.Үнэхээр энэ ярьж байгаа улсуудын ярианд залхаж байна. Дандаа нэгнийхээ ярьсныг давтаад байх юм, ингэж байхын шаардлага юу байна.

Үнэхээр санал нэг байна гэдгээ хэлчихээд, яг зарчмын ерөнхий санал шүүмжлэлтэй холбоотой, оносон үг хэлэх улсуудыг хэлүүлмээр, түүнээс бие биенийхээ ярьсныг давтан хуулбарласныг эрс эсэргүүцэж болиулмаар байна, ийм санал байна.

Ж.Уртнасан:Уучлаарай, депутат тууд аа, та нар сая ажигласан байх.Энэ санал хураалт хүчин төгөлдөр болж чадахгүй байна. Энэ санал хураалтанд орох хүмүүсээс дөнгөж 61 хувь нь буюу 261 хүн санал хураалтанд оролцож байна.Дахин санал хураалт явуулъя.Томъёоллоо дахин хэлье.Бид цөөнхийг хүндэтгэж, цөөнхийн

саналаар санал хураалт явуулж байгаа гэдгийг эрхбиш танхим мэдэрч байгаа гэдгийг би ойлгож байна. Ингээд Ерөнхий санал хураалтыг тасалъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Анхаарна уу?

Танхимаас:

Хурлын даргаа энэ чинь яагаад саналаа давтахгүйгээр, уг хэлж болдоггүй юм бэ? яриаар юм зөндөө байна шүү дээ. Яагаад зарим нь 10-20 удаа босдог, зарим нь яагаад ганц ч болдоггүй юм бэ? энэ чинь адилхан эрхтэй гээ биз дээ. Сая улсууд зөндөө ярилаа шүү дээ, үүнийг ойлгож үзэх арга алга уу?

Ж.Уртнасан: Эрхэм депутат аа? та бидний дэгд байгаа шүү дээ, санал хураалт явуулаад, цөөнх болчихвол цөөнх үгээ хэлдэг, цөөнхөө хүндэтгэж, дахин санал хураалт явуулдаг.

Одоо цөөнхийн саналыг сонсьё.

274 дүгээр тойргийн депутат Л.Цог-Очир:

Депутатуудын өмнө заавал нэрээ дуудуулж, үгээ хэлнэ гэж байгаа хүн хэд байгаа бол, гарыг нь өргүүлээд судалгаа хийвэл яасан юмбэ? Ер нь хэлүүлэх нь зүйтэй байх л даа.

Бичгээр өгөхгүй, би заавал үгээ хэлнэ гэж байгаа, депутат хэд байгаа бол, гарыг нь өргүүлчихмээр байна. Цөөн байвал бүгдийг нь сонсьё л доо.

Ж.Уртнасан: Заавал үг хэлье гэсэн улсууд гараа өргөж байна уу?

Депутатууд аа нэг ухаалаг гэж болохоор хувилбар байна, энэ гар өргөхийн оронд одоо бид нар цахим техникээ ашиглаад үзвэл яасан юм бэ? Заавал үг хэлье гэж байгаа улсууд, ирцэн дээрээ дарахгүй юу? тэгвэл дарааллаараа энд нэрсийн жагсаалт гараад ирнэ, тэнд тийм баримжаа авъя.

Урьд гарсан саналыг давхардуулахгүйгээр, би заавал уг хэлнээ гэж байгаа депутатууд ирц гэсэн товчоо дарах ийм томъёолол оруулж байна. Анхаараарай.

Танхимаас:

Түрүүн биччихсэн нэрс бий шүү дээ, наад нэр чинь дуусаагүй байна, хоёрдугаарт, энэ дундуур уг хэлэх ажил их муу байна шүү. Түрүүчийн депутатын хэлдэг үнэн. Зарим нь 12-13 удаа уг хэлээд, зарим нь бол ганц ч удаа санал сэтгэгдлээ хэлээгүй, иймэрхүү байгаа явдал байна шүү дээ. Түүнийг бас анхаарч үзээд энэ дунд талынхаа улсыг жичид нь авч үзмээр байм юм. Тэгвэл ямар вэ?

Ж. Уртнасан: Цөөнхийн саналыг сонсьё.

297 дугаар тойргийн депутат Тангад:

Надад ярих юм байна. Цөөнх болж уг хэлэх эрхгүй болчих гээд байх шиг байна. Тэгэхээр би ийм л юм хэлэх гэсэн юм. Надад тэр Үндсэн хуулийн зүйл тус бүрээр хэлэлцэхэд санал гаргах эрх үлдэх байх. Хэлнээ. Би ганцхан энэ Их цаазын төслийн үзэл баримтлалын талаар л хэдэн зүйл хэлэх гэсэн юм.

Яагаад гэвэл энэ чинь төсөл бол үнэхээр сайхан чанартай, өндөр түвшинд боловсруулагдсан төсөл байна. Гэтэл уг хэлсэн депутатуудын гаргаж байгаа санал бол энэ сайхан төслийг үе мөчөөр нь хуваах болгочих гээд байна. Хуучин тогтолцооны үндсэн хуулийг хэвээр нь хадгалах ийм санал их олон гараад байна, нөхдүүд минь. Ийм учраас би их санаа зовж байна. Ерөөсөө бид Үндсэн хуулиа баталж чадах юм уу? үгүй юм уу? Хуучин үндсэн хуулийг мэдээж хэрэг батлахгүй.

Тэгэхээр бид чинь ерөнхийлөгчийнхөө илтгэлийг сонсчихлоо. Ерөнхийлөгчийн илтгэлд энэ Их цаазын төслийн үзэл баримтлал, орж ирсэн байна шүү дээ. Бид түүн дээрээ ярьсангүй. Дандаа бүлэг зүйлүүдийн санал яриад байна.

Ерөөсөө энэ үзэл баримтлалаар шинэ төсөл маань ямар үзэл баримтлалтай вэ гэвэл бид шинэ Монгол улсын, шинэ нөхцөлд амьдарч байгаа, шинэ тогтолцоотой төрийн эх тулгуур хуулийг бид боловсруулж батлах ёстой. Түүнээс биш, хуучин засгийн, хуучин дарангуйлын, нэг намын үзэл сурталтай, хуучин системийн Үндсэн хуулийг хэвээр нь засамжилаад үлдээчихаж ердөө ч болохгүй шүү дээ, нөхөд минь. Та нөхөд минь үүнийг ойлгооч дээ. Бид ийм учраас яаж байна вэ гэвэл, улсынхаа нэрийг ч, хуулийнхаа ч нэрийг, сүлд, тэмдгийг заавал өөрчлөх шаардлагатай шүү дээ. Яаж өөрчлөх нь, ямар байх нь бид ярьж байгаад сонгоод авна биз. Таван хошуу мал нь сүлдэнд байна уу? шонхор шувуу нь байна уу? тэр бол жичдээ асуудал шүү дээ. Хамгийн гол нь өөрчлөх болсон гол шалтгаан байна шүү дээ. Бид шинэ тогтолцооны үед, шинэ монгол улсад байж байна шүү дээ. Түүнийг л бодох хэрэгтэй байна. Хуучнаараа байж яагаад ч болохгүй, заавал өөрчлөх бодит шаардлага байна шүү дээ.

Тийм учраас бид энэ үзэл баримтлал дээрээ үндэслэх хэрэгтэй байна. Түүнээс гадна Их цаазын төсөл дээр ололттой, дутагдалтай тал байна. Тэр хандлагаа л ярих хэрэгтэй байна. Хамгийн гол ололт бол энэ хуулийн мэдээж хэрэг хоёрдугаар бүлэг, хүний эрх, эрх чөлөөний талаар заалтууд байгаа. Тэгэхээр энэ хүний эрх, эрх чөлөөний тухай талаар гол үндэслэл болгож, түүнээсээ ургуулж авч л бид энэ шинэ цаазынхаа төслийг үндэс болгомоор байна. Гэтэл уг хэлж байгаа олон депутатууд энэ хоёрдугаар бүлгийн энэ зарчмын чухал бүлгийг бараг баталгаагүй болгох гээд байна.

Энэ Хоёрдугаар бүлгийн 17 дугаар зүйлийн II, III, IV, XV зүйлд заасан хүний эрхийн асуудал чинь ерөөсөө хэрэгжихгүй болчих гээд байна. Хэрвээ л газрыг хувьд өмчлүүлэхгүй юм бол. Ерөнхийлөгчийн илтгэлд дурдсан тоо баримтыг энд нэг депутат хэллээ, 0,3 хувь гэж. Бид улсын хэмжээний бүх газрыг 100 хувь гэж аваад үзэх юм бол түүний чинь 82 хувь нь хөдөө

аж ахуйн эдэлбэр газар, малын бэлчээр байгаа.Цаана нь үлдэж байгаа 18 хувиас дөнгөж 0,3 хувийг л иргэддээ өмчлүүлэх тухай асуудлыг яриад байгаа шүү дээ.Тэр таслал байгаа юм уу үгүй юм уу тэр тодорхой биш байна.0,3 гэснийг бодоход заавал таслал, өөрөөр хэлбэл 0,аравны 3 гэж хэлмээр юм шиг байх юм.Ерөнхийлөгч уншихдаа 0,3 гээд унших нь билээ.Хэвлэл дээр бас таслал байгаа, байхгүй хоёр нь мэдэгдэхгүй гарчихсан. Хэрвээ 0,3 хувь бол өчүүхэн хэсэг шүү дээ.Үүнийгээ иргэдэд өмчлүүлснээр монгол улсын тусгаар тогтнол алдагдана гэдэг чинь ер нь ямар хариуцлагагүй нотолгоо вэ? Энэ чинь ерөөсөө утгагүй юм шүү дээ.Бид ийм асуудлыг л бодох хэрэгтэй байна шүү дээ нөхөд минь.Тийм ч учраас энэ хуулийнхаа гол сумыг, гол дэвшилттэй зүйлийг нь бодох хэрэгтэй байна.

Нөгөө талаар энэ хуулийн төсөл дээр бас дутагдал байна. Тухайлбал III бүлэг дээр, их хурлын гишүүний хугацаа, бүрэн эрх, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа, шүүхийнх, Засгийн газрын... энэ чинь хоорондоо огт уялдаагүй болчиж оод бид гол зорилгоосоо ухраад байнаа.

Яагаад гэвэл төр, засгийг тогтворгүй болгож байна.Бид чинь төрийнхөө шинэ тогтолцоог бөх болгоё, батжуулъя, тогтвортой болгоё гэж яриад байдаг, хуулиараа тогтворгүй болгочих гээд байна шүү дээ.Жишээ нь, Их хурлын гишүүний сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулийг ойрын аравхан жилд аваад үзэхэд бид 6 удаа сонгууль хийх болж байна.92 онд Ерөнхийлөгчийн болоод, Их Хурлын гишүүнийх, 95 онд Их Хурлын гишүүнийх 50 хувь, 96 онд Ерөнхийлөгчөө дахиад бүрэн эрхийн хугацаа дууссан учраас сонгоно.98 онд дахиад Их Хурлын гишүүний 50 хувь, 2000 онд дахиад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан.2001 онд дахиад ингээд Их Хурлын гишүүний 50 хувийг сонгоно.Энэ чинь 10 жилд 6 удаа сонгууль хийнээ гэдэг чинь бид ямар сонгууль хийхийн дон туссан улс биш шүү дээ.Бид хийх өөр ажил байна шүү дээ. Тийм учраас энэ хугацааг бүгдийг нь адил байх зарчим, хэдэн жил байх нь 4 юм уу, 5 гэдгийг бид ярьж байгаад тогтоноо.

Түүн дээр тогтож болно.

Цааш нь намын сонгуульд эхний сонгуульд ялсан нам дараагийн сонгуульд ялагдал хүлээж болно шүү дээ. Тэгэхээр энэ төр чинь тогтворгүй болчино шүү дээ, засаг чинь. Тийм учраас үүнийгээ бас бодох хэрэгтэй байна. Тэгээд бусад тодорхой асуудлын талаар бүлэг, зүйл бүр дээр ярьж болно. Гол нь бидэнд чиглэл баримтлал хэрэгтэй байна.

Баярлалаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Бичээч

Б.ЭНХТУЯА

ЦЭНДСҮРЭН

У.Аварзэд / 390-р тойргийн депутат/ -Үндсэн хуулийн төсөлд Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал өөрөө тарна гэж заасан байгаа.Түүнчлэн Улсын Их Хурлын шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавина гэж заасан.Гэтэл Ерөнхийлөгчийг Их Хурлаас огцруулна гэжээ.Иймхэн хавчигдмал эрхтэй Ерөнхийлөгчийн хэрэг байна уу? Ерөнхийлөгчөө Ерөнхийлөгч шиг болгосноор юм гэсэн бодол байна.Эрх иймхэн байхад Ерөнхийлөгч яаж ажиллаж, юу хийх билээ.Дуугүй суух нь аргагүй болох юмаа.

Засгийн газартай ажиллах явдал ч их бүрхэг байгаа.Ийм зовлонг хүмүүс мэдэхгүй байгаа учраас Очирбат олигтой юм хийхгүй таг болдоо, цаадуулдаа уусчихлаа гэж ярьдаг болсон юм.Урьдын Очирбатыг бараг танигдахааргүй Очирбат болгоод хоч цол өгөөд байгаа явдал чухамдаа манай энэ хуулийн зохицуулалт тохироогүйгээс болж байна гэж би боддог.Ийм ч Очирбат байгаагүй гэдгийг хүмүүс бас мэднэ.

Гадаадын тогтолцоонд хэт шүтэхгүйгээр жинхэнэ монгол хийцийн эрх үүрэгтэй Ерөнхийлөгчтэй болцооё гэсэн ийм бодол байна.Ер нь Бага Хуралд ямар нэгэн даруулга зайлшгүй шаардаг даад байгаа юм.Ганцаараа Их Хурал болчих юм бол улам ч том юмаар дарж байхгүй бол болохгүй болох нь тодорхой болсон.

Засаглах эрхийг олон тийш нь үрэн таран хийж цацаж лигд хуваарилсан мэт харагдах боловч төр засгийн бүх эрхийг Их Бага Хурал тас атгасан хэвээрээ, Улс төрийн товчооны хойт дүр болж тодорсоор байна.

Ерөнхийлөгчийгөө ямар боловч бүх ард түмнээсээ шууд сонгож, Их Бага Хуралд Хэтэрхий баригдаад байхгүйгээр зохих хэмжээний эрх мэдэлтэй, тодорхой ажилтай болгосноор байна.Огцрох болдог юм бол огцруулж л орхино.Ийм муу ёрын юм болохгүй биз ээ.Францын маяг руу нэлээд ойртсон ийм Ерөнхийлөгчтэй байхад манайд Чойбалсан, Цэдэнбал маягийн хүмүүс дахиад төрөх ч үгүй, төрүүлэх ч үгүй, энэнээс айх хэрэггүй

юм гэж бодож байна.

Төрийн толгой олон салаа болсноор түмний үйлс будилчихаад байгааг бид харах хэрэгтэй байна. Парламент эавал хоёр танхимтай байх нь зүйтэй болж ирж байна.

Засгийн газартаа ч зохих хэмжээний эрх, тухайлбал яахдаа банкиг нь хариуцуулж байж, эдийн засгийн бүх шаардлагыг тэднээр үүрүүлмээр байна. Цаашид Засгийн газрыг одоогийн засгийн газрын ^{хэлдэн} бүтэл муутай гишүүдийг байнга байх юм шигээр бодож бид хэтэрхий хаширлаж болмооргүй байна.

Төслийн 16 дугаар зүйлд гадаад иргэний үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай харилцан адил байх зарчим баримтална гэж заасан байгаа юм. Үүний чинь цаана бол цагаачдыг нь хүлээж авна, тэдэнд газрыг нь түрээсээр, олон жилээр эзэмшүүлнэ гэж хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй ийм нуугдмал зам нээгдчихээд байгаа юм биш үү. Одоо манай хүн амын 30 хувь нь хятадын эрлийз болсон гэсэн ийм мэдээ байгаа.

Өөрийн иргэнд хувьчлаад байгаа дэлгүүр, гуанзууд маань ч хятад иргэдийнх болчихоод байгааг бид харж байгаа шүү дээ. Ер нь өмч хувьчлал, газрын хууль, жижиг, дунд үйлдвэр, худалдааны бодлогуудын арга бол хятадын бодлого хүчтэй байгаа. Ийм учраас гадаад, дотоодын иргэдэд гаэрыг өмчлүүлэхгүй, түрээслүүлэхгүй, зөвхөн төлбөртэйгээр түр ашиглуулах тухай хуульд хатуу зааж үлдээмээр санагдаж байна.

Манай иргэд түрээсээр ч юм уу, өмчилж авсан газраа хятадуудад зохих хэмжээний шовгороор яаж ч өгөхөөс буцахгүй болох нь түрүүчийн юмнуудаас тодорхой харагдаж байгаа. Ер нь байдлаас бодоход Ерөнхийлөгч, парламентын дарга, Ерөнхий сайд нарыг гурван үеийн монгол хүн байхаар тогтоох нь зөв гэж үзэж байна.

Хэрэв цагаачдыг хүлээж авах, тэдэнд газар түрээслэхийг

энэ хуулиар зөвшөөрөх юм бол хамаг ашигтай газар, нутаг маань хятад иргэдийн ногооны талбай, хувийн үйлдвэр, худалдааны талбар болж монгол удам угсаа, цэвэр монгол цус, хүүхдийн хөх толбо дахин цэвэршихгүйгээр бузартаж, яваандаа монгол монгол биш болох ийм аюулд тулгарч болох юм гэсэнд сэтгэл зовж байгаа.

Ер нь гаднаас цэргийн хүчээр довтлох нь ч юу бол, харин удамшлын дайн болж, удам угсаанд сэв сууж болох юм. Ер нь хятадууд болдоггүй гэж ярьдаг. Харин оросуудтай 70 жил нөхөрлөөд, тийм ч их бузарлаагүй шүү. Хааяа нэг ганц нэг, өдрийн од шиг юм байдаг биз ээ.

Одоогийн багийн, аж ахуйн нэгжийг дагаж сумууд байгуулагдсан гэж худлаа юм яриад байна. Тэгэх юм бол цөөхөн сангийн аж ахуй ингэсэн л байх. Ихэнхдээ сум бүрт нэгдэл, сангийн аж ахуй байгуулж сумаа түшиж гарсан шүү дээ. 1950-иад оны сүүлчээр 3-4 сумыг нийлүүлж томруулаад, төр, засгийн алба хөл, толгой нь мэдэгдэхгүй болж хөвж гүйцээд, буцааж хуучин сумуудаа дахин байгуулаад, нэгдлүүдийн бригадыг тогтворжихоор багуудаа татан буулгасан юм шүү дээ.

Гурав дөрвөн аймаг, сумыг хүчээр нийлүүлж, цөөн том аймаг, хошуутай болох юм бол ёстой завхарсан юм болж гүйцэнэ гэж бодож байна. Одоогийн аймаг, сумуудын захиргаа ажлаа зохих ёсоор явуулж чадахгүй болчихоод байхад тэр том аймаг, хошууд их сайн ажиллана гэж ямар хүнд бодогдоод байдаг юм болоо. Зовлон үзэж явсны хувьд бид ийм ойлголттой байгаа. Бид шийдэх эрхгүй, ард түмэн мэдэх ёстой асуудал гэж байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрмөөр байна. Хэрэв зүтгэснээрээ зүтгээд байх юм бол төр, ард түмнээсээ, төр засаг маань ард түмнээсээ холдон хөндийрч олон сум, бригад, хэсгийн төв асар их нутаг бэлчээр эзгүйрч, балгас болон хулширч, хөдөөгийн хүмүүс аймаг, хошууны төв рүү шилжин суурьших урсгал хөдөлгөөн газар авч, ард түмний туйлын хатуу ширүүн эсэргүүцэлтэй тулгарч, гарцаагүй засаж залруулахад хүрнэ.

Одоогийн багийн дарга чухам юм хийх юм болоо? Албан татвар, мал, ноос, сүүг сарын мянгаас доошгүй төгрөгийн цалинтайгаар гуйж айл хэсэхээс өөр олигтой юм хийх болов уу даа гэж бодож байгаа. Дээр үеийн багийн даргын бүтээлч, дайчлагч байсныг мөрөөдөөд байх шиг байна. Тулган захиргаадалтын тэр үе одоо сэргэхгүй шүү дээ. Хэрэв томруулах юм бол аймаг, хошууны төвүүд бараг л бүгдээрээ нутгийнхаа өрөөсөн захад аль нэг хуучин төвд суурьших болно.

Энэ зун Хөвсгөл аймгийн наадамд ирсэн зарим хүмүүс аймгийнхаа сүүлчийн баярыг үзэж байна. Манай аймгийн төв Архангайн төв рүү шилжих юм гэнэ билээ гэж ярьж байсан. Аймаг, сумуудыг томруулахад хөрөнгө мөнгө хэмнэнэ гэж хий зөгнөж, үндэслэгч анхдагч болох гэдэг хүмүүс ч бас байдаг бололтой. Тэгэхдээ асар их хөрөнгө үрэн таран болж, чирэгдэл, хүнд суртал, хэл ам, бэрхшээл их хэмжээгээр нэмэгдэнэ гэдгийг бас ойлгомоор байна.

Бага Хурлын гишүүд хошууны талаар санал өгөхдөө аймаг, сумын мэдлэгтэй, хороо, хоринь мэдэгдэхүүнтэйгээрээ тод ялгарч "Ардын эрх" сонинд бичигдсэн байсан шүү дээ. Төрийн хүмүүсийн сэтгэл хөдлөлт буруу тийшээ хөвөлзөөд байх юм бол улс, ард түмэн ихээхэн хохирох болно.

Дөрөвдүгээрт, депутат нөхөр Адъяасүрэн хуучин нэр, бэлгэдлүүдийг өөрчлөхгүй л бол 70 жилийн муу муухай бүхнийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болж, сүүд болохоор сүрдүүлж байхад, депутат Мижид хуучин зүйлийг шинэчлээгүй бүхэн хуучинсаг үзэлтэн болохгүй, шинэчилсэн хүн бүхэн шинэчлэгч болохгүй гэж цөхрөнгөө барах маягтай ярьж байх юм.

Өөрчилж шинэчилсээр л байгаа, гагцхүү ард түмний хүсэл зоригт тохируулж өөрчлөх ёстой юм. Нөхөд минь учир, ач холбогдол багатай, цаг үе хугацаагийн нь олох олохгүйгээр хэтэрхий намархах, холбоорхох, шинэрхэх, хуучирхах үзэлд автагдаж бид болохгүй байна.

Бага Хурал маань чухам л ийм байдлаас болж түр тархийж, заримдаа хуралдаж чадахтай үгүйтэй болж, цөөнхийн, хажуугийн санал гэгчээр дайрсаар байгаад олонхийн зөв саналыг буруутган нураадаг, уурлах, уйлах, хэрэлдэх, болчимгүй юм ярих, хурлаа хаяж гүйхдээ хүрч байдгийг олон түмэн мэдэж байгаа. Ийм байдлаас болж тус хуульд тусгасан зарим зүйл ч бидэнд бэрхшээл учруулсаар байна. Ер нь Бага Хурлынхны байдал ноцтой, түвэгтэй байдаг ч учраас ном Гончигдорж даргад алдарт гавьяат найруулагч цол хүртээгээ биз ээ. Ийм байдал цаашид үргэлжлэх юм бол алдар гавьяагүй хэдэн хүн болж, ирсэн замаараа буцаж ч мэдэх юм. Нам, холбоод асуудалд заавал хөндлөн тийш нь чангааж, юм бүхнийг хэтэрхий улс төржүүлэх хэрэггүй байна.

Харин Бат-Үүл, Элбэгдорж хоёр нэлээд төлөв даруу болж яваа юм байна. Байнга босон харайж атаклаад байдаг нь багасаж байгаа нь зөв юмаа.

Том нам, холбооны удирдагчид даанч ингэмээр байгаа юм. Элбэгдорж их аятайхан төв төвшин, сайн боловсруулсан үг хэлж бидэндээ сургамж хайрласан явдал нэн таалалтай, шинэ үзэгдэл боллоо. Ингэж байж л бид төр, улсынхаа ноён нурууг тулж түшицлэх учиртай гэж бодож байна. Баярлалаа.

Ж. Уртнасан – Уучлаарай бид цөөнхийн саналыг сонсож байна. Бид дэгээ хүндэтгэх ёстой юм. Манай дэгд зааснаар бол бид цөөнхийг хүндэтгэж саналыг нь сонсоод, тэр томъёоллоороо дахин санал хураалт явуулах ёстой. Одоо би ерөнхий санал шүүмжлэлийг тасалъя гэдэг энэ томъёоллоор дахин санал хураалт явуулахыг хүсч байна. Яагаад вэ гэхээр сая санал хураалтанд оролцсон 393 депутатын 283 нь буюу 72 хувь нь ерөнхий санал шүүмжлэлийг зогсооё гэсэн санал ирүүлээ. 94 хүн татгалзаж, 16 хүн түдгэлзсэн. Бид цөөнхийн зарим хэсгийг сонслоо. Магадгүй цаашаа үргэлжлэх юм бол энэ дэг зөрчигдөж, энэ олон хүн нөгөө бичүүлсэн дарааллынхаа биш, ерөөсөө зогсож байгаагаараа үг хэлэхэд хүрэх нь ээ. Ийм учраас хурал замбараагүй байдалд орно. Одоо

6.

дэгийнхээ дагуу санал хураалт дахин явуулахыг хүсч байна. Суудал суудалдаа сууж санал хураалтанд бэлтгэнэ үү. Санал хураалтын томъёолол нь ерөнхий санал шүүмжлэлийг тасалъя гэсэн түрүүчийн санал хураалтыг дахин санал хураалгаж байна. Дэгээ хүндэтгэмээр байна. Бид дэгээ баталсан шүү дээ депутатууд аа.

/танхимаас/

-Байн

байн санал хураалгаж, баахан хүн үг хэлүүлж ингэж үймүүлж байх хэрэггүй байна шүү дээ. Дэгийнхээ дагуу ерөнхий санал шүүмжлэлээ явуулъя л даа. Түрүүнээс хойш үг хэлсэн бол олон хүн үг хэлэх байлаа шүү дээ.

Ж.Уртнасан -Ерөнхий санал шүүмжлэл явуулъя гэдэг хүмүүс чинь олонхи болж чадахгүй бол бид хурлыг дэгийн дагуу үргэлжлүүлэхээс өөр арга байхгүй шүү дээ депутатуудаа. Үүнийг болгооно уу.

Эрхэм депутатуудаа, суудалдаа сууна уу. Санал хураалтад бэлтгэмээр байна. Дэгээ хүндэтгее.

А.Бааст /332-р тойргийн депутат/

-Хурлын даргаас

хүсэхэд дэг хэлэлцэнэ гээд бид хоёр өдөр барчихсан юм чинь үндсэн асуудлаа хэлэлцэх болохоор яагаад нэг бүтэн өдөр, тал өдөр зарж болдоггүй юм бэ гэсэн нэг ийм санал байна. Үндсэн асуудлаараа яагаад хоёр өдөр хэлж болдоггүй юм бэ? Давхардаж болно үг, тэгэхэд нэг ийм асуудал байна. Нэг хэсэг нь өөрийнхөө үзэл бодлыг хүчлээд, тэр ч битгий хэл үндсэн гол чанар хадгалах, одоо агуулгын чанартай зүйлээр дээрээсээ дэгээ эвдэж байгаад 40 минут видео киногоор тавиад, одоо дахиад телевиз, радиогоор сурталчлаад байгаа. Гэтэл энийг чинь өөр бодолтой хүмүүс бас үзэл бодлоо, хариугаа хэлж болдоггүй юм уу, ард түмнийхээ саналыг.

Ж.Уртнасан -Зүйл, бүлэг тус бүр дээр хэлэлцэхэд бидэнд санал хэлэх өргөн боломж бий шүү дээ депутатуудаа. Одоо дахин

санал хураалт явуулъя. Дэгийн дагуу хоёр дахь санал хураалт явуулъя.

Д. Пүрэвдорж /27 дугаар тойргийн депутат/ -Хурлын даргаа би протоколд юм тэмдэглүүлэх гэсэн юм. Би тийм эрхтэй байх гэж бодож байна. Би үг хэлэхгүй. Хэрэв миний эрхийг хасвал би одоо хурлаас гарлаа. Эсэргүүцэж байгаа улсууд нэрээ хэлмээр байна. Миний горимын санал хэлэх гэж байгааг эсэргүүцэж байгаа депутатаар нэрийг нь хэлүүлмээр байна. Зүгээр ингэж шуугимааргүй байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д. Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.18
Кассет Ш-32
10.15-10.30

Танхимаас:

Үгээ ургэлжлүүлбэ. Санал хураагаад олонхийн санал аваагүй шүү дээ. Дийлэнх олонхи болоогүй.

27 дугаар тойргийн депутат Пүрэвдорж:

Санал хураачихсан гэж би бол бодож байна. Тийм учраас би протоколд юм тэмдэглүүлэж хүсэлтэй байна, Хурлын дарга зөвшөөрөл өгвөл.

3 өдөр ерөнхий санал шүүмжлэл явагдлаа. Ихэнхийг нь ижил давтагдсан ийм санал явлаа. Миний үүнийг протоколд тэмдэглэж байгаа байхаа гэж бодож байна. Өөр саналтай депутатуудыг асуусан ч үгүй, гол тэр 3 өдөр санал хэлсэн хүмүүсүүд ихэнх нь давтагдсан, өөр саналтай депутатууд нэлээн бий. Тэр хүмүүсүүдээр үг хэлүүлсэнгүй гэдгийг протоколд тэмдэглүүлбэ, ингээд бид нар, өөр саналтай хүмүүсүүд зүйл анги дээрээ ярьж.

Ж.Уртнасан: Депутатууд аа, бид дэгээ хүндэтгэвэл яасан юм бэ? олон түмнээ хүндэтгэвэл яасан юм бэ? одоо санал хураалтанд бэлтгэмээр байна. Бид дэгийн дагуу дахин санал хураалт явуулаад үзье. Ямар дүн гарахыг үүгээр шийдвэрлэж болох байх.

332 дугаар тойргийн депутат Бааст:

Энэ Пүрэвдоржийг хүндэтгэж болоод байгаа юм, энд байж байгаа бусад үгээ хэлэх улсуудыг яагаад хүндэтгэж болдоггүй юм бэ? Пүрэвдорж юм л бол микрофоныг шүүрч, булааж аваад хурал удирдаж байдаг болсон байна. Энэ чинь ямар журам, зарчим болж байна вэ? Би үг хэлээгүй, одоо ч хэлж чадаагүй байгаа.

Ж.Уртнасан: Санал хураалтанд бэлтгэмээр байна депутатууд аа,

80 дугаар тойргийн депутат Зарьжиган: Биднийг хүндэтгэхгүй байгаа учраас бид санал хураалтанд оролцохгүй.

Танхимаас:

Олонхи нь үгээ хэлчихээд, тэд нар чинь одоо үг хэлэхгүй татгалзсан улсуудын тоонд орчихоод байгаа шүү дээ.

Одоо яагаад энэ улсуудын үгийг сонсч болдоггүй юм бэ? 1,2,3 гээд... цөөнхийн саналыг олон удаа хүндэтгэж, олон удаа санал хураалгаж байсан. Яагаад өнөөдөр болохоор цөөнхийн саналыг сонсч болохоо байчихдаг юм бэ? Одоо дарааллаараа үгээ хэлээд явж л байна л даа. Дундуур нь хичнээн цаг аваад хаячихлаа шүү дээ.

Ж.Уртнасан: Бид дэгээ л баримаар байна.

Танхимаас:

Дэгээрээ, микрофоныхоо дарааллаар ингээд явж байхад, дундуур нь санал хураана гээд үймүүлчихлээ шүү дээ.

Ж.Уртнасан: Эрхэм депутатууд санал хураалтанд бэлтгэнэ үү? бид дэгээ баримаар байна. Бид нэг л дэгтэй, нэг л зорилготой учраас та бүгдийг суудалдаа сууж санал хураалтанд орохыг урьж байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Саналаа өгөх, эсэх тухай асуудал бол депутатын хувийн хэрэг юм. Тэгэхдээ бусдыг уриалмааргүй байна. Бид л нэг л дэгтэй, нэг л зорилготой гэдгийг дахин сануулж байна. Хэрвээ дэгийн дагуу явах ёстой юм бол бид цөөнхийг хүндэтгэж саналыг нь сонслоо. Одоо цөөнхийг хүндэтгэж санал хураалт явуулъя. Тэгэхдээ ерөнхий санал шүүмжлэлийг тасалъя гэсэн энэ томъёоллоор дахин санал хураалт явуулах гэж байна. Цөөнхийн саналын дагуу.

244 дүгээр тойргийн депутат Лоржхорлоо: Тэгэхээр нэг хэсэг нь бол саналаа хэлчихсэн байна. Нэг хэсэг нь давхардаж ярьж байна гээд дургүйцэж байна. Бид нэг л юм ярьж байгаа учраас нэг л юм ярина шүү дээ. Түүнээс Үндсэн хуулийн тухай л хэлэлцэж байгаа болохоор тэр тухайгаа л ярина. Түүнээс өөр юм ярихгүй шүү дээ, Үндсэн хуулийнхаа тухай л ярина. Зарим нь бол тэгээд байна. Тэр улс яасан юм бэ гэхээр өөрснөө 10-аад босч хэлчихээд, одоо уйдахаараа бусдын эрх чөлөөг хааж байна.

Би ийм л саналтай байна.

Ж.Уртнасан: Уучлаарай, депутатууд аа, бид одоо гол үзэл маань төвлөрч байгаа гэж ойлгож байна. Ингээд үймээд байж яах вэ? бид дэгээ л дагамаар байна. Яах гэж бид дэг баталсан билээ. Санал хураалтанд бэлтгэнэ үү, депутатууд аа.

Танхимаас:

Энэ ёсоор бол, дэг ёсоор бол ерөнхий санал шүүмжлэл явуулж байж, дараа нь явах ёстой шүү дээ.

Ж.Уртнасан: Үндсэн хуулийн зүйл тус бүрээр явахад бидэнд уг хэлэх эрх маань нээлттэй үлдэж байгаа. Тийм учраас би депутатуудын уг хэлэх эрхийг хорьж байна гэж бодохгүй байна. Дэгийн дагуу олонхийн саналыг хүндэтгэж, хурал үргэлжилж байна гэж ойлгож байна. Депутатуудыг суудалдаа сууж, санал хураалтанд оролцохыг урьж байна. Эрхэм депутатууд суудалдаа сууна уу?

Танхимаас:

Энд нэг асуух юм байна. Энэ ерөнхий санал хураалтанд саналаа өгч чадаагүй хүн, тодорхой зүйл ярихдаа, ерөнхий зүйл ярьж болох уу, үгүй юу?

Ж.Уртнасан: Зүйл тус бүрээрээ ярихад нь тэндээ гаргаж ярьчихаж болохгүй юу?

Танхимаас:

Дараа хүний санал давхардахгүйгээр хэлэх уг чинь ингээд бүрмөсөн хаагдчихна шүү дээ. Тийм учраас тийм зөвшөөрөл олдвол болимоор байна. Тэгэхгүй бол уг хэлж болдогсон бол хэлмээр байна.

Танхимаас:

Энэ чинь мөн л болиулчимна. Зарчмын холбогдолтой зүйлүүд гарчихлаа, одоо санал хураалт тасалъя л гэнэ.

Явж байгаад тийм л болно. Энэ чинь дундуур сууж байгаа нэг хэсэг депутат 10 өдөр ямар ч идэвхгүй, хуралд сонсогчийн үүргээр л оролцлоо. Удаа дараалан бид бичиг өгсөн. Бодох хэрэгтэй шүү дээ. Урдуур, хойгуурх нь хэлчихээд, зарим нь 10-20 босоод байгаа юм, яагаад энэ чинь уг хэлэх эрхээ хасагддаг юм бэ? бид нар.

Танхимаас:

Хурлын даргаа, нэг юм асууя. Одоогийн энэ нэрсийн жагсаалтанд байгаа депутатууд дээгүүрхэнх^н уг хэлэх бололцоог олгох уу? Энэ дарааллын дагуу.

Танхимаас:

Сая ерөнхий санал шүүмжлэл хэлэхээр депутатууд нэрээ өгсөн шүү дээ. Тэгээд нэг хэсэг нь уг хэлж чадалгүй хоцорлоо. Тэгэхээр үлдэж байгаа, нэр нь байгаа хүмүүсүүдийг эхний оочерт нь оруулах талаар арга хэмжээ авч өгвөл бид санал хураалтыг зөвшөөрч байна. Тэр дарааллаар нь явъя. Үлдсэн депутатууд эхлээд эхний очерт нэрээ хэлье. Тэгвэл уг хэлээгүй хэсэг нь хоцорч байгаа учир одоо болж байна. Ингээд ерөнхий санал шүүмжлэлийг таслахыг зөвшөөрч болж байна. Хэрвээ ^{Тэр} та талаар сайн анхаарч өгмөөр байна.

Ж. Уртнасан: За сонслоо.

Танхимаас:

Ардын Их Хурлын даргаа, ер нь уг хэлэхийг ингээд албадаж таслах шинжтэй болоод явчихлаа. Тэгэхээр ийм депутатууд уг хэлэх гэснийг бид тасаллаа гэдгийг нэрээр санал хураагаад та сониндоо тавьж өгөө. Ийм депутатуудаар бид уг хэлүүлсэнгүй, тасаллаа гэж. Өөр арга байхгүй. Бидэнд давхардуулахгүй хэлэх санал байна. Гэтэл та нөхдийн таалалд нийцэхгүй байгаа бололтой. Таслах гээд байна. Тэгэхээр үүнийг та нэрээр санал хураагаад, нийт ард түмэнд зарлаж өг, ийм депутатууд уг хэлэх гэснийг Ардын Их Хурлаас зөвшөөрсөнгүй, дарга нараас.

Ж. Уртнасан : Баярлалаа. Их ухаалаг санал байна. Бид дэргийнхээ дагуу санал хураалт явуулъя.

Хэрвээ цөөнх үгээ хэлэх боломж алдвал нэгдүгээр нээлттэй хаалга маань зүйл тус бүр дээр саналаа хэлэх боломж үлдэнэ, хоёрдугаарт, таны саналыг хүндэтгэж бид энд үгээ хэлж чадаагүй депутатуудын нэрийг компьютерт жагсаалтаар авчихъя. За баярлалаа, санал хураалтанд бэлтгэнэ үү.

Депутат/нэр, тойргоо хэлээгүй/

Царгаа, энэ чинь ингэнэ шүү дээ. Хэрвээ зүйл, бүлгээр нь ярих юм бол ерөнхий санал чинь дахиад л задгайраад явчихна шүү дээ. Бид чинь саналаа ярьж байгаа ерөнхий зүйл, бүлэг дээр нь бие биенийхээ санал бодлыг сонсоод, найруулгын тусгал хийх болохоос биш, ерөнхий саналаа ярих юм бол тэгээд задраад явчихна биз дээ. Тэгнэ биз дээ. Хэрвээ би энэ зүйл найруулгад хэлээгүй, ерөнхий саналаа бол одоо босоод хэлэхээр бүр үг, үсэг тайлбартай ярих гээд байна. Тэгэхээр би чинь эхлээд тайлбараа урьдаар ярина гээд байгаа шүү дээ. Нэрээ бүр эрт бичүүлчихсэн шүү дээ, тэгээд бид хүлээгээд суугаад байна. Олон депутат, бид энд сууж байна. Тэгээд энд одоо тухайлбал, энэ харьяаны Адъяасүрэн толгойлсон хэсэг хүмүүсүүд өөрсдийнхөө нэрийг эхэнд нь бичиж өгчихөөд, бид нарын нэрийг дараа нь өгчихөөд, тэгээд бид хүлээгээд суугаад байна. Түүнээс бид байгууллагын нэг хурал хийж байгаа биш. Улс орныхоо өнцөг булан бүрээс бүрдээд ирсэн. Хөдөлмөрчид, төлөөлөгчдийнхөө үгийг хэлэх ийм бодолтой энэ хүмүүсүүд сууж байна. Түүнээс юм болгон дээр биш, дэгээ баримтлах гэж гэж би дэгийн дагуу л явж байна. Ийм л төвшин улсууд тэнд суугаад байна шүү дээ. Түүнээс зарим нь ингэж урьдаж босоод, янз бүрээр үйл ажиллагаа явуулаад байх юм. Энэ ямар учиртай байдаг юм бэ? Үнэхээр бидний ярьж байгаа юм, дийлэнх ингээд сонсоод байхад, давхардаж байгаа юм байна. Мэдээжийн хэрэг, өнцөг булан бүрээс чинь энэ үг давхардан, давхардсаар л орж ирж байгаа шүү дээ. Түүнээс чи түүнийг нь хэл, би үүнийг нь хэлье гэж найруулаагүй. Ийм учраас бид үгээ хэлмээр байна.

Ж.Уртнасан: Эрхэм депутатууд аа, энэ цөөнх болоод үгээ хэлэх гээд байгаа депутатуудад би бас нэг зүйлийг сонордуулмаар байна.

Бид замын эхэн дээр байна. Бид Үндсэн хуулиа дөнгөж хэлэлцэж эхэлж байна. Хэрвээ зарчмын саналаар бид ингэж маргах юм бол энэ жил Үндсэн хуулиа хэлэлцэж барахгүй шүү. Бид цөөнхийг хүндэтгэж саналыг сонсч байна. Олонхийн саналаар шийдвэрлэдэг учраас бид хэн нь олонхи болох нь вэ гэдгийг дахин үзмээр байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү. Хэрвээ бид маргах юм бол их замбараагүй, их ээрчимгүй, ард түмэнд та бид үүргээ гүйцэтгэж чадахгүй хүрнэ. Ийм учраас Хурлын дарга шаардах эрхтэй юм бол би анх удаа нэг шаардаж үзье.

Эрхэм депутатууд суудалдаа сууна уу? Санал хураалтанд бэлтгэнэ үү? гэж би хатуу шаардаж байна.

Танхимаас:

Хурлын даргаа надад горимын ганцхан санал байна. Би яг энэ улсуудтай ижилхэн бас хоёр өдөр үгээ хэлэх гэж хүлээсэн юм. Гэхдээ цаг болоод ганцхан зүйлийг хэлье гэж бодож байна. Бид аль аль талаа бодоод... би горимын саналаа хэлье болж байна уу? Тэгэхээр энд хэлэх гэсэн улсууд маань, нэгэнт өөрсдөө саналаа хэлж чадаагүй болохоор протоколоороо бичээд өгье. Хэлсэн, өгсөн хоёр ижилхэн шүү дээ. Би бас ижилхэн хоёр өдөр л хүлээсэн юм. Тэгэхээр цагаа гамнаад, саналаа аваад, тэгээд саналаа бид нар бүгдээрээ протоколоор бичсэнийгээ өгчихье. Өөр арга байхгүй юм байна.

Ж.Уртнасан: Бичсэн саналыг нэрийн жагсаалтаар авъя гэсэн шүү дээ. Үг хэлж чадаагүй депутатуудыг...

Танхимаас:

Харин наана чинь нэрээ өгсөн 100г-гаад шахуу улсууд чинь та одоо магадлаад үзэх юм бол бүгд үгээ хэлсэн улсууд байгаа. Түүнийг үл тооцье. Ганцхүү бид үгээ хэлж чадаагүй бид гоморхох юм алга, харин түүнийгээ бичээд өгчихье. Ингэж аль алиныгаа хүндэтгэх л арга байна.

Ж.Уртнасан: Бичгээр өгөх санал нээлттэй байгаа шүү дээ. Бид энд аваад нэгтгэж байгаа.

50 дугаар тойргийн депутат А.Далхжав:

Хурлын даргаа, түрүүн Зарыкхан дарга санал гаргалаа. Нэрсийг нь гаргаж зарлая гэж.Зарлаад зогсохгүй энэ үгээ хэлэхээр үлдэж байгаа улсуудын үгийг, бүрэн эхээр нь хэвлэлд нийтэл гэдгээ бас давхар зарлах нь зүйтэй байна.

Ж.Уртнасан: Далхжав депутат аа, бид өчигдөр зарласан шүү дээ.Энд авсан бүх үгийг бид хэвлэлд нэртэй нь тавина гэж.

Бүрэн эхээр нь шүү, бүрэн эхээр нь.

Ж.Уртнасан: Мэдээж хэрэг.


Депутатууд аа саналхураалтанд бэлтгэнэ үү.Санал хураалт явуулъя.Томъёоллыг энэ маргаан дунд мартсан байж болох юм. Ерөнхий санал шүүмжлэлийг тасалъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.Бэлтгээрэй.

Анх удаагийн санал хураалтаас 9 хүн энэ санал хураалтанд орсонгүй.Нийтдээ 384 депутат буюу нийт санал өгсөн депутатуудын 90 хувь нь энэ санал хураалтанд оролцлоо.

289 хүн буюу 75 хувь нь дийлэнх нь энэ санал тасалъя гэсэн ийм санал ирүүллээ.84 депутат буюу 22 хүн татгалзаж байна.11 депутат буюу 3 хувь нь түдгэлзэж байна.Ингээд олонхийн саналаар ерөнхий санал шүүмжлэлийг тасалж байна.Үг хэлж чадаагүй депутатуудыг бид компьютерт нэрээ бичиж авахыг хүсч байна.Үг хэлэх хүсэлтэй байсан депутатууд ирц гэдэг товчийг дарж бидэнд нэрээ бичүүлнэ үү.Анхаараарай,үг хэлж чадаагүй депутатуудын нэрийн бүртгэлийг авч байна. Ирц гэсэн товч дарахыг хүсч байна.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.18.
Кассет № III-33
10.30-10.24

Ж.Уртнасан -Депутатууд аа! нэр гарч байгаа.Та бүхэнд дахин тайван дэгээ уужуухан харахыг хүсэж байна. Одоо бид жинхэнэ халуун яриандаа орох болов уу гэж бодож байна. Депутатууд уг хэлж, санал гаргасны дараа, өөрөөр хэлбэл санал,шүүмжлэл тасалсны дараа бүлэг,зүйл тус бүрээр хэлэлцэж, саналын зөрүүтэй эарчмын асуудлууд дээр санал хураалт явуулна. Үүн дээр та бид жинхэнэ Их цааз гэх үү,Үндсэн хууль гэх үү,туг сүлд нь хэвээр үлдэх үү,өөрчлөх үү гэдэг дээр бид саналын зөрүүтэй зүйл дээр санал хураана шүү дээ. Үүндээ бэлтгэж байхыг та бүхнээс хүсэж байна. Бүлэг зүйл тус бүрээр хавтасны эхнээсээ эхлээд эцсээ хүртэл ярихад бэлтгэнэ үү гэж бодож байна.

Баярлалаа, 269 хүний уг хэлье гэсэн нэр ирж байна. Уг хэлье гэсэн хүсэлтэй хүмүүс ийм олон байгаа юм байна. Зарим нь анддуурч дарах шиг боллоо. Тухайлбал манай дарга Батбаяр би уг хэлээгүй гээд дарчихсан чимь энэ жагсаалтанд орчихсон байна. Мөн би ч уг хэлээгүй дарчихсан энэ жагсаалтанд мөн орчихсон байна. Ингээд 269 хүн уг хэлье гэж, зүйл, бүлэг тус бүрээр уг хэлэхэд та бидний хэлэх уг гарах байх. Бид нэр авлаа.

Уучлаарай, депутатууд аа! санал шүүмжлэл таслая гээд уг хэлээгүй хүмүүс гэхээр уг хэлээгүй гээд өөрсдөө дарчихсан юм шиг байна. Томьёолол буруу болсон байна гэдгийг би мэдэрч байна. Тэхээр та бүхэнд сануулъя. Зарыкхан депутат хэлсэн, бид ерөнхий хэлэлцүүлэг дээр уг хэлэхгээд хэлж чадаагүй хүмүүс гээд цөөнх болсон цөөхөн хүн байгаа. Өнөөдрийн бүртгэлээд тэдний 116 хүнээс оая 5 хүн уг хэлчихсэн байсан. Миний бодлоор зарим нь угээ бичгээр хэлээд, 100 хүрэхгүй хүний нэр гарах ёстой болов уу гэж бодсон. 269 хүний нэр бичигдсэнд бид гайхаж байна. Санал хураах хэрэггүй. Одоо дэгийнхээ дагуу Их цаазынхаа нэр, зүйл,бүлэг тус бүр дээр бид өргөн санал шүүмжлэлээ явуулах нь зүйтэй гэж бодож байна.

Тийм учраас санал шүүмжлэлээ, Монгол улсын Их цааз гэдэг нэр дээр ярья. Хуулийн нэр дээр саналаа хэлье.

Танхимаас: -Шууд саналаа хураая л даа, зөндөө ярьсан шүү дээ. Эхлээд саналаа хураагаад дараа нь цөөнхийн санал болвол ярья л даа.

Танхимаас: -Даргаа 7-р микрофонд эвшөөрөл өгнө уу. Горимын санал байна.

Танхимаас: -Даргаа горимын санал хурааж өгөхгүй юм уу, шууд саналаа хураана гэж зөндөө ярьсан шүү дээ. Та өөрөө жаахан анхааралтай бай л даа. Шууд санал хураая гэж хэдэн хоног бүгдээрээ ярилаа шүү дээ.

Танхимаас: -Шууд саналаа хураачихаад цөөнхийн саналыг сонсоё.

И.Уртнасан -Уучлаарай, депутатууд аа! та бид үүн дээр тулгамдаж өөрийнхээ бодол саналыг илэрхийлэх гээд байх шиг байна. Тэхээр бид Ерөнхий хэлэлцүүлгээ ярьчихлаа. Депутатууд аа, сонссоно уу? Тэхээр үүн дээр бид хуулийн нэр гээд хавтаснаасаа эхлээ. Үүн дээр Монгол улсын Их цааз гээд биччихсэн байна.

Танхимаас: -Маргаантай байгаа 6,7 асуудлаа эхлээд тусгаж авмаар байна.

Ж.Уртнасан -Бид хуулийнхаа нэрнээс эхлээ.

Танхимаас? -Хурлын даргаа, үүнийгээ яаж хэлэлцэхээ эхлээд тогтмоор байна шүү дээ. Ингээд зогсчих юм уу, түрүүнийх шиг нэрс өгөх юм уу, тэхээр дахиад голоор сууж байгаа хүмүүс юу ч хэлж чадахгүй байна шүү. Яаж хэлэлцэхээ эхлээд тогтмоор байна. Нэрсийн жагсаалтаар юм уу, микрофоны очроор юм уу, ойлгомжгүй юм болоод байна шүү.

3.

Танхимаас: -Санал хэлүүлмээргүй байна.

Танхимаас: -Тэртэй тэргүй санал хураагаад Үндсэн хууль гээд гарна шүү дээ. Одоо бүгд л Үндсэн хууль, Их цааз гээд ярих нь юу байгаа юм бэ? Саналаа хураагаад хэрэв Үндсэн хууль болвол болоод явна бие.

Ж.Уртнасан -6 микрофон зэрэг ярихаар тун эвгүй байна. 1-р микрофон саналаа хэлээдхээ ч.

72-р тойргийн депутат А.Болат -Надад ийм юм ойлгогдож байна.Уг хэлэх гэж байгаа нөхдүүдийн санал нь мэдээж хоёр хуваагдах гэж байгаа. Улсын нэрийн тухайд гэхэд нэг хэсэг нь БНМАУ, нөгөө хэсэг нь Монгол улс гэсэн хоёр томъёолол дээр тогтчихоод байгаа л даа. Тиймээс хокуланг нь зэрэг яриулах шаардлагагүй юм шиг санагдаж байна. Магадгүй өөрийнх нь санал олонх болж байгаа хүмүүс одоо тайлбар хэлэх шаардлагагүй. Тийм учраас уг хэлэх хүнийхээ тоог цөөлж ялангуяа цөөнхийг нь хүндэтгэх зарчмыг гол болгох үүднээс давын өмнө бид улсын нэр, хуулийн нэр гэсэн хоёр зүйл дээр шууд саналаа хураагаад, цөөнх болсон хүмүүсээ сонсмоор байна.Олонх болсон хүмүүс тайлбар хэлэх шаардлагагүй.

Танхимаас: -Даргаа буруу ярьж байна шүү.Төрийн байгуулалтаас эхлээ.

Ж.Уртнасан -Хоёрдугаар микрофон хэлээрэй, дараа нь гурав бэлтгэж байгаарай.

Танхимаас -6 дээр дуусана шүү дээ. Их Хулын даргаа, яагаад долоог хасаад байгаа юм бэ?

Ж.Уртнасан -Хүмүүсээ тайван бай, микрофоны дарааллаар сонсьё. тайван байна уу?

184-р тойргийн депутат С.Билигсайхан -Бид хоёр өдөр сонслоо. Надад ийм сэтгэгдэл төрж байна. Юу гэхээр зурагдсан пянз шиг, өөрөөр хэлбэл ганцхан зүйл дээр бүгд тогтоод яриад

яриад байна шүү дээ. БНМАУ байх ёстой, Үндсэн хууль байх ёстой, Сүлд, далбаа хэвээр байх ёстой гээд ярьчихаад эцсийн эцэст санал хураалгана гэдэг нь юу гэсэн үг вэ? Тэхээр би өөр саналтай байна. Гол нь Их цааз гэсэн олон янзын хувилбар гарч байгаа. Тэр бүр дээр санал хураалгачихъя. Хэрэв цөөнх болсон хүмүүсээрээ тайлбар тавиулаад, зарчмаараа явъя. 3 удаа хураалгадаг тэр зарчмаараа явъя.

25-р тойргийн депутат Л. Энэбиш - Депутатууд нэг зүйл дээр анхаарах хэрэгтэй байна. Ийм байдлаар явбал бид хуулиа анхааралтай батлаж чадахгүй. Бид өнөөдөр шууд бужигнаад санал авна гэж байна. Энэ хуулинд байгаа зүйлүүдээ, жишээ нь газар өмчлүүлвэл ийм сөрөг үр дагавартай, өмчлүүлэхгүй бол ийм сөрөг үр дагавартай, үүнийг сайн ойлгохгүйгээр шууд санал хураалтанд орох гэж байна шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ нөхөд минь! Хүмүүсүүд сонсцгооно уу, бужигнаад байхад болохгүй байна шүү дээ. Бид учир байдлыг ойлгож байж санал хураалтанд орохгүй бол болохгүй шүү дээ, энэ хамгийн гол зүйл юм. Гэхдээ улсын нэр, хуулийн төсөл хоёр дээр болно, цөөнхийн хоёр, гурван санал гарч байна, хуулийн нэр дээр, түүгээр нь санал хураая, бусад зүйл дээр нь эхлээд зарчмаа тохирохгүй бол болохгүй шүү дээ. Хэрэв ингэж явбал болохгүй шүү дээ, үүнийг сайн анхаарах хэрэгтэй байна.

Л. Дожоодорж 31-р тойргийн депутат - Одоо номоороо эхлээ. Бид хоёрхон зүйл дээр ярих гэж байна шүү дээ. Хуулийн нэр, улсын нэр хоёр дээрээ ярья. Би үүн дээр товчхон саналаа хэлье гэж бодож байна.

М. Уртнасан - Зарчмын саналаа л хэлье. Өөрийнхээ саналаа дараа болоё.

Л. Дожоодорж - Хүмүүс эхлээд санал хураая гэж яриад байна. Тэгж болно. Дараа нь цөөнхийн саналыг маш нухацтай сонсох хэрэгтэй байна. Хоёрхон хувилбар гараад байна шүү дээ. БНМАУ, Монгол улс гэсэн хоёр л зүйл байгаа. Мөн 3 дээр

Их цааз, Үндсэн хууль, Их засаг гэсэн гурав байна. Энэ гурав дээрээ саналаа хураацаад дараа нь ярилцъя. Хэрэв ингэхгүй бол бүтэн өдөр юм болох гээд байна шүү дээ. Зөв гэж намайг дэмжиж байна. Одоо саналаа хураая.

Б-р микрофон -Тэхээр одоо шууд санал хурааж болмооргүй байна. Үг хэлээгүй цөөн хүмүүсүүд энэ зүйлүүддээ учраа шалтгаанаа, саналаа хэлээд, дараа нь саналаа хураагаад явмаар байна. Улсын нэр байна, төрийн сүлд байна, мөн бэлэг тэмдгийн чухал зүйлүүд байна шүү дээ.

Д.Божоодорж -Төрийнхээ сүлдийг дараа болно.

Д.Баасанжав 393-р тойргийн депутат -Эрхэм нөхөд өө! бид гэрийнхээ ханыг нь босгож, бүсийг нь татахгүйгээр тооно болгож гээд болохгүй байна. Тэхээр тооньхоо тухай ярихад ханьхаа тухай сайн ярихгүй бол яаж болдог юм бэ? Тийм учраас нэг зүйлийг би та нарт сонордуулъя. Өнөөдөр БНМАУ улс юм уу, Монгол улс юм уу гэдгийгээ ярихын тулд та нар ард гэдэг үгээс айгаад байна гэж хэлж байна. Би айлгадаг зүйлийг чинь энд хэлье. МАХН-ын Төв Хорооны дарга До.Лувсаншаравын бичсэн лам нарын асуудал гэсэн номон дотор үүнийг 28 онд бичсэн ном, үүнд лам нарыг нийтээр нь бутцохиж устгах явдал нь өнөөдрийн тулгарсан асуудал боллоо гэж хэлээд, дараа нь одоо ингэж устгахад ард анги нь 49,8 хувь байна, ноёд, лам нар нь 50 гаруй хувь байгаа 100-гийн хагас нь, ингэж хэлж энэ ард гэдэг үг чинь орж ирсэн шүү дээ. Тэхээр эхлээд Монгол улсаасаа эхлээд, Монгол улсынхаа Их засагаасаа эхлээд дарааллаад явах санал байна. Олон зүйлүүд байсан.

Танхимаас -Даргаа, горимын санал байна, зөвшөөрөл өгнө ү
Ж.Уртнасан -7-р микрофон.

Танхимаас: -Даргаа, одоо горимын санал гээд цаг идээд яах юм бэ? Хэлдэг зүйлүүдээ хэлээд явъя л даа. Тэгэхгүйгээр хурлын дундуур хэд, хэдэн юм орж ирж, хамаг цаг авсан шүү дээ. Хурлын дарга, дэгийнхээ дагуу явж байхад нь дундуур нь таслаж байгаад замбараагүй байдалд оруулчихсан шүү дээ. Хурал ийм зам-

бараагүй байж яаж явах юм бэ. Хэлдэг үгийг нь хэлүүлээд цааш явъя л даа. Түрүүнээс хойш хэлсэн бол хичнээн хүн уг хэлэх бололцоо байлаа шүү дээ. Тиймээс одоо саналаа хэлэх гэсэн хүмүүс саналаа хэлээд явмаар байна.

Ж.Уртнасан -8-р микрофон саналаа хэлнэ үү.

-Миний бодол нь төсөл маань нэлээд шүүрхий төсөл байна. Үүнийг би олон талаар сайн төсөл болсон гэж хэлж чадахгүй. Хоёр бүтэн өдөр уг хэлсэн хүмүүс маань тэдний олонх 80 хувь нь санал зөрөөтэй байж байна. Тиймээс миний санал нь ямар байна вэ гэвэл нэгэнт шүүрхий учраас олон зүйл дээр их цаг зарна.Зарим зүйл,бүлгийг бүрэн эвдэнэ.Зарим зүйлүүд нь их заваагдана. Үүн дээр урьдчилсан боловсруулалт хиймээр санагдаад байна. Тэхээр шууд зүйл анги дээрээ хэлэлцэх юм уу, эсвэл ерөнхий санал шүүмжлэлийн хоёр өдрийн үйл ажиллагааг дүгнэж, цэгнэж, ЗАРИМ I боловсруулалт хийгээд явах юм уу гэсэн асуудал дээр санал хураалт явуулах нь зүйтэй байна.

Ж.Уртнасан -За баярлалаа, уучлаарай, депутатууд аа! Хэд,хэдэн бүлгээс бидэнд санал ирж байна.Бүлгүүд зөвлөлдөө гэж байна. Тэхээр бүлгүүдийн зөвлөлтөөнд зориулж завсарлага хүртэл 10 минутын хугацаа өгч байна. Завсарлага 20 минут, Энэ үед бүлгийн ахлагч нар хурлын удирдлагуудтай уулзахыг урьж байна.

Танхимаас -Ардчилсан эвсэл депутатын бүлэг "А" зааланд орно шүү.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн *Ц.Баярмаа*

Ц.БАЯРМАА

БИЧЭЭЧ С.Туул

Ж.Уртнасан:—Эрхэм депутатууд аа.Бид хоёр өдөр ерөнхий санал солилцох журмаар ярилаа.Энэ ерөнхий ярилцлагын маань үр дүн ямар болж байгааг та бүгд депутатууд бүгд өөрсдөө шүүн тунгааж байгаа байх гэж найдаж байна.Бид цаг багатай гэдгээ нэг бодмоор байна.Ерөнхий хэлэлцүүлгийн энэ зарчмын дагуу бид зарчмын саналуудыг ажлын хэсэгт бичгээр авсан энэ санал 130 гарч байна.Түүнийг бид хэвлэлд нийтлэх болно.Шүүн тунгаана. Зүйл тус бүрээр хэлэлцэхэд депутатууд саналаа хэлэх байх гэж бодож байна.Сая депутатын бүлгийн ахлагч нар бид нар уулэлаа. Бүлгүүд саналаа нэгтгэж олон хүнийг төлөөлж ганц нэгээрээ, бүлгээ төлөөлж уг хэлнэ гэдгийг их нааштай,цаг хэмнэсэн алхам гэж тооцож байна.Зарим маргаантай асуудлуудыг үндэслэлийг сайн олохын тулд энэ хуулийг оруулж байгаа субъект, хуулийг боловсруулсан комисс, Ерөнхийлөгч маань бас зарим тайлбар тавьж байх нь зүйтэй болж байна.Хуулийг оруулсан субъект буюу Улсын Бага Хурлын дарга Гончигдорж зарим үндэслэлүүдийг хэлж байвал бидэнд их ашигтай юм болов уу гэж ингэж бодож байна.

Жишээ нь та бид нар оцоо ингээд хэлэлцээд эхэлье гэхэд энэн цээр бичсэн эхлээд бид энэ Үндсэн хуулийнхаа нэрийг гээд ингээд эхлэхэд л Монгол улсын гэх үү, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гэх үү гээд маргаж эхлэх юм шиг байна.Ингэж учир зүггүй маргавал бид энэ жилцээ хуралдаан дуусахгүй.Улсын нэр, хуулийн дотор тусгай зүйл болсон учраас улсын нэрээ тэндээ л очиж ярья.Их цааэ гэж нэрлэсэн тухайд хуулийн ерөнхий нэр байх уу оноосон нэр байх уу, яагаад Их цааз гэж нэрлэсэн юмбэ гэдэг талаар товч тайлбарыг депутатын хувьд, Бага Хурлын даргын хувьд Гончигдорж дарга бид депутатуудцаа тайлбарлаж өгье.Тэгэхгүй бол дахиад бид эцэс төгсгөлгүй маргаан болно гэсэн ийм чиглэл орж байна.Ийм учраас бид зарчмын санал хураах зүйлүүд цээр зарим тайлбар авч байх нь зүйтэй болов уу гэсэн ийм боцолтой байгаа юм.

Бид хэрэв саналаа хэлээд байвал та бүхэн шүүн тунгааж байгаа байх.Ард түмнээр нэг жил хэлэлцүүлсэн энэ хэлэлцүүлгийг

2.

бид үргэлжлүүлж байна.Ерөөсөө л нэг жил үргэлжилсэн тэр ярилцлага цаашаа үргэлжилж байна.Ийм хэлбэрээр явах км бол бид энэ жилдээ энэ Их цаазынхаа тухай асуудлыг хэлэлцэж, ард түмний хүсэн хүлээсэн шийдвэр гаргаж чадахгүй маргалдахад хүрэх нь ээ.Ийм учраас дэгээ хатуу баримаар байна.Ер нь оруулж ирсэн субъектын саналыг сонсож баймаар байна.За одоо микрофон дээр Бага Хурлын дарга Гончигдорж гуайг урьж байна. Их цааз, энэ хавтаснаасаа эхлээд явъя.

Ардын Их Хурлын 296 дугаар тойргийн депутат Д.Батжаргал:
-Санал авамгүй байна дарга аа.Энэ чинь одоо хэвлэлээр зөндөө яалаа, асуулгаар хариуллаа.Өөрөө эхний удаа тайлбарласан.Одоо өөрөө өөрсдийнхөө тархиар саналаа хэлээд, хурлын дарга удирдаад Их цааз гэх үү, засаглал гэдэг км уу, ингээд гурван санал, хичнээн санал гаргасан км тэрэн дээр нь шүүгээд хэлмээр байна.Түүнээс одоо тайлбарлана, ахиад энэ тайлбар дээр бид нэмж одоо ингээд л бөөн маргаан болоод байна. Тийм учраас хурлын дарга нэрээ дэвшүүлээд Их цааз гэх үү, БНМАУ-ын Цааз гэх км уу, ийм нэг асуулт гаргамаар байна.

Хоёрдугаарт, ер нь хоёрхон нэрэн дээр биш, өөр нэр ч гаргамаар бодогдож байна.Өөр шинээр хичнээн нэр байдаг км тэрнээс дэвшүүлээд саналыг нь аваад явмаар байна.Түүх яриулаад санал аваад байвал ахиад наадахь дээр чинь маргаан, асуудал гаргаад ахиад ер нь хэмжээлшгүй км болно.

Ардын Их Хурлын 157 дугаар тойргийн депутат Д.Одончимэд:
-Бид хурлыг шуурхайлах, хэлэлцэж байгаа асууцлаар хурдан үр дүнд хүрэх талаар хоёр санал хэлье.Бид олон хоног асууцлаа ярилцлаа, семинар, зөвлөгөөн ч авлаа.Видео киногоор ч үзлээ. Одоо Гончигдорж даргыг дахин дахин гаргаж ингэж энэ хүнийг ч зовоогоод, өөрснөө ч тодорхой үр дүнд хүрэхгүй ингээд байх шаардлагагүй гэж би бодож байна.Ерөөсөө одоо яах вэ гэхлээр улсын нэрийн асуудал, хуулийн нэрийн асуудал хоёр хамгийн эхэнд тавигдаж байна гэж би ойлгож байна.Тэгэхээр хуулийн нэрэн дээр бол Их цааз, Их засаг, Үндсэн хууль гэсэн гурван

3.

хувилбар намаржин, зунжин яригдсан. Энэ дээр нэмээд өөр нэр өгөх хувилбартай хүн байвал тэр хүн гарч тэрийгээ хамгаалаг. Тэгэхгүй юм бол энэ гурав дээрээ саналаа хураагаад, дараагаар нь цөөнх нь саналаа хамгаалаад ингээд л цаашаагаа яваад байна.

Жишээлэх юм бол хуулийн нэр дээр саналтай хүн тэрийгээ хэлчихье. Би бол Их цааз, Их засаг, Үндсэн хууль алин нь ч сайхан гэж бодож байна. Эүгээр хэрвээ энэ хуулийг бусад бүх хуулийн эх хууль юм уу, бүх хууль энэнээс эх үүсвэртэй гэж үзэх юм бол би Эх хууль гэсэн нэрийг оруулъя гэж бодож байна. Энэнийгээ дараа нь хамгаална гэж бодож байна. Улсын нэрийн тухайд бол гурван вариант байгаа. Нэгэнт боссоных энэнийг хэлчихье яах вэ. Тэгвэл депутатууд намайг уучлаарай. Ер нь депутатуудад харин би нэг зүйл хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Бид жаахан маргахдаа соёлтой баймаар байгаа шүү. Нэг нэгэн уруугаа дайрдаг, довтолдог, боль, суу, энээ тэрээ гэж хашгирдаг чинь бол танхимын соёл гэж Зоригоо эртээд шүүмжилсэн тэр үнэн юм шүү. Түрүүний миний хэлдэг журмаар хурлаа цааш нь явуулах саналтай байна.

Ардын Их Хурлын 296 дугаар тойргийн депутат Д. Батжаргал :
-Хуулийнхаа нэрнээс эхэлбэ: Би саналаа хэлбэ. Тэгэхлээр Их цааз гэж нэртэй байна, Их засаглал гэж байна, тэгээд Үндсэн хууль гэж байна. Тэгэхлээр миний өөрийн хувийн сэтгэгдэл Их дархлал гэж нэрлэвэл яасан юм бэ. Энэ дээр юү гэхлээр зэрэг их гүн боцвол эүгээр байна. БНМАУ-ын Их дархлал гэж. Энэ юү гэж байна гэхлээр зэрэг бид нар Богд хан уулаа дархалж байна гэж хэлсэн. Дархалсан. Дархлал гэдэг нэр дотор бол таалагддаг ч үг байна. Их засаглалын агуулга ч байж байна. Тэгэхлээр зэрэг дархлал гэдэг үг дээр хэл эүйн хувьд харж үзэж нэр дэвшүүлвэл, асуудал дэвшүүлвэл яасан юм бэ гэсэн санал байна.

Ш. Уртнасан: -Депутат нөхөд өө. Хуулийнхаа нэрийг бид нар ер нь санал хураалтыг бид их олон хувилбар дээр хийвэл санал их олон тасарч бутраад бүгд дийлэнх олонхийн санал болж чадахгүй гэдгийг ойлгож байгаа байх. Тэгэхээр хууль маань ерөнхий нэртэй байх юм уу, оноосон нэртэй байх юм уу гэдэг дээр

4.

санал хураалт явуулчихаад оноосон нэртэй байна гэвэл бид Их цааз, Үндсэн хууль энэ хоёр үндсэн санал дээр хураагаад хажуугийн санал Их засаг, Эх хууль гэсэн саналууд орж ирж байгаа. Ингээд саналаа хураагаад явбал ясан юм бэ?

Ардын Их Хурлын 26 дугаар тойргийн депутат Д.Сүрэнхорлоо: -Би уг хэлж чадаагүй байгаа юм. Тэгэхээр одоо би ийм саналтай байна. Одоо яаж нэрлэх юм. Монгол гэх юм уу, Бүгд Найрамдах гэдгээрээ явах юм уу гэдгийг чинь одоо би Бага Хурлын даргын тайлбарыг сонсох нь зүйтэй гэж бодож байна. Энэ чинь бид чинь тэр нарийн учир холбогдлыг мэдэхгүй улсууд, тэгээд өөр өөрийнхөөрөө зүтгээд ерөөсөө санал сонсохгүй ээ гээд ингээд яваад байх юу байх вэ, бас бид тэр учир холбогдлыг нь олох нь зүйтэй байх гэж бодож байна. Дэгэн дээр чинь хэлэлцэнэ гээд байж л байгаа.

Ардын Их Хурлын 263 дугаар тойргийн депутат З.Алъяа: -Энэ сүлдний талаар гадаа корицорт их сайхан янэ янэйн сүлд тавьчихлаа. Би горимын санал хэлье. Одоо энэ засаг захиргааныхаа нэгжийн талаар ямархуу янэтай зураглал байгаа юм, энэнийг бас нэг үзмээр байна.

Д.Дожоодорж: -Одоо ерөөсөө саналаа хураая. Нэрэн дээр ийм санал гарч байгаа шүү дээ. Их цааз гэх үү, Их засаг гэх үү, Үндсэн хууль гэх үү гэдэг ийм гурав дээрээ саналаа хураая.

Ж.Уртнасан: -Депутатууд аа. Ийм юм байгаа шүү дээ. Оноосон нэр, ерөнхий нэр гээд бид нэг хоёр юм гаргаад ирсэн шүү дээ. Ерөнхий нэрийн хувьд Үндсэн хууль гэдэг бол ерөнхий нэр. Бид хуулиа оноосон нэртэй болгохын тулд Их засаг, Их цааз, Эх хууль гэсэн ийм гурван хувилбар дээр ярих болчихоод байна шүү дээ. Тэгэхлээр эхлээд бид нар ерөнхий нэртэй байх уу, оноосон нэртэй байх уу гэдгээр санал хураалт явуулж шийдэх хэрэгтэй болж байна. Дахиад хэлье. Ерөнхий нэртэй байх уу, оноосон нэртэй байх уу гэж. Тэгэхлээр хуулинцаа бид оноосон нэр өгье гэсэн ийм томъёоллоор санал хураалт явууллаа шүү.

Танхимаас:

-Их Хурлын дарга аа! Үндсэн хууль гэдэг чинь яагаад оноосон нэр биш болж байгаа юм бэ? Хууль гэдэг чинь ерөнхий нэр шүү дээ. Тэрэн дотор Үндсэн гэсэн оноож тодорхойлсон нэр өгч байна. Тэрийгээ яагаад ерөнхий гэж нэрлэж байгаа юм бэ? Хууль гэдэг чинь ерөнхий нэр биш юм уу? Ингэж завхруулж, нугалж болохгүй шүү дээ.

Ж.Уртнасан:-Оноосон нэр, ерөнхий нэрийн тайлбар сонсохын тулд эхлээд бид уг нь Бага Хурлын даргаас товчхон томъёолол авчих байсан л даа. Бүгдээрээ хэрэггүй гэж тооцсон учраас бид энүүгээрээ л болъё. Үндсэн хууль оноосон нэртэй байна гэдгээр санал хураалт явуулъя.

Танхимаас:

-Улсууд сайн ойлгохгүй байх шиг байх юм. Оноосон нэр юу хоёрыг, хуулийн ангилал, Үндсэн хууль гэдэг чинь Үндсэн хууль, бусад хууль гэсэн хуулийн хоёр ангиллыг ярьж байгаа болохоос биш хуулийн оноосон нэр биш ээ гэдгийг ойлгоогүй байх шиг байна. Тайлбар өгвөл зүйтэй болов уу гэж бодож байна.

Ж.Уртнасан:-Дүнгээ сонсгочихъё. Ингэж байна шүү дээ. Бид саналаа зарим нь сайн ойлгосонгүй гэж байх шиг байна. Хууль оноосон нэртэй байна гэсэн томъёоллоор бид хэлсэн шүү дээ. Үндсэн хууль гэдэг бол ерөнхий нэр ээ. Бид хуулиа оноосон нэртэй болгохын тулд Их цааз, Их засаг, Эх хууль гэсэн оноосон нэр өгөх гэж оролдож байгаа юм аа гэдгийг манай Бага Хурлын дарга тайлбар тавьсан, түрүүн ярьсан, та бүхэн санаж байгаа байх. Тэгэхээр бид сая оноосон нэртэй байна гэсэн санал хураалт явууллаа. Оноосон нэртэй байна гэж 45 хувь нь буюу 157 хүн зөвшөөрч байна. Үндсэн хуулинд оноосон нэргүй, ерөнхий нэртэй байна гэсэн саналыг 51 хувь нь буюу 181 хүн хэллээ. Одоо хоёрдугаар микрофон дээр депутат Ламжав.

Ардын Их Хурлын ЭЗ дүгээр тойргийн депутат Д.Ламжав:- Эрхэм хүндэт дарга аа, би танд нэг зүйлийг сануулмаар байна.

6.

Депутатуудад. Дэгийн 12-ын "д"-д зарчмын асуудлаар гуравны хоёр нь баталж байж тооцно гэсэн км байгаа. Тэгэхээр ийм олон асуудал гарна. Тэгэхээр энэ дэгийнхээ энэ заалтыг анхааралдаа аваасай. Жишээлбэл оадынх зарчмын асуудал мөн үү биш үү, энэ бол мөн, тэгэхээр одоо тэр 51 гэдэг бол энэнийг яаж шийдсэнээс хамаарах км л лая.

Энэ дээр санал хурааж шийдэх км уу, дарга шийдэх км уу энэ бол ийм л асуудал байгаа. Энэнийг одоо шийдэхгүй бол болохгүй гэж бодож байна.

Ардын Их Хурлын ЗЭЗ дугаар тойргийн депутат Д.Баасанжав: Бид дэгэн дотор Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг хэзээ ч уг хэлэхийг нь нээлттэй орхисон биш бил үү. Хэлүүлэхгүй гэж хааж байгаац больсон шүү дээ. Ер нь ингэж Бага Хурлын дарга аа, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийг өргөн барьсан тэр газрынхаа, тэр субъектынхээ толгойг нь тусгаарлачихаад ингээд хуралдаад байдаг ийм парламент байдаг км уу, үгүй км уу? Ийм Их Хурал байж болох уу?

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



П.ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

Уртнасан: -Тангад гуай саналаа дуусгасан уу.

297-р тойргийн депутат Тангад: -Дэгийн дагуу энэ асуудал дээр заавал олонхийн саналаар шийдэхгүй болбол гуравны 2 хувиар шийдэхгүй болбол эүгээр ердийн олонхиор шийдэж ердөө болохгүй шүү. Заавал оноосон нэр байх эсэх талаар бид саналаа солилцох хэрэгтэй. Тэгж байж энэ асуудлыг шийдэхгүй бол болохгүй шүү. Би бол хувьдаа оноосон нэр байхгүй болбол ерөөсөө болохгүй гэж үзэж байна. Үндсэн хууль гэдэг маань хуучин социалист бүгд найрамдах монгол ард улсын үндсэн хууль. Одоо тэр чинь байхгүй. Одоо чинь шинэ монгол байна. Бид шинэ нөхцөлд амьдарч байна. Тийм учраас бид төрийнхөө шинэ хуулийг юу гэж нэрлэх вэ гэсэн оноосон нэр заавал байх хэрэгтэй. Ямар нэр нь тохиромжтой байна, тэрнийгээ ярилцъя.

Уртнасан:

-Депутатууд аа, та бүхэнд энэ компьютерийн бичлэгээс бас хааяа тайлбарлаж хэлж баймаар байна. Ард түмний санал хүсэлтийг хэрхэн авсан тухай олон депутатууд ярьсан. Тэгэхээр төслийн нэрийн талаар 562 санал ирсэн юм байна. 562 саналаас Их цааз гэж нэрлэх хүн, нэрлэх санал 68, Үндсэн хууль гэж нэрлэх санал 294, Их засаг гэж нэрлэх хүн, санал 75, Их хууль гэж нэрлэх санал 23, бусад санал 104 ирсэн байна. Үүнийг бид та бүхэнд компьютерийн санамжид бичсэн энэ зүйлүүдийг хааяа танилцуулж байх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

132-р тойргийн депутат Чулуунбаатар: -Тэгэхээр би нэг зүйлийг депутатуудын анхааралд сонордуулмаар байх юм. Сая депутат Тангад гуайн хэлсэн үгийн эхний хэсэгтэй холбоотой юм. Тэр бол их зүйтэй ярилаа. Өөрөөр хэлбэл улсын бага хурал олон хууль баталсан. Тэр хуулиудыг маань өнөөдөр шүүмжилж байгаа ч бий, гайгүй ч гэж үзэж байгаа бий, ингэж хууль батлахдаа улсын бага хурал хуулийг өргөн барьсан субъектын уг санаа бодлыг дээд зэргээр хэдийгээр нэр нь тааруухан байгаа ч гэлээ гэсэн энэ бага хурал хууль тогтоохдоо тэр хуулиа өргөн

барьсан субъектынхаа үгийг байнга сонсдог, байнга асуудаг гэтэл өнөөдөр манай их хурал дээр арай нэг тийм өөр амьсгал бий болоод байна. Шаардлагатай үед энэ хуулийг өргөн барьж байгаагийнхаа хувьд бусад ажилажиллагаагийн нь дараагаар нь дүгнэнэ. Энэ хуулийг өргөн барьж байгаагийн нь хувьд улсын бага хурлаас үгий нь сонсож баймаар байна. Тэр үгийг заавал дарга нь ч албагүй, шаардлагатай хүнээ дарга томиллоод ч хэлүүлж болно. Ингэхгүй болбол хэт өрөөсгөл болно гэдгийг Их хурлын депутатууд ч Их хурлын дарга ч анхааралдаа аваач ээ , хэрэгцээтэй мандаа асуугаад, аль эсвэл санаачилгаараа тайлбар өгч болно шүү дээ.

/танхимвас/

-Санал хураалт дахин явуулах уу, томъёоллыг ойлгосон уу?

22-р тойргийн депутат Дашням: -Сая санал хураалтаа саналд оролцсон хүмүүсийн ихэнх нь юунд санал өгч байгаагаа сайн ойлгосонгүй юу гэж би бодлоо. Яагаад гэвэл оноосон нэр гэж юуг хэлж байгаа км бэ гэж , миний энэ хажууд олон хүн асууж байна л даа, энэнээс үзэхэд бол , тэгэхээр оноосон нэр байх уу, үгүй юу гэдгээр санал хураасан шиг санаж байна. Тэгэхээр юунд өгөхөө мэдэхгүй байвал санал өгөхөд хэцүү байх л даа. Зарим хүн хэлж байна, Үндсэн хууль гэдэг бол оноосон нэр гэж, миний бодлоор үндсэн хууль бол оноосон нэрийн үүрэг гүйцэтгэгчээс нь тайлбар нэр, тэгэхээр оноосон нэрийн учир гэдэг бол бид нар нэг бодъё л доо, бид нар бүгдээрээ хүн гэдэг ерөнхий нэртэй, хэрэв надад Дашням км уу, хажуудах хүнд маань Дорж, Самбуу гэж оноосон нэр өгөхгүй бол энэ бол ямар байдалд хүргэх вэ гэдэг бол тайлбарлалт алга, тэгэхээр оноосон нэрэнд хүрнэ гэдэг бол ерөөсөө нийгмийн сэтгэлгээний тодорхой түвшний асуудал км. Өнөөдөр бид нар км-ыг ерөнхий хэлдэггүй, км-ыг нэрээр нь нэрлэдэг жинхэнэ нэрээр нь нэрлэдэг тийм хэмжээнд манай нийгмийн оюуны сэтгэлгээ хүрч ирсэн гэж би бодож байгаа км. Энэ маань ч бид нар өнөөдөр өөрчлөлт хийнэ үү үгүй юу гэдэг өөрчлөлт хэн ямар маягаар оролцох гэж байгаа гэдэг тэр нэр нүүрий маань ч харуулж байгаа тийм утга агуулгатай гэж бодож байна. Ийм учраас оноосон нэр гэдэг утгаа ойлгоод манай депутатууд дахиад санал хураагажсай гэж би бодож байна.

Тэгэхд би энийг өөрөөр тунгааж бодоод, өөрөөр харьцах байх энэ асуудалд.

Уртнасан:

-Уучлаарай депутатууд аа, саяын депутатуудын саналыг хүндэтгэж байна. Үнэхээр бид энэ хуулийг оруулж хэлэлцүүлж байгаа субъект, бага хурлынхаа санал, шолыг хэрхэн яагаад энэ ард түмнийг 294 хүн Үндсэн хууль гэж нэрлэе гэсээр атал оноосон нэр өгч Их цааз гэж нэрлэж оруулж ирэв ээ гэдгийг бид тайлбарыг нь сонсож байвал та бидний танин мэдэхүүд их ач холбогдолтой юм. Ийм учраас Бага хурлын дарга Гончигдоржийг индэр дээр урьж байна. Оноосон нэрийн тайлбарыг та нэг хэлж өгөхгүй юу. Энэ хуулийн нэрийн талаар, ер нь хэн нэр оноосон нэрийн талаар товч тайлбар хэлж өгмөөр байна. Бага хурлаас хэн нь ч байж болно л доо, та томилчих л доо, Зардыхан даргыг юм уу Чимид даргыг гээд эс вэл Маамыг ч гээд хэлж болно.

-Гончигдорж : - Эрхэм депутатууд аа, тэгэхээр та бүхэнд бага хурлаа төлөөлөөд нэг хүн хариулж болох хэр хэмжээндээ бол би та бүхэнд хариулсан. Яг асуудал, асуудалд дээр орох дээр зэрэг гол нь энд ямар үндэслэлийн үүднээс ингэсэн юм бэ гэдэг талаар хэлээд, тэр үндэслэл үнэхээр таны сэтгэлд нийцэж байна уу үгүй юу гэдэгээс үндэслээд та бүхэн саналаа өгөх ийм л утга учраар бид ойлгож байгаа, тийм учраас эмзэглэхгүйгээр, яг ингээд нарийвчлаад ирэх лээр зэрэг бүгдэд нь тийм нарийн зүйлийг хэлж чадахгүй шүү дээ. Мэдээж хэрэг, тийм учраас энэ дээр болбол гол нь энийг яаж байхад ажлын хэсгийг ахлаж байсан юмуу, эсвэл энэ дээр жичлэн судалгаа хийлгэж байсан. ийм улсуудаар дамжуулан хариулт өгүүлье гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд түүнээс гадна бага хурал дээр бид олонхиор л асуудлыг шийдээд ирсэн шүү дээ. Тийм учраас тэнд цөөнх болж байсан бага хурлын гишүүд ч бий, олонхи нь болж байсан ч бий, тийм учраас бага хурал гэдгийг төлөөлөх утгаараа л ярина. Тэрнээс тэр гарч ирж байгаа депутатын үзэл бодол биш, зүгээр бага хурлынхаа гишүүдийг нэр цохож хэлэхдээ ч тэднийг тийм агуулгаараа ярина гэдэгт бүрнээ найдаж байгаа. Тийм учраас бид нарын констучи гэсэн зүйл үгийг улсын хамгийн дээд хуулинд байгаад бусад хууль зөвхөн үүнд нь нийцэж явдаг бөгөөд энэ хууль тогтоог

дохдоо бас бусад хуулийгаа бодоход өндөр саналаар тогтоогддог, харьцангуй тогтвортой байдаг, энэ хуулийг дэлхий нийтээр Конституци гэж нэрлэж байгаа, энэ нэрийг бид тухайлбал Основное закон гэдгээр дамжаад Монгол руу оруулах уу, Конституци гэдгээр шууд Монголд оноосон нэр олж бид нэрлэж чадах ийм хэлний баялаг байна уу, үгүй юу гэдэг дээрээ л ярьж байгаа юм гэж ойлгож байгаа. Тэгээд бага хурал дээр бол энийг Их цааз гэсэн оноосон нэрэн дээрээ олонхийн санал гараад ингэсэн юм. Тийм учраас их цааз гэж нэрийг яагаад сонгож авав гэдэг талаар нь бага хурлын нарийн бичгийн дарга Чимидээр та бүхэнд товчхон үндэслэлээ хэлүүлж гэж бодож байна.

Б.Чимид: -Олонхийн саналаар Их цааз гэж орсон. Бага хурлаас Би эртүүд 3 зүйл хэлсэн. Давтах шаардлага байж магадгүй. Бид бол нэгдүгээрт Үндсэн хууль, бүх хуулийн дотор бол Үндсэн хууль гэдэг үг бол харьцангуй тусгай нэр гэж би ойлгосон. Дэлхийн улсуудын Үндсэн хууль гэж ерөнхий нэрэн дотор болбол бас хуулиудыг ангилдаг Монголын ангилалтын дотор аль алинд нь тусгай нэр байх ёстой гэж үзсэн. Дэлхий дахинд ойлгогддог ганцхан нь бол Үндсэн хууль гэсэн ерөнхий үг байгаа. Конституци гээд эхэлчихсэн явж байна. Монгол дотор хуулийг 2 хувааж байгаа юм. Үндсэн буюу гол юмаа заасан хууль, тусгай тодорхой харьцааг зохцуулдаг хууль, үндсэн ба ердийн хууль гэж, Үндсэн хууль энэ тохиолдолд бол ердийн олон хуультайгаа адилхан бас нэг ерөнхий нэртэй явж байгаа. Ердийн хууль бол дотроо, иргэний, эрүүгийн, гэр бүлийн, малын, гаэрын гээд байж болно. Тэр шиг, энэ үндсэн хууль бол бас өөртөө нэртэй байдаг, ёс бий л дээ. Жишээлбэл бид Америк гэж хэлжээ гээд дургүйцэхгүй байх гэж бодож байна. Америкийн Үндсэн хууль бол Конвент нэртэй батлагдсан. За Английн үндсэн хуулийн акт бол янз бүрийн нэртэй байгаа. Зарим нь Билли гэж байгаа, зарим нь акт гэж байгаа, ингээд нийлүүлээд хэлж байгаа юм. Бид бол дэлхийн нийтийн хэлээр ярья гэвэл конституци гэж Монголын Конституц гэж хэлж болж байгаа юм. Монголын үндсэн хууль гэж хэлж болж байгаа юм. Монголын үндсэн хуульдаа нэр өгье гэвэл олон янзын саналыг хүлээж авч болж байгаа юм. Яагаад Их засаг гэсэн бэ гэхээр би энэ

үгийг хэзээ ч гүйцэт хэлж чадаж байгаагүй. Нэг бол хэвлэлийн хуудсанд хавчигдаж, нэг бол минутаг хавчигдаж байсан учраас 2 зүйл дээр тогтож хэлье гэж бодож байгаа юм. Одоо байдал нь Их засаг, Их цааз, энэ 2 дээр эргэлзэж байх шиг байна. Их засаг гэдгийг бид ер нь түүхийн үүднээс хүндэтгэж үзнэ. Гэхдээ Их засаг гэдэг хууль байсан уу, үгүй юу гэдгийг одоо биеэр нотолсон зүйлгүй. Түүнээс гадна Их засаг гэж яг тийм нэртэй хууль байгаагүй, гэдгийг манай судлаачид эрт эдүгээ гаргасан.

Монголын хууль цаазын эртний түүхийг хүннүгээс авахуулаад 27, 30-аад он хүртэл судалсан, I-хан бүтээл байдаг юм. Ганц том бүтээл. Энэ бол Монгол улсын эрх зүйн хууль цаазын түүхийн ^{сэдэв} дэвтэр гэж ийм дэвтэр байгаа. Ингээд болбол I-рт заншил, 2-рт хааны зарлиг, 3-рт хааны сургаалийг нийлүүлээд заншлын болоод тогтоосон эрх гэж хуулийн онол ярьдгаар "Их засагийн хууль" гэж нэрлэвэй гэсэн байгаа

Энэ засаг гэдэг үг нь хаягдаад ийн гэдэг нь хаягдаад, төсөөлж хэлбэл едоогийн хэлдгээр төрийн хууль, хааны зарлиг, ерөнхийлөгчийн зарлиг гэдэг шиг ийм харьяалахын тийн ялгагч нь алдагдсан ийм байгаа. Энийг нотолж байгаа хэдэн бүтээл бий. Тэгэхээр Өвөрмонголын судлаач Сайшаал нэлээн Чингэсийн товчоо мэт 2 боть дэлгэрэнгүй ном бичсэн. Тэрэн дотроо энэ хуулийн нэр бол Их засгийн бичиг гэдэг нэртэй байсан гэж байгаа. Би шинэ үсэг дээр хөрвүүлээд хэдэн хувь цохилчихсан байж байгаа. Сайшаал Их засаг хуулийг олон хуулийн хэлэнд Великий ясаа, би англиар мэдэхгүй юм ясаа гэдэг маань англи дээрээ бас байгаа, 1938 онд англич их засгийн хуулийн 64 зүйлийг сийрүүлэн бичсэн байгаа. Тэрийг бид улс төрийн академийн зарим англи хэл мэддэг, хууль бас судалдаг, ийм хүмүүсээс судлахад ясаа гэдэг үг нь хэвээр байгаа, би нүдээрээ лавлаж үзсэн. Ясаа гэдэг үг болбол тэр үеийн уйгар турк гаралтай үг, энэ цааз гэдэг үгтэй нийцнэ гэсэн байгаа юм. Цааз гэдэг үгийг одоо орж ирж байна. Монголын хууль бол эртний, Монголчуудын өөрийн тогтоосон Их засгийн дараагийн хуулиуд бол голдуу цааз нэртэй байсан. Түүн дотор монголын 2 их том хууль их цааз нэртэй байгаа юм. 1640 онд баруун зүүн монголын ноёд энэ 2 монголын хямралыг багасгах, гадаадтай, гадаадын зарим улс гүрний хамтран тэмцэх зорилгоор

янз бүрийн асуудлыг одоогийн зарим хүний хэлж байгаагаар дан эрүүгийн асуудал биш, төрийн асуудлаас гэр бүлийн асуудал хүртэл ийм олон асуудлын нэгтгээд их цааз гэдэг хууль баталсан, их цааз гэдэг хуулийг гадаадад хэвлэсэн нь энэ байгаа юм. 1880 онд хэвлэгдсэн байгаа юм. /Сангпербургт/ энэ тэрнээс хойш олон хувилбар хэвлэгдсний I нь бол энэ байна. Энэ одоо Москва 1981 он. Тэгэхээр манай их цааз гэдгийг бол гадаадад хэрэглэж байгаад бид одоо хэрэглэхгүй болчихож: Энэ нь бол бол хуулийн түүх судлагчид бид гаргаж тавиагүй нь буруу гэж ой өөрсөн дээрээ бурууг авч болохоор байгаа юм. Хууль гэдэг уг яагаад гараад ирсэн гэхлээр монголын феодалууд, феодал, ноёд ^{ТҮНМЭЛ} ГЭХ мэт энэд болбол лам нар, том лам нар Рэнбуучи цолтой лам нар хүртэл энэ дотор байгаа, Хасаг ойрадын том феодалууд нийлээд, ноёдууд нийлээд энэ хуулийг баталсан. Дараа нь 2 дахь хууль нь болбол 1907-1928 он хүртэл бүгд 20-иод хууль батлахдаа 3 хошууны Их цааз гэж баталсан юм. Энэ үед болбол Монгол 2 хуультай явж байжээ. Гаднаас хүлээлгэсэн хуулиуд, монгол ноёд дотроо өөрөө өөрийгөө бас тусгаар тогтносон байдлаа хамгаалахын төлөө явуулж байсан хуулиуд тэгэхлээр монгол ноёдын тэр үеийн эрх баригчид нэг үгээр хэлбэл тэр үеийн чуулгануудын халхын 4 чуулган гэж байсан, баталж байсан хуулиуд бол цааз нэртэй. 3 хошууны их цааз гэж хууль байгаа, миний цүнхэнд, хоцорчихлоо. Тэгэхээр тэрний зэрэгцээгээр бол 1734 оноос хойш 1791 оноос хойш Халх ойрадын хууль наана чинь байна уу, үгүй юу, их засаг, тэр нь бол хууль зүйлийн бичиг гэж байсан юм. Монголчууд өөрийнхөө тогтоох дээр зэрэг цааз гэж нэрдээд байдаг, Манжийн хаанаас нэрлэх дээрээ зэрэг хууль зүйл гэж гарч ирээд байдаг. Энэ хуулийг өвөрмонголд манай улсын номын санд 64 дэвтэр бичмэл хууль байдаг л даа. Бид бас зах зухаас нь үзэж л байсан юм. Энийг саяхан Өвөрмонголд хэвлэхдээ энэ гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг. Тэгэхээр Манжаас дагуулж байсан хуулиуд нь хууль зүйлийн бичиг нэртэй, Монголын өөрснөө тогтоож оролдож байсан, нэгэнт бид хараат орон байсан гэдгээ санаж ярьж байна. хуулиуд нь цааз буюу их цааз нэртэй байсан. Тийм учраас бид хуулийнхаа хуучин уламжлалыг лавтай уламжлалыг бичээд хүмүүсээс гаргасан саналын нэг хэсгийг нь баримтлаад ингэж гарчиг-

лаад тэгээд Үндсэн хуулийнхаа төсөл дээр нэг янэ, бага хурлынх нэг янэ байхгүйн тулд бага хурлын гишүүдийн олонхийн саналаар анх хэлэлцүүлсэн төслөө оруулаад, энэ нэрэн дээр нь яриулах нь зүйтэй гэж үзсэн юм. Ингээд тулгачихъя гэж бодвол санаа тийм томъёогоор оруулаагүй. Энийг хэрэгжүүлэх дээр болох юм гэж. 3 хошууны их цааз бол Великий воложений гэсэн ийм нэрээрээ байгаа, Насанбалжир гуай энэ халх журмын 2 хэсгийг хэвгүүлсэн, янэ бүрийн эх байгаа юм. 2 эхтэй, хоёу-ланд нь болбол 3 хошууны их цааз гэж бичсэн байгаа. Тэрнийг манай зөвлөхүүд, бас лавлаж хэлж болох юм. Ийм утгаар Их цааз гээд байгаа юм. Ер нь 1924 онд Үндсэн хууль гарах хүртэл Монголчууд өөрийнхөө үндсэн хуулийг цааз гэж нэрлэхээр төлөвлөж байсан. 1920 онд ардын засгийн ирээдүйн засаг төрийн асуудлаар тодорх йлсон бичгүүд дээр бол Монгол улс улсын их хурлыг хуралдуулж, үндсэн цааз дүрмийг тогтооно гэсэн ийм үг байгаа. 1922 оноос эхлээд цааз, хуулийг эмхэтгэх хэлтэс гэж Засгийн газар байгуулсан, тэгээд Үндсэн цаазыг тогтоотол наана нь бага сага зүйлийг шийдэж байя гэсэн олон тогтоол бий. Би архиваа заримы нь энд авчруулж олшруулж тавьсан. Ийм учиртай. Цааз гэдэг үгнээс айхгүй байхын үндэс нь тэр ээ. Энэ үед бол тэр одоогийн ойлгоод байгаа мухруйлах ялыг бол одоо үхүүлэх, алах, мухруйлах гэдэг 3 үгээр хэрэглэж байсан. Ийм л юм. Энэнээс жаахан сэжиглээд, муу ёр мор гээд байх шиг байна. Бид бол хуучин түүхээсээ сэжиглэх болбол нэг их хэрэггүй болов уу гэж миний хувьд бодож байгаа. Тэрийг гуйвуулсан тайлбар их гарлаа. Их засгийн хууль дээр бол би юу хэлэх гээд байгаа вэ гэвэл 2 шалтгаанаар энийг авахад жаахан хувьдаа татгалзаж байгаа юм. I-р их засгийн хууль гэсэн тийм нэртэй хууль одоогоор олддоггүй байгаа юм. Их засаг хууль гэж. Засгийн хууль, засгийн бичиг, Ясаа гэсэн ийм нэртэй явж байгаа. Энэ одоогоор олддох бид их сурсан. Тайванд байж магадгүй гэсэн таамаглал бий. Энийг нэвтрүүлэх хэрэггүй байх. Яагаад гэвэл бид эрж байгаа учраас. Эрвэл их түүхийн сурвалж, эрж байгаа учраас шүү, Америк энэ тэрээс сурвал тэр том том номын сангуудад байдаг, ном авч байна. Персийн номын санд I хувь нь байсан гэж бичсэн байгаа юм. Тэгэхдээ хүний хэлж бичүүлсэн хувь гэж. Тэр нь бас олддохгүй болчихоод байгаа юм. Бид бас дундад азийн Бүгд найрамдах улсуу-

даас сурж үзэж л байсан, олодохгүй байна, тийм учраас энийг дэлгэрүүлж тавиад хэрэггүй. Хоёрдугаар шалтгаан юу гэхлээр эерэг хэрвээ Их засаг хууль гэж яг тэрүүгээрээ нууц товчоонд буюу энэ номонд бичигдсэнээр Богд самбар дээр бичигдсэн хууль Өвөрмонголын номонд бол хуулиас бичгөн дээр бичсэн гээд зурагтай, хөрөгтэй гардуулж байгаагий нь хүртэл зурсан энэ хувилбараараа олдвол ямар байх вэ гэдгий нь тунгааж байж, урьдчилан зээлдэхгүй байх юм сан гэж, 2 -р санал бол хэрвээ тийм бичиг байсан болбол тэр түүхийн том бичгийг өнөөдрийн нэрээр зээлдэхгүй юмсан. Их засаг гэдэг энэ хууль түүхэнд 2 нэрээр орж ирвэл 1000 жилийн дараа аль нь вэ гэсэн маргаан гарахад давхардахгүй байх юм сан гэсэн ийм нэг үгээр хэлбэл жаахан мухар муйхаг гэж болох, нэг үгээр хэлбэл, миний бодож байгаагаар жаахан алс харъя гэж хэлж болохоор ийм юм бодчихоод тэрэндээ итгэчихээд байгаа юм. Хэлний нөхөд бол нууц товчоонд засаг гэсэн хууль гэсэн үг байхгүй, цааэ гэсэнүг байхгүй гэсэн гол сөрөг сэдэв гаргаж ярьж байгаа юм байна. Хуулийн нэр томъёог хэлнийхээс гадна хуульчид судалдаг, хэлний улс, тэр хуулиа хэр зэрэг судалж байна вэ гэдгий сайн мэдэхгүй байна. Ийм байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

 Ш. БУРМАА

1991.XI.18.

Кассет № 36

II.59-12.15.

273 дугаар тойргийн депутат Н.Жанцан: –"Цааз" гэдэг үгний тухай Чимид гуай тайлбар өглөө.Тэгэхээр "цааз" гэдэг үг бол ер нь түүхэн тодорхой үед хууль гэсэн утгатай байсан нь үнэн.Гэхдээ энэ бол амьдралын явцад бас "цааз" гэдэг үг бол утгаа гэсэн ийм үг байгаа юм.Эхлээд хууль гэсэн утгатай байгаад сүүлд нь хязгаарлах, хориглох гэсэн утгатай болоод хамгийн сүүлд, сүүлийн 70-аад жилд цааз гэдэг үг бол цаазлах буюу алах ял гэсэн ийм утгатай болсон үг юм байгаа.

Тэгэхээр олон улсын жишгээс аваад үзэх юм бол хууль гэсэн үгэнд бол энэ хязгаарлах, зөвшөөрөх, хамгаалах гэсэн ийм утга бол ямагт сууж байдаг.Гэтэл цааз гэдэг үгэнд магадгүй хориглох, зөвшөөрөх гэсэн утга нь суучихаад хамгаалах гэсэн утга нь нэлээн үгүйсгэсэн байгаа юмуу гэсэн ийм хандлага байгаа юм.Ийм учраас ерөөсөө нэгэнт амьдралын явцад утгаа гэсэн үгийг бид хууль гаргаж буцааж аваачиж сэргээх нь зүйд хэрхэн нийцэх бол гэсэн асуудал хуульч хүний хувьд надад бодогддог юм.Тийм учраас хууль гэдэг үг нь байж байх ёстой юм.Үндсэн хууль гэдэг томъёоллын тухайд аваад үзэх юм бол энэ нэг талаасаа бол энийг оноосон нэр гэж үзэх талтай.Жишээлбэл, Их хууль гэдэгтэй Үндсэн хууль бол яг ижил утгатай.Хууль хуулийн үндэс болсон хууль.Их хууль гэдэг бол хуулиудын эх болсон хууль. Энэ утгаараа бол үндсэн гэдэг тодотголтой хууль гэдэг үг бол явж болох юм гэж би ингэж боддог юм.Ийм учраас Улсын Бага Хурал дээр цөөнх болсон хүний хувьд энд би саналаа хэлж байна.Хууль гэдэг үгийг хууль гаргаж заавал халах шаардлагагүй юм.Үндсэн хууль гээд явахад энийг нэг талаасаа энийг тодотгол буюу оноосон үг гэж ойлгож байна.Зөвхөн амьдралын явцад алга болчихсон ийм утгатай "цааз" гэдэг үгийг хууль гаргаж албадан сэргээх бол шаардлагагүй юм гэж би боддог хүн.

143 дугаар тойргийн депутат Г.Зуунай: –Би цөөнх болж үгээ хэлбэ гэж бодож байна.Би хоёр, гурван минут илүү хэлж магадгүй, даргын нэлээн дургүй хүрчих шиг боллоо.

Улсын Бага Хурал дээр би дандаа цөөнх болж байсан, Их цааз гэж нэрлэхгүй гэж. Тийм учраас би энийгээ тайлбарлая гэж бодож байна.

Нэгдүгээрт, санал хураахад Үндсэн хууль гэж санал хурааж болохгүй гэж би бодож байна. Яагаад гэвэл, бид Үндсэн хууль гэж нэрлэсэн ч, нэрлээгүй ч энэ бол үндсэн хууль. Дэлхийн ихэнх улсын нэр дээр конституция гэдэг нэрээр тогтсон. Яаж нэрлэлээ ч гэсэн Үндсэн хууль гэдэг рүү дэлхий нийтийн хэвшил рүү орно. Энэ ерөнхий нэр гэдэг дээр би тогтож байгаа. Тийм учраас энэ дээр бол, бид оноосон нэр өгөх гэж оролдоод болохгүй бол Үндсэн хууль нэрээрээ үлдэх ёстой. Тийм учраас Үндсэн хууль гэдэг нэрээр түрүүлж санал хураахгүй байгаа ч гэсэн нэгдүгээр миний зарчмын санал хэлэх гэж байна.

Хоёрдугаарт, чи яагаад Их цааз гэж нэрлэхгүй ёсгүй юм бэ гэж. Чимид гуай сая нэлээн тайлбарлалаа. Яагаад гэвэл, Их цааз гэдэг бол хууль цааз гэдэг хоршоо үг байгаа. Хууль цаазгүй ч болоосой, хуучин нутагтаа очих юмсан гэсэн ардын дуу хүртэл бий. Тэгэхээр сүүлдээ шилжсэн утгаараа хууль гэдэг үг байгаа ч болов, толгой авна гэдэг утгаараа орсон, шилжсэн утгаараа ийм хоёр утгатай үг ээ. Тийм учраас монголын ард түмэн нэгэнт сүүлчийн утга нь амьдралд нь их ойр, амь амьдрал сүйтгэдэг энэ утга нь ойр байгаа учраас тэр луу аваачиж нэрлэх гэж зүтгүүлэх нь буруу байгаа.

Нөгөөтэйгүүр "ясаа" гэж хууль бий гэж Чимид гуай тайлбарлалаа. Тэрнийг бид олдох хэрээрээ хайсан, еөдтэй юм олдохгүй байгаа. Энэ бол хуучин үсгээр бичсэн "ёсоо, жасаа" гэсэн нэг үг хувираад яваад байдаг юм шиг байна лээ. Тэгэхээр юу гэж нэрлэх ёстой вэ гэхээр бид энийг, миний санал бол нэлээн олон депутат ийм саналтай байх шиг байгаа юм. Их засаг гэж нэрлэх ёстой гэж бодож байгаа юм. Яагаад Их засаг гэж нэрлэх ёстой вэ гэдгийгээ хоёр, гурван үндэслэл хэлбэ гэж бодож байна.

Нэгдүгээрт, Үндсэн хууль буюу конституц гэдэг үг бол АНУ-ын хууль гарсан 1776 оноос хойш хэрэглэж ирсэн 200-гаадхан жилийн түүхтэй ерөнхий үг. Тэгвэл Монгол улс бол Их засагтай,

Их хуультай, төрт ёстой улс байсан.Одоогоос 700-800 жилийн өмнө Үндсэн хуультай байсан, тэр нь Их засаг хууль байсан. Өнөөдөр энэ хууль их биеэрээ олодохгүй байгаа нь үнэн боловч ийм хуультай байсан гэсэн бичиг баримт их бий.Энэ талаар эрдэмтэд, тухайлбал, нөхөр Чоймаа сонинд хоёр удаа бичсэн. Энүүнийг уншихыг хүсэхгүй байна.

Хоёрдугаарт, яагаад Засаг хууль гэж нэрлэх ёстой юм бэ гэвэл, өнөөдрийн бидний тогтоох гэж байгаа Үндсэн хууль маань засаг, төрийн бүтцийг бид тогтоож өгөх гэж байгаа. Төрийн тогтолцоо ямар байх юм бэ? Хүний эрх ямар байх юм бэ? Ерөнхийлөгч нь ямар эрхтэй байх юм, Засгийн газар нь ямар эрхтэй байх юм.Энэ засгийн бүтцийн тухай хэлж байгаа учраас Засаг хууль гэж нэрлэх үндэслэлтэй юм.Ийм учраас дахиад хэлэхэд, эцсийн санал бол Үндсэн хууль гэж санал хураалгалгүй Их засаг, Их цааз, бас депутатуудын гаргасан санал дээр санал хураагаад олонхоор нь шийдэх.Ингээд энэ бүгд дэмжигддэггүй юм бол Үндсэн хууль гэдэг нэр бол хүссэн, хүсээгүй үлдэнэ гэсэн ийм л зарчмын санал хэлэх гэсэн юм.

264 дүгээр тойргийн депутат Б.Банди: -Нэгдүгээрт, горимын шинжтэй нэг санал байна.Энэ асуудлыг хэлэлцүүлэхэд бас арай хөнгөн талаас нь авч үзэж байвал ямар вэ? Жишээлбэл, нэрийн тухай санал хураалгахад тусгай, ерөнхий гэдгээр эхэлж санал хураалгана гэдэг бол нэг шат дамжлага нэмж байгаа юм шиг надад хувьд санагдаж байх юм.Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль гэж нэрлээ, Их засаг гээд 3, 4 нэр гараад хэдэн сар хэлэлцээд, ечигдөр, өнөөдрийн ярилцлага дээр тодорхой болоод байхад энэ хэдэн нэрэн дээр шууд саналыг хураалгаад цөөнхийг нь саналыг сонсчихвол арай хямд төсөр шийдэгдэж болохоор ийм юм гэж нэг горимын шинжтэй санал оруулмаар байна.Тэгээд цөөнхийг сонсвол яасан юм бэ?

дээр хүмүүсүүдийн ярьж байгаатай холбогдуулж би ганц, хоёрхон минутын санал байна.Цааз гэдэг нэрийн тухайд түүхийн сурвалж бичгээс үзэхэд Нууц товчоонд байдаггүй гэж яригдаж байгаа юм байна.Үндсэндээ тийм үг... Их засаг гэдэг хууль байдаггүй юм байна.Энийг Чимид гуайн ярианаас сая ойлголоо.

Албан ёсоор олдоогүй байгаа гэж. Тэгэхээр цаазыг бол хүмүүсүүд хүлээж авах шинж алга л даа. Энэ бол өнөөдөр, өчигдрийн бид нарын ярианаас ч урьд ард түмнээр хэлэлцүүлсэн ярилцлагын дүнгээс ч үзэхэд энэ тодорхой ийм байгаа юм.

Монгол-Ойрадын цааз бичиг гэдэг тэр хууль бол Их засаг хуулиас 400-гаад жилийн дараа гарсан юм шиг байгаа юм. Тэр хууль бол үндсэндээ 190 хэдэн зүйлтэй хууль гэж үзэж байгаа юм байна. Тэр хуулийн ихэнх нь эрүү, иргэний шинжтэй асуудлыг тусгасан учраас тухайн үедээ магадгүй "цааз" гэсэн нэрийг хэрэглэж байсан болов уу гэсэн улсуудын таамаглал байгаа юм.

Өнөөдрийн бидний энэ гаргаж байгаа хууль маань эрүү, иргэний шинж, бусад үндсэн бүх асуудлуудыг хамарсан үндсэн шинжтэйгээрээ ихээхэн ялгаатай юм гэж үзэж байна. Нөгөө талаар нь хүмүүсүүд ярьж байна. Анхнаасаа цайруулах гэсэн ийм санаатай толь бичигт тусгагдсан үг гэж ярьж байгаа юм. Гэхдээ энэ утгаа гэж хориглох, хязгаарлах гэдэг санаа нь давамгайлж 30-аад оны сүүлч үеэс эхлээд "толгой авах" гэсэн утга нь хүмүүсүүдийн яс, мах, цусанд шингэсэн ийм үг юм. Тийм учраас энийг мэдээжийн хэрэг, хэрвээ бид ингэж шийдвэрлэх юм бол ард түмэн ихээхэн гомдох ийм үндэстэй гэж үзэж байгаа юм.

Үндсэн хууль бол мэдээжийн хэрэг 1924 онд "основной закон" гэдгийг орчуулсан байна гэж яриад, тайлбарлаад байгаа юм, зарим хүмүүсүүд. Тэр орчуулгаас ч түрүүн хичээнгүй сайд Цэрэндорж энэ чинь гурав, дөрвөн төрийн нүүрэнд тодорхой алба ханиж байсан, дорно дахин өндөр соёлтой, олон хэл мэддэг, түүхээ мэддэг хүн. Энэ хүн өөрөө энэ нэрийг өгсөн, Үндсэн хууль гэж нэрийдсэн байгаа юм. Тэгэхээр Үндсэн хууль гэдэг үг бол хуулиудын үндэс гэдэг утгаараа ч, аль ч талаас нь аваад үзэхэд үүнийг Үндсэн хууль гэж нэрлэх тал дээр мэдээж олонхийн санал байгаа юм. Ийм учраас ерөөсөө шууд Үндсэн хууль, Их засаг, Их цааз гэдэг энэ гурван нэрэн дээрээ, шаардлагатай гэж үзвэл ганц, нэг хөндлөнгийн саналыг оруулаад шууд санал хураагаад цөөнхийн саналыг сонсвол яасан юм бэ гэсэн саналтай байх юм.

Тусгай, ерөнхий гэдгийг хэлэлцүүлэхгүйгээр.

М. Уртнасан: -Цөөнх үгээ хэлмээр байна.

399 дүгээр тойргийн депутат Д. Чилхаажав: -Би горимын санал хэлмээр байна. Энэ хуулийн нүүрэн дээр эхлээд Монгол улсын Их цааз гэж байгаа. Тэгэхээр "Монгол улс" гэдэг нэрэн дээрээ эхлээд тогтоод цаашаа явбал зүгээр байсан юмуу гэж ийм бодолтой байгаа юм.

Би бол Их цааз гэсэн нэрээр энэ Үндсэн хуульд тусгайлж нэр өгөхийг зүйтэй гэж үздэг хүмүүс. Түрүүн уг хэлсэн хүмүүс ерөнхий санал шүүмжлэл дээрээ нэлээн буруу ярих шиг боллоо. Үндсэн хууль гэдэг нэрийг өөрчлөх, цаашид хэрэглэхгүй болох гээд байна гэж ийм утгаар их ярьсан. Үндсэн хууль гэдэг нэрийг ерөөсөө өөрчлөх гээгүй. Их цааз гэж оноосон нэр өгөх гэж байгаа болохоос энэ талаар их буруу ярьсан.

Хүмүүс ярьж байна, өнөөдөр хүмүүс хүлээж авахгүй гэж. Түүхэн уламжлалыг сэргээхийн үүднээс түүхэн уламжлалаа зөвхөн өнөөдрийн хүмүүсийн таашаалд нийцэх эсэхээс нь авч үзэх юм бол энэ хэзээ ч нийцэхгүй. Бид түүхээсээ 70 жил тасарсан учраас өнөөгийн хүмүүс бол өх түүхээ мэддэг хүн үнэхээр бараг байхгүй болсон. 40, 50-иад насны хүмүүс мэдэхээс тэрнээс дооших, манай хүмүүсийн, манай улсын ихэнхийг бүрдүүлж байгаа залуучууд үнэхээр мэдэхгүй. Санал асуухад аягүй бол Үндсэн хууль гэж нэрлээ гэж гарч ирнэ. Энэ нь ч одоо зөв. Яагаад гэвэл, түүхээсээ тасарсан учраас аргагүй юм.

Тэгэхээр депутатууд бид ард түмний саналыг зөвхөн хэлж өгдөг! дамжуулагч биш ард түмний нэр тэр саналууд дотроос жинхэнэ шижрийг тунгаадаг, үнэн зөвийг олж төрийнхөө үйл хэрэгт тусгаж чаддаг ийм л хүмүүс байх ёстой. Тэгээд сонгогчид, ард түмэн тэгэж л хэлж байсан, энүүгээр оруулах ёстой гэсэн ийм байдлаар аливаа асуудалд хандаж болохгүй байх аа. Тэгэхээр Их цааз гэж нэрлэх нь зүйтэй гэж би бодож байгаа юм. Ер нь төрийн насыг өөрийнхөө настай жишиж болохгүйн адил төр, улсын түүхийг өнөө үеийнхний түүх юмуу, зөвхөн хоёр,

гурван үеийнхний түүхээр хязгаарлаж болохгүй.Энийг бид хатуу санах ёстой болов уу гэж бодож байна.

280 дугаар тойргийн депутат Ш.Цэндбаяр: -Хоёр үндэслэл хэлье.Нэгдүгээрт, БНМАУ бол дэлхий нийтийн жишгээр хүн төрөлхтөний түүхэн замнал руу явж байна.Ийм учраас бид бол ямар ч тохиолдолд, ямар ч үндэслэлээр онцгойрох ёсгүй гэж бодож байна.Ийм учраас бид дэлхий нийтийн нэр томъёо, Үндсэн хууль гэдгээ хадгалах хэрэгтэй юм.

Хоёрдугаарт, Их цааз, Их засаг гэдэг түүхэн тодорхой үед гарч ирсэн энэ томъёо түүхэн тэр өв уламжлал болоод үлдэх хэрэгтэй юм.Тэрийг Чимид гуайн баталж хэлснээр магадгүй 1000 жилийн дараа аль үеийнхэн энэ Их цааз, Их засгийг гаргаж ирэв гэдэг, будилахад хүрнэ.Ийм учраас миний санал Үндсэн хууль гэдэг нэрээ хадгалах нь эхитэй.Энэ маань онцгой, БНМАУ-ын Үндсэн хуульд олгогдсон онцгой нэр томъёо гэж ойлгож байна.

271 дүгээр тойргийн депутат Ж.Даргахуу: -Би түүхэн уламжлал, соёл иргэншлээ хүндэтгэж үзнэ.Гэхдээ нэгдүгээрт, авах, гээхийг хослуулж зохицуулмаар байна.

Хоёрдугаарт, өмнөх үеэ, тухайлбал, XII дугаар зуун гэдэг юмуу, XVI дугаар зуун гэдэг юмуу өмнөх цаг мөчийг өнөөдрийн аугаа XX зуунтай энэ зууны түвшинтэй эн зэрэгцүүлж адилтгаж авч үзэх бодлогыг юуны өмнө баримтламааргүй байна.Тийм учраас би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр ер нь хуулийн нэр дээр Их цааз гэсэн нэр томъёог өөрчилж Үндсэн хууль, эсвэл өөр нэр томъёо гаргаж болох байна гэсэн санал хэлэх байна.

Д.Чилхаажав: -Цөөнх ярьж байгаа юмуу, олонх нь ярьж байгаа юмуу, дандаа олонх яриад байх юм.

Ж.Уртнасан: -Цөөнх ярина гэж байгаа шүү дээ.Олонх бол саналаа хэрэггүй, санал хураалгасан шүү дээ.Цөөнхөд орж байгаа нь саналаа хэлмээр байгаа юм.

Д. Лундээжанцан: -Оноосон нэр хэрэгтэй, хэрэггүй юу гэж байгаагийн "хэрэгтэй" гэж байгаа нь ярина шүү дээ.

Ж. Уртнасан: -Тийм ээ. Оноосон нэр хэрэгтэй гэдэг дээр ярих хэрэгтэй.

Ж. Даргахуу: -Оноосон нэр хэрэгтэй. Тийм учраас би гол нь юу гэж хэлэх гэж байна гэхээр еер нэр томъёо гаргаж ирж болох байна, жишээлбэл. Энд бол, Их эрх, Дээд хууль гэх мэтчилэн нэр гаргаж үүн дээр шууд санал хураах арга барил баримталбал яана вэ гэсэн саналтай байна.

44 дүгээр тойргийн депутат Ш. Сүрэнжав: -Би бол оноосон нэр гэдэг дээр саналтай байна. Ер нь цагийн жамыг сөрж болдоггүй, өнөөдрөө бас мэдэрч байна. Тэгээд энэ "их" гэдэг үгэн дээр би тайлбар, өөрийнхөө үзэл бодлыг хэлмээр байна. "Их" гэдэг чинь Их Нацагдорж, Их монгол Шаравжамц гээд "их" гэдгийг монгол хүн яагаад томъёолж хэлээд байдаг юм бэ? Яагаад том Нацагдорж, том Шаравжамц гэж хэлсэнгүй юу? Тэгэхээр их гэдэг бол их учир холбогдолтой үг ээ. Хуулийнхаа урьд их гэдэг зүүлт байж байх нь зүйтэй гэж бодож байна.

Тэгээд "Их засаг" гэж нэрлэх санал байна. Тэр "Их засаг" гэдэг дээр Чимид гуай гаргаж байна. Энэ субъект гэж ярьж байгаа улс бол яах вэ, өөрийнхөө үүднээс зүтгүүлэлгүй яах вэ, гэхдээ юм хэлэхдээ, хүний нэг логик байна л даа, тэр яах вэ гэхээр "манжи" яаж байсан юм бэ гэж хэлчихвэл Манжид дургүйцсэн сэтгэлийн үүднээс энээс татаж авна гэсэн логик байх шиг байх юм. Ер нь Их цааэтай холбоод хэлчихбэл энэ нь болохоо байчихна гэж ингэж домог маягийн юм өөрсдөө их зохиож, яг нарийн "барь ир" тэр чинь хаана байна гэхээр гар дээр тавьчих юм нь хаа нь ч билээ, юу ч билээ. Тэгэхээр ингэж субъект болж байгаа улс зүтгүүлэхдээ учрыг бодох байх аа.

Тэгээд "Их засаг" гэж хэлмээр байна. Түрүүчийнх дээр яах вэ гэхээр, "цааз" гэдгийг чинь ард түмэн яагаад авахгүй байна вэ гэдэг сэтгэл зүйн талыг бас бодож үзмээр байна л даа. Эцсийн эцэст энэ чинь очоод хүний сэтгэлийн толинд тусна шүү дээ. Сэтгэлийн толинд бууна. Сэтгэлээ энэрээд үзье. Ингээд хэдэн янзаар хэлээд үзэхэд аль нь буух нь вэ? Тийм учраас "Их засаг" гэдгийг хэлэлцүүлэхдээ урьд нь тэр оноосон нэрээр нь, "Их засаг" гэдэг нэрээр нь урьд талд нь оруулж, Үндсэн хууль гэдгийнхээ урьд оруулж эхэндээ дуудаж болж байна. Эхэнд хэлсэн юм хүртэл саналд их өөр үйлчилгээтэй байдаг. Хурлын дарга ерөнхий удирдаачийн хувьд сэтгэл зүйн талыг их бодолцож байх болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Д.Содном /160 дугаар тойргийн депутат/ -Хуулиндаа оноосон нэртэй байя гэдэг саналыг би дэмжиж байгаа юм.Тэгэхээр энэнтэй холбогдож өгсөн тайлбарын дотроос би нэг зүйлийг хэлмээр санагдаж байгаа юм.1640 онд баруун монголын ойрдын 30 гаруй ноёд цуглаад баталсан, Их цааз нэртэй баталсан хуулийг агуулгаар нь үзвэл, тухайлбал, дотор нь бичигдсэн 130-200-гаад зүйлтэй тэрийг уншаад үзэхэд тэрийн тогтолцоо, улс орны амьдрал, ард түмний хэв заншил ийм юмнуудыг бататгасан зүйл бол тэрэн дотор бараг байхгүй, дан шийтгэл яллалт ямар байх вэ гэдгийг ясан, өөрөөр хэлбэл манай одоогийнхоор бодоход Эрүүгийн хуультай их ойрхон тийм агуулгатай хууль байна билээ.Тийм учраас Их цааз гэдэг нэр 1640 онд гарсныгаа жинхэнэ Үндсэн хуулийн агуулгаар ойлгох ёстой нэр үү, эсвэл эрүү байцаан шийтгэх хуультай агуулгаараа нийлж байгаа нэр үү гэдгийг бид бодмоор юм шиг байна билээ.Тийм учраас миний санал бол одоо Их засаглал гэдэг нэр нь байвал агуулгаараа таарсан тийм нэр болох болов уу гэсэн тийм л санаа байдаг юм.

Д.Лүндээжанцан /15 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр би нэг ийм саналтай байгаа юм.Хууль тогтоогч бид нар энэ монгол улсынхаа шинэ Үндсэн хуулийг батлахдаа хууль цаазын сэтгэлгээг нэг алхам урагшлуулах нь зүйтэй юм гэж бодож байгаа юм.Ийм учраас нэг оноосон нэр бол, Үндсэн хуулиндаа оноосон нэр өгөх нь зайлшгүй хэрэгтэй юм гэж бодож байгаа юм.Чухам ямар оноосон нэр байх вэ гэдэг дээр нь депутат бид бүхэн хоорондоо сайн ярьж байгаад урьдахь түүх, төр ёсныхоо хууль цаазат төр ёсныхоо уламжлалд нийцсэн ийм нэр байвал илүү зүйтэй юм болов уу, тэгэхдээ тэр нэр нь тэр урд талд нь байсан хуулинд дотор нь чухам юу байв гэдэг нь онц биш, ямар үгийн гарал, хууль цаазны тийм түүхэн уламжлалаа түшсэн нэр байвал ясан юм бэ гэсэн ийм бодол байгаа юм.Ийм учраас би энэний хувьд Их цааз гэдгийг ерөнхийд нь дэмждэг хүн.Энэний нэг гол буруутны нэг гэж хэлж болно.Өнгөрсөн онд Ерөнхийлөгчид монгол

улсын тулгар цааз гэдэг баримт бичиг бидний хэсэг залуучууд, хуульчид өргөн барьсан, үүнээс бас цааз гэдэг үгийн юу гарсан байх. Гэхдээ Цааз гэдэг үг бол монгол үг юм. Энэ бол хууль гэдэг утгатай монгол үг ээ. **Юан** улсын үед монгол улсын нэвтэрхий хууль гэдэг нэр томъёо нилээн хууль цаазын биеэ даасан нэр томъёо болж гарч ирсэн. Үүнээс өмнө үйлчилж байсан эхэлж гарсан нэр томъёо. Ийм ч учраас нэгдүгээрт, нийгмийн харилцааг зохицуулдаг хууль, хоёрдугаарт, хориглоно гэсэн утгатай, гуравдугаарт бол толгой авна гэсэн иймэрхүү **мухируулна** гэсэн утгатай үг. Энэ үг бол 70-аад жилийн туршид биш 1961 онд анх эрүүгийн хуулинд анх орсноос хойш сүүлийн 30 жилд л газар авчихсан ийм үг байгаа юм. Сүүлийн үед ард түмнээр хэлэлцүүлснээс хойш сүүлийн хэдэн сарыг харахад Их цааз гэдэг үг хүмүүсийн аманд нилээн хэвшиж, хүлээж авах хандлагатай болж байна уу даа гэж харагддаг. Гэхдээ үүнийг эсэргүүцэж байгаа, хүлээж авахгүй байгаа, санаа сэтгэлд нь тохирохгүй байгаа хүмүүс ч олон байгаа. Иймд юмыг нэг тийш нь хэт үгүйсгэх хандлагаар авч үзэж болмооргүй санагдах юм. Хоёрдугаарт бол аливаа нэр томъёо бол зарчмын асуудал мөн үү үгүй юу гэдэг асуудал. Зарчмын асуудлыг улс төрийн тогтолцоонд өөрчлөлт оруулах, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт оруулах ийм зүйлийг зарчмын асуудал гэж үзмээр байна. Энэн дээр бид бүхэн сэтгэлгээний ач холбогдолтой юм. Хоёрдугаарт бол манай Үндсэн хуулийн хэлбэржилт, боловсруулалтанд ач холбогдолтой юм. Иймд Их цааз гээд оноосон нэр өгснөөр манай үндсэн хуулийн агуулга өөрчлөгдчихгүй. Хоёрдугаарт бол улаан мөнгөний гарлага гарахгүй юмаа гэдгийг бас зөв ойлгоосой гэж бодож байна.

Н. Уртнасан -4 дүгээр микрофон.

141 дүгээр тойргийн депутат Авхиа - Манай Үндсэн хуулийг нэргүй явж ирсэн гэдгийг үнэндээ гайхаж байна. Хууль гэдэг чинь ерөнхий нэр, тэрэн дээр Үндсэн хууль, эрүүгийн хууль, хилийн хууль, иргэний хууль гээд тодотгосон нэрнүүд байгаа. Тэгэхээр Үндсэн гэдэг бол тодотгосон нэр нь байгаа юм. Тэгэхлээр Үндсэн хуульд оноосон нэр өгнө гэдэг нэрийдлээр өгөх юм бол ер нь бусад хуулиудад бас л одоо оноосон нэр өгнө гээд бас нэрийг нь өөрчлөх үү. Эрүүгийн хууль, хилийн хууль гэх мэтчилэнгийн хуулиудыг.

Энэ учраас ер нь энэ оноосон нэр өгнө гэдэг санал хурааж байгаа явдлыг ч буруу гэж бодож байна. Манай хууль бол Үндсэн хууль бол жинхэнэ нэртэй явж ирсэн, цаашдаа ч энэ бол Үндсэн хуулийн тодотгосон нэр ээ гэж бодож байна. Ер нь цааз гэдэг үгийг бэлэгдлийн сайхан үг болгох гэж эарим улсууд их оролдож байгаа юм. Янэ янэаар их тайлбарлаж байгаа юм. Энэ бол ингээд явахгүй ээ. Ер нь яалаа ч гэсэн хар юмыг цагаан болгож болохгүй. Цааз гэдэг чинь хяэгаарлах, хориглох, цээрлэх, хамгийн эцэст нь цаазлах гэсэн үг байгаа юм. Гадаадын, өөрөөр хэлбэл хятадаар бол **цээз** гэсэн хоморголон устгах гэсэн үгээ гэж сүүлийн үед сонин хэвлэлд бичиж байгаа. Энэ учраас бид Үндсэн хуулиа цааз гэдэг үгээр нэрлэж хэрхэвч таарахгүй гэж бодож байна.

Ер нь энэ учраас би нэрлэсэн нэр өгнө гэж санал хурааж байгаа явдлыг ч буруу гэж бодож байна. Яагаад гэвэл манай хууль бол урьд нь нэргүй байсан, одоо тодорхой нэр өгнө гээд цааз гэдэг нэрийг тулгах гэсэн арга байх. Энэ учраас ард түмнийхээ санал бодлыг харгалзаж үзээд Үндсэн хууль гэдэг нэрээрээ нэрлэх нь зүйтэй. Ер нь дээр үеийн халх журам монголын бусад хуулиуд бол дандаа гол төлөв эрүүгийн харьцаануудыг зохицуулж байсан. Тэнд бол дандаа л шийтгэх, зэмлэх, цаазлах, хориглох ийм зүйлүүд байсан. Манай Үндсэн хууль бол тогтоосон, бататгасан ийм харьцаануудыг тогтоож байгаа. Хориглосон юм хэд хэдэн зүйл байгаа. Энэ талаас нь ч гэсэн авч үзэх хэрэгтэй гэж бодож байна. Ингээд ард түмнийхээ /сонсогдоогүй/ харгалзаж Үндсэн хууль гэдэг нэрээр нэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

И. Уртнасан - Цөөнх үгээ хэлье гэдэг дээр тогтсон шүү. Цөөнх нь үгээ хэлмээр байна.

234 дүгээр тойргийн депутат Дэмбэрэл - Би Үндсэн хуулийн нэрийг түүний агуулгатай нь холбож үзэж байгаа. Их цааз гэсэн нэр өгч байгаа нь бас санамсаргүй зүйл юмуу гэж бодож байна. Их цааз гэж нэрлэвэл шүүх эрх мэдэл гэсэн хэсэг Сүмбэр уул мэт энэ хуулин дотор байх ёстой. Хоёрдугаарт Их цааз гэж нэрлэвэл Үндсэн хуулийн хүний эрх зөрчигдөх байдалтай энэ сөргөлдсөн үг болж хувирна гэж бодож байна. Хүний эрх, иргэний эрхийг

Их цааз гэсэн байдлын нэр томъёотой үгээр сэргүүлэн хуулиа нэрлэвэл ашигтай болж чадах болов уу, үгүй болов уу. Нөгөө талаар энэ Үндсэн хууль гэсэн үг бол еерийн үндсэн гэдэг үгээрээ ялгах тодотголтой болж тодорхой нэр болж байна гэж ойлгож байна. Ийм учраас хурал, хурлын тэргүүлэгчийн зүгээс хуралдааны даргын зүгээс энэ тодотгол, нэр томъёоны талаар санал хурааж байгаа нь онохгүй байна гэж, оноосон нэр гэдгээр санал хурааж байгаа нь онохгүй байна гэж үзэж байна. Нөгөө талаар их хууль гэсэн томъёоллыг бол би хувьдаа шүүмжлэлтэй хандаж байна. Их бол юм болгоны үндэс болж чадахгүй, харин эх, эцэг аль аль нь нийлж байж л үндэс болно. Хэрэв ингэхэд хүрвэл эцэг хуульч гээд нэрлэхийг гээд санал гаргаад байх болно. Ийм салаа утгатай үгнүүдийг Үндсэн хуулийн нэрээр нэрлэмээргүй байна гэсэн саналтай байна.

31 дүгээр тойргийн депутат Дожоодорж -Би цөөнхийн талын хүн. Ингэхлээр Их цаазыг эсэргүүцэж байгаа, Үндсэн хуулийг ч зөвшөөрөхгүй ийм саналтай хүн. Их цаазыг гадаад хэлэнд орчуулах юм бол алах хядах л болох байх. Тийм цаазтай, тийм хуультай оронд ямар хүн халдах бол оо, их айх болов уу. Хоёрдугаарт, 1924 онд Үндсэн хууль гэж яагаад өгсөн юм бэ гэхлээр зэрэг Коминтерний төлөөлөгч Ренчин мэтийн хэд хэдэн буриад нар зөвлөсөн байдаг Цэрэндорж гуай нарын хүмүүсүүд. Тэдний уул нь хэлсэн саналын үндсэн дээр Үндсэн хууль гэж анхлан тогтсон. Тэрнээс хойш энэ нэр явж ирсэн. Энэ үндсэн хууль бол одоо манай улс төр, нийгмийн тогтолцоонд үйлчилж чадахгүй, нэр нь таарахгүй гэж үзэж байгаа. Хоёрдугаарт бол манайх ерөөсөө 1940 оны сүлд, 1960 оны сүлд дандаа зөвлөлтийн сургагч нарын зөвлөлгөөнөөр хийгдсэн. Үүнийг дараа ярина. гэдэг хүн бол 17-р армийн зураач хүн бол манай 1940 оны сүлдийг зурсан байгаа. 1960 оны сүлдийг Чүлтэм зурж үүнийг Улс Төрийн Товчоо ширээн дээрээ баталсан байгаа. Ингэж гаргасан зүйл юм. Үүнийг дараа тодорхой ярих үндэстэй гэж үзэж байна. Ингээд энэ цааз гэдгийг одоогийн ард түмэн бол алах, хядах гэдгийг ойлгож байгаа. Үүнээс ард түмэн айхавтар их эвгүйрхэж байгаа. Энэ нэр томъёо их буруугаар явжээ гэдэг нь ойлгомжтой. Тэгэхлээр одоо Их засаг

гэдэг дээр л санал хураах явдал хэрэгтэй байгаа. Их засаг гэдэг бол монголын хуулийн хамгийн ахмад хууль. Америкийг 200 жилийн өмнө хууль тогтоосон гэж ярьж байна. Тэгвэл Монгол 2000 жилийн өмнө Хүннүгийн үеэс засаг төрийн хуультай байсан. Дэлхийн хамгийн ахмад хууль цаазтай улс. Үүний хамгийн ахмад хуулийн нэг бол Их засаг гэж нэрлэж байгаа. Энэ дээр түүхийн баримтууд байж байгаа. Хуульчид өөрийнхөө хуульчлалыг гаргаж байгаа. Тэгэхээр энэ дээр Чингис хааны өөрийн цагаан дэвтэр дээр хөх бичиг бичиж дэвтэрлэсэнд ингэж байгаа: Их засаг хууль байгаа. Тэр хуульд бол ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй гэсэн ийм хууль байгаа. Энэ хууль нь Чингис хааны үеийн гаргасан ийм үндсэн гол хууль. Энэ хууль бол жинхэнэ дарлагч ангийн эрх ашгийг хамгаалсан 1600 оны хуулиудтай адилгүй. 1600 оны үед гаргасан Их цааз бол үнэхээр дарлагчдын эрх ашгийг хамгаалсан бөгөөд алах, хядах, цаазлах гэсэн зорилалтай ийм эрүүгийн хуультай хууль байсан байгаа юм. Одоогийн цаазлах гэдэг үгийг эрүүгийн хуулин дээр үлдэг, нэг статъяан дээр үлдэг.

Манай улсын Үндсэн хуулийн нэрэнд яав ч тохирохгүй. Үүнийг депутат нөхдүүд минь сайн ойлгож үзээч ээ.

Ж. Уртнасан -7 дугаар микрофон.

247 дугаар тойргийн депутат Шоовдор -Би цөөнх болж цөөнхийн саналыг дэмжиж уг хэлье гэж бодож байна. Тэгэхлээр ард түмнээр энэ хуулийн төслийг хэлэлцүүлэхдээ Их цааз гэсэн нэрээр хэлэлцүүлсэн. Тэгэхлээр хамгийн гол нь ард түмэн сонгогчид маань Үндсэн хууль гэдэг нэрээр батлуульа гэдэг эх үндэс маань болбол Их цааз гэдэг нэрнээс зайлсхийсэндээ л Үндсэн хууль гэдэг нэрээр хэлэлцүүлэе гэсэн олонхийн санал гарч байгаа. Тэрнээс биш ер нь Үндсэн хууль гэдэг нэрээ өөрчлөхгүй гэсэн тийм санаа ч байхгүй ч байж магадгүй гэж бодож байна. Тэгэхлээр Улсын бага хурлаас оруулсан тэр санал, энэ төслийг Чимид гуай тайлбарлалаа. Эндээс ойлгож үзэхэд урьд өмнө эрт дээр үеийнхээ хуулийн нэрийг их шүүсэн юм шиг байна. Өөрөөр

хэлэх юм бол миний ойлгож байгаагаар Их цааз гэсэн нэр тийм хууль байсан учраас л авчихсан юм гэсэн юм ойлгогдож байна. Тэгэхлээр миний бодлоор бол улс орон маань энэ эгзэгтэй их чухал үед ирлээ, сэргэн мандалтын маань үе эхэллээ. Ийм учраас энэ үетэйгээ тохирсон тийм нэр өгөхөд болохгүй юм байхгүй гэж бодож байна. Ийм учраас Их засаг гэсэн энэ хууль их зүйтэй, их аятайхан таарч байгаа. Ер нь бид гэсэн хуулиа баталчихаад очоод тайлбарлахад ч гэсэн ард түмэндээ хэлэх үгтэй, тайлбар олцохоор, ямар ч байсан тэрний сэтгэл санаанд нийцүүлж, ойлгуулж болохоор ийм нэр юм гэж бодож байна. Нөгөө талаар ер нь хуулийнхаа нэрийг өөрчлөх нь депутатын хувьд, энэ танхимд сууж байгаагийн хувьд хэлэхэд энэ нэрээ өөрчлөх нь буруу ч үгүй болов уу. Ер нь ч өөрчлөх нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд санал хураах асуудлыг зохион байгуулахдаа нэр нэр дээр хураалгавал зүйтэй болов уу гэж Их хурлын даргаас хүсч байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Handwritten signature

/Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

285 дугаар тойргийн депутат С.Батсүх: Би нэг товчхон санал хэлье.

Ер нь энэ Их цааз гэдэг үг бол ард түмний дунд, ялангуяа манай хөдөөгийн малчид, хөдөлмөрчдийн чихэнд ихээхэн хатуу үг болж сонсогдож байгаа.Ерөөсөө яаж ч байсан гэсэн толгойг нь авах, амь насыг нь хохироох гэдгээс өөр утгаар ойлгож чадахгүй байгаа юм.Үүнтэй холбогдуулж би бас нэг юм хэлмээр байна. Одоо мөрдөж байгаа энэ эрүүгийн хуулинд маань хууль, ялын дээд хэмжээ авсан хүний асуудлыг гүйцэтгэхдээ ямар нэртэй бичгүүд гаргаж байгаа вэ? Би бол цаазаар авсугай гэдэг тогтоол гардаг байхаа гэж бодож байна.Ингээд үзвэл энэ үг ерөөсөө өнөөдрийн монголчуудад, өнөөдрийн ард түмний сэтгэл зүйд хэрхэн нийцэж тусах вэ гэж ийм юм бодогдоод байх юмаа.Махав хуулинд бол оноосон нэр өгье гэвэл тэр болохгүй гээд зүтгээд байх юм алга.Гэхдээ тэр оноосон нэр маань Үндсэн хуулийн агуулгыг илэрхийлсэн баймаар санагдаж байна.Миний бодлоор Жанцангийн саналтай нэг байгаа юм.Хууль бол ерөнхий нэрээ.Тэр олон ерөнхийгийн дотроос Үндсэн хууль гэж нэрлэж гол хуулиа хэлсэн байхаа гэж. Ингэхээр уул нь энэ утгаараа байсан ч болохгүй юм байхгүй.Хэрвээ болдог юм бол Их хууль гэвэл одоо бас их гэдэг ихээхэн хүндэтгэлтэй, их аугаа юмыг илэрхийлсэн энэ утгаараа угаасаа болохгүй юм байхгүй гэж бодож байна.

63 дугаар тойргийн депутат Х.Цүрэвдагва: Энэ хоёр чиглэлээр саналаа хэлье гэж санаж байна.

Нэгдүгээрт хуулийг оноосон нэртэй байх талаар.Бид нар мэдэж байгаа.Түүх шашинаасаа мэдэж байна.Монгол улсад бол ер нь хуулинд оноосон нэр өгдөг байсан ийм уламжлал бий.Хуулийн мэргэжлийн улсуудын бичсэн бүтээлээс ингээд аваад үзэхэд Чингисийн Их засаг гэдэг нэр томъёо бий.Ойрд Монголын Их цааз гэдэг ийм нэр томъёо бий, Халх журам гэдэг нэр томъёо явж байгаа хуулийн нэр.Үүнээс гадна бид нар энэ хувьсгалаас өмнө, 70 жилээс өмнө манай түүхэнд эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны, үйл ажиллагаагаа тэмдэглэсэн протоколыг хүртэл

нэрлэж байсан. Манай депутатууд сайн мэдэж байгаа байх. Улаан хацарт гэдэг баримт бичиг бий, Хугархай нүүрт гэдэг баримт бичиг бий. Энэ утгаас нь аваад үзэхэд манай хуулинд хууль цаазны энэ түүх уламжлал хуулиндаа тодорхой нэр өгч байсан ийм юм бий.

Ийм учраас хуулийг тодорхой нэртэй байх бололцоотой гэж үзэж байна. Яг энэ хэлэлцэж байгаа төсөл дээр, хуулийн нэр дээр бол би Их засаг гэдэг энэ хуулийн нэр дээр санал өгнө. Энэ нь ямар учиртай вэ гэвэл түрүү нэг депутат хэлсэн Их засаг гээд нэрлэхэд энэнд нэг их алдаа байхгүй гэж боддог. Яагаад гэвэл энэ хуулийнхаа төслөөр бид нар төрийнхөө тогтолцоог хуульчлан батлах гэж байна, төрийн эрх мэдлээ хуульчлан хуваарилах гэж байгаа учраас Их засаг гэдэг нэр нь илүү дөхөмтэй гэж ингэж үзэж байна.

157 дугаар тойргийн депутат Д.Олончимэд: Бид цөөнхийн тал үгээ хэлж байна. Нэгдүгээрт. Цөөнх цөөнхдөө магадгүй би энд ганцаараа ч болж магадгүй. Тэгэхдээ зарим улсууд араас бичиг ирүүлж байна. Эх хууль гэдэг нь зөв юм байна. Яагаад гэвэл бид шинэчлэгдэж байна, Эх Хуулийн баяр гэж хийсэн ч сайхан болох юм байна тэх мэт. Миний хувьд Их цаазын төлөө үнэндээ саналаа өгөхгүй байна. Ер нь Их цааз гэдэг дээр сүүлд нь нэрээр хураах юм бол хамгийн нэгдүгээрт миний нэрийг өгөөгүй гэж бичсэн ч одоо болно. Тэгээд ер нь би Эх хууль гэдэг ийм хуультай больё, оноосон нэрийн талд байна. Эх хууль гэдгийг хамгаалж хоёр, гурван зүйл хэлье гэж бодож байна.

Эх хүний эх, юмны эх булгийн эх, Э-гээр эхэлж байна. Их биш үү эх. Бусад хуулиуд нь бол энэ эх хуулийн хүүхдүүд байдаг. Усны эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг. Бид Эх хуулийг бол маш гоё хууль гаргах хэрэгтэй. Бусад хуулиуд нь энэнээс урган гарахад ямар ч зөрчил байхгүй байх ёстой гэж ингэж үзэж байна. Эх нь хээр алаг бол Унага нь шийр алаг гэж ярьдаг байх. Ингээд ярих юм бол олон юм яримаар байна. Ямар ч байсан би өөрийнхөө Эх хууль гэдэг дээр санал хураалгаж өгөөсөй гэж Их Хурлын даргаас хүсч байна.

90 дүгээр тойргийн депутат О.Нямлаваа: За би Үндсэн хуулийн оноосон нэр дээр саналтай байгаа хүн. Тэгэхээр Их цааз гэдэг нэрийг болбол миний хувьд зөвшөөрөхгүй байгаа. За их цааз гэдгийг бол би улсын гол хуулийн нэр биш, шүүн таслах хуулийн нэр гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд ч энэ нэр дээр Эрүүгийн хуульд бол Их цааз гэсэн нэр томъёо байх нь илүү зохимжтой байхаа гэж бодож байгаа.

Үндсэн хуулийн нэр дээр бол дээр улсууд тодорхой тайлбарлаж ярилаа. Үндсэн хууль болбол оноосон нэртэй байх шаардлагатай. Би болбол энэ дээр Эх засаг гэсэн нэртэй байлгая гэсэн ийм саналтай байгаа. Энэ дээр бол тайлбарлаж ярих шаардлагагүй юмаа.

52 дугаар тойргийн депутат Э.Бат-уул: Юуны өмнө энд их олон ахмад хүмүүс байна. Би тэдэнд хандаж нэг зүйлийг хэлэхийг хүсч байна. Тэр нь юу вэ гэхээр би өөрийнхөө уг сурвалж, үндэс угсаанаасаа таслагдаж гайтай хүмүүсийн гайгаар хохирсон тийм залуу үеийнхний төлөөлөгч. Цаашдаа үнэхээр Монгол улсаа хөгжил цэцэглүүлэхийн тулд, Монгол байхын тулд би өөрийнхээ тэр өвөг дээдсийнхээ уг сурвалжруу маш их хүчтэй тэмүүлж байгаа тийм залуу үеийнхний төлөөлөгчөө.

Тэгээд би болбол харамсалтай нь тэгж их таслагдсаныхаа хувьд үнэхээр өнөөдөр тэр Их цааз гээч нь юу юм бэ, Их засаг гээч нь юу юм бэ, тэрний түүх, уг сурвалж нь ямар байсан юм гэдэг бүхнийг тэгж бүрэн дүүрэн хэлж чадахгүй тийм харалган болсон үеийнхний төлөөлөгч гэдгээ хэлчихмээр байна. Өөрөөр хэлбэл тийм их түүхийн том ном хаялцаж чадахгүй. Харин депутатуудын хүрээнд болгоомжтой юмаа яриачээ гэж санал хэлмээр байна. Юуны өмнө Үндсэн хууль, Их засаг гэдэг нэрүүдийг сонгож авахдаа үндэслэл болгож байгаа зүйлээ их бодож хэлээчээ. Зарим нэг нь хуулиудын эх хууль учраас Үндсэн хууль гэж нэрлэе гэж байна. Зарим нь засаг төрийн тогтолцоог тогтоож өгдөг учраас Их засаг гээ гэж байна. Яг үнэнийг хэлэхэд, олон их суут хүмүүсийн үзэж байгаагаар бид нар өнөөдөр зарим нь арван мянган хүнийг төлөөлж ирээд, зарим нь дөрвөн мянган хүнийг төлөөлж ирээд Монгол улсын

2 сая иргэн яаж амьдрах тухай нийгмийн гэрээ, эсвэл хамтын гэрээ ч гэж хэлдэг тэр гэрээнд гарын үсэг зурахаар ирсэн улсуудаа Энхийгээ нэгдүгээрт ухаараачээ. Тийм учраас энд зөвхөн засаглалын тухай ярьдаггүй, энд тийм учраас хуулиудыг гаргах тэр үндсэн баримт бичигийн тухай ч ярьдаггүй, бид өнөөдөр хамтын гэрээ, нийгмийн гэрээ байгуулахаар ирсэн улсууд шүү. Тэгэхээр би ингэж бодож байна. Монголчууд үнэхээр хүнд бэрх үедээ Чимид даргын хэлж байснаас ч, сонин бичиг дээр гарснаас ч би ингэж ойлгож байсан. Монголчуудыг хүнд бэрх үедээ энэ хамтын гэрээгээ байгуулдаг байжээ. Тэр байгуулсан гэрээгээ Их цааз гэж нэрлэдэг байжээ. Гэтэл яагаад ч юм бэ энэ Их цааз гэдэг нэрийг нь зориуд Монголчуудаас жигшээхийн тулд сүүлд нь цаазаар авах ч ял ч юмуу ийм хэлбэрээр оруулчихажээ. Уг нь энэ монголчууд тэр Их цааз гэдэг нэрээ хэрэглэхдээ монголчууд тусгаар тогтнож яаж амьдрах вэ гэдэг хамтын гэрээгээ байгуулсан тэр нэрээ билэгшээж хэлсэн юм байжээ гэж би ойлгож байгаа юм. Тэгээд ч бид нар ер нь хэлдэг шүү дээ. Өнөөдөр халдашгүй дархан, тусгаар бүх юмаа бэхжүүлэхдээ бид нар дархан цаазтай гэж хэлдэг. Тэрнээс бол дархан цаазтай гэхээр очоод бугыг нь буудчих, амьтныг нь намначих гэж байгаа юм билээ. Харин битгий, тэр бол халдашгүй шүү гэж. Өнөөдөр бид тэр монголын халдашгүй бүхнийг энд томъёолж гаргаж ирэх гэж байна. Өнөөдөр бид 2 саяулаа хамтарч амьдрах тэр халдашгүй дархан эрхүүдээ томъёолж гаргах гэж гэрээ байгуулах гэж байна.

Тэгэхээр бид нар зүгээр үнэхээр уг сурвалж, нэр томъёогоо мартчихсанаасаа болоод магадгүй санаатайгаар тэр тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан тэр өвөг дээдэс үеэс зориуд дархан цаазалж гаргаж ирсэн тэр Их цаазыг минь тоглох гэж зориуд тэр нэр хүндийг нь унагах гэж цаазаар авах ял болгож хувиргасан байсныг нь өнөөдөр бид ойлгохгүй тэр улс төрийн тоглоомд нь яваад орчихсон байхвий. Тийм учраас энэ дээр үнэхээр тэр 61 онд хууль гаргахдаа цаазаар авсугай гэдэг нэр томъёог оруулсан хүн байвал энийг хэлчихмээр юмаа. Ямар учиртай оруулж ирсэн юм бэ төрийг гэдгийг. Тэгж байж бид нар ярихгүй бол болохгүй юм шиг байна.

Одоо микрофоны ард зогсож байгаа 5 хүний нэрийг авлаа. Ингээд энэ хүмүүсээр санал таслая.

301 дүгээр тойргийн депутат М.Жамсран: Тэгэхээр би Үндсэн хуулийн агуулгыг бодож цөөнхийн санал дээр үг хэлэх гэж байгаа юм. Энд Үндсэн хууль гэж хуучин хууль болбол яахав агуулгын хувьд үндэс ишлэлд тулгуур түшиг болох талаасаа нийтийн саналыг илэрхийлж байсан нь үнэн байхаа. Их цааз гэдгийн хувьд бол нэг л энэ хүнлэг энэрэнгүй нийгэм байгуулна гэж байгаа бидэнд чинь нэг л билэгдэлгүй л нэр болчихвий гэж эмээж байна. Их засаг гэдэг хуулийг би болбол яасан юм бэ гэдэг ийм санал байгаа юм. Би энэ нэгийг нь хэлэх гэж байна. Одоо төр засгийн шинэ тогтолцоо тогтож байгаа энэ үед бид нэгийг мэдэрдмээр байна. Ну гэхээр бид Үндсэн хуультай байхдаа энэ хуулийг чинь их зөрчдөг олон улс байсан, хуулиа зөрчдөг хуульчид олон байсан. Засаг төрийн тэргүүнүүдээс маань энэ хуулийг чинь хөсөрдүүлж, завхруулдаг байлаа. Тэгэхээр энэ төрийн хуульчдыг ч тэр, засаг төрийн удирдагч нарыг ч тэр нэг барьж байдаг даруулга, өөрөөр хэлбэл энэ олон депутатууд хэллээ. Бид нэг толгойтой байя гэж хэлээд байна. Тэгэхлээр энэ нэг толгойтой болж, ер нь засаг төрийн удирдагч нь бай, хуульчид нь ч бай, иргэд нь ч бай нэг захирагдаж байдаг нэг их засагтай байх нь зүйтэй юмуу гэж бодоод байна. Ийм л санал байна.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: Надад нэг ийм хэд хэдэн үндэслэлийг хэлье гэж бодсон юмаа. Нэгдүгээрт Үндсэн хууль, Их цааз гэдэг энэ хоёр нэрэнд хоёуланд нь сөв суучихлаа гэж би ингэж ойлгож байна. Ийм учраас сөв суучихлаа, бид их шүүмжиллээ, их ярьлаа, ер нь Их цааз гэдэг үгэнд нэлээд дээр үеэс нааш нэлээд хэдэн жил их сөв суужээ. Тэгэхээр Их засаг гэсэн энэ нэр илүү тохиромжтой юмаа гэж бодож байна. Чагаад би энэнийг сонгож авч байна вэ гэвэл ийм үндэслэл байгаа юмаа. Монголын нууц товчоо гэсэн тэр үгэн дотор хууль, төр гэсэн энэ үгийг засаг гэдэг үгээр төлөөлүүлж байсан яг тэнд иймэрхүү үгнүүд байгаа юм. Засаг өгүүлэх, засаглах, засаг давах, засаг хөндөх, засаг хөндөх гэдэг бол хууль зөрчих гэсэн

засгийнхаа эсрэг, тэр төрийнхөө эсрэг үйлдэл хийх гэсэн ийм утгыг агуулж байсан юм байгаа юмаа. Тэгэхээр энэ үгийг энд оруулах нь зөв юмаа гэж бодож байна. Дараачийн нэг зүйл бол энэ Их засаг, засаг гэдэг энэ уг, энэ ухагдахуун их Чингис хааны үед нэлээн гарч ирсэн. Энэ Чингис хаан гэдэг энэ сайхан нэрээ монголчууд бид хайрлах ёстой. Арилжаа наймаанд голдуу ашиглах болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ хүний нэрийг бид ямар нэгэн байдлаар мөнхжүүлбэ, үлдээе, энэ төрийг маань төвхнүүлсэн суут ухаантай энэ мэргэн хүний нэрийг, тэр өвөг дээдсийнхээ юмыг үлдээе гэх юм бол энэ Их засаг гэсэн тэр үеийнх нь хуулиар, тэр үеийнх нь ухагдахуунаар энэ их хуулиа нэрлэх юм бол болох нээ гэж ингэж бодож байгаа юмаа.

Дараачийн нэг зүйл дээр намайг эмзэглүүлсэн зүйл бол одоо Их засаг гээд нэрлэхээр хойцдоо будлина гэж ингээд байх юм. Би ердөөсөө ингэж ойлгохгүй байна. Бидний хойч үе бол биднээс илүү хэрсүү, магадгүй биднээс ч илүү ухаантай, биднээс илүү мэдээлэлтэй ийм улсууд байх байхаа. Эд бол хэзээ ч будилахгүй гэж ингэж бодож байна. Дараачийн нэг зүйл бол би хууль зөрчижээ гэж би бодохгүй, Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн бол би засгаа хөнджээ. Их засгаа хөндсөн байна. Их засаг хөндөгджээ. Би энэнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой, ял хүлээх ёстой гэж ингэж бодоход ердөөсөө болохгүй юм алгаа. Энэ дээр зүгээр хөнджээ гэдэг дээр би нэг юм хэлэх гэсэн юм. Үндсэн хууль гэсэн энэ хууль гарсны дараагаар монголын нийгмийн өнгө болсон мянга мянган сайхан хүмүүс энэ хуулийн нэрийн дор үрэгдэж байсан. Энэ хуулийг би тийм зуун мянгаараа, хоёр зуун мянгаараа үрэгдэж байсан энэ тоо өнөөдөр болтол гарахгүй байгаа. Тэгэхээр би ийм нэрээр энэ шинэ Монгол сэргэж байгаа үед хуулиа нэрлэж чадахгүй байгаа юмаа.

Дараачийн нэг зүйл болбол их хурал гэж байна, их засаг гэж байна. Энэ бүхэн хоорондоо их авцалдаатай зүйл юмаа гэж ингэж ойлгож байгаа. Ийм учраас Их засаг гэдгээрээ засаг дарга, засаглал, тэр гэдэг утга энэ дотроо явж байгаа гэж ойлгож байна. Ингээд Их засаг гэдэг энэ нэрний төлөө байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн
Бичээч

В. Ожун

ЭНХТУЯА
В. ОЖУН

Ш.Шагдарсүрэн/-283 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр би бол юу гэж ойлгож байна вэ гэхээр өнөөдөр юмыг нэрээр нэрлэх цаг ирсэн үе гэж бодож байгаа юм.Тэгээд үзэхээр оноосон нэр юманд хэрэгтэй гэж, аливаа нэг зүйлд бол.Эндээс нэг ингэж ойлгож байгаа юм.Тэгэхээр оноосон нэр хэрэгтэй гэдэг үүднээсээ цөөнх талд нь орж уг хэлэх гэж байгаа юм.

Тэгэхээр яахав зүгээр бидний энэ өнөөдрийн Үндсэн хууль гэж яриад байгаа уг маань бол гарцаа байхгүй түрүүн Дожоодорж гуай хэлж байсан основной закон гэсэн юмыг орчуулсан махчилсан уг мөн гэж би хувьдаа ойлгодог.Тэгэхдээ тэдний үндсэн хууль бол конституция гэж бичээд доор нь хаалтан дотор основной закон гэж хийсэн байдаг.Би бол ингэж санаж байна.Буруу байж болох юм.Тэгэхээр уг конституции гэсэн уг ямар гарал үүсэлтэй вэ гэхээр грек гарал үүсэлтэй юм гэнэ билээ, хамтран төр барих гэсэн ийм утгатай уг юм гэнэ билээ. Ер нь дэлхийд ихэнх тохиолдолд төр конституция гэсэн уг бол Испанид ч бай, Грект ч бай, Англи талдаа ч бай нэг ийм үндэстэй явдаг юм байна билээ.

Тэгэхээр бас бид орчуулаад нэгэнт ороод ирсэн учраас эргүүлээд орчуулах тухай бас яригдах ёстой байх гэж бодож байна.Манай Үндсэн хууль англи, орос бусад хэл дээр орчуулагдах л байх л даа.Тэр талыг нь бас ямарваа нэгэн зүйл дээр,орчуулган дээр юмны алдаа гарч ирдэг тал байдаг.Энэ талаас нь би хэлж байгаа юм шүү, уучлаарай.Тэгэхээр жишээлбэл бид Үндсэн хууль гэхихээд основной закон л гэж орчуулахаас өөр конституции гэж орчуулах боломж байхгүй юм шиг надад ойлгогдож байна.Энийг бодолцооч.Бид бол дэлхий ертөнцтэй хамтарч, цаашдаа хамт төр гэр бүлийн дотор явах гэж байгаа улсууд гэдгээ бодолцоод ингээд ойлгохгүй юу гэж хэлэх гэж байна.

Тэгэхээр бид энэ юуг хэлэлцэхэд үнэхээр олон талаас нь ярьж байгаа нь зүйтэй хэрэг.Гэхдээ бид өнөөдөр төр уламжлалт

ёсоо сэргээх гэж байгаа энэ цагт энэ нэрийг өөрчлөх ёстой. Өөрчлөх цаг үе бол өнөөдөр мөн. Ингэж ойлгож байна. Бид бүгд л уламжлалаа сэргээнэ, өнөөдөр монголын онцлогтой байна гэж ингэж ярьж байгаа. Энэнтэй ч гэсэн өнөөдөр нэрээ өөрчилж, оноосон нэр өгөх явдал бол монгол монголоороо өөрийн бодолтой явж байна гэсэн ойлголт төрүүлэх, бидний ярьж байгаа зүйлэнд үйл ажиллагаа маань нийцэх ёстой гэж үзэж байна.

Зүгээр Их цааз гэвэл хатуудчих байх гэж ингэж яриад байна. Ард түмний дунд бол яриад, энэ үнэн. Зүгээр харамсаж байгаа нэг зүйл бол бид өв уламжлалаасаа хэтэрхий салчихсанд байгаа юм уу даа гэж бодож байна. Өнөөдөр түүхэн талаас нь ч яг таг ингээд хэлээд өгчих ийм бололцоо бид нарт жилийн хугацаанд олдсонгүй. Бага хугацаа юм байна гэж би ингэж ойлгож байна.

Тэгэхээр энэ бүгдийг бодоод Их цааз гэдэг нэрээ өгч болох юмаа. Үнэхээр хатуугаар ойлгогдоод байж болох талтай, гэхдээ энэн дотор ч гэсэн сууж байгаа бид бүгд л хүмүүсийг сонсож байлаа хэдэн өдөр. Бид бүгд л ард түмнийг төлөөлж ирсэн гэж ингэж ярьж байгаа. Тэгэхдээ тодорхой хэсгийг төлөөлж яваа нь үнэн байх. Тэгэхдээ би бол тэгж хэлж чадахгүй. Гэхдээ ер нь энэн дотор ярьж байгаа хүмүүсээс хатуу гар хэрэгтэй гэж ингэж ярьж байгаа. Энэнтэй ямар нэг хэмжээгээр нийцэж байна гэж би ойлгож байна.

Төр өнөөдөр нэгэнт гарсан хуулиа биелүүлэх, биелүүлүүлэх, хэрэгжүүлэх ийм юмаа авч явах үүднээс ч гэсэн би энэнээс нэг их зөрөөд байгаа юм алга гэж бодож байна.

Гуравдугаарт, Их цааз гэж нэрлэчингүүтээ, дотор нь агуулга нь бол ухаандаа би л хувьдаа өнөөдрийнх шиг ийм хуулийг энэ яваа насандаа, өнөөдөр хүртэлх насандаа ийм хууль үзээгүй, төслийн нь хувьд, ардчилсан гэдэг талаас нь хэлж байна.

Тэгэхээр гол нь агуулгандaa байдаг байх гэж бодож байна.

Түүнээс тэр Их цааз гэж нэрлэчингүүтээ л бүгдээрэнгий нь цааш нь харуулчих юм шиг ингэж яриад байгаа нь их ойлгомжгүй байна гэж би хэлэх гэж байна. Ерөөсөө тэгж хэлэх гэж байна. Авхиа гуайн түрүүний хэлдэг тэр оноосон нэр үү, үгүй юу гэдэг дээр би шал өөр саналтай байна. Тэгвэл эхлээд энийгээ оноосон нэр мөн, биш дээр нь хүртэл ярих болох гэж байна шүү дээ.

Б.Лханаасүрэн /191 дүгээр тойргийн депутат/ –Тэгэхээр бид энэ Их цаазынхаа төсөлд хоёрдугаар хуудасны гуравдугаар мөрөнд зураас татаж байгаад ингэж бичиж байгаа. Төр ёс түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж гэж, тэгэхээр энийг ингэж өвлөө гэж байгаа бол, бид энэ нэрнээсээ эхлэж өвлөж авах асуудлаа эхлэх нь зүйтэй юм гэж үзэж байна. Яагаад Үндсэн хууль гэж нэр өгөх асуудлаас би татгалзаж байна вэ гэхээр энэ уг хүмүүс ярьчих шиг боллоо. 1924 онд ЗХУ-ын основной закон гэдгийн орчуулга. Конституция гэдэг чинь конституционной гэсэн грек байна уу, итали гаралтай уг. Энэ бол орос уг биш. Яагаад Зөвлөлт хаалтан дотор основной закон гэж бичиж байна вэ гэхээр энэ бол оноосон нэр. Тийм учраас энэн дээр бид хэрэв түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж хадгалъя гэж бодож байгаа бол бид энэ нэрнээсээ эхлэж манай өвөг дээдсийн хэдэн үеийн туршид өвлөж ирсэн энэ нэрнээс эх авъя.

Их цааз гэдэг уг эмзэглэл төрүүлээд байгаа бол Их засаг хууль гэж бичээд хаалтан дотор Үндсэн хууль гэж бичиж болно. Монгол улсын Их засаг хууль. Энийг ард түмэн хүлээж авна гэж бодож байна. Тэгэхээр энэ Их засаг гэдэг уг бол түрүүн хүмүүс ярилаа. Энэ бол монголын 2200 гаруй тусгаар төрийн энэ түүхэнд энэ уг бол байсан, ийм хууль байсан. Эрдэмтэн, мэргэдийн бичсэнээр, миний уншиж үзсэнээр Чингисийн дараахь өөрийн нь угсааны 37 хаан ийм нэртэй хууль байсан байна. Гэхдээ тэр хууль нь олддоогүй боловч түүхийн ном сударт бичигдэж үлдсэн. Энэ бол нууц товчооноос эхлээд. Тийм учраас эрхэм депутатуудад би юу гэж хэлье гэхээр Их засаг хууль гэдэг нэрээр нэрлээд энэ бол утга агуулгаараа дотор нь бичигдсэн юм бол маш сайхан

4.

тохирно.Тэгээд шаардлагатай бол Үндсэн хууль гээд ард нь хаалтан дотор биччихье, зөвлөлтийг дуурайгаад.Энийг бол хүлээж аваач гэсэн ийм санал байна.Энэ бол манай тулгуур хууль.Оноосон нэр өгөх нь зүйтэй.

П.Мөнхдорж /21 дүгээр тойргийн депутат/ -Үндсэн хуулийн төсөлд оноосон нэр өгөх талд нь байна.Тэгэхдээ дараахь саналыг хэлмээр байна.

Бид өнөөдөр түүхийн гүн рүү хэтэрхий туйлширч бас таарахгүй.Өнөөдрийн соёл, иргэншлийн түвшингээ бас бодолцох ёстой болов уу гэж бодож байна.Ингээд алах цаазлах, засаглах захиргаадах гэсэн агуулгаас зайлсхийж ерөөсөө Их хууль гээд нэрлэчихвэл ард түмэн хүлээж авах юм биш үү гэж бодож байна.

Д.Чойжамц /153 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр оноосон нэр, ерөнхий нэр гэдэг хэлбэрээр томъёолол гаргаж санал хураасан маань миний хувьд буруу боллоо гэж бодож байна.Тийм ч учраас эргээд санал шүүмжлэл нөгөө маргаандаа орчихлоо.Ийм учраас энэ саналыг таслан зогсоогоод шууд нэрээр санал хураах шаардлагатай гэж бодож байна.

Түрүүчийн тэр томъёололд бол цаад талд нь бас учир байна.Энийг бид илэрхий ингэж зохион байгуулж болохгүй байх гэж би ингэж бодож байна.

Д.Дүйсэсанги /103 дугаар тойргийн депутат/ -Хурлын даргад санал хэлмээр байна.Би өчигдрөөс хойш саналаа өгөх гээд чадаагүй.Миний өмнө нэрээ өгсөн, миний хойно нэрээ өгсөн хүн өчигдөр миний өмнө санал шүүмжлэлээ хэлж байгаа байна билээ.Тэгэхээр би өнөөдөр сая өөрийнхөө саналыг яг холбогдсон асуудал дээр хэлмээр санагдаад байна.

Ж.Уртнасан -Уучлаарай, танд хүндэтгэл үзүүлье.Та тойргийн дугаар, нэрээ хэлээд саналаа хэлнэ үү.

Д. Дүйсэсанги –Тэгэхээр би энэ Үндсэн хууль дээр ч гэсэн, Их цааз дээр ч гэсэн, засаглал дээр ч гэсэн надад санал нийлэхгүй асуудлууд их байгаа юм. Тухайлбал, хаант засгийн үг томъёолол нь одоо парламентын засаглал байгуулж байгаа бид нар хэрэгжүүлэх гээд байгаа юм шиг надад санагдаад болохгүй юм. Энийг миний сэтгэлд таарсан юу хүн хэлэхгүй байх шиг байгаа юм.

Нөгөө талаар энэ үндэс гэдэг үгийг чинь гадаад үг гээд зарим нь тэгж байх юм. Тэгвэл би монгол хүн ургамлын үндсийг юу гэсэн монголоор хэлдэг юм бэ гэж үг асуумаар байгаа юм. Өрөөсөө огт болохгүй, хэлмээр үг гарч ирээд байх юм.

Тухайлбал, энэ нийгэм, төр чинь тухайн үедээ түүх гэж яриад байна, түүх нийгэм үеэ өнгөрөөдөг байх гэсэн тийм уламжлал байх гэж бодож байна. Урд хаант засагт ч бай, Чингисийн үед ч бай, за энэ манай ардчилсан 70 жилийн үед үеэ, түүхээ өнгөрөөснийг үгүйсгэхгүй, би энийг үнэн, энэ шинэ төрийн тогтолцоо гарч ирээд жил гаруйхан болж байгаа үед би үгүйсгэхгүй, болсон гэдгийг баталж байгаа хүний нэг байгаа юм.

Тэгэхдээ энэ үндэс гэдэг үгнээс жигшээд байна гэсэн сэтгэл байна гэж би олонхийн санал болсон ч гэсэн энийг бас хамгаалах гэж бодоод байгаа юм, өөрийнхөө тайлбараа. Жишээлбэл, үндэс гэдгийг ерөнхий томъёо гэж хэлж байна, би бол энийг ерөнхий үг гэж байна, энийг бол томъёолсон, мөн онож хэлэх нэг үг гэж хэлмээр байна. Их гэсэн, үндэс гэсэн ялгаагүй гэж бодож байна. Засаг гэсэн, төр гэсэн хоёр ялгаагүй гэж бодож байна. Жишээлбэл, төр хууль гээд гаргавал, их төр хууль гэсэн, их засаг хууль гэсэн нь ижил ойлголт гэж би бодож байна.

Ингэхээр би энэ Үндсэн хууль гэдгийг ер нь ерөнхий нэр биш, Үндсэн хууль хэдийгээр удсан нэр боловч үеэ өнгөрөөгөөгүй, өөрөөр хэлбэл үлдэх нэр, Үндсэн хууль хэвээрээ

байна гэсэн өөрийнхөө саналыг баталж хэлэх гээд, бодогдоод байна.

Ж.Уртнасан -За баярлалаа.Дэгийн дагуу завсарлах цаг болж байна.Хоёр зарлал байна.

Ардчилсан эвсэл бүлэгт орсон, мөн орох хүсэлтэй депутатууд өнөөдөр 14.30 цагт хоёрдугаар давхрын "А" танхимд цугларна уу.Барсболд гэж зарласан байна.

Ардчилсан эвсэл бүлэг.

Үдийн хоолны дараа 13.30 цагт МАХН-ын бүлгийн ажлагч нар 301 дүгээр өрөөнд цугларна уу гэсэн ийм зарлал ирсэн байна.

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Саналаа хураачихаад таръя.Одоо сая дууссан шүү дээ.

Ж.Уртнасан -За дэгийн дагуу завсарлая.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

А.Ийсанов

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.18
Кассет III-40
15.02-15.16

Ж.Уртнасан: Депутат нөхдийн өдрийн амгаланг айлтгая.
Хуралдаанаа үргэлжлүүлье.

Та бидэнд энэ техникийн хэсгээс зайлшгүй сануулж өгөөч гэсэн жижигхэн зурвас ирснийг та бүхний анхааралд толилуулья. Компьютерийн коноп өөрөөр хэлбэл бидний дардаг гарыг дарахдаа заавал өлгөж байна уу? утас мушгирч коноп эвдэрч, зарим компьютерийн гарууд энэ маань ажлаас гарч байна. Ийм учраас ариг гамтай хандана уу? гэсэн ийм сануулга ирж байна. 4,5 гар эвдэрснийг техникийн хэсгийнхэн сая сольж ажиллагаанд оруулжээ.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Сая бид санал солилцсон. Хуулийн оноосон нэр дээр ярьсан. Одоогийн байдлаар та бидний тогтоод байгаа юм хоёр нэр. Их цааз гэдэг бол үндсэн төсөл дээр байгаа нэр. Хажуугийн санал гэж авч үзэх юм бол Засаг хууль, Үндсэн хууль гэсэн ийм хоёр нэр дээр ярим болж байна. Ийм учраас санал хураалтанд бэлтгэнэ үү.

Анхаараарай, санал хураах томъёоллыг өгье. Бидэнд ирсэн олонхи саналаар бол хажуугийн саналын олонхи нь Их засаг, гэсэн оноосон нэр дээр санал хураалт явуулж байна.

Саналын дүнг танилцуулъя. Ирцийн 384 депутат саналаа өгсний 90 хувийн ирцтэй байна гэж ойлгож байна. Дахин шалгах уу? За баярлалаа. Олонхи депутатууд техникаэ шалгахын тулд эхлээд ирцээ нэг авъя гэж байна. Энэ зөв байж магадгүй. Ирц бүртгэж эхэллээ.

За баярлалаа. Ирц 401 хүн байна. Зарим хүмүүс яарч сандраад товчоо дарж чадаагүй байж болох юм. Одоо томъёоллыг дахин сануулъя. Зарим хүмүүс томъёоллоо сайн ойлгосонгүй гэсэн ийм санал ирж байна. Тэгэхээр хуулийн оноосон нэр Их засаг гэдэг дээр санал хураалт явуулж байна. Анхаараарай, Их засаг.

Уучлаарай, депутат нөхөд өө! та бидний буруугаас биш шиг байна. Техник гажигтай байж болох юм. Гуравдахь саналаа хураал-галаа гэж зэмлэхгүй байх гэж бодож байна. Томъёоллоо бид өөрч-лөхгүй, анхааралтай байна уу? Хуулийн оноосон нэрийг Их засаг гэдэг дээр дахин санал хураалт явуулж байна.

За баярлалаа. Одоо хажуугийн саналын хоёр дахь хувилбар хуулийн оноосон нэрийг Үндсэн хууль гэж томъёолж байна. Их цааз бол үндсэн хувибар шүү дээ. Тэр хэвээрээ үлдэж байгаа. Тэр бол бидний хэлэлцэж байгаа асуудал. Хажуугийн саналуу-даар санал хураалт явуулах ёстой. Үүнийг та бүхэн бас ойлгох байх. Анхаараарай, Үндсэн хуулийн оноосон Үндсэн хууль гэдэг дээр санал хураалт явуулъя.

Хэлэлцэж байгаа хуулийнхаа төслийг Үндсэн хууль гэж нэр-лээ гэсэн хүн 68 хувь^{ийн} буюу 270 депутат Үндсэн хууль гэж нэрлээ гэж байна. 110 хүн буюу 28 хувь нь татгалзлаа, 18 хүн түдгэлзсэн байна. Энэ дашрамд дахин хэлэхэд ард түмний санал хураалтаар Их цааз гэдэгт 68 санал, Үндсэн хуульд 294 санал ирснийг та бүхэнд бас дахин сонордуулъя. Одоо цөөнхийн саналыг сонсьё.

Уучлаарай, би алдаа гаргаж байх шиг байна. Манай нөхдүүд хуулийн зөвлөх сануулж байна. Тэгэхээр бид Үндсэн санал дээрээ санал хураалт явуулалгүйгээр бас цаашаа явж болмооргүй юм шиг байна. Тийм учраас санал хураалтанд бэлтгэнэ үү. Их цааз буюу манай Бага Хурлын та бидэнд өргөн барьсан үндсэн санал дээр санал хураалт явуулъя. Хуулийн оноосон нэр Их цааз. Санал хураалтанд бэлтгэнэ үү?

Цөөнхийн саналыг сонсьё. Микрофоны дарааллаар явъя. П микрофон.

56 дугаар тойргийн депутат Р. Гончигдорж:

Би цөөнхийн санал бишээ. Би энэ Их Хурлын явж байгаа аргач-лал дээр Бага Хурлыг нэг жил удирдсан, юм хэлмээр байна.

3.

Ерөөсөө ингэж яваад байх юм бол бид нар ерөөсөө болохгүй шүү. Нэгдүгээрт, эхлээд бид оноосон нэр өгөх үү, оноосон нэр өгөхгүй юу гэдэг дээр санал хурааж цөөнх болчихоод, тэгээд ярьсныхаа дараагаар оноосон нэрийг нь хоёр задлаар санал хурааж болдог юм уу? Болохгүй шүү дээ. Цөөнх чинь юуны төлөө байна вэ гэхээр оноосон нэртэй байх уу? эсвэл Үндсэн хууль нэртэй байх уу гэдэг дээрээ санал хурааж явчихаад, тэгээд түүний дараагаар яг л тэр саналаа тогтох ёстой шүү дээ. Цөөнхийг сонссоны дараагаар, цөөнхийг сонслоо, олонхи бол түрүүн оноосон нэр өгье гэдэг цөөнх байсан учраас одоо ингээд оноосон нэр өгөх үү, үгүй юу гэдэг дээр дахиад санал хураах ёстой л доо. Тэгээд дараагаар тэр нь ахиад цөөнх болох юм бол тэгээд оноосон нэр өгөхгүй гэлээ, өөрөөр хэлбэл цаана нь Үндсэн хууль үлдлээ тэгээд л болчихлоо. Тэгээгүй, оноосон нэр нь олонхи болчих юм бол, оноосон нэр дотроосоо шүүх ёстой байхгүй юу? тэгэхгүй бол бид нар 3 юман дээр хураахад хүн ийм гурван юмны нэгийг сонгож авна шүү дээ. Тэгэхээр зэрэг санал чинь гурав хуваагдаж яригдахаас биш, 3 хуваагдахад олонхийн тухай ярьдаггүй шүү дээ. Тийм учраас би аргачлалынх хувьд эрхэм Их Хурлын даргад хэлэх гэсэн юм. Ийм юман дээр чинь бас аргачлалыг нь зөвлөж, заримдаа ийм юмыг нь хэлмээр байна шүү дээ. Түүнээс цөөнх болж байгаадаа гомдох юм ерөөсөө байхгүй. Тийм учраас үнэн хэрэг дээрээ Их засаг гэж нэрлэх, Их цааз гэж нэрлэх, Их хууль гэж нэрлэх энэ болгон маань нийлээд оноосон нэр өгье гэдэг санал юм.

Үндсэн хууль гэдэг маань нөгөө талд нь байж байгаа шүү- дээ. Ингэж юмыг дандаа хоёр хуваагаад саналаа аваад байхгүй бол юмыг дандаа хоёр хуваагаад санал аваад байхгүй бол ерөөсөө болдоггүй.

148 дугаар тойргийн депутат Д. Баттулга: Цөөнхийг төлөөлж хэлье. Тэгэхдээ би магадгүй зарчмын шинэ шалгуур ч гэдэг юм уу? томъёолол ч гэдэг юм уу? үндэслэл ч гэдэг юм уу тийм юм гаргаж чадахгүй. Түрүүн гаргадаг бүхнийг гаргасан.

Тэгэхдээ би энд депутатуудад нэг л юм хэлмээр байна. Юу вэ гэхээр Үндсэн хуулийн оноосон нэрийг Үндсэн хуулиа гэж санал авч байгаа дээр ингэж дийлэнх олонхи нь гэхэд би гайхаж байна. Юу вэ гэхээр Үндсэн хуулийн оноосон нэр, Үндсэн хууль шүү гээд дийлэнх 68 хувийн саналаар баталчихаар гадна бид нар хүмүүсийн шоог, инээдийг хургэнэ. Энэ бол бид депутатууд. Тэгвэл үүний оронд Үндсэн хуулиндаа оноосон нэр өгөхөө больё, Үндсэн хууль чигээрээ байж байг гэвэлнэг өөр хэрэг. Энэ чинь бид саналыг юун дээр яаж өгөх вэ? яаж авах вэ гэдэг дээр бас бодмоор байна шүү дээ. Эндээс гарч байгаа шийдвэр чинь бас тийм үндэслэлтэй, маш их хуулийн үндэслэлтэй байх хэрэгтэй байна. Түүнээс ерөөсөө одоо нэг төрөөгүй хүүхдэд, хүүхэд гэсэн нэр өгмөөр биш. Бид нар түүнийг.

Хоёрдугаарт, энэ дээр оноосон нэрэндээ байх уу? үгүй юу? гэдэг. Түүн Гончигдорж дарга хэлсэн. Оноосон нэрэндээ байх уу? үгүй юу гэдэг дээр санал аваад, түүнийхээ дагуу ярих ёстой байна. Сүүлд нь тэр нь юу ч үгүй болоод, тэгээд Үндсэн хууль маань өөрөө оноосон нэр юмаа гэсэн тийм юм гаргаж ирж байна гэдэг дээр


Бид ямар ч нэр өглөө гэсэн, яасан ч гэсэн Үндсэн хууль байдгаараа л байна. Үүнийг бол хэн ч үгүйсгээгүй. Үндсэн хуулийг хэн ч үгүйсгээгүй.

Гуравдугаарт нь би энэ ард түмний санал гэдэг дээр энэ ард түмний өгсөн саналыг хүндэлж байна, ойлгож байна. Хүмүүс, ард түмний дунд хэлэлцүүлээд санал авсан. Саналаа өгсөн тэр хүмүүсийг би хувьдаа, депутатын хувьд үнэхээр хүндэтгэж байгаагаа илэрхийлэхийн ялдамд энэ 500 хүний саналыг авчихаад энэ ард түмний санал шүү гэж хэлэх чинь учир дутагдалтай гэдгийг хэлмээр байна. Юу вэ гэхээр Үндсэн хууль, ямарваа хүний чинь мөн чанар тийм байдаг шүү дээ. Эсэргүүцэж байгаа юманд аа маш их эмоц өгдөг, энэ дээр би бол үүнийг эсэргүүцэж байгаа гэдэг чинь тэр хүн юмаа бичнэ, юмаа тайлбарлана, тэр рүү маш их санал ирдэг гэдгийг бид бас ойлгох хэрэгтэй шүү.

5.

Тийм учраас ард түмний санал гэдэг дээр бид ухаалаг хандах хэрэгтэй байх.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.18.
Кассет № III-4I
15.16-15.32

Тангад 297-р тойргийн депутат -Хурлын даргаас нэг зүйлийг хүсмээр байна. Үүнийг протоколд бичмээр байна. Процедурын ажиллагаа буруу явагдаад, хурлын дэг өөрчигдөөд байна. Хурал түрүүнд санал хурааж болох байсан, 6 минутын өмнө завсарласан. Энэ нь мөн л нэг зөрчил. Хэрэв тэр үед нь санал хураасан бол хүмүүсийн санал нь яах ч байсан билээ. Их завсарлагааны дараа санал явагдаж байна. Нөгөө талаар түрүүнд санал хураахад оноосон нэр өгөхүү, үгүй юу гэдэг асуудал дээр санал хураагаад, энд би санал гаргасан юм. Би тэхдээ оноосон нэрийг байх ёстойн тухай ярьсан болохоос биш, ямар оноосон нэр өгөх үү гэдэгт би санал хэлээгүй байсан. Тэхээр процедур зөрчигдөөд байна шүү дээ. Хэрвээ оноосон нэр өгөгдөх тухай ярилцлага явагдвал би оноосон нэрийнхээ талаар ярих байсан. Жишээ нь манай шинэ төр, шинэ тогтолцооны нэр өгөхтэй байх нь зайлшгүй чухал байна. Ялангуяа үүн дээр Үндсэн хуудийн Их цаазын төслийн тухай Ерөнхийлөгчийн илтгэлд бид ямар журам, зарчим, үзэл баримтлалаар шинэ Их цаазын төслийг гаргаж ирсэн юм бэ гэдгийг ярьсан байгаа шүү дээ. Тэхээр бид оноосон нэрээ зөв сонгож авах хэрэгтэй. Миний бодлоор бол Монгол улс чинь бидний амьдарч байгаа орон нутаг дээр 800 шахам жилийн өмнө нэгдсэн Монгол улс байгуулагджээ. Жижиг, тархай бутархай хаана л нэг улсуудын. Энэ хүн хэн бэ гэвэл эзэн богд Чингис хаан. Бид энэ аугаа их хүний төрсний 830 жилийн ойг тэмдэглэхээр дурсгалт, буянтай үйлс бүтээхээр шийдчихээд байна. Хөшөө дурсгалын суурийг тавина гэж шийдээд байна.

Депутатууд, нөхдүүд минь одоо хоёрдахь дурсгалаа бид хиймээр байна. Өөрөөр хэлбэл эзэн богд Чингис хааныг нэгдсэн Монгол улс байгуулсны тулгуур гэл хууль нь Их цаасат хууль байсан. Энэ тухай түүхийн сурвалжид олон бичсэн байдаг. Харасмалтай нь эзэн богд Чингис хааны тухай түүхийн сурвалж бичиг Монголд байхгүй байсан. Одоо түрүүч нь эхлэж

2.

гарч байна. Та нөхөд уншсан байх, Чингис хааны цадиг гэсэн сайхан ном бичигдсэн, үүнийг Монгол улсын алдартай эрдэмтэн, түүхч Ш.Нацагдорж гуай бичсэн байгаа юм. Тэр зохиолд Их засаг гэдэг нь эзэн болд Чингис хааны төрийн тулгуур үндсэн хууль байсан гэдгийг тодорхой бичсэн байгаа шүү дээ. Энэ нь олон төрлийн түүхийн сурвалж бичиг, мөн гадаадын олон орнуудын тэр үеийн сурвалж бичгүүдээс авч дүгнэлт хийж бичсэн нотолгоо байгаа юм. Тэхээр бид анхны **нэгдсэн** Монгол улсын төрийн тулгуур эх бичгийн нэр Их засаг гэсэн нэрийг өгчихвөл бид одоо хуучин тогтолцооноосоо арай гэж салаад, шинэ Монгол, шинэ төрийн тогтолцоо, шинэ эдийн засгийн тогтолцоо байгуулж байгаа энэ сайхан тулгуур хуулийн нэр нь үнэхээр өнөөдөр нэр байна шүү дээ нөхөд минь. Та нөхөд үүнийг эргэцүүлж бодооч дээ.

Тийм учраас би юу гэж санал болгож байна вэ гэвэл Их засаг гэсэн хуулийн нэрийг хүлээж авах нь ард түмний таашаалд нийцнэ шүү. Би Баттулгын саяны ярьсан саналыг дэмжиж байна. Их цаазын төслийн талаар өгсөн санал нь нийт ард түмний бүх сонгогчдын санал бий шүү. Идэвх, зүтгэл гаргасан нэг хэсэг хүмүүсийн санал байгаа юм. Цаана нь дуугуй, Их цааз гэсэн нэрийг зөвшөөрчихөөд байгаа, санал өгөөгүй өдий, төдий хүн бий шүү.

Ц.Элбэгдорж/427-р тойргийн депутат/ -Үг хэлэхээс өмнө нэг зүйлийг хэлэхгүй бол болохгүй байна. Хэрэв бид зарчимтай, дэгтэйгээ явъя гэж байгаа бол 5 минутын өмнө та шавдуулж байгаад 5 хүн микрофон дээр зогсож байна гээд хэлүүлээд санал хураалгах ёстой байсан. Би санал хураалгах гээд шавдуулж байна гэж ойлгосон. Гэтэл 5 минутын өмнө завсарлуулсан. 5 минутын өмнө хүмүүсийн ярьсан бүх яриа, үндэслэл энэ хоёр цагийн хооронд алга болсон. Хоол идэх хооронд бүгд алга болсон. Би депутатын хувьд үүнд эсэргүүцэл илэрхийлж байна. Хурлын дарга, удирдлагуудад, яагаад санал хураалгаагүй бэ? Би түрүүнийхээ үндэслэлийг дахин унших шаардлагатай юу? Би хоёр, гурван зүйлийг хэлье гэж бодож байна.

3.

Үндсэн хууль гэдэг дээр сэв суусан. Их цааз гэдэг дээр сэв суусан. Нэг хэсэг нь Үндсэн хууль гэж батлаж магадгүй, нөгөө хэсэг нь хүлээж авахгүй л болно. Их Хурлаас батласан юм гээд хүлээж авна л биз. Бид хоёр гол зүйлийг бодох ёстой шүү дээ. Бид энэ хуулиа настай хууль гаргая гэж бодох юм бол хэрвээ Үндсэн хууль гэдгээр гараад, дотор нь нэлээд олон зүйл өөрчлөгдвөл биднийг байхад дахин өөрчлөгдөх цаг ирэх байх, өөр хүмүүс өөрчлөх байх гэж би бодож байна.

Дараагийн зүйл гэвэл эсэргүүцсэн нь санал ирүүлээгүй. Их цааз гэж нэрлэе гэж бодож байсан, Үндсэн хууль, Их цааз гэж нэрлэхгүй гэж эсэргүүцэж байсан 500 хүнээс ч санал өөрөөр ирүүлсэн юм бил үү. Ард талд байгаа I сая гаруй монголчууд Их цааз гэдгийг зөвшөөрч байсан байж болно шүү дээ. Мөн Их засаг гэдгийг ч зөвшөөрч байсан байж болно. Үндсэн хууль гэдэг нэр нь ямар ч байсан солигдох юм байна гэж та бидэнд найдаж, итгэсэн байж болно шүү дээ.

Дараагийн зүйл гэвэл Чингис хаанд хөшөө босгож, тэмдэг хийнэ гэж байна. Тэгснээрээ бид Чингис хаан, эцэг, өвгөд, дээдсийнхээ уламжлал, тэр бүх зүйлийг хадгалаж, өвлөж үлдээж байгаа юм биш ээ, нэг хөшөө бостосноороо. Харин тэр үед байсан хууль, төрийн ухаан, тэр бүх зүйлийг хууль, нэрнээс нь авахуулаад, Их засаг гэж нэрнээс нь авахуулаад хийж өгвөл жинхэнэ хөшөө, уламжлал нь бидний түүх рүүгээ эргэж харах юм болох байх аа.

Дараагийн зүйл Үндсэн хууль гэсэн нэр дор монголын ард түмний сор болсон, зуу, мянгаараа сайхан хөвгүүд ал агдсан. Энэ нэрний дор тэд хэлмэгдэж байсан. Энэ хууль хэзээ ч биелэгддэггүй байсан. Тэнд хүний эрхийн тухай тодорхой заалтууд байхд тэр нь биелэгддэггүй байсан. Би тэдний гавьяаг доромжлохыг хүсэхгүй байна. Үндсэн хууль гэдэг нэрийн дор дахин хэдэн зуун хүнийг хэлмэгдүүлэхийг хүсэхгүй байна.

Тэд энэ хуулийн нэрэн дор 1924 оноос хэлмэгдсэн. Хэлмэгдлийн он нь 1924 оноос гарсан юм, би үүнийг ямар нэгэн намтай, ямар нэгэн зүйлтэй холбоод байгаа юм биш ээ. Гадна, дотноос тулгасан түүхийн эмгэнэлээсээ бид салвал салая, салахгүй бол хоёрын хооронд ингэж салаад яах юм бэ? Дахин 5 жилийн дараагаар Их цааз ч юм уу, Их засаг ч гэсэн хууль гаргах шаардлагатай болох байх.

эрхэм

Дараагийн үг Их засаг гэсэн үг, соёмбо гэсэн үг өнөөдөртөө сөвтзэгүй байгаа. Энэ хоёр үгийг битгий сөвтээгээ чээ. Магадгүй соёмбо, сүлдэндээ үлдэх байх, үүний төлөө бид явах байх. Их засаг гэсэн үгийг битгий олон талаас нь шүүмжилж, сөв суулгаа чээ. Сөв суулгаж чадахгүй байх гэж би бодож байна. Сөв суугаагүй энэ сайхан үгээрээ хуулиа нэрлэе л дээ.

9-р тойргийн депутат С.Зориг —Эрхэм депутатуудад цөөнхийн саналыг хоёр, гурван үндэслэлээр гаргая гэж байгаа юм. Би Их цааз гэсэн томъёоллыг дэмжиж байна. Гол шалтгаан нь гэвэл Үндсэн хууль гэсэн нэрийг бид 1924 оноос эхлэж хэрэглэсэн. Түүнээс өмнө тийм тулгуур Үндсэн хууль гэсэн баримт бичиг байгаагүй. Тийм учраас шинэ нэр томъёог гол нь тэр үеийн манай эрдэмтэд, мэргэд бусад орны туршлагаас хараад, мөн гол нь ЗХУ тулгуурлаж хийсэн 21 оны хувьсгал байгаа юм. Тийм учраас тэднийхийг гол нь орчуулсан байх. Орос үгэнд Конституция гэсэн үг юм гарлаас орж ирсэн үг юм. Тийм учраас орос хэлэн дээр орчуулахдаа Основной закон гэж орчуулсан. Тэр нь монгол хэл дээр буухдаа Үндсэн хууль гэж бууж байгаа юм. Тийм учраас би Үндсэн хууль гэсэн үгийг юу гэж ойлгож байна вэ гэхээр 1924 онд орж ирсэн орчуулгын нэр томъёо байна. Тэхээр бид үүнийгээ аваад үлдвэл цаашдаа орчуулгын Монгол хэлээрээ өөрийнхээ гол баримт бичгүүдийг томъёолдог тэр хандаагыг үргэлжлүүлсэн, 70 жилийн заншил одоо хүртэл тасраагүй үргэлжилж байна гэсэн ойлголт төрж магадгүй.

Хоёрдугаарт Содном гуай ярьж байсан, Их цааз гэсэн асуудал нь салбар хуулиудыг томъёолсон зүйл байсан гэж байна. Тэхээр

би Содном гуайд нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Янз бүрийн орны Үндсэн хуулиуд өөр өөр байдаг. Жишээ нь Их Британи, Умарт Ирландын нэгдсэн вант улсын үндсэн хууль нь Үндсэн хууль гэж заасан баримт бичиг байхгүй. Хэд, хэдэн хуулиудаас нэгтгэж бүрдсэн голдуу акт гэсэн нэрээр явдаг зүйл байгаа юм.

Бусад гол харилцаанууд нь тухайн орны уламжлал, зан заншлаараа зохицуулагддаг. Тийм учраас тэр үеийн засаглалын үед гол харилцаанууд нь феодалын үеийн хаант засаглалаараа зохицуулагддаг байсан учраас тэр цаашдын зохицуулалтанд ороогүй зүйлүүдийг Их цааздаа багтаахыг оролдсон байгаа юм.

Их засаг гэж нэрлэх нь юугаараа боломжгүй байна вэ гэхээр нэгдүгээрт явцуурах утга гараад байна. Манай нийгмийн харилцаа нь зөвхөн улс төрийн харилцаа биш, мөн нийгэм бүлэгүүдийн хоорондын харилцаа, гэр бүлийн харилцаа, эдийн засгийн харилцаа, энэ бүх зүйлүүд байдаг. Их засаг гэж нэрлэх тохиолдолд зөвхөн улс төрийн харилцааг зохицуулсан ийм баримт бичиг мэтээр ойлгогдож магадгүй байна.

Хоёрдугаарт түүхэн баримтаар Их засаг гэдэг зүйл нь нотлогдоогүйг түрүүнд Чимид гуай сануулсан. Тийм учраас бид ийм байдалд орох гээд байна. Бид алмас гэдэг нэрийг их дуулсан, түүнийг дуулсантай адилхан нэг хүнийг алмастай дүрслэж байгаатой адилхан байгаа юм. Алмас гэдэг нь нэг нь сармагчнаас гарсан гэдэг, нөгөө нь сармагчин биш өөр гаригаас бууж ирээд уруу шатан дахь үед нь орчихсон юм гэж дүрслэж байгаатай адилхан байдалд орох гээд байна.

Дөрөвдүгээр үндэслэл юу бэ гэхээр түрүүнд Их Хурлын дарга Уртнасан гуай хэлчихсэн. Энэ нь формальлогикийн төвшинд тафтология гэж нэрлэдэг. Үндсэн хуулиа Үндсэн хууль гэж нэрлэхээр санал хураая гэж, тэр нь юу гэхээр оноосон нэр биш гэж нотлож байгаа логик зүйл байгаа юм.

Тавдугаар асуудал нь юу бэ гэхээр түрүүнд Их Хурлын дарга алдчих шиг боллоо. Ард түмний санал, асуулгаар Үндсэн

хууль гэдгийг зөвнөөрсөн гэсэн. Ард түмний санал асуулгыг бид явуулаагүй. Үүнийг бүх ард түмэнд нэрийг нь заагаад, томъёолоод, бүх нийтийн санал асуулга явуулахыг хэлдэг. Юу гэхээр сонин, сэтгүүл дээр саналаа илэрхийлэхийг уриалсан, түүний дагуу 500-гаад хүн байна уу, 500 хүний санал болохоос биш бүх нийтийн санал, асуулгууд явуулаагүй юм аа. Их цааз гэсэн нэрийг нэгэнт оноочихсон болохоор түүнийг дэмжиж байгаа хүмүүс захиа бичихгүй, захиа бичиг байгаа хүмүүс нь голдуу өөр нэр өгөх саналтай хүмүүс нь захиагаа явуулсан.

Эцсийн асуудал нь бид уламжлал сэргээх асуудлыг нэлээд ярьж байна. Энэ асуудлыг ярих нь гол нь хувцасыг өмсөх асуудал биш ээ. Үгүй бол гэрээ бариад, гэртээ амьдрах нь гол нь биш юм. Хамгийн их удаан уламжлагддаг зүйл маань бидний окуны өв байгаа юм. Тиймээс бид тунгуур хуулиа хэлэлцэхдээ окуны өвийг сэргээх асуудал дээр илүү анхаарах нь зүйтэй. Тэгвэл өөрийн ард түмэн, түүхийн өмнө, өвөг дээдсийнхээ өмнө бид үүргээ гүйцэтгэж байна гэж ойлгож болох байх аа.

С.Баярцогт /288-р тойргийн депутат/ -Би хүмүүсийн үндэслэлийг давтахгүйгээр өөрийнхээ саналыг хэлбэ гэж бодож байна. Нэгдүгээрт хурлын даргад процедурын хувьд алдаа гаргасныг сануулъя. Хоёрдугаарт хурлын дарга нь ямар нэгэн тодорхой бодлого бариад, асуудалдаа хандаад байна уу гэсэн субъектив дүгнэлтэнд хүргэж байна. Үүн дээр анхаарна биз.

Би өөрийнхээ саналыг хэлэхийн тулд жижиг юмнаас эхлээ гэж бодож байна. Манай улс жижигхэн улс юм. Ийм улс гэдэг нь өөрийн хэл соёл, түүхээрээ бахархаж байж, хэл соёлоо хадгалаж, өөрийн нэр усаараа нэрлэж байж, өөрийн нэр хүнд, алдраа авч гардаг, өөрийгээ илэрхийлж чаддаг, би хувьдаа тэгж ойлгодог.

Манай улсад үйлчлэж байгаа Үндсэн хууль, дээдлэж байгаа төрийн сүлд энэ бүх зүйл ямар нэгэн юмны загвар, хууль байсан гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Бидний удаан хийж ирсэн Их

7.

Хурлууд, тэдгээрийн баримт бичиг, одоо улс төрийн хэллэг болсон бүх зүйл маань орчуулгын юм. Монголоор хүмүүс одоо улс төрийнхээ илтгэлүүдийг монголоор бичиж байна. Үүнийгээ зөв, бурууг нь орос дээр эргэж орчуулчихаад, дараа нь үүнийгээ эргэж монгол болгож байж, энэ нь үнэхээр зөв байна гэж ойлгодог. Манайд үнэхээр улс төрийн хэллэг алга байна, цэвэр монгол хэллэг, яагаад гэвэл бид уг үндэснээсээ тасарсан учраас ийм байдалд орчихсон байгаа юм. Тэгээд үүнийгээ сэргээд ирэхээр их, бага хэмжээгээр ойлголцод хүрэх гэхээр 70 жилийн явж ирсэн түүх нь, уучлаарай бидний аав, ээжийн явж ирсэн түүх нь худлаа юмны төлөө байжээ, эсвэл гомдмоор байж гэсэн үүднээс хандахаа болио чээ. Эргээд бид өөрийнхээ улсыг тодорхойлох эрх бидэнд анх удаа олдож байна шүү дээ. Би Зөвлөлтийн эсрэг үзэлтэй хүн биш ээ. Гэхдээ Зөвлөлтөөс бүх зүйл шалтгаалж байсан гэдгийг хүн бүр ойлгож ёстой шүү дээ.

Ядаж энэ хуулийн нэр нь монголоороо, яаж ч орчуулагдсан монголоороо Их засаг гэсэн тэр нэрээрээ явж байгаасай гэсэн бодол байна. Энэ утгаараа би Бага Хурал дээр дэмжиж байсан. Энэ нь Их цааз юм уу, Их засар юм уу, ямар нэгэн хэлээр энэ нь монголоороо бичигдээд, аль ч улсын хэл дээр орчуулагдахдаа монголоороо байгаасай гэсэн үүднээс энд хандаж байна. Бусад бүх үндэслэлийг нь манай нөхдүүд хэлсэн байгаа. Үүн дээр бид ухаалаг хандах ёстой шүү дээ. Жижиг улс төр бодлогоороо гарч чаддаг, улс төрийн бодлогоороо ч гарч чаддаг. Эдийн засгийн хувьд ч, дэргийн хувьд ч баталгаа үнэхээр бага байна. Гэхдээ энд байгаа цөөхөн монголчууд бид үүн дээрээ нэгдэх ёстой шүү. Яагаад өөрийнхээ юмыг өөрийнхөөрөө нэрлэхээсээ эмээгээд байдаг юм бэ, эмзэглээд байдаг юм бэ. Монгол улс үнэхээр 70 жилийн түүхтэй гэж үү. Өнөөрсөн бүх зүйлээсээ Монгол гэсэн нэрээ гаргах ёстой. Үндсэн хууль гэдэг нь хүн бүр мэдэж байгаа, энэ нь эхлэж гарч ирсэн үндэс нь гэвэл засгуудын хоорондын тогтолцооны эрх мэдлийн хуваарилалтын асуудал байсан. Энэ нь цаашдаа өргөн утгатай болсон. Гэхдээ хуучнаараа нэрлэдэг. Конституция энэ нь өргөн утгаараа нийгмийн бүх харилцааг зохицуулж байгаа юм. Үүн дээр та бүхэн бодох ёстой байх шүү.

8.

Би оноосон нэр дээр байя гэдэг дээр эхлэж санал хураалгах хүсэлтэй байна. Дараа нь үнэхээр оноосон нэртэй байя гэж бодож байгаа хүмүүс нэгдэх ёстой шүү. Хэрвээ бид хоёр хуваагдвал хэзээ ч санал нэгдэхгүй. Тийм учраас аль нэг нэр дээр нэгдээд, миний гол зорилго нь монголоор нэрлээ гэсэн бодолтой байгаа юм. Магадгүй Үндсэн хууль гэдэг нь оросоор орчуулагдаад, эргээд монгол хэл дээр ирж байж энэ нь үнэхээр ээв байна шүү гэж ойлгож байсан үе байсан ч юм бил үү, үгүй ч юм бил үү. Бид монголоороо нэрлэх ёстой шүү, сүлд дээрээ ч, нэр дээрээ ч, улсынхаа нийслэлийн нэр дээр ч гэж бид бодох л ёстой шүү дээ. Бид жижигхэн улс шүү дээ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ц.БАЯРМАА

Бичээч С.ТУУЛ

Ардын Их Хурлын 167 дугаар тойргийн депутат Ш.Гүрбазар:
 -Тэгэхээр бид будаатай аяганд хэдэн нэр хийгээд шигшээд нэгийг нь хүүхэддээ нэр өгч байгаатай ажилгүй юм аа энэ. Ямар нэгэн хэмжээгээр нийгэм, эдийн засгийн өөр байгуулал уруу орж байна. Жаахан бодох л талаас нь байвал яасан юм бэ. Би эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж байгаа юм биш. Эсэргүүцэхийн тулд бас цөөнх болж байгаа юм биш. Жишээ нь одоо Дорноговь аймгийн 10 мянган хүн намайг төлөөлөхдөө миний 10 мянган хэгийг хэлээрэй гэхээсээ илүү намайг Их Хуралд төлөөлөх эрхээ надад өгсөн байх гэж бодож байна. Тийм учраас би эргээд тэр сонгогчдынхоо өмнө хамаагүй хариуцлага хүлээе. Би Их засаг гэдгийн төлөө тэмцсэн гэж би хариуцлага хүлээе. Хамаа байхгүй. Нэгэнт л сонгосноос хойш төлөөлөх эрх нь байх ёстой болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт бид бол ямар нэгэн хэмжээгээр өөрийгөө ялсан эрмэлзэлтэй байж байж энэ мэдэхгүй юм гэдгийнх нь дайсан гэдэг ойлголтоос салах болов уу гэж ингэж бодож байна.

Хоёрдугаарт, монгол хүний хувьд ярихад бид монгол монгол гэж их ярих юм. Бид үнэхээр урагшаа л явж л байгаа бол нэгэнт тэр галт тэрэг чинь хөдөлчихсөн бол нийгэм, эдийн засгийн шинэ байгуулалд ортол л зоригийг хийморь цагана гэдэг, зарим юмыг жаахан зоригтой хөдөлгөө. Хоёрдугаарт бид өнөөдөр нэг юмыг уриалж, нэг юмыг их бодмоор байна. Бид коридорт цай ууж, хоол идэхдээ сайхан ярьчихаад орж ирэхлээрээ зөрөлдөөц өөрийнхөө үзэл бодолтой суугаад байх юм. Өнөөдөр биднийг ард түмэн юу гэж шаардаж байна гэвэл үндэсний зөвшил гэдгийг шаардаж байна. Олонхийн зөвшил гэдгийг шаардаж байна. Бүгдээрээ зөвлөө, хэлэлцье, тэгээд хамгийн бодитой юмыг ард түмэндээ өгье. Тэгснээрээ ганцхан Гүрбазар гүрийснээрээ очоод алдартай болчихгүй. Их Хурал зөв шийдвэр гаргаснаараа мэргэн болох болов уу гэж бодож байгаа юм. Бид монгол монгол гэж ярьсан юм бол, би бол үндэсний үзэлтэй, жаахан монгол гэж ярих дуртай, тусгаар тогтнол гэж ярих дуртай ийм л хүн л дээ. Зүгээр ер нь ингээд ярихад бол хэрвээ бид монгол гэж ярьж л

байгаа юм бол яцаж хуулиа нэг монгол нэртэй, оноосон нэртэй болгочихвол. Нэг Их засаг гэсэн хуулиар хэлчихэд яагаад болдоггүй байсан юм бэ. Үндсэн хуулийг үзэн ядахаа байя, бидэнд хэрэг тус болоо л биэ, өнгөрснийг нулимахаа байя, тэгэхдээ бас хоймор ч үгүй, үүд ч үгүй болж байгаа энэ эх орон шинэ нийгэм эдийн засгийн байгууллыг байгуулж байхдаа ямар ч байсан нэрлэсэн хуультай эхэлчихэд бидэнд юу нь саад болоод байгаа юм бэ?, ганцхан би бол Их засаг дээр жаахан болсон, хоёрдугаарт би саян депутатын саналтай нэг байна. Би бодохдоо оноосон нэр лэмжсэн бүхэн яцаж Их цааз нь болдоггүй юм бол Их засаг дээрээ саналаа өгөх болов уу гэж бодож байсан, горимын хувьд алдаа, тэгэхээр депутат миний хувьд бол оноосон нэр дээр юм уу Их засаг дээр дахиж санал хурааж өгөөчээ. Үндэсний жаахан эвшилд орё. Бүгдээрээ болвол яасан юм бэ л гэсэн санал байна. Энэ бол ятгалт биш ээ. Гуйлт ч биш.

Ардын Их Хурлын 24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар:
 -Бид 1924 оноос эхлэн Үндсэн хууль нэртэй хуультай болсон, энэ хуулиуцад маш олон сайхан заалт байсан, тунхаглалын чанартай маш олон сайхан заалт байсан, гэсэн хэдий боловч энэ хуулиуц хэзээ ч монгол оронд хэрэгжиж байгаагүй, монгол орныг авраагүй, энэ үед бол олон хүн хэлмэгдсэн тухай ярьж байна, үнэн хэрэг дээрээ энд зөвхөн хүн хэлмэгдсэн юм биш, монголын зан заншил, монголчуудын түүх соёл, монголчуудын амьдрах хэв заншил, хэвшил, бидний сэтгэлгээ бүх юм маань энэ үед бол хэлмэгдсэн. Өөрөөр хэлбэл бид 24 оноос хойш Үндсэн хууль нэртэй тийм тунхаглалтай л байсан. Энэ тунхаглалаас бол юу нь ч хэрэгжиж байгаагүй. Ийм учраас би энэ муухай, хуучин заншлаас салъя л гэж бодож байна. Энэнээс салах нь зүйтэй байх.

Нөгөө талаас бол түрүүн депутат Зориг хэлсэн. Дэлхийн олон улсууд бол конституция гэдэг нэрийн дор бол тэр маш олон хууль эрхийн актуудын цуглуулгыг хэлдэг, тухайлбал Англи улсад конституция гэдэг нэрийн дор бол хэдэн мянган хуудастай том зузаан ном бий, Швед улсад ч бол конституция гэдэг нэрийн дор 4 хууль бий. Гэх мэдээр ингээд дэлхийн олон улсууд бол конституция гэдэг нэрийн дор бол тэр нийгмийнхээ тулгуур болж байгаа олон

хууль эрхийн актуудыг нэгтгээд, энэ нэгтгэсэн кмаа конституция гэж нэрлэдэг. Ингэхээр бид нар энэнийг ч гэсэн аль аль талцаа бас бодолдох нь эүйтэй болов уу гэж бодож байна. Эцэст нь бол тэр санал хураалтыг би тэр оноосон нэртэй байх эсэх талаар анхнаасаа хураасан тэр хэлбэрээрээ хураах нь эүйтэй болов уу гэж хэлэх байна.

Ардын Их Хурлын 22 дугаар тойргийн депутат Л. Дашням: -Би туруун бодохдоо оноосон нэр өгөх үү үгүй юу гэдгээр санал хураах юм байх гэж ердөө тэрүүгээр л саналаа өгсөн юм. Одоо болохдоор хүмүүс саналаа үндэслэж ярьж байх шиг байна. Би бас хэдэн үг хэлье гэж бодож байна. Энэ урьдчилсан санал хураалтаас үзэхэд ер нь хуучнаараа байя, өөр шинэчилье гэсэн энэ санал бол ойролцоолуу байгаа юм шиг надад санагцлаа. Харин нөгөө хэсэг нь бол хоёр санал дээр хуваагдаж байна. Би бол депутат Элбэгдорж, депутат Шоовдор нарыг дэмжиж, энэ өөрчилье гэж байгаа нийт олонхоо саналыг дэмжиж, оноосон нэр өгье гэдэг ийм санал байгаа юм. Тэгэхлээр би дэмжиж юу хэлэх гэж байна гэвэл Их цааз гэдэг нэрээр бид нар бүх ард түмнээр хэлэлцүүлээ. Цааз гэдэг үг бол ард түмэнд бууж байгаа өнөөгийн үгсийн сангийн утга нь бол ойлгогдож байгаа нь бол ихээхэн хувирсан учраас өөрөөр хэлбэл тэр цааз гэдэг үг бол тэр гуравдугаар утгаараа үгсийн сангийн ард түмэнд хүрч байгаа учраас их эмээглэж байна.

Өөрсдийнхөө цаазалж байсан, хүнээр цаазлуулж байсан тэр сэтгэлийн өвчин бол өнөөдөр арилаагүй байна. Тийм учраас энэ нэртэй зууралдсаар байгаад магад ч үгүй манай ард түмэн Их цааз, Үндсэн хууль, Үндсэн хууль, эх хууль, тулгуур хуулийнхаа мөн чанар уруу орж ярьж чадсангүй ингээд өнгөрчих шиг боллоо. Тэгэхээр нэгэнт Чимид гуайн ойлгуулж байгаагаар бид нар уламжлал маань Их цааз гэж нэрлэвэл хэдийгээр их үнэн, тэр шугам маань үнэн зөв явах боловч ард түмэн нэгэнт энэ үгсийн сангийн утгаас болоод эмээглэж байгаа учраас би бол цаавад тэр уруу нь тулгахгүйгээр Их засаг гэж нэрлэвэл ерөөсөө энэ шинэ өөрчлөлтийнхөө түүхэнд ч нийцэж байна, бүх ард түмэн ч

өөрөөр хүлээж авна гэж. Юу вэ гэвэл энэ саналыг Үндэсний дэвшлийн намын намын бүлгээс, хурлаас манай журмын эвийн нөхдүүд бас ийм бодолтой байгаа юм. Юу вэ гэвэл Засаг гэдэг уг бол ерөөсөө уг гарвал үүслийг нь авах юм бол яс ёс тэр үгнүүдтэй нийцнэ. Монгол хүн бол нэг ясаа л барьдаг, ясны сайн юм бол сайн л юм гэж боддог. Тийм учраас Их засаг гэж нэрлэхэд энэ бол нийцэх байх. Чимид гуайн хэлж байгаа тэр хоёр их засаг болохлоор холилдоож хойч үе маань ерөөсөө учрыг нь олохгүй гэдэг, тэр бол харин хойч үеийнхээ оюуныг арай басамжилсан хэрэг байна. Одоо бид шинэ үеийн Элбэгдорж, хуучин хувьстлын үеийн Элбэгдорж хоёрыг чинь ялгаад л байгаа шүү дээ. Одоо бид нар Олсэр ч гэнэ үү эрдэмтэй, мэргэн тэр хүнээ бас хэдэн хүн байсныг нь ялгаад л байгаа шүү дээ. Тийм учраас тэрний хувьд бол санаа зовох юм ерөөсөө байхгүй. Харин шинэчилье, өөрчилье гэж байгаа тэр саналаараа энэ хуулиа Их засаг гэж нэрлээд тэгээд цаашаа цэгийнхээ цагуу явъя. Харин оноосон нэр өгөх ёстой гэдэг саналыг хураалгаагүй та завсарласан явдал бол таны буруу шүү. Би тэрнийг завсарлагаанаар өөрөө шууд очиж танд хэлсэн. Одоо цахиад л сануулчихъя. Бие биендээ сануулдаг, шүүмжилдэг энэ бол ерөөсөө парламентын цотоод ёс, сайхан ёс шүү дээ. Энэ чинь. Бие биендээ сануулдаг, тэгээсэй гэдэг шүүмжлэлийг, тэрнээс тулгаж байгаа юм биш.

Ардын Их Хурлын 143 дугаар тойргийн депутат
Г. Зүүнай:

—За би цөөнхөөс санал хэлэх гэж байна. Тэгэхлээр өнөөдөр Улсын Их Хурлын II чуулган Үндсэн хуулийн анхны шийдвэрээ гаргах гэж байна. Түүх биднийг шүүнэ. Улсын Их Хурал бол шүүгддэггүй газар биш. Ерөнхий шүүмжлэл цээр би уг хэлэх санаатай байсан уг олддоогүй, би энд товчхон хэлчихье гэж бодож байна. Улсын Их Хурал өнгөрсөн анхдугаар хуралдаанаараа хэд хэдэн төмөр алдаа гаргасан гэж би хувьдаа боддог. Ардын Их Хурал. Тэгэхээр өнөөдөр бид тийм алдаа цахиад гаргаж болохгүй байх. Бид ард түмэнд тайлагнах ёстой. Бид мэргэн шийд гаргах ёстой, царга ч энэ утгаар мэргэн удирдах ёстой. Ардын Их Хурал нэг тогтоол

гаргасан, гурав хоноод устгасан шүү. Тэгэхээр бид энэ дээр жаахан ухаантай санал өгөхийг уриалмаар байна. Ардын Их Хурлын өнгөрсөн чуулганаар Ардын хянан шалгах хороог өмч хувьчлах хяналтын байгууллагыг урьдчилж тараасан бидний нүгэл байгаа. Гэх мэтчилэнтгээр бидэнд олон алцаа бий. Ерөнхий шүүмжлэл дээр уг хэлэх цаг олдвол би хэлнэ гэж бодож байгаа. Тэгэхээр би депутатуудад хандаж ингэж хэлмээр байна. Энэ ард түмэн Үндсэн хууль гэгцтээр нь болоод, батлаад ирээрэй гэж сонгогчдын үгэнд орж байгаа депутатууд жаахан ухаалаг болмоор байна. Үндсэн хууль гэдэг чинь хүнийг хүн гэж нэрлэх үү гэсэнтэй адилхан юм аа. Өөрөөр хэлбэл Зөвлөлтийн основный закон гэдгээс хуулж авсан уг. Дэлхий нийтийн хэлээр конституция гэдэг үг байгаа. Энэнийг основный закон гэж орос хэрвээ орчуулаагүй, общий закон гэж орчуулсан бол манайд одоо Ерөнхий хууль гэж нэрлэсэн байгаа. Тулгуур хууль ч гэж болно, гол хууль ч гэж болно, ээж хууль ч гэж болно, аав хууль ч гэж болно. Тийм учраас энэ бол тайлбар ерөнхий нэр. Тийм учраас энэ бол оноосон нэртэй байх ёстой.

Энэ утгаар нь бид бол Засаг хууль гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Үндсэн хууль буюу конституция гэдэг үгийг толин дээр байгаа, урьд нь ч харж байсан, сая ч ороод харлаа, хоёр үндсэн утгатай байгаа. Нэгдүгээрт байгалийн амьд организмын бүтэц зохион байгуулалт гэсэн утгаараа байгаа. Хоёрдугаарх дээрээ орсоор структур гээд тодорхойлолт нь төрийн тогтолцоо, хүний эрх, нийгэм, эдийн засгийн тогтолцоог заасан гол хуулийг үндсэн хууль, конституция гэнэ гэж. Тэгэхээр энэ үндсэн хууль гэдэг чинь тайлбар үг шүү дээ. Тийм учраас манай депутатууд дахиж нэг мэргэн оюундаа бодоод Засаг хууль юм уу Их засаг гэдэг дээр санал дахиж хураалгах, цөөнхийн саналыг давтан хэлж байна. Бид дэгийн цагуу л явж байгаа. Ахиад гурав дахь удаагаа хэлэхэд бэлэн байгаагаа ахиад хэлье.

Ардын Их Хурлын 7 дугаар тойргийн депутат Ц.Баддорж:— Би эхлээд горимын санал хэлмээр байна. Түрүүн уншсан. Оноосон нэр өгөх үү, үгүй юу гэдэг дээр хэлэлцээд дахиж санал хураах нь

6.

зүйтэй байх аа гэж бодож байна. Цөөнхийн хувьд хэлэх саналаа давхардуулж хэлмээр байна. Бид ер нь тийм туйлшрах хандлагатай улсууд л даа. Шил гаруйн өмнө бид энд цуглараад анхныхаа хураллааныг хийж байхдаа ер нь одоо бүх юмаа, тэрүүгээрээ уламж-лаад, тэрүүгээрээ хуучин ёс, заншил, бүх юмаа бид ярьж байсан, хэрвээ тэр үед магадгүй Их цааз, Их засаг гэсэн ийм нэр ороод ирсэн бол бид нар дийлэнх олонхийн саналаар баталчих байсан байх. Гэтэл өнөөдөр дахиж нөгөө тийшээгээ туйлшраад ер нь бүх юмыг нь өөрчилж болохгүй юм байна. Хуучнаар нь үлцээе гэсэн ийм санал зонхилоод байх шиг байна. Энэнд магадгүй манай одоо нийтэм, эдийн засгийн өнөөдрийн энэ бодит байдал нэлээн нөлөө-лөөд байх шиг байна л даа. Засгийн газрын гаргасан зарим нэг алдаа, тэр циллэр, алтны энэ алдаа гэх мэтийн ийм юмнууд их нөлөөлж байх шиг байна аа. Тэгэхдээ бид жаахан алсыг харж, ер нь нэг арван жилийн дараа, тавин жилийн дараа магадгүй зуун жи-лийн дараа ямар байх бол оо гэдгийг жаахан бодохгүй бол болох-гүй юм шиг надад бодогдоод байгаа юм.

Тэгэхээр энэ Үндсэн хууль гэдгийн тухайд бол олон дахиж хэллээ. Основный закон гэсэн орос хэлнээс орчуулсан энэүгийг л бид ингээд авсан.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг бас л одоо народная рес-публика гээд социалист бүх орнууцыг нэрлэснийг орчуулаад авсан. Тэгэхлээр бид энд ингэж хуран чуулчихаад тэгээд шууд ерөөсөө эхнээсээ эхлээд, Үндсэн хуулийнхаа нэрэн дээр л шууд ингээд хуучин юмнаасаа эхлээд унах юм бол ард түмэн өнөөдөр магадгүй тээнэгэлээн хүлээж авлаа ч гэсэн арван жилийн дараа хүлээж авахгүй байх аа гэж бодогдож байна. Өөр нэг хэлмээр юм бол тэр Үндсэн хууль гэдэг нэрийг ард түмний дийлэнх нь ингэж санал болгоод байгаа гэж байна. Энэ ер нь юу л бол доо. Тухайл-бал манай сонинд ирж байсан саналууд бол Их цааз гэдгийг эсэр-гүүцсэнцээ Үндсэн хууль гэж байх нь зүйтэй гэсэн санал зонхилж байсан болохоос биш ер нь бол Үндсэн хууль гэсэн нэр хэрэгтэй гэсэн ийм санал бол ховор байсан байх аа. Тийм учраас түрүүн нэг депутат хэллээ. Энэ Их цааз-Үндсэн хууль гэдэг бол хоёулаа нэрний хувьд сөв суучихсан ийм нэр ээ. Энэнийг бол хэрэггүй байх аа гэж, энэн дээр жаахан боцвол яасан юм бэ гэсэн ийм санал-тай байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙДСЭН

П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

72-р тойргийн депутат Лунаа: -Тэгэхээр би цөөнхийн талд анх удаа уг хэлэх гэж байна. Ер нь монгол хүн бол бахархахын эхтэй. Тэрнийг бас нэг эргэж бодмоор, өнөөдөр их жаахан улс мөртлөө Америк, Япон, Солонгос гэж их ярьж байгаа. Ер нь Монгол хүний бахархал гэж үзвэл энд хүн үүссэн ч гэж ярьдаг. Бидний яриад байгаа Америк энэ тэрд чинь эндээс нүүж очсон ч гэж утгаар нь хэлж болно. Юу хэлэх гээд байна вэ гэвэл төрийн их олон депутат, ийм ард түмэн. Тэгээд өнөөдөр уламжлалаа сэргээгнэ гэж их ярьж байгаа боловч ойрхон зуур эргэлдэж одоогоос 10 хүрэхгүй жилийн өмнө намайг алба хашиж байх ийм үед бол юу гэж байсан бэ гэхээр ер нь юм боловсруулчихаад оросоор юу гэж байх юм бэ, энийг хэлээдэх, тэгээд таашаалтай байвал тэр чигээр нь тогтоолын нэрийг ч тэр аливаа нэрийн юмыг ч тэр ингэдэг л байсан, өнөөдөр ялгаа байхгүй бид ерөөсөө бидэнд үнэхээр олон хүний уг байна, үндсэн хууль гэдэг бол хүний толгой тархинд ч тогтоогүй, сайн зүйл ч өгөөгүй, үнэхээр маршал Чойбалсан, Цэдэнбалын гэрээслэлийг маш хатуу барьж биелүүлж, энэ дээр их хатуу зогсох, ерөөсөө цаашдаа ч болов бараг юм өөрчлөгдөхгүй ийм хандлагатай харагдаж байна л даа. Энэ чинь өөрчлөх ёстой юмыг өөрчлөх ёстой, өөрчлөхгүй юмыг өөрчлөхгүй байх ёстой юм. 15-хан жилийн дараа Монголын нэгдсэн улс байгуулагдсаны 800 жилийн ой болох гэж байна. 2006 онд, энэ утгаараа зүгээр одоо олон хүн давтаж ярилаа, Үндсэн хууль гэж нэг байсан нэрэн дээрээ, байгаа юмтайгаа л буцъя гэж байгаа юм шиг ийм байдлаар хандах нь бол дэндүү ухвар мөчид хэрэг болж байна. Тийм учраас одоо төрийн их уламжлалтай, оюун санааны их түүхтэй, энэ цөөхөн монголчууд өнөөдөр яагаад барагдчихаагүй вэ гэвэл амьдралын их философитой ийм ард түмэн Ийм учраас энэ юман дээрээ эргэж үзвэл яасан юм, бид анхныхаа энэ хүндтэй, улсыг шуугиулсан, дэлхий дахиныг харж нааш нь ширтүүлсэн ийм асуудал хэлэлцээд эхнийхээ шийдвэрийг гаргахдаа бахь л байдгаараа ярьж ярьж байдгаараа шийдэж байгаа нь бол бас эргэж харууштай юм уу гэж бодож байна. Тэгэхээр бид одоо бодож байна шүү дээ, ер нь монголын нэгдсэн улс байгуулагдсаны 800 жилийн ой болох гэж байгаа, үнэ-

хээр Монгол хүн сэргэн мандаж байгаа, хуучин өнгөрсөн 70 жилийнхээ эам будилж явж гэдгээ ойлгож байгаа өнөө үед бол үнэхээр хамгийн гол энэ хуулиа бол Их засаг хууль гэж нэрлэвэл яасан юм гэдэг энэ санаан дээр дахин санал хураалгаач ээ гэж ингэж хэлэх гэсэн юм.

219-р тойргийн депутат Чойжилжав: -Олон янзын юм нэрлэж ярьж байгаа нь бол бидний эрхийн асуудал байх гэж бодож байна.Энэ эрхээ эдлэхээ мэдчихээд,үүргээ бага анхаарч байна.Өнөөдөрийг хүртэл бид зарчмын нэг ч асуудал шийдсэнгүй. Энийгээ шийдэхийн тулд жаахан олон янзынхаа юмыг нэгтгэж нэг юм руугаа ойртож байгаа тал руу нь яримар байна. Жишээ нь өнөө өглөө ингээд санал хураагаад 51 %-ийн санал авлаа шүү дээ.Тэгсэн ямар юм болсон гэхлээр зэрэг энэ асуудал бол ерөөсөө зарчмын асуудал юм уу үгүй юу гэдгээ шийдээгүй. Тэрэнтэй холбоотой.Энэ хэрвээ зарчмын асуудал байсан бол тэр асуудлыг чинь 75 %-иар шийдэх ёстой.Зарчмын асуудал биш юм бол тэр 51 % шийдчихсэн.Тэгэхээр энийгээ одоо ямар асуудал юм бэ гэдгийг шийдэж чадсангүй шүү дээ.Хэрвээ Үндсэн хууль гэдэг чинь тэр асуудлаар Үндсэн хууль гэдэг санал хийдэгдчихэж байгаа бол энэ бол зарчмын асуудал, ерөөсөө аргаа хэлэлцэх гэж байгаа бид одоо нэг шат нь энийгээ шийдье, дараагийн шат нь өөр юм хийж аргаа хэлэлцэж байгаа бол энэ зарчмын биш асуудал.Тэгвэл 51 %-иа бид зөвшөөрөх ёстой.Энэнээс л эхлээд явмаар санагдах юм.Миний ярьсныг ойлгов уу, үгүй юу, би тийм л юм хэлмээр санагдах юм.Өөрөөр хэлбэл тэр Үндсэн хууль гэдэг чинь одоо оноосон нэр юм уу, үгүй юу гэж мэдэхгүй байна шүү дээ бид нар.1 гэвэл, 2 гэвэл Үндсэн хууль гэдэг саналыг чинь хэсэг хүмүүс нэг нэг тодорхой хэмжээний хүмүүсүүд тавиад байна шүү дээ.Энэ асуудлыг чинь I дүгээр асуудлаа шийдчихэж байгаа юм бол энэ чинь зарчмын асуудал шүү дээ.Тэгээд бид Үндсэн хуулийг хэлэхгүй бол оноосон нэр лүү орё гээд дараагийнхаа өөр юмнууд руу орчихно шүү дээ. Гэтэл ерөөсөө энэ асуудал шийдэх гэж байна гэж үзэхгүй, бид аргаа шийдэж байна гэж үзэх юм бол ялгаагүй л зарчим биш учир 51-ээрээ бид шийдчихээд дараагийн асуудалдаа орчихмоор байна

шүү дээ. Энийгээ шийдмээр юм шиг санагдах юм.

I4-р тойргийн депутат Лхагвасүрэн: -Би цөөнхийн талд орж нэг үг хэлмээр байх юм. Тэгээд ямар ч улс орныг энэ тусгаар тогтносон улс мөн үү биш үү тодорхойлдог 5 үндсэн фактор байдаг юм шиг байгаа юм. I-рт нь би энийг яахав зарчмын асуудал учраас нэр томъёоны асуудал дээр зарчмын асуудал хэлэлцэх гэсэн учраас гэж өөрөө ойлгоод энд 5 фактор хэлээд өгчихье гэж бодож байна. Улс төрийнхөө хувьд тэр үү, улс орон хэр зэрэг биеэ даасан бодлого явуулдаг км гэдгийг нь товч харгалзаж үздэг юм байна. 2-рт, эдийн засгийнхаа хувьд хэр зэрэг бусад орны хараат байна, хараат байдалд байна уу, үгүй юу гэдгийг харж үздэг. 3-рт, үндсэн гол фактор нь ямар фактор байна вэ гэхлээр тэр улс орон өөрийн үндэсний хэлтэй, үндэсний бичиг үсэгтэй байна уу үгүй юу гэдгийг харж үздэг. 4-рт, үндэстний машин байна уу үгүй юу, үндэсний зан заншил байна уу, үгүй юу гэдэг энэ 5 фактораар авч үздэг км байна. Энэ ч утгаараа ^{МОНГОЛ УЛС} нэгдсэн үндэстний байгууллагын биеэ даасан бүрэн эрхт гишүүн улс болжээ гэж өөрсдийгөө үзэж ирсэн. Гэтэл өнөөдөр бид яаж байна вэ гэхлээр Үндсэн хуулийн нэр, нэрэн дээр бид анхаарах хэрэгтэй байна л даа. Манай 70-аад жил манай хуучин монголчуудын хэрэглэж байсан хэл маань өнөөдөр юу болчихсон билээ, үнэндээ бол орчуулгын хэл болчихсон байж байгаа шүү дээ. Тийм учраас миний хувьд бол юу гэж хэлэх гээд байна вэ гэхлээр үнэхээр монголын тусгаар тогтнолыг одоо цааш нь авч явъя гэж байгаа км бол хэл, ёс заншил дээр нь хүртэл анхаарахгүйгээр, зөвхөн ганцхан улс төр, эдийн засгийнх нь асуудал дээр авч үзээд, энэ асуудал бол бүрэн төгс би болохгүй гэж үзэж байна. Тийм учраас Их цааз гэдэг энэ нэр дээр санал өгөөсэй гэж эрхэм депутатуудаас хүсэхээр байна.

II-р тойргийн депутат Бямбаа: -Энэ ерөөсөөн түрүүн улсууд ярьчихсан учраас би 2,3-хан үг хэлье гэж бодож байна. Тэр Их цааз гэдгийн хувь дээр би түрүүн тайлбараа хэлчихсэн. Энэ бол үгийн утга, гуйваж, хүмүүст буруу сэтгэгдэл үлдээснээс ийм болчихсон гэж би үзэж байна. Их засаг бол үнэхээр Чингисийн

үеийн засаг, одоо Чингисийнхээ сүлдийг хэрэглээд, Чингисийнхээ тугийг хэрэглээд, 750 жилийн ойг хийлээ, 2 жилийн наадмаа хийлээ, ингээд байгаа юм чинь Чингисийн нэртэй гарсан Чингисийн үеийн Их засаг гэдэг хуулиар Их засаг гэж нэрлэхэд юу нь болохгүй байгаа юм бэ, бид чинь бас монголоо хурлын хуралдааны дараагаар харахад Монгол орон ч үнэхээр ардчилал нь хөгжиж байна, бүх юмаа шинэчилж байна, хуулиа хүртэл Их засгийнхаа үеийн хуультай, түүнд нь сүлд тэмдэгнүүдээ аваад байсан, үнэхээр өөр тийшээ явж байна, жинхэнэ Их монголын үеийн тэр уур амьсгал одоо бүрэлдэж байна, ингэхээр бусад орны хэн нэгний хавчилт шахалтанд орохгүйгээр, өөрснөө юмаа шийдэж байна, шинэчлэгдэж байна гэдэг утга агуулга ойлгогдмоор байна. Тэгэхээр би бас нэг ийм юм бодогдоод байна. Энэ бага хурал оруулж ирсэн гэхээс бага хурлаас оруулж ирсэн санал, нэр томъёог нэг зарим нь нэг тийм жигшээд өр нь нэг жийрхээд бага хурал руу жаахан нүд үзүүлэдэг хандлагаар хандаад байгаа юм биш байгаадаа, тэгэхээр эд л нэг болохгүй юм хийчихсэн байх, энийг хүлээж авахгүй гэсэн юм зарим хүний толгойд байдаг юм биш байгаа гэж бодож байна. Бага хуралд чинь хийсэн алдаа ч бий, алдаанаасаа хийсэн, бүтээсэн юм нь их байгаа шүү дээ. Ялгаа байхгүй, тэрийг бид тухайн үед нь ярина. Тэн дээр шүүмжлэх ч юм бий, өөрчлөх ч юм бий, засч эзлэх ч юм бий. Тэрнийг бол бид тэр үед нь бага хурал гэж өмөөрөх ч үгүй, тэрнээс айж эмээх ч үгүй, бага хурлынхны дарамт шахалтанд орох ч үгүй. Энэ дээр бас бага хурлынхан олонхи, цөөнхийн талд байгаад байгаа болохоор л бид л нэг юм хийчихээд бид л тулгаж хүлээлгэх гээд байна гэж битгий хар санаачээ, нөхөд минь жаахан уудам ухаанаар бодож үзээч гэж гуйх байна.

-396-р тойргийн депутат Б.Чимид: -Би нэг тоонд эргэлзээд байна. Энэ тоонд их сонин юм гарлаа. Их засаг дээр 40 %, Үндсэн хууль дээр 68 %, Их цааз дээр 15 хувь, бид ингээд 123 %-иар саналаа өгчихөөд байж байна. Энийг зарим нь одоо дуусгая гээд байна. Түүхэнд бид саналаа бичнэ, мөрөө үлдээж байгаа бол ядам хувь нь 100 хувь байх ёстой юм. 123 %, би бичиж авсан юм, 1-рт, 2-рт энд саналаа хураахдаа заавал 100-д мөргүүлж баймаар байна даа. 1 хүн 2 юман дээр санал өгөөд байна. Тийм учраас нэг хүн 1 л юман дээр санал өгмөөр байна. 3-рт, ийм зарчим барьдаг,

1-рт хажуугийн санал хурааг, 2-рт дахиад 2 хажуугийн санал байгаа, тэрнийг хурааг, тэрний аль нь ч олонхи болохгүй бол төслөөр үлдэж баймаар байна. Тэрнээс төслийг санал хураалгах гэж байгаа юм бол эхэнд нь хураалгамаар байна. Бүгдийг нь хурааж дууссан хойно төслийг унагах гэж байгаа юм шиг тэгж санал хурааж болохгүй. Тийм учраас баланслуулах арга, дэс дарааг сайн олмоор байна. Хуулийн нэрийн тухайд бол би өөрийг ерөөсөө зүтгүүлэхгүй. Тэрнийг би олон хэлсэн. Зүгээр ер нь болбол 1924 онд гарсан маргааныг бид тасалж байгаа гэдгээ мэдмээр байна. 1924 оны Үндсэн хуулийг 2 комисс хийсэн. Шүүх яамны сайд Магсаржав даргатай комисс, олон янзын хууль, олон хөрөнгөтөн орнууд, барууны орнуудын хууль судлах үндсэн дээр хууль хийсэн. Тэр үзэл суртлын талаар буруу байна гэж үзээд дараагийн комиссыг томилсон. Тэр комисс маш цөөн хугацаанд ажилласан, одоо яг бидэн шиг ийм шахуу ажилласан байх

Энэ 2-ын хоёулангийн нь төслийг нь архивт хадгалалдаж байгаа нэр нь Монгол улсын, БНМАУ-ын нэг нь бүрэн эрхт гэдэг үгтэй байх, Үндсэн хууль, цааз нэртэй юм. Би бол монгол үгийн гарлаар нь яриад байгаа болохоос биш, бид бол орос гаралтай үг авах уу, уйгар гаралтай үг авах уу, монгол гаралтай үг авах уу, манж гаралтай үг авах уу гэдгээ ярьж байгаа гэдгээ ойлгомоор байна. Би олон юм яриад яахав, тэгэхээр монгол гаралтайгийн нь бид шилж авсан ухаантай юм. Тэр үгийн одоогийн ойлгож байгаа утга нь буруу болчихсон байж л дээ. Энэ бурууг бол 24 оноос хойш л буруу болгосон байна шүү. Тэрнийгээ сайн бодмоор байна. Эцэст нь хэлэхэд бол Их засаг гэж авбал, зүгээр мухар Их засаг гэж авч болохгүй. Их засаг хууль ч гэж бас болохгүй. Их засгийн хууль гэж авбал бид жинхэнэ нэрээр нь авна. Энийг Англи, орос руу орчуулбал бид Чингисийн их засгийг Конституци гэж орчуулахад хүрэх юм байгаа юм. Нэг нь Грит ясаа гэж байна, нэгийг нь Стэт ясаа гэж байна, нэгийг нь Великий ясаа гэж байгаа юм. Энэ одоо Марксын зохиолоос авахуулаад одоогийн судлаачдын зохиолд орсон, тэр их засгийн нэрийг бол өөрчилж орчуулж болохгүй тэрийгээ цэврээр авч үлдээ гэсэн санааг би өглөө хэлсэн болохоос биш ганцхан цааз гэдэг үгийг авах гэж зүтгэсэн юм байхгүй. Ер нь би энэ нэрэндээ санал өгөхгүй ч байж болно. Яагаад вэ гэхлээр энэ олон буруу нэр зүүгээд байна, Их

засаг, би бол Их засгийн хууль байхгүй гэж хэлээгүй шүү, Их засаг гэж нэртэй хууль байгаагүй, Их засгийн гэдэг хууль байсан гэж яриад байгаа шүү, тэгэхээр авбал зөвөөр нь авах ёстой байх, Их засгийн гэж авбал энэ хуулинаас тэр засгийн эрхтэй холбоогүй асуудлууд нь үндсэндээ хасагдчих гээд байгаа гэдэг тэр депутат Зоригийн санаа бол бодуштай санаа шүү.

6-р тойргийн депутат Нямбуу: - Би 1960 оны үндсэн хуулийг батлахад оролцсон. 31 жилийн дараа 2 дахь хүндтэй үндсэн хуулийг батлахад оролцож байгаа хувь заяандаа баярлаж байна. Үндсэн хуулийн явж ирсэн түүхий нь үзэхэд анхдугаар Үндсэн хууль 16, 2 дахь нь 20, 3 дахь нь 31 жил амьдраад өнөөдөр бид дараачийн хуулийг батлах гэж байна. Тэгэхдээ урт удаан настай хууль болоосой гэдэг ийм л хуулийг бид гаталж, баталж гаргах юм сан гэж цөмөөрөө бодож байгаа байх, би ч тэгж бодож байна. Хүмүүсийн ярьж байгаа байдлаас үзэхэд үндсэн хуулийн шинэ үндсэн хуулийн төслийн талаар бодол санаа өөр өөр байх шиг байна. Миний үзэж байгаагаар 60 оны үндсэн хуулиас хойш үндсэн их өөрчлөлт гарч, шинэ оны үндсэн төслөөр ч их өөрчлөлт хийхээр төлөвлөсөн байна. Тэгээд энэ олон хүмүүсийн нэлээд олон хүмүүсийн яриад байгаагаар Үндсэн хуулийн I талы нь км уу, өөрөөр хэлбэл хуулийн нэр, улсын нэр, сүлд, дуулал, гэх мэтчилэн энэ зүйлүүдийг хэвээр нь үлдээе гэсэн ийм санал гаргаад байна. Хэрэв ингэж үзээд энэ хэвээрээ үлддэг юм бол, үндсэн хууль маань урт, удаан настай хууль болж чацахгүй. Хойч үе маань энийг одоо уучлахгүй, улс орны дэлхий дахины, аль аль нь хувьсал өөрчлөлт бол тургэн хугацаагаар явагдаж байна. Тийм учраас бид удахгүй I, 2 жилийн дараа улсын нэр, аль аль энэ зүтгэж байгаад баталсан зүйл маань өөрчлөгдөж Үндсэн хуульд маань нөхөөс орох тийм байдалд орно. Бид өөрчлөх ёстой юмыг өөрчлөхгүй, хойд үедээ үлдээе гэж би хувьдаа бодохгүй байна. Тэгэх дээр хүмүүсүүд жаахан алсыг хараач ээ, ирээдүйгээ бодооч ээ, ядаж 31 жил биш 50 жилийн настай, тийм хууль батлах юмсан гэдэг бодлын үүднээс бодож үзээч ээ гэж бодож байна. Үндсэн хууль гэдэгт бол би хувьдаа дургүй байгаа. Би ер нь Их цааз гэж нэрлэчихсэн ч болох км гэж бодож байсан, энэ дээр олон хүн дургүй байгаа юм байна, ард түмэн ч дургүй байгаа юм байна, дараад нь Их засаг гэдэг юу гарч ирлээ, Үндсэн хууль гэдгээсээ Их засаг гэдэг нь ч арай өөр илүүтэй юм уу гэж

ингэж бодож байна .Тэгээд хүндэт нөхдүүд минь энэ хуулийн нэрэн дээр ч гэсэн дараагийн улсын нэр, бусад тэр юун дээрээ ч гэсэн бодож удаахан настай хууль батлах юмсан гэдэг дээрээ санал бодол төвлөрүүлж, бодож санаач ээ гэж ингэж хүсч байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

414 дүгээр тойргийн депутат Д.Цэрэн: -Би энэ хуулийн талаар Ерөнхий үг хэлэх гэж оролдоод багтаагүй. Тэгэхээр одоо би зарим нэг санаагаа хэлье гэж бодож байна.

Тэгэхээр сая нөхөр Нямбуу ярилаа. Бид энэ Үндсэн хуулийг ихээхэн үл үндэстэй, ирээдүйгээ харж батлах, боловсруулах хэрэгтэй. Энэ хуулийг батлах гэж манай мэргэжлийн байгууллагууд ард түмнээрээ хэлэлцүүлээд Ерөнхийлөгч, Үндсэн хуулийг боловсруулах комисс, манай Улсын Бага Хурал энэ хооронд их зүйлийг хийсэн гэдгийг зохих ёсоор үнэлж байна. Би дээр үг хэлсэн улсуудын нэгэн адилаар. Тэгэхээр ер нь Үндсэн хуулийг 3 удаа урьд бид батлаад, одоо 4 дэхээ хэлэлцэж байна. Энэ хэлэлцэж байгаа хуулин дээр, уучлаарай депутатууд, би буруу юм хэлээгүй байх гэж бодож байна. Бид энэ хуулиа нэгдүгээрт их сайн судалмаар байна. Маш сайн судалмаар байна.

Энэ дээр судлахгүйгээр зүгээр үг үсэг, хэллэг, янз бүрийн зүйлээр ингээд оролдоод байвал бид олигтой хууль гаргахгүй, нэгдүгээрт ийм санал байна.

Хоёрдугаарт, манай урьдах батлагдсан гурван удаагийн Үндсэн хууль бол дандаа, түрүүн нэг хүн хэлсэн, бүгдийг тунхаглалын чанартай байсан гэж хэлээгүй, нэлээн олон заалтууд тунхаглалын чанартай байсан. Би энэ Үндсэн хуулийг тийм хэлбэрээр батлах юм бол ёстой хойч үедээ бас хараагдана. Би ганцхан юм хэлье. Энэ чинь хүний эрхийн тухай асуудал дотор мөн л урьдынхтай адилхан жагсах, үл хэлэх, хэвлэн нийтлэх эрхтэй, урьд нь бас ийм л байсан. Бид урьд хэвлэн нийтлээд буруудаж байсан, үг хэлээд буруудаж байсан. Одоогийн хуулин дээр юу гэж заасан байна вэ гэхээр энийг хуулиар зохицуулна гэж байгаа. Энэ юу гэсэн үг вэ? Би энийг ерөөсөө ойлгохгүй байна. Ер нь энэ мэтээр ингээд Үндсэн хууль дээр дахиж эргэж харж, сайтар хэлэлцэхгүй бол болохгүй нээ.

Тэгэхээр хурлын дэг дээр, зохион байгуулалт дээр нэг шүүмжлэл байна. Бид анхнаасаа ерөнхий шүүмжлэл гэж хэлэхгүйгээр хэрвээ би энийг хурлын даргад анхааруулж байна. Ерөнхий шүүмжлэл гэж юу ярих ёстой вэ гэдгийг хэлж өгөөч ээ. Тэгэхгүй бол депутатууд чинь бүлгээр, зүйлээр ярих юмаа яриад цаг алдаад байна. Тун болдоггүй юм бол бид анхнаасаа эхлээд ерөөсөө ерөнхий зүйл гэж ярихгүйгээр шууд бүлэг, хэсэг, зүйлээр ярьсан бол едийд нэлээн хэдэн асуудлыг бид яриад шийдсэн байх байсан, цаг алдлаа. Ийм учраас энийг түргэвчилэх, ер нь ойрын хугацаанд батлахгүй бол бидний цаад талын үлдэж байгаа хугацаа их бага үлдэж байна. Ийм учраас бид олон талаас нь сайн харья.

Нөгөө талаар, бид энэ хуулийн заалт баталгаа байна уу, үгүй юу гэдгийг манай депутатууд бас сайн бодмоор байна. Нэлээд заалтууд дээр миний уншиж үзэж байхад албан ёсны баталгаа байхгүй, тунхаглалын чанартай юм маших байна. Ийм зүйлүүдийг манай нөхдүүд бодвол сайн байна. Тэгээд бид шинээр сэтгэх нь зүйтэй байх юм. Хуучин талаараа, ард түмэн захисан юм, энэ нь ойрхон байдаг юм гэдэг үзэл бодлоо бас эргэж депутатууд дүгнэлт хийж үзээч, шинэ юман дээр эргэж зогсохгүй бол, түрүүн Нямбуу гуайн хэлдэг шиг хэлэлцсэний дараагаар богино настай хууль хийчихээд ахиад тэрэн дээр нөхөөд хийх гэж байх ийм болчимгүй байдалд орчих вий дээ гэдгийг бодолцох нь зүйтэй. Биднийг, зөвхөн монголын ард түмэн төдийгүй, дэлхий нийт харж байгаа. Энэ Их Хурлаараа, өөрийнхөө Үндсэн хуулийг батална гэсэн ямар янзын юм гарах нь вэ гэдгийг, ийм учраас манай төлөөлөгчид ард түмний захиасыг гэдэг, данцаа тийм ойлголтоосоо салаад жинхэнэ Үндсэн хуулиа батлах оюуны чадавхи, боловсролынхоо чадавхийг энэ дээр гаргах цаг болсон байна гэдгийг хэлмээр байна.

355 дугаар тойргийн депутат Х. Баянмөнх: -Тэгэхээр би бодож байсан, хоёр хоногийн түрүүн ярьж ч байсан. Бидний зовлон бол ганц зүйл дээр байгаа. Мэдэхгүй, чадахгүйдээ ч байгаа биш, мэддэг чаддагтай ч байгаа биш, одоо ард түмний санаа сэтгэлд нийцсэн хууль баталж өгөөрэй гэж хүсч байна.

Төгье гэвэл бид өнөөдөр яг монгол орныхоо ард түмний хүсэл эрмэлзлийг харгалзах ёстой боллоо. Урт настай, ирээдүйтэй хууль батлах гэвэл өнөө маргаашийн зарим нэг зовлонг умартах хэрэгтэй боллоо. Энэ хэцүү, хоёр замын уулзвар дээр бид зовж байна.

Үндсэн хуулийг боловсруулах комисс юмуу, Бага Хурал яг энэ зовлонг эдэлж ирсэн байна. Тэрийг бид биеэрээ амсаж эхэллээ гэж хэлсэн. Тэр самалныхаа ^{хувьд} бид өнөөдөр энэ дээр уг хэлэхээр зогсч байна. Бид 7 хоног болсны дараа өнөөдөр хамгийн анхныхаа шийдвэрийг ухарч гаргасан. Яг өнөөдөр ард түмэн юу хүсч байгаа вэ гэдэгт тааруулж гаргасан. Ингэвэл цаашид бүх шийдвэр, бид өнөөдөр яг ард түмний хүсч байгаад тохирч гаргах гэнэ ээ. Үндсэн хууль бол ирээдүйтэй, урт удаан ийм хууль болох чадвар бол анхны шийдвэрээс эхлээд ухарлаа. Энэ тал дээр бол өөрөөр хэлбэл, цаг ямагт цөөнх болох юм байна гэсэн үндсэн би энэ үгийг хэлж байна.

Уул нь бол оноосон нэр өгөх үү гэдэг дээр Их цааз, Их засаглал гэдэг хоёр нэг үлдэх ёстой байсан. Ерөнхий нэрэн дээр Үндсэн хууль үлдэх ёстой байсан. Ингээд санал хураахад Их цааз, Их засаглал хоёр дээр бол Их засаглал дийлэх юмаа гэдэг нь нэгэнт бидэнд ойлгомжтой болоод хурал завсарласан. Гэтэл хурлын завсарлагааны дараа өнөөдөр 15 цагт санал хураахад Үндсэн хууль гэдэг нэр нь их санал авч байна. Энэ болно, болохгүй юм байхгүй. Гэхдээ бид анхны шийдвэрээ ингэж л гаргавал цаашид бүх зүйлүүд, өнөөдрийнхөө арга барил руу эргэж орох болно. Ийм байдалд хүрч байна гэдэгт санаа зовж би хэлж байна.

399 дүгээр тойргийн депутат Д.Чилхаажав: —Горимын шинжтэй санал хэлье. Түрүүн завсарлахын өмнө нэг санал хураахад 37,7 хувь нь Үндсэн хуульдаа онцгойлсон нэр өгье гэж санал хураалтаар ийм санал гарсан. Гэтэл энийг яг хэлэлцүүж дуусаад тухай үед нь санал хураасан бол зүгээр байсан юм. 5-6 минут дутуу байхад завсарлуулсан явдал бол их нөлөөлжээ. Магаад гэвэл, тэр үед хүмүүсийн санал бодол төвлөрсөн байсан. Харилцан ярилцаж ойлголцсон байлаа. Гэтэл одоо яг тэр

үед санал хураалгаагүйгээс их будиллаа. Энийг нэгдүгээрт хэлье.

Тэгээд би одоо энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад анхнаас нь эхлээд жаахан буруу замаар явчих уу даа гэдэгт их сэтгэл эмзэглэж байна. Магаад гэвэл, Үндсэн хуулийн ерөнхий санал шүүмжлэлийн явцад уг хэлсэн 91 хүний бараг 80, 90 хувь нь Үндсэн хуульд зарчмын үндсэн өөрчлөлт хийхгүй байя, өнгө, будгийн засал хийе гэсэн аястай уг хэлсэн. Энийг би юугаар хэлж байна вэ гэхээр, сүлдийг өөрчлөхөд л тайлбарын өөрчлөлт болъё, улсын нэрийг өөрчлөхгүй байя, далбааг өөрчлөхгүй байя, орон нутгийн засаг захиргааг өөрчлөхгүй байя гэсэн дандаа ийм саналаар хэлсэн.

Эхлээд юу шийдэх ёстой байсан вэ гэхээр, Үндсэн хуулиа зарчмын хувьд өөрчлөх үү, яах вэ, эсвэл өнгө, будгийн засал хийгээд орхичих юмуу, яах юм бэ гэдэг дээр шийдвэл зүгээр байж уу даа гэсэн саналтай байна.

Ер нь аливаа өөрчлөн байгуулалт шинэчлэлт, хувьсгалыг өнөөдөрт зориулж хийдэггүй. Өнөөдрийн үеийнхэнд зориулж хийсэнгүй. Ийм учраас энэ өнгө будгийн засал хийгээд орхих юм бол энэ бол өнөө үеийнхэнд зориулсан хууль болно. Зөвхөн өнөөдрийн үе, энд амьдарч байгаа хүнд зориулсан хууль болох байх.

1924 оноос хойш 3 удаа үндсэн хууль батлахдаа дандаа улс төрийн үзэл бодлын шинжээр сүлдээ өөрчилж байсан, ардчилсан шатны сүлд гээд нэг өөр сүлд, социалист шатны сүлд гээд нэг өөр сүлд, хувьсгал ялсны дараах сүлд гээд нэг өөр сүлд. Яахаараа монгол хүний бэлгэ тэмдэг, төрийн бэлгэ тэмдгүүд үзэл суртлыг дамжиж ингэж өөрчлөгдөж байх ёстой юм бэ? Яахаараа Үндсэн хуулийн нэр ч гэсэн үндэснийхээ нэрийг авч болдоггүй юм бэ гэсэн бодолтой байгаа юм.

Манжийн дарлалын үед байсан манай төр, засгийн удирдах хүмүүс, одоогийн бидний яриад байгаагаар бол өөрөө удирдах ёсныхоо төр хуулийг Их цааз гэж нэрлэж, өөрийнхөө үндсэн монгол хэлээр нэрлээд байж болсон юмыг яахаараа бид өнөөдөр

эрх чөлөөтэй болсон энэ үедээ Их цааз гэсэн энэ нэрээ үндсэн монгол нэрээ аваад энэ хуулиндаа хэрэглэж болдоггүй юм бэ гэсэн үзэл бодлын үүднээс би Их цааз гэдэг нэрэн дээр зогсоод байгаа юм.

Ер нь түүх соёл, төрт ёсныхоо уламжлалын зүйлсээс нэлээд их алдсан, 70 жилийнхээ юмыг бид уламжлаад түүх, соёлоо гэж үзэх үү, эсвэл энээс арай зайтай ахиухан харах уу гэдгийг өнөөдөр эрхэм депутатууд бодолцож үзэх нь зүйтэй байх аа. Би түрүү ч хэлсэн, бид өөрсдийнхөө бодлыг өнөө үеийнхэндээ нийцүүлж түүх соёл, төр ёсныхоо уламжлалыг өнөө үеийнхээ таашаалд нийцсэнээр авч үзнэ гэвэл энэ өрөөсгөл болно. Ийм учраас бид ирээдүйдээ ч, өнгөрсөн үе рүү ч зоригтой алхах, хол харах хэрэгтэй болов уу гэж үзэж байгаа юм. Ингээд хэрвээ энэ саналыг эхэлж хураалгахдаа энэ Үндсэн хууль онцгой нэртэй байх уу, үгүй юу гэдэг дээр нэг хураагаад хоёр дахь санал Их цааз гэх үү, Их засаг гэх үү гэдэг энэ нэрийг бол нэрээр санал хураавал яасан юм бэ гэсэн саналтай байна.

184 дүгээр тойргийн депутат С.Билэгсайхан: -Тэгэхээр сүүлийн 60, 70 жилийн манай монголын түүх бол хүний эрхийг зөрчиж, гэм зэмгүй олон мянган хүмүүсийн амь насыг хөнөөсөн, амь амьдралаар нь тоглосон ийм он жилүүд байсан. Энэ он жилүүдэд основной закон үйлчилж байсан. Тэгэхээр би ингэж бодож байна. Эрхэм Ерөнхийлөгч, БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар болон эрхэм депутатуудад нэг хүсэлт байна.

Энэ гэм зэмгүй хэлмэгдсэн олон арван мянган хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэж, энэ түүхэн шийдвэр гаргахын өмнө нэг минут дуугай зогсоё гэж хүсье. Ийм санал оруулж байна. Тэгээд шинэ Үндсэн хуулиндаа орёе. Их Хурлын даргаа миний саналыг хүлээж авна уу.

Ж. Уртнасан: -Ярьж байгаа зүйл дээрээ тогтож яримаар байна.

С.Билэгсайхан: -Шинэ юм руу орж байна, хуучнаараа гэдэг чинь, бүгдээрээ дандаа хуучнаараа сэтгээд байж байна шүү дээ. Үнэхээр бид нар энэ асуудлыг жаахан хол харж ингэж шийдэх ёстой байж, дандаа нэг хуучин загвараараа бид нар ингээд яваад байж болохгүй шүү дээ. Магадгүй, бид нар өнөөдөр ийм шийдвэр гаргаж чадахгүй гэхэд дараагийн Их Хурлын төлөөлөгчид энэ шийдвэрийг бол гаргаж таараа. Тийм учраас би Их Хурлын даргаас гэм зэмгүй хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэж, 1 минут хүндэтгэхийг хүсч байна. Ийм санал оруулж байна.

Ж.Уртнасан: -Билэгсайхан депутат аа, хэлэлцэж байгаа асуудал дээрээ саналаа төвлөрүүлбэ.

101 дүгээр тойргийн депутат Р.доржбат: -Миний хувьд төслийн нэр, томъёон дээр үүх түүх яриад байх юм алга. Бид нэг асуудлаар мөн ч их ярилаа, ялангуяа зарим депутатууд бол өөрийнхөө бодлыг ард түмний нэрийг барьж, сонгогчдын нэрийг их барьж, би ч гэсэн бас сонгогчидтой л хүн. Гэтэл манай сонгогчид юу гэсэн бэ гэхээр, ганцхан чи Үндсэн хууль гэдгээр л энийг батлуулаад ирээрэй гэж надад хэлээгүй. Уулзсан сонгогчид цөмөөрөө санал өөр өөр байсан. Энэ гурван хувилбар байсан, одоо бидний энэ батлах гээд байгаа, хэлэлцүүлээд байгаа гурван хувилбарыг хэлж байсан. Ялангуяа Их засаг хууль гэдгийг энэ нь илүүтэй юмуу, нөгөө хоёрынхоо бодвол гэж ийм санал өгсөн.

Би одоо санал өгөх юм бол энэ л санал дээр байна гэж бодож байгаа.

С.Билэгсайхан: -Их Хурлын даргааа би депутатын хувьд санал оруулсан шүү дээ. Хуучнаасаа салцгаан л даа бид нар. Гэгээн дурсгалыг хүндэтгэхгүй гэх юм бол больё. Миний саналыг хэлэлцүүлэхгүй гэд гээд баталъя. Би заавал санал хураалгахыг хүсч байна. Би тэгвэл ганцаараа зогсоё.

Хамгийн гол нь бид нар шинэ үе руу орох гээд байна шүү дээ. Нөгөө хуучин, шинэ тогтолцоо руу орох гэж байна.

Тийм учраас тэр сайхан хүмүүсийн, гэм зэмгүй олон арван мянган сэхээтэн байж байгаа, лам хуврагууд байж байна, гэм зэмгүй олон ардууд байж байгаа, малчид байж байгаа. Тэднийхээ гэгээн дурсгалыг яагаад хүндэтгэж болдоггүй юм бэ?

Хэрвээ энэ хүмүүсийг хэлмэгдүүлсэн нь зөв гэсэн юм бол би саналаа татаж авлаа. Энэ үнэхээр зөв, хэлмэгдүүлдэг асуудал нь зөв гэдэг юм бол, би тэгвэл саналаа татаж авлаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан -Бид ингэж их улс төржүүлж, олон юм руу саналаа явуулмааргүй байна. Дэгээ баримтаар байна. Цөөнхийн саналаа сонсоод санал хураалтаа явуулъя гэсэн саналтай байна.

Бид мэдээж хэрэг Их хурлын депутат санал тавьж байна, хүндэтгэж байна, бид бүгдээрээ ойлгож байгаа, хэлмэгдэгсдийнхээ дурсгалыг бид хүндэтгэнэ, хүндэтгэлгүй яах вэ. Бид эсэргүүцэж байгаа юм байхгүй ээ. Гагцхүү бид хуралдааныхаа дэгийг барьж цагаа жаахан хожиж авмаар байна.

-Нэгдүгээр микрофон. -За олон хүн гайхаж байгаа байх.

Билэгсайхан -Би нэг ийм хүсэлт тавьж байна. Би саналаа заавал хэлэлцүүлэх хэрэгтэй шүү дээ. Өөрөөр хэлбэл миний саналыг дэмжиж байгаа депутатууд босч хүндэтгэхийг хүсч байна. Хэрвээ ингэхгүй бол дахиад л шинэ батлагдах хууль маань хүний эрхийг хамгаалах баталгаа байна уу гэж.

Ж.Уртнасан -Та бид хамтын оюун ухаанаараа л шүүж батална шүү дээ Билэгсайхан депутат аа. Нэгдүгээр микрофон.

Дашбалбар -Би олонхийн саналыг дэмжиж, олонхийн талд байгаа хүн. Гэхдээ би ийм юм хэлье гэж санасан юм. Эхлээд цөөнх нь уур нь хүрч магадгүй. Яагаад гэвэл би олонхийг хамгаалж ярих учраас. Сүүлд нь /сонсогдоогүй/ Тэгэхээр би аливаа юм аргумент сайтай учраас би эхлээд өөрийнхөө бодлыг хэлэх гэсэн юм. Гэхдээ би цөөнхөд багтаж байгаа гэдгээ сүүлд нь хэлнэ гэж хэлсэн ганц хоёр өгүүлбэрээр. Ардчилал, олон ургальч үзэл гэж байгаа бол хэн нэг депутат нь хэн нэг депутат руугаа уг хэлээр дайрахгүй байгаасай гэж бодож байна. Уг хэлээр дайрна гэдэг бол ардчиллын хамгийн тод илрэл биш байх гэж бодож байна. Тэгэхээр би Үндсэн хуулийг гэж нэрлэснээр бид нар хэлмэгдүүллийг дэмжиж байгаа юм огтхон ч биш гэж бодож байна нэгдүгээрт. Хоёрдугаарт, Үндсэн хууль гэж нэрлэснээр монгол уг биш орос уг болж байгаа юм гэж зарим нь хэлэх гээд байх шиг байна. Үндсэн хууль гэдэг бол мэдээж монгол уг. Нөгөө талаас гэвэл уг үсэг хөөцөлдөөд байна гэж байна. Хэрвээ Үндсэн хуулийг уг үсэг бүгдийг нь

нягтлахгүй юм бол бид Үндсэн хууль болгож чадахгүй. Үүнийг бас санах ёстой. Их цааз гэдгийг би эсэргүүцэж байгаа. 2 сая монголын ардтүмнийг цаазлахгүйгээр юм бол Их цааз гэдэг үг хэрэггүй. Энэ бол монгол үг биш манж хятадаас гаралтай үг. Үүнийг давхар хэлэх гэсэн юм. Хоёрт гэвэл Үндсэн хууль гэдэг оноосон ч нэр мөн, үндсэн ч нэр мөн гэдгийг санах ёстой. Ер нь би нэг юмыг сайн ойлгохгүй байна. Македон Александр нэг хүнийг байнга дагуулж явдаг байсан, тэр хүндээ хэлдэг байсан. Өглөө болгон сануулж байгаарай. Үхлийг сана гэж. Чингис хаан хэлдэг байсан. Тангууд улс өмнө байгааг өглөө болгон сануулж байгаарай гэж. Тэрэн шиг энд би цаг үргэлж жүжиг тавигдаж түүнийг найруулж байгаа шүү гэдгийг өдөр болгон депутатуудцаа сануулж байх юмсан гэж бодож байна.

Хоёрдугаарт, оноосон нэр гэж яриад байна. Оноосон юмуу оноогоогүй нэр гэж ерөөсөө байхгүй. Энэ бол махенац үндсэн хууль гэдэг бол оноосон нэр ч мөн, тодорхой нэр ч мөн. Гэхдээ би эв эеийг сахихын үүднээс энд би өөрийнхөө аргументийг сүүлд нь хэлнэ гэсэн. Цөөнх нь яаран битгий уурлаарай гэж хүсэх байна.

Үндсэн хуулийн тухайд бол Цэвээн Жамсранов гуай сайн ноён хааны зарлигаар гэдэг юмуу хүсэлтээр улсын эрх гэдэг өгүүлэл 1914 онд бичсэн. Тэрэндээ Үндсэн хууль гэж дурдсан гэж манай томоохон сэхээтнүүд хэлж байгаа. Хоёрдугаарт, 1924 онд Ардын засгийн түр газар Богд хаан хоёрын тангарагийн гэрээнд Үндсэн хууль гээд заачихсан байгаа. Түүхэн баримт ерөөсөө байхгүй гээд хэлээд байгааг би гайхаж байна. Үзэл бодол гэдэг бол үзэл бодол байх ёстой. Хэдэн хундага архи, таваг хоолоор бид үзэл бодлоо худалдаад байж болохгүй байх гэж бодож байна. Нөгөө талаас гэвэл Үндсэн хууль гэдэг нэрээс болоод бид хэлмэгдээгүй, харин Үндсэн хуулиа хэрэгжүүлээгүйгээс болоод хэлмэгдэж байсан. Үүнийг бас сайн санаасай гэж санаж байна. Хоёрт, үнэхээр Үндсэн хуулиа биелүүлье гэж боддог юм бол Улсын бага хурлын байнгын хорооны дарга Энхсайхан Ардын эрх сонин дээр бичихдээ Үндсэн хуулийг баримтлах хэрэг байхгүй, төгөх юм бол ардчилал хохирно гэж өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндсэн

хуулиа зөрчөөд хууль тогтоох байгууллагын гишүүн өөрөө хэлж байсан шүү. Үүнийг би санахыг хүсч байна. Ингээд би хамгийн сүүлд нь цөөнхийн саналыг яагаад хамгаалж байна гэдгээ хэлье. Үүний өмнө бас нэг үг хэлчихье. Монгол хэл орчуулгын хэл болсон гэж надтай санаа нэгтэй зарим нөхдүүд хэлж байна. Монгол хэл хэзээ ч ялагдаж байгаагүй, монгол хэл монгол хэвээрээ байгаа шүү. Монгол хэлийг орчуулгын хэл болсон гэж үзэж болохгүй. Ингээд би ганцхан санал хэлье. Үүнийг дэмжиж ч магадгүй, дэмжихгүй ч байж магадгүй, энэ бол нэг хүний санал. Болохгүй бол Их хууль гээд нэрлэчихье.

Ж. Уртнасан - За гуравдугаар микрофон.

18 дугаар тойргийн депутат Ганболд - Ер нь одоо ингээд дийлэнх улсууд нэр томъёоны талаар саналаа хэлж байна. Миний бодлоор бол эхний ээлжинд үндсэндээ хэл томъёоны улсууд, хуульчид, манай түүх судлалын улсууд хэлсэн. Тэгэхлээр өнөөдөр энэ нэр томъёоны хувьд мэргэжлийн талаас хандах хандлага, энэ талаар хэлэх зүйл бол үндсэндээ нийт улсуудын хэлснээр шавхагдаж байна гэж ойлгож байна. Тэгэхлээр үүнийг судлаагүй улсууд ямар нэгэн хэмжээгээр үүнээс хөндий улсуудын хувьд бол ямар шалгуураар энэ асуудалд хандах вэ гэдэг ийм асуудал гарцаагүй тавигдаж байгаа. Үүний тоонд би өөрийгөө оруулж байгаа. Ялангуяа өнөөдрийн залуу үе бол бид нар өөрсдийгөө, би хувьдаа эмзэглэж явдаг. Аливаа асуудалд үнэхээр монгол сэтгэлгээгээр хандаж чадаж байна уу үгүй юу гэдэг дээр байнга эмзэглэж явдаг хүн. Бид бол ямар нэгэн хэмжээгээр ихэнх нь зөвлөлтийн боловсролтой, ихэнх зүйлээ хуулж, дууриаж явж ирсэн нь үнэн. Тийм учраас миний хувьд бодогдож байгаа зүйл юу байна вэ гэхлээр нэгэнт өнөөдөр мэргэжлийн хүрээнд хэлэлцэгдсэн, мэргэжлийн хүрээнд бүх дүгнэлтүүд гарч ирээд, хэл, хууль зүйн, хэл зүйн хүрээнд гарч ирсэн нөхцөлд бид хэд хэдэн шалгуураар энэ асуудлыг энэ хуулийг яаж нэрлэх вэ гэдэг асуудал дээр хандах хэрэгтэй байх аа. Энд жишээлбэл, цаг үеэ зөв тусгах асуудал байна, хоёрдугаарт, жинхэнэ монгол нэр болж уу үгүй юу, гуравдугаарт, үнэхээр бид нарын тэр хүрэх гээд байгаа нийгмийн үндсийг тавьж өгөх, тэр тунхаглах гээд байгаа үндэснийхээ тусгаар тогтнолыг илэрхийлж чадахуйц ийм

үг болж чадаж уу гэдэг хэд хэдэн шалгуур байх ёстой. Миний хувьд бол, нийт депутатуудын хувьд ч бас тийм байгаа байх. Үнэхээр бид өнөөдөр ярьж байгаа юм. Маш хариуцлагатай үед цуглачихсан улсууд аа гэж. Хариуцлагатай үед цуглаад хамгийн эхний хариуцлагатай тодорхой шийдвэрээ гаргах гэж байгаа. Тийм учраас энд үнэхээр хариуцлагатай хандаж бие даасан тусгаар улс, үнэхээр монгол төрийнхөө загварыг сэргээх гэж байгаа гэдгээ монгол уламжлал угсаагаа авч байгаа гэдгээ илэрхийлж чадах юм бол энэ орчуулгынхаа сэтгэлгээнээс салъя гэсэн бодолтой байна. Аль 1924 онд Зөвлөлт улс өөрөө батлахдаа халилтан дотроо хийж гаргаж ирсэн Основное закон гэдэг үгийг орчуулаад бид өнөөдөр энэ үндсэн хуулийнхаа баримт бичгийнхээ Их цаазынхаа хавтсан дээр тавих юм бол хов живийнхээ өмнө буруутан болох байх аа. Ийм учраас эцэст нь өнөөдөр хүн болгон ард түмний санал гэж ярьж байгаа. Тэгэхээр бид ард түмний саналын дагуу буюу өнөөдөр санал хэлж байгаа цөөн хүний хэлсний дагуу шийдэх үү, эсвэл ард түмнийхээ ашиг сонирхолд нийцүүлж шийдэх үү гэдгийг ялгаж ойлгох ёстой. Тийм учраас үндсэндээ ард түмэн ялангуяа хойч үеийнхээ ашиг сонирхлыг үндэс болгоод бид үүнийг живхэнэ монгол нэр орчуулгын сэтгэлгээнээс салж нэрлээ гэсэн саналтай байна.

Их цааз гэдэг үнэхээр түрүүний депутатуудын хэлснээр ямар нэгэн хэмжээгээр ихээхэн сэтгэжээ. Тийм учраас энэ уламжлалаа дагаад Их засаг гэдэг нэрээр энэ хуулиа нэрлээ гэсэн саналтай байна.

Ж. Уртнасан -4 дүгээр микрофон.

63 дугаар тойргийн депутат Пүрэвлагва -Энэ дээр бас ганц нэг юм хэлэхгүй бол болохгүй нь ээ. Ер нь монголчууд бид чинь өөрснийгөө бурангуй бүдүүлэг гэж бодоод, бусдаас зээлдэх сэтгэлгээгээр амьдардаг энэ хэвшил сүүлийн 70 жилд л бий болсон шүү дээ. Харин соёлт хүн төрөлхтөн монголчууд биднийг дэлхийн соёл иргэншилд ихээхэн зүйл хувь нэмэр оруулсан ийм нүүдэлчин улс гэж ингэж үздэг юм байна. Монголчууд биднийг модон

тэрэгний цөн араанаас эхлээд тэрт ёсны уламжлал хүртэл олон эүйлээр дэлхийн соёл иргэншилд хувь нэмрээ оруулсан гэж үздэг юм байна. Ийм үүднээс аваад үзэхэд Их засаг анхдагч уу, конституц гэдэг нэр томъёо анхдагч уу гэдгийг депутат та нар минь бодооч ээ. Их баярлалаа.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

178 дугаар тойргийн депутат Энхбаатар -Аливаа ард түмэн бол эрс шинэчлэл, хувьсгал өөрчлөлтийг хийхэд бас их хүлээж авдаггүй юм байна л даа. Ялангуяа Азийн ард түмэн бол. Тэгэхээр бид нар бол бид нар чинь олонх цөөнх болоод байгаа чинь бидний буруу биш. Үнэхээр бид чинь Азийн ард түмэн болсон монгол улсыг бүрэн төлөөлж ирж байгаа өнцөг булан бүрээс нь ирсэн ийм депутатууд энд байна. Бидний, ард түмний дунд байдаг хөшүүн сэтгэхүйг тэр чигээр нь өөрснөө өөрөө тээгээд аваад явж байгаа болохоор иймэрхүү юм байгаа байх. Нөгөө талаас бид нар чинь төрийн эрх барих дээд байгууллагын гишүүд шүү, депутатууд шүү гэдгээ ойлгоод үзэх юм бол өндөө талаас нь харж болох байх. Бид үнэхээр шинэ монгол улсыг байгуулах гэж байна. Эндээс чинь бүх юм эхэлнэ. Одоо ихэнх нь ярьж байна. Уламжлал, түүх соёлоо сэргээе гэж байна. Тэгэхээр эргээд нэг харцгаая. Юу юугаа сэргээх гээд байгаа юм бэ бид нар хуруу дараад үзчихье. Хичнээн уламжлал, ямар юм байгаа юм бэ. Одоо бид нар чинь сэргээх гээд байгаа. Тэгэхээр биднийг чинь олон жил сургаж ирлээ шүү дээ. Чингисийн байлдан дагуулалтаас авахуулаад монгол улс бол мөхсөөр, сөнөсөөр, бутарсаар, задарсаар байгаад л яг мөхлийн даваан дээр Ардын хувьсгал ялаад Хувьсгалт намаар толгойлуулаад социализмыг бариад л удахгүй коммунизмд ороод жаргах гэж явна гэж. Нэг ухаантай хүн ингэсэн гэсэн. Чингисийн үеэс авахуулаад 1921 он хүртэл унасан юм бол асар өндөр дээрээс унасан юм байх нээ дээ. Үнэхээр асар өндөр дээрээс унасан байгаа юм. Ингээд харах юм бол бидэнд бахархмаар, дэлхий дээр гайхуулмаар юм зөндөө байгаа юм. Бид нар тэр цагаан шонхор шувууг шүүмжлээд л байна. Гэтэл дэлхий дээр нэг ч улс шувуугаар төрийнхөө сүлдийг хийгээгүй байхад монгол улс цагаан шонхор шувуугаар сүлдээ хийчихээд явж байсан. Дэлхий дээр

ном хэвлээгүй байхад монголчууд анх ном барлачихсан байсан. Дэлхий дээр ерөөсөө парламент гэж байхгүй байхад Онон мөрний эрэг дээр чинь анхны парламент их хуралдай хуралдаж байсан. Дэлхий дээр ямар ч улсад үндсэн хууль байхгүй байхад монголчууд их цаазтай байсан. Америкийн үндсэн хууль 200 жилийн түүхтэй гээд магтаад л байдаг, манай Их цааз чинь өвөг эдэг нь болохоор Их цаазтай байсан шүү дээ. Энэ бүгдийгээ бид нар буцааж сэргээе, энэ уламжлалаа гаргаж ирье, энэ монгол улсынхаа өвөрмөц энэ юуг дэлхий дээр олон юмаар бахархах ёстой улс. Тэрийгээ бүгд мартчихсан. Одоо Монгол улс гэж дэлхий дээр бидний магтаад байгаа Америк, Япон, Англи, Францын хаана нь ч очоод жирийн хүнээс монгол гэж хаана байдгийг асуухад мэдэхгүй шүү дээ. Газрынх нь, нутгийнх нутаг дэвсгэрийн ~~дэлхийн картан дээр~~ зааж өгч чадахгүй, Чингисийн Монгол гэж нэг юм байдаг юм гэж толгойд нь байдаг юм билээ. Тэгэхлээр бид нар тэр дээр үеэс уламжлалтай энэ хэдэн юунуудаа сэргээе гэсэн ийм санааны үүднээс энэ Их цаазыг дэмжье гэж бодож байна.

Нөгөө талаас бид нар бас нэг дасамтгай улсууд юм. Дээр үед чинь сүй тавиад ахуй амьдрал дээр ч гэсэн нэг ноён нэг тайжтай сүй тавиад нэг охиныг нь аваачаад хүүдээ өгчихөөд тэгээд яваандаа дасна биз, гэр бүл болоод явна гээд үнэхээр дасаад л тэр нь гэр бүл болоод л явдаг. Тэрэн шиг төрийн сүлдийн маань Сталин багш манайд өгчихсөн, май үүнийгээ ав гээд тугийн тухай мэдэхгүй, Улаанбаатар хотыг ч нэг орос хүн Улаанбаатар гээд нэрлэчихсэн, бид нар чинь сүүлийн 70 жил, сүүлийн 40 жил үнэхээр бүх юманд дасчихаж. Салж чадахгүй гээд байх юм. Үнэхээр шинэ Монголыг байгуулья гэж байгаа юм бол бүх л энэ уламжлалаа сэргээгээд бүх л юм өөрөө өөрийгөө цэвэршүүлээд шинэчилье гэсэн энэ үүднээс хандаж уламжлалаа сэргээе гэж байгаа бол Их цааз гэдэг дээр тогтох нь зүйтэй байх аа гэж бодож байна.

Ж. Уртнасан -6 дугаар микрофон.

393 дугаар тойргийн депутат Баасанжав -Тэгэхээр би хамгийн эхлээд хурлын даргадаа хандаж уг хэлмээр байна.

Бид хурлын хамгийн анхны өдрөөс эхлээд ямар нэгэн үл мэдэгдэх хорооны тулгалт юмуу шахалт юмуу нэг бичгийг уншиж сонгосон. Дараа нь энэ дотор үндсэн хуулийн нэрийг, бусад ер нь л энэ өөрчлөлт хийх юм бол амиараа дэнчин тавина шүү, өөрчлөлт хийхгүй байх явдлыг хамгаална гэсэн ийм юуг уншиж сонгосон. Дараа нь Бага хурлын гишүүдийг өрөөсөө ийм уур амьсгалд оролцуулахгүй гэж эндээс дэгдэж ирлээ. Энэ бүхэн бол еер хоорондоо холбоотой юмуу, хайш нь хурлын дарга маань сая пропердурин алдааны тухай олон хүн хэлсэн. Тэрнийг давтахгүй, энэ алдаа ч гэсэн бас үүнтэй холбогдоод байгаа юм биш үү. Тэгэхлээр дарга минь дотоод сэтгэлдээ удирдагдаад байна уу, гадаад сэтгэлдээ удирдагдаад байна уу гэж бас нөхөр ёсоор хэлмээр байна. Ингээд дараачийн асуудал бол би түрүүн хэлсэн. Гэрийнхээ ханыг нь **дугуйлж бүсийг нь татахгүйгээр** унь, тооно өлгөх гээд байх шиг байна гэж. **Энэ хананы тухай одоо би хэлье.** Энэ хана бол хүний эрх ээ. Хүний эрхийг бол мөнгөтэй бол хийнэ, мөнгөгүй бол орхичихно гэх шиг нилээн олон хүн санаад байх шиг байна. Тэгвэл бид мөнгөтэй ч бай, мөнгөгүй ч бай улс төрийн системээрээ хүний эрхийг баталгаажуулах гэж байгаа гэж би ингэж ойлгож байна. Би энэ тухай ганцхан баримтыг одоо сая маргаад байгаатай холбогдуулаад хэлье.

Хүний эрхийг дээд зэргээр хөндсөн газар яадаг вэ гэхлээр Чилийн хунтын гашуун их хэлмэгдүүллэйн төлөө Чилийн шинэ ерөнхийлөгч бүх ард түмнээсээ уучлал гуйж байх юмаа. Тэгэхдээ тэр өөрийнхөө нутаг ард гуйгаагүй шүү. Хүний эрхийн талаас нь гуйж байна. Германы Гельмут Коль хоёр германы нутгаас дэлхийн хоёр дайн эндээс гарсанд баг европын ард түмнээс уучлалт гуйж байх юмаа. Японы эзэн хаан мөн уучлалт гуйж байх юмаа Хятадын ард түмнээс. Америкчууд Хиросин, Нагасакт бөмбөг хаясныхаа төлөө уучлалт гуйж тэнд асар их мөнгөн тусламж өгч байх юмаа. Тэгэхлээр энэ бүхэн бол уучлал ер нь урьдахаасаа яаж салах вэ, яаж шинэ байдалд орох вэ гэдэг сэтгэлийн тэнжээг харуулах ийм юм байдаг юм байна шүү гэдгийг би зориуд тэмдэглэж хэлье гэж бодсон юм. Ингээд би дараа нь саяныхаа ярьж байгаа энэ сүлдтэйгээ, хуулийнхаа нэртэй холбогдуулаад нэг зүйл хэлье. Тэгэхлээр хуулийн нэрийг би түрүүн хэлсэн. Тэгэхдээ бас аргумент хэлье. Хуулийн нэр

гэдэг бол Их засаг байн гэж. Бидэнд ямар нэгэн өөр өөрийнхийгөө тулгаад, өөр өөрийнхөө полици дээр юу яагаад тэрэндээ мугуйдлан зүтгээд байх юм байхгүй, бидэнд альтернатив санал олдог ийм чадал байх хэрэгтэй байх гэж бодож байна. Энэ чадалтай байхыг төрийн түшээ байх хүний шинэ чанараас шалтгаална шүү гэж хэлээд биднийг явуулснаас биш миний үгийг дамжуулж хэлээд ирээрэй, тэгээд гүйцэх нь тэр шүү гэж явуулаагүй гэж би өөрийгөө ухаарч байгаа. Ийм юм бол Монголчуудын дэлхийн соёлд оруулсан түүх гэж сая хэллээ. Өдий төдий жилийн түүхэнд монголчууд нууц товчоо гэдгээрээ алдаршиж орсныг ноднин тив дэлхийнхэн монголд ирсэн 750 жилийн ой харуулсан биш үү. Тэгвэл тэр нууц товчоонд чинь орчихсон Их засаг гэдэг хуулиараа Үндсэн хуулиа нэрлэчихэж болохгүй яах вэ. Тэгэхэд бид нар одоо болтол байсан үндсэн хууль бол үнэхээр хэлмэгдүүллийн дээр байсан ийм хууль гэдгийг би бас хэлэх байна. Харамсалтай нь энэ хуулиа барьж олон дахин хэлмэгдүүлж байсан учраас үүнийг учрыг мэдэхгүй хүн мэдэхгүй байх шиг байна. Би бол бас чиг мэдэхийн нэгэн хувьд мэдэхийн амьд гэрчийн хувьд энэ хуулиудын наран дор, өөрөөр хэлбэл 70 жилийн, энэ үндсэн хуулиудын наран дор монгол түмэн, монголын соёл, монгол хэл, монгол бичиг, сүм хийд, хичнээн олон хүн хэлмэгдсэн билээ гэдгийг эргэн бодоход бид хуулиа, нэрээ ч өөрчлөх хэрэгтэй юм байна. Гэм зэмгүй, түмэн олондоо амар амгаланг тунхагласан энэхүү их засаг гэдэг хуулиндаа байхад аль алиндаа нэг их зүүгүй таарч байгаа юмуу гэж бодож хэлэх гэсэн юм. Баярлалаа.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Э. Баяндүүрэн

/Д. БАЯНДҮҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

Их хурлын даргаа.

184 дүгээр тойргийн депутат С.Билэгсайхан: Тэгэхлээр миний саналыг хүлээж авсангүй та нэгдүгээрт. Энэ бол уг нь хуучнаасаа салъя гэсэн тийм албан ёсны тийм төрийн уучлал үзүүлэх ёстой байсан юм бид нар. Хоёрдугаарт би горимын санал хэлмээр байна. Өөрөөр хэлбэл энэ Их цааз, Үндсэн хууль, Их засаг гэсэн энэ нэрүүдээр нэрээр нь санал хураалгамаар байна. Нэрээр нь. Тэгээд сонин дээр албан ёсоор тийм тийм депутатууд Үндсэн хуулийн төлөө, тийм тийм депутатууд нь Их цаазын төлөө өглөө гэсэн ийм асуудал гаргаачээ гэсэн ийм хүсэлт байна.

Билэгсайхан аа. Саналаа татаж авч болохгүй. Би Билэгсайханы саналыг дэмжиж байна.

Билэгсайхан: Би саналаа татаж аваагүй шүү дээ.

Элбэгдорж:

Ердөөсөө тэр гэм зэмгүй амь үзэгдсэн олон зуун охид, хөвгүүд, тэр олон зуун монголчуудын тэгээн дурсгалыг хүндэтгэх ганц газар бол Ардын Их Хурал. Ардын Их Хурал гэдэг энэ утгаараа дахин хуралдаачуу, үгүйчүү. Одоо хүндэтгэх цаг хугацаа нь гэвэл тэр үед мөрдөж байсан их хуулиасаа нөгөө нэг их хууль руу орох гэж байгаа яг энэ зааг мөч дээр бид нар хүндэтгэх ёстой. Монгол улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөө, сайн сайхны төлөө харгис дэглэмийн уршиг, гадны шахалтын эрхшээлээр амь үрэгдсэн охид, хөвгүүдийнхээ төлөө нэг минут хүндэтгэл илэрхийлье, эмгэнэл илэрхийлье гэсэн ийм үгтэйгээр энийг хийх ёстой. Одоо хийх ёстой. Өөр цаг хугацаа байхгүй. Их цааз, Үндсэн хууль гээд юмуу ингээд цаашаа явчих юм бол энэ цаг мөч, энэ торгон мөч ингээд алдардана. Одоо хийх ёстой. Энийг шаардаж байна. Билэгсайханы саналыг дэмжиж байна.

Билэгсайхан: Би бол саналаа татаж аваагүй байгаа шүү дээ. Миний саналыг хүндэтгэхгүй байна гэж үзээд байгаа юм.

Элбэгдорж:

Тэр Монголын төрт ёс, билэгдлийн сэтгэлгээ, уламжлал заншлыг бүгдийг устгасан энэ түүхээсээ бид нар нэг минутаар одоо салъя л даа. Яагаад болдоггүй юм бэ.

Танхимаас:

Наадахь чинь бодууштай л даа. Тэгэхдээ дэгэнд нь оруулж анхнаас нь ярилцахаа яасан юм бэ. Дундуур нь юу гэж оруулаад байгаа юм бэ.

Элбэгдорж:

Яахаараа дундуур нь депутат санал гаргаж ирж тавьж болдоггүй юм бэ. Дэгэнд нь оруулахаа мартсан байж болно. Одоо яг энэ торгон хором дээр тавья гэж бодож байсан байж болно шүү дээ.

Билэгсайхан:

Тэгвэл энэ олонхийн санал хураалгая л даа. Миний саналыг.

Элбэгдорж:

Үгүй санал хураах ёсгүй. Хүндэтгэж байгаа нь босох ёстой.

Билэгсайхан: Тэгвэл хүндэтгэж байгаа нь босоод зогсчихье. Тэгвэл.

Их хурлын дарга удирдах ёстой шүү дээ.

Танхимаас: Дарга хуралаа удирдая.

Дарга хурлаа удирдаарай.

Элбэгдорж:

Их Хурлын дарга удирдах ёстой шүү. Ярилцаж байгаа асуудал руугаа орёе, хөндийрчихлээ, цаг хэмнээ гэдэг байдлаар ийм их агуу их энэ цаг мөч, торгон хоромыг бид нар өнгөрөөж болохгүй.

Та түрүү тийм асуудал тавьж байсан.

Билэгсайхан:

Надад бол маш олон жагсаалт байгаа. Өчнөөн, төчнөөн хүнийг дээд хэмжээ, арван жилээр авсан тийм жагсаалт байж байна. Тэр хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэж яагаад болдоггүй юм бэ.

Танхимаас:

Билэгсайхан депутат аа. Анх бол тэгж хэлээгүй шүү дээ.

Энэ 400 гаруй депутатыг төрийн өмнө буруутай, урьд 70 жилийнхээ нуглийг хүндэтгэе гэсэн утгаар хэлсэн учраас төрийг хүлээж аваагүй шүү дээ депутатууд. Ингэж асуудлыг тавих байсан бол арай өөр байх байсан байх.

Бид уг нь дэгээ барьж хуралдмаар байх юм. Хэлэлцэж байгаа үндсэн асуудлаа яримаар байх юм. Хэлмэгдэгсдийн талаар дүгнэлт авах гэж ингэж хуралд дарамт үзүүлэхийг би хувьдаа, зүгээр хэлмэгдэгсдийн талаар гаргасан шийдвэрийг бид өөрчлөх гээгүй, түүнийг

буруу гээгүй.Тэгэхээр бол дэг журмаараа явж байгаа байх.Хэлэлцэж байгаа.Тэгэхээр бид хуралдаанаа хүндэтгэмээр байна, хэлэлцэж байгаа асуудлаа хүндэтгэмээр байна.Харин зүгээр харилцан бие биенээ шүүмжилж байж дутагдлаа засах явдал байлгүй яах вэ.Тэгэхээр цаг алдаж байна.

Бид тэгэхээр одоо цөөнхийн саналыг сонсоод дахин санал хураалтандаа бэлтгэмээр байна.

Элбэгдорж:

Ардын Их Хурлын удирдлага албан ёсоор хүлээж авсангүй шүү.Энийг хүндэтгэх асуудлыг депутатууд тавьсан, албан ёсоор Ардын Их Хурлын удирдлага хүлээж авсангүй.

Билэгсайхан:

Тэгвэл албан ёсоор энэ гэгээн дурсгалыг манай депутатууд хүндэлсэнгүй гэдгийг би албан ёсоор телевиз, радиогоор мэдэгдэнэ.Би ийм санал оруулахад дарга хүлээж авсангүй шүү дээ.Тийм биз дээ.Гэгээн дурсгалыг хүндэтгээч гэж албан ёсоор би Ерөнхийлөгчид тавьлаа,Ардын Их Хурлын даргад бас тавьлаа.Тийм биз дээ.Энэ чинь зарчмын асуудал шүү дээ.

Цагдарсүрэн:

Тэгэхээр бид бол энд сууж байхдаа энд байгаа депутатуудаас нэлээд үгийг сонссон.Юу гэж сонссон бэ гэхээр бид бол төрийн эрх барих дээд байгууллагын хүмүүсээ, төлөөлж ирээд ингээд байж байгаа хүмүүсээ гэж ингэж ярьж байгаа.Тэгэхээр үнэхээр түрүүний зарим нэг хүмүүстэй санал нэгтэй байгаа.Ард түмэн гэж яриад байдаг нь бас учир дутагдалтай шүү үнэхээр.Ард түмэн бол төрийнхөө бодлогыг тодорхойлоход оролцдог болохоос биш тодорхойлдог биш шүү.Энэ үүднээс нь хандвал ард түмэн гэж их хольж яримааргүй байна.Нэгэнт л одоо... Би семинар өгөөгүй гэж бодож байна.Энийг семинар уу, үгүй юу гэдгийг дарга хэлж өгнө биз дээ.Тэгэхээр би үгээ хэлчихье гэж бодож байна.Энд бол хүмүүс өөрсдөө өөрсдийгөө тэгж байгаа.Би депутатын хувьд, бид ард түмнийг төлөөлж ирсний хувьд.Би хувьдаа тэгж хэлж чадахгүй гэдгээ түрүү хэлсэн.Ер нь ард түмэн бол төрийн бодлогыг тодорхойлоход оролцдог болохоос биш яг тодорхойлно гэсэн юм өнөөдөртөө байхгүй байгаа шүү.Төрийн эрх барих

дээд байгууллагын төлөөлөгчид тэднийг төлөөлж ирснийхээ хувьд энд үнэхээр өөрсдөө одоо тодорхойлох ёстой. Энэ үүднээсээ хууль болбол бодлого гэж ингэж ойлгогдож явдаг юм байна лээ. Ингээд үзэхээр би ингэж холбож хэлж байгаа юм. Тэгэхээр өөрсдөө жинхэнэ өнөөдөр түрүү бол зарим нэг гишүүн хэлсэн. Бидэнд өнөөдөр өөрийнхөө нэрийг өөрсдөө өгөх тийм боломж олдож байгаа үе бол мөн гэж. Энэнтэй би 100 хувь санал нэгтэй байгаа гэдгээ хэлье.

Хоёрдугаарт зарим нэг хүмүүс ингэж байгаа. Энэ бол манж уг, энэ бол түвд уг. Энэ бол юутай холбож үзэж байна вэ гэвэл бид юмаа мартсантай холбоотой. Түүхийн зурвастай холбоотой гэж үзэж байна. Тэгээд би нэг зүйлийг хэлэх гэж байна. Ер нь дэлхийд болбол хэлийг, аливаа улс орны хэлийг аваад үзэхэд түүний бараг 60, 70 хувь нь гадны үгээс бүрддэг юм гэнэ лээ шүү. Ийм юм байдаг юм байна лээ. Хэрвээ яг энэ уг хаанаас гаралтай юм бэ гэвэл ном мэтчилэнгийн үгнээс эхлээд ярьцгаах юм шиг байгаа юм. Тэгэхээр энэн дээр нэг их айхтар яагаад баймааргүй байна гэж ингэж хэлэх гэж байна.

Туравдугаарт саяны тэр депутат хүний тавиад байгаа саналыг би үнэндээ бас дэмжиж болж байгаа юм. Зүгээр цаг хожигдсон байж болно. Энэ бол яагаад гэвэл бид шинэ үед шилжиж Үндсэн хуулийн нэрээ өөрчилж, яг өөрчлөгдөх гэж байгаа зааг мөн гэдэг үүднээс нь би хандаж тэрнийг дэмжихэд бэлэн байж байгаа хүн гэдгээ хэлье.

118 дугаар тойргийн депутат Л.Мамбалдорж: Хурлын дарга ер нь хурлаа жаал удирдмаар байна. Ер нь нөхөр журмын хувьд хэлэхэд ийм байна.

Яагаад вэ гэвэл бид эхний асуудлыг бид ярилцаад 5 цаг гаруй болчихлоо. Энэ чинь 70 зүйлтэй, 200 гаруй хэсэгтэй юм байж байгаа. Ингэх юм бол бид 1000 гаруй цаг хуралдаж байж одоо хуралдаж таарахгүй байна. Ийм учраас Ардын Их Хурлын дарга зарим санаачилгыг гартаа авна гэж байгаа. Тэгэхээр би бодож байна. Үндсэн хууль, Их цааз, Их засаг гэдэг дээр бүгд ерөнхий

юмуу, оноосон юмуу гэдэг дээр хүн болгон яг тийм гэж хэлж чадахгүй байна шүү дээ. Бүгд л бол оноосон бол оноосон, ерөнхий бол ерөнхий гэсэн хандлагатай байна.

Тийм учраас та хурлын даргын хувьд ерөөсөө Үндсэн хууль гэдгийг бүрэн авч хаяад Их цааз, Их засаг гэдгээр нь шууд оруулаад санал хураалгах хэрэгтэй. Ингэх юм бол бидний асуудал нэлээд хурдан шийдэх болов уу гэж бодож байна.

19 дүгээр тойргийн депутат Б.Батсайхан: Надад энэ депутатуудын анхааралд хандуулаад нэгэн зүйл байна л даа. Энэ ямар учиртай юм бэ гэхээр бид өнөөдөр бүтэн өдөр боллоо, ямар ч асуудал шийдсэнгүй. Энэ дээр байгаа депутатууд бол бүгдээрээ сонгогч түмнийхээ саналыг бодож байна гэж байгаа. Энэ их зүйтэй юм шиг байна. Тэгээд өөрийнхөө нэг саналыг хэлэхгүй бол болохгүй юм шиг санагдлаа.

Энэ дээр ийм зүйл байна. Бид 70 жил хөгжсөн. 70 жил хөгжихдөө бид бас 70 жил үйл явдлын хойноос биш, хойноос нь явсан, урд нь биш хойно нь явсан тал бий. Бид 70 жил хөгжиж ирэхдээ дэлхийн хөгжилтэй орнуудын хойно орсон уу гэхээс урд нь ороогүй байхаа. Тэгэхээр бид бол яахав гэхээр энэ дээр нэг зүйлийг тодотгож хэлэхэд бид энэ Үндсэн хууль гэж байгаа асуудлыг онолын талаар нь бүх улсууд ярьчихлаа. Бид Их засаг гэж байгаа асуудлаа би сонгогч өвгөний ярьсан нэг юм хэлчихвэл та нарт их ойр байх гэж бодож байна. Тэр хүн 19 дүгээр тойргийн 13 дугаар хорооны хөгшин. Энийг хэвлэл дээр бичсэн ч болно. Яагаад гэвэл надад ингэж захисан юм. Хүү минь Их цааз нь цаазаасаа Их засаг нь дээр юм. Энэ яагаад гэвэл бид Их засаг маань засаглалын хуулиудаар гарч ирж байсан. Их цааз гэхээр дархан цаазтай уул санаанд ороод байх юм. Бодоод байхад бас харьцангуйгаар ойлгоход зөв ч юм шиг байгаа юм. Дархан цаазтай уул гэвэл Богд уулаас авахуулаад дархан цаазтай ан амьтан гээд л нэг цаазалсан, хорисон юм шиг санагдаад байх юм. Харин Их засаг гэдгийг бид бүгд ихээр дэмжиж байна гэсэн ийм саналыг хэлж байсан юм. Ер нь бид бол өнөөдөр үйл явдлынхаа анхны алхам дээр гарч ирж байгаа учраас энийгээ Үндсэн хуулийн доторхи

агуулга маань ч шинэчлэгдэж байгаа учраас нэр нь хүртэл шинэчлэгдэх ёстой болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл хэлбэрээсээ агуулгад шилждэг, агуулга нь, хэлбэр нь ямар хэлбэртэй байна агуулга төдийчинээ баяжмал байх ёстой болов уу гэж бодож байна. Эцэст нь өөрийнхөө нэг саналыг хэлэхэд энийг болбол Их засаг гэдэг дээр нь ингээд санал хураалт явуулбал яасан юм бэ гэж бодож байна. Харин саяны депутат нөхөр Элбэгдорж, Билэгсайхан эд нарын хэлсэн зүйлийг энийг маш ухаалгаар бодож явахгүй бол энэ улс төрийн үйл явдал болно. Яагаад гэвэл энийг телевиз, радиогоор мэдээлэх юм бол БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатууд өнгөрсөн бүх хэлмэгдэгсдээ үл хүндлэв гэдэг асуудал дэлхий нийтэд цацагдах болно шүү дээ. Тийм учраас бид энэ асуудлыг харьцангуйгаар ойлгож авбал яасан юм бэ. Үнэхээр бид тэр олон зуун хэлмэгдсэн хүмүүсээ хүндэтгэхэд буруутах юм байхгүй, харин энийг болбол дэлхий нийт баяртайгаар хүлээж авна байх гэж бодож байна.

180 дугаар тойргийн депутат Д. Жумлаанбаатар: Бид бол бусад газрын хурал цуглааныг хараад байхад ингэж хуралдах ч гэж дээ гэж бас хэлж байсан. Гэтэл одоо дэлхий дахин, улс орондоо бол одоо төрийн түшээн нар зургаа авахуулж байна л даа. Тэгэхээр бид нар ингэвэл яасан юм бэ. Одоо энэ протоколыг хөтлөөд ер нь хэн хэдэн минут ярьж байна вэ. Сүүлд нь ингээд хурлын дун гарахад төдөн минутыг тэр хүн авчээ. Тэгж санал шүүмжлэл дахиж эргэж оржээ гэж ингэж дунг гаргамаар байна.

Хоёрдугаарт тэр саян тэр Билэгсайхан эд нарын ярьж байгаа энэ саналыг бас бодолцож үзэх ёстой. Энийг харин бид анхааралгүй үнэндээ дэгэндээ оруулсангүй. Тийм учраас одоо санал хураах нь шиг байна. Хуулийн. Энэ хураахын өмнө энэ хэлмэгдэгсдийн дурсгалын асуудлыг шийдэх нь зүйтэй байхаа гэж миний хувьд бодогдож байна.

Гуравдугаарт би бодож суулаа. Манай сонгогчид ч хүртэл хэлсэн. Тэр Их засгийг бол манжийн чиглэлтэй гээд байгаа юм. Манж руу орлоо гээд байгаа юм. Их цаазыг бол бид нарт хүлээж

авахад хүнд байна гэж байсан.Би бол өөрийн бодлоор бол Их цаазыг дэмжиж байсан.Энэ олон сар жилээр шахуу ноцолдож байж арай гэж гаргасан оноосон нэр нь Их цааз.Ингээд байдлыг ажиглахад Их цаазыг танхим хүлээж авахгүй шинжтэй байна.Ийм учраас бид бүх юмыг эхлэх гэж байна.Одоо ерөөсөө Үндсэн хуулиар эхлэх байсан.Тийм учраас одоо Монголын Эх хууль гэсэн энэ нэрийг аваад очиход бид сонгогчиддоо очиход Эх хууль гэсэн нэрнээс татгалзахгүй байхаа гэж.Ингээд Эх хуулиа ч эхлэнэ, цаашдаа шинэчлэлт ч энүүгээрээ эхлэх байхаа гэж ингэж бодогдож байна.Э шүү.Эх хууль.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Э.Мурза

ЭНХТҮЯА
В.ОМУН

Ардын Их Хурлын 429 дүгээр тойргийн депутат Д.Рэнцэннаг:
 -Би энэ дээр нэг ийм хоёр гурван зүйл ярьж гэж бодож байгаа юм. Хамгийн нэгдүгээрт энэ хуулинд одоо нэр онооё гэж байгаа асуудлыг, нэгэнт нэр оноосон хуулийг, онооно гэж байгаа асуудал чинь бол утгагүй асуудал аа гэж би ойлгож байна. Хоёрдугаарт, оноосон нэртэй хуулийн дэг, ерөөсөө дахиж санал авалгүйгээр эвсарладаг хурлын даргын эв гэж ойлгож байгаа. Ерөөсөө хууль гэдэг үгэн дээр ерөөсөө энэ чинь Үндсэн хууль гээд нэрийг нь оноогоод өгчихсөн хууль байна шүү дээ.

Цаашилах юм бол энэ дээр юу ярих гэж байна гэхлээр энэ нэгэнт нэрээ өгсөн энэ хуулин дээрээ бид нар эргэж тогтож, ард түмнийхээ саналыг нэлээн авах нь зүйтэй байх гэж бодож байна. Бид өнөөдөр бас нэлээн хэдэн хүмүүсүүд бид шинэчилэгдэж, өөрчлөгдөж байна гэж ярьж байгаа. Энэ Үндсэн хуулиараа байлгая гэж байгаа, энэ санал гаргасан олон зуун ард түмэн чинь өөрснөө бас шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа ийм ард түмний үг шүү гэдгийг зориуд эндээс хэлж гэж бодож байна. Хоёрдугаарт миний нэг ярих гэж байгаа зүйл бол зарим хүмүүсүүд олон зуугаараа хэлмэгдсэн хүмүүсүүдийн гэгээн дурсгалыг хүндэтгэе гэж ярьж байгаа юм. Тэгэхээр манай төр засаг энэ хэлмэгдсэн хүмүүсүүдийг бүгд ойлгож байгаа. Үнэн. Дарангуйлын засгийн үед олон зуун шилдэг хүмүүсүүд амь насаа алдсан. Тэрнийг засаг төр харж, хүндэтгэж, дурсгалын самбар, жагсаал, цуглаан зөндөө хийж байгаа, цаашдаа ч их хийнэ. Яг өнөөдрийн хувьд бол ерөөсөө ингээд энэ хуучин Үндсэн хуулиас болоод энэ бүх зүйлүүд ингээд хэлмэгдсэн учраас одоо бид босоод хүндэтгээд яана гэдэг бол миний бодож байгаагаар, ерөөсөө шинэчлэгдэн батлах гэж байгаа хуулиа батлаагүй байж өмнөх хуулиа үндсэнд нь ураад галд хийчихлээ л гэсэн үг байх. Ийм учраас энэ дээр жаахан бодож болгоовол яасан юм бэ гэсэн ийм нэг бодол байна. Дараагийн гурав дахь санаа бол энэ одоо 70 жилийн дотор Монголын ард түмэн харанхуй нүхэн дотор явж ирлээ гэж бас нэлээн хэдэн депутатууд яриад байгаа юм. Энэнийг миний хувьд хоёр талтай үзэх нь зүйтэй гэж бодож байгаа юм. 70 жилийн дотор манай ард түмэн олсон ололт ч бий. Алдсан алдаа ч

бий. Олсон нь лалдсанаасаа илүү байхаа гэдгийг бид энэ дээр бас үгүйсгэхгүй байхаа гэж ингэж бодож байна.

Ингээд хамгийн төгсгөлд нь ерөөсөө хэвз хурга шиг настай хууль батлах уу, хээнцэр настай хууль батлах уу гэдэг нь хамгийн гол нь доторхи, агуулга, өгүүлбэртээ л нэлээн нарийн тунгаах байх шүү. Эндээ нэлээн шингэх байх гэдгийг хэлээд, өнөөдөр улсынхаа хуулийн нэрийг Үндсэн хууль байлгаач гэсэн энэ Монголынхаа ард түмний сэтгэл зүрхийг цуг эндээ хамтран тусгалцаж, хуулиа Үндсэн хууль гэхэд буруутахгүй байх гэсэн ийм саналыг би нэмж хэлье гэж бодож байна.

Ж. Уртнасан:—Уучлаарай депутатууд аа. Бид цөөнхийн саналыг их тэсвэртэй, тэвчээртэй сонслоо. Анхдугаар хэлэлшүүлэг явж байна. Тэгэхээр одоо ер нь санал хураахад бэлэн болчихжээ гэсэн ийм мэдрэмж бий боллоо. Тэгэхээр уучлаарай ийм санал хураалтуудыг томъёолж байна. Зарим депутатууд завсарлагын өмнө санал хураалта-сангүй гэсэн энэнийг хүлээж авч байна. Зарчимч шүүмжлэл км. Бид одоо хууль маань ерөнхий нэртэй байх уу, оноосон нэртэй байх уу, оноосон нэртэй байна гэдэг дээр санал хураалт явуулъя. Хууль оноосон нэртэй байна. Энэ дээр маргаантай байгаа шүү дээ. Зарим хүмүүс бол ерөнхий нэр гэсэн. Зарим хүмүүс бол оноосон нэр гэсэн. Энэнийг бид

—Хурлын дарга аа! Санал хураахаас өмнө үндсэн гэдэг үг оноосон нэр мөн үү биш үү гэдгийг шийдэж байж санал хураамаар байна.

Ж. Уртнасан:—Хэрвээ Үндсэн хууль гэдгийг оноосон нэр гэж үзэх км бол бид түрүүчийн хувилбараар орчихно. Тийм учраас одоогийн санал хураалтыг ингэж явуулъя гэж бодож байна. Томъёоллыг. Үндсэн хууль оноосон нэртэй байна гэсэн энэ томъёоллоор санал хураая. Оноосон нэртэй байна гэвэл бид хоёр хувилбар дээр, хажуугийн хувилбар буюу Их засаг гэдэг дээр санал хураалт явуулна энэ дийлэнх олонхийн санал авч чадахгүй бол төслийн Их цааз

3.

гэдэг дээр санал хураалт явуулаад энэ асуудлыг шийцье гэж бодож байна.

Ардын Их Хурлын 231 дүгээр тойргийн депутат Б.Амарбаян:— Үндсэн хууль гэдэг чинь оноосон нэр шүү дээ. Хуульчид өөрсдийнхөө мэргэжлийг хамгаалаад байна. Би багш хүний хувьд мэргэжлээ хамгаалъя гэж бодож байна. Үндсэн гэдэг хууль гэдэг үг бол ерөнхий нэр, үндсэн гэдэг бол тодотгосон, оноосон нэр шүү дээ. Тэгэхлээр одоо энэ Их цааз ч гэсэн мөн ижил шүү дээ. Их гэдэг, тэр цааз гэдэг оноосон нэр л байж байна. Энэ чинь ялгаагүй, эаавал үндсэн гэдэг үгийг л ерөнхий нэр гэж авах гээд байдаг ямар ухаан байдаг юм бэ? гурван нэрэн дээрээ, гурвуулан дээрээ л хураая гэсэн ийм санал байна.

Ж.Уртнасан:— Горимын санал гурвыг сонсоё.

Ардын Их Хурлын 72 дугаар тойргийн депутат А.Болат:— Би энэ ерөнхий, оноосон гэдэг энэ хоёр үгэн дээрээ бид төөрөлдөхгүйгээр ерөөсөө л тодорхой, энэ гурван нэр дээр, өөрөөр хэлбэл Үндсэн хууль, Их цааз, Их засаг гэсэн гурван томъёон дээр гурвууланд нь дэмжсэн утгаар нь, эхлээд жишээлбэл Их цааз, хоёр дахид нь Их засаг гэх мэтчилэнгээр гурвуулан дээр нь эхлээд нэгдүгээр шатны санал хураалт аваад, энэ хоёр дээр, олонхийн санал авсан хоёр хуулинд дахиж санал хураах байцлаар ингэж саналаа тогтоовол тодорхой юм уу гэж бодож байна. Бидэнд бол ерөнхий, оноосон гэдгээр жаахан хүмүүсийн ойлголт чиглэгдэхгүй байх шиг санагцаад байна. Ийм саналтай байна. Ингээд тус тусад нь санал хураалтаад хамгийн олон санал авсан хоёр хууль дээр эргэж дахин санал хураалтаад ингэж шалгаруулбал арай шуцарга байх байх.

Ардын Их Хурлын 17 дугаар тойргийн депутат Т.Очирхүү:— Тэгэхээр ер нь цаашдаа ингэх нь зүйтэй л дээ. Нэгэнт Их Хурал Бага Хурлын төслийг авчихсан, хүлээж авчихсан, тэр төсөл дээр ажиллаж байгаа учраас тэрэнд оруулж ирсэн санал бол үндсэн төсөл болдог. Хажуугаас, хажуугаас орж ирсэн санал гэдэг бол депутатууд Их засаг, Үндсэн хууль өөр өөр саналууд орж ирвэл тэр

хажуугийн төсөл болдог. Тэгэхээр хажуугийн төслийг хураагаад тэр нь аль алин нь олонхи болохгүй болбол орж ирсэн үндсэн төсөл хэвээрээ үлддэг ийм ёстой. Нэгдүгээрт энэнийгээ бариацээ гэж санал болгосмоор байна. Хоёрдугаарт нь түрүүнээс хойш олон депутатууд тайлбарлаж байна. Үндсэн хууль гэдэг бол хэд хэдэн оронд олон хууль эрхийн актаас бүрдсэн ийм зүйл байцаг гэж. Тэгэхээр Үндсэн хууль гэдэг чинь нэгдүгээрт тэр байна. Хоёрдугаарт нь орчуулгын шинжтэй ийм зүйл байна. Тэгэхээр энэнийг бол оноосон нэргүй, энэ хуулийн ерөнхий нэр гэж үзээд тэгээд ерөнхий нэртэй байх уу, энэ хууль маань тодорхой нэртэй байх уу гэдэг дээр хураагаад хэргээ тодорхой нэртэй байна гэвэл Их цааз, Их засаг гэдэг хоёр дээр хураах хэрэгтэй. Хураахдаа эхлээд Их засаг дээр хураах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ хажуугийн санал. Тэгээд олонхийн санал авахгүй болбол Их цааз гэсэн үндсэн төсөл хэвээрээ үлддэг ёстой. Энэ бол парламентын хууль хэлэлцэж байх гол дэг шүү дээ. Ингэж хийвэл яасан юм бэ гэсэн горимын санал байна. Эхлээд тэгж хураая. Тэгээд дараа нь тодорхой гэвэл хажуугийн саналыг эхэлж хураагаад ингээд тогтоё гэж.

Ардын Их Хурлын 244 дүгээр тойргийн депутат Б. Доржхорлоо: Тэгэхээр Их цааз, Их засаг гэсэн нэрээр санал хураая гэж байна. Дөрөв дэх, хажуугийн санал гэдэг юм уу, дөрөв дэх хувилбар гэлцэг юм уу, Их хууль гэсэн нэрээр санал хураагууштай байна. "и"-гээр шүү.

Тэр "э" гэдэг эх биш, "и" гэдэг их шүү. Их хууль гэдгээрээ.

Ж. Уртнасан: Уучлаарай депутатууд аа. Энэ маргаантай бүдэгхэн үлдэж байгаа асуудал байгаа юм. Тэгэхцээ үүнийг та бүхэн уужуу ухаанцаа тунгаана биз. Үндсэн хууль гэдэг ерөнхий нэр гэдэг ийм томъёолол нэг хэсэг нь өгч байгаа юм. Нэг хэсэг нь хууль гэдэг ерөнхий нэр, үндсэн гэдэг оноосон нэр болж байгаа шүү гэж. Оноосон нэрэн дээр гурав дахь хувилбар болгож Үндсэн хуулиа оруулаад байгаа. Энэ явдал бидний дунд учир битүүлэг хэвээрээ, нээлттэй үлдэж байна гэдгийг депутатууд ойлгоорой. Ингээд одоо үүнийг болгооно байх гэж бодож байна. Тэгэхээр

одоо ямар хоёр хувилбараар санал хураалгах гэж байна гэхлээр хууль оноосон нэртэй байна гэдгээр санал хураалт явуулах гэж байна. Эсвэл бас нэг ийм хувилбар гарч ирж байна. Хүмүүс учир битүүлэг байна гээд байвал бид нар Үндсэн хуулийг, нэг ийм хажуугийн санал хураалт явуулж болж байна. Үндсэн хуулийг оноосон нэр гэж үзнэ гэдгээр санал хураалт явуулчихъя.

Хэрвээ ингэх юм бол, Үндсэн хуулийг оноосон нэр гэж үзэх юм бол бид депутатуулын саналаар, Болатын саналаар гурван удаа санал хураалт явуулаад хоёр нь үлдээд, тэгээд төсөл дээрээ ярих болно. Ийм л дамжлагууд байна. Үүнийг сайн ойлгоорой.

Арлын Их Хурлын 13-р тойргийн депутат Д.Цог:— Энэ маш чухал хариуцлагатай асуудал бидний өмнө тулгараад байна. Тэгэхлээр би багш хүн биш хуульч хүн учраас өөрийнхөө ойлголтыг хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл хууль зүйн ойлголт явагдаж байна. Түрүүн нэг багш хүн багш гэж хэлж байгаа байна лээ. Ер нь хууль тогтоомж гэсэн бөөн юм байдаг, бөөн ойлголт, энэнийг дотор нь үндсэн хууль, ердийн хууль, хууль тогтоомжийн бусад акт гэж ангилдаг. Гурав ангилдаг. Ерөнхий ангилалтай. Ингэхгүй бол бидний ойлголт зөрж магадгүй. Хууль тогтоомжийн бусад актад бол Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын бүх шийдвэр орж явдаг, ийм ерөнхий ангиллаа бид нар ойлгохгүй бол бид нар төөрч магадгүй гэж бодож байна. Энэ бол ерөөсөө хуулийн ангилал гэж би хэлэх гэж байгаа юм. Үндсэн хууль гэдэг бол. Оноосон нэр биш. Үндсэн хууль, ердийн хууль, хууль тогтоомжийн бусад акт гэсэн гурван ангилал байгаа юм. Энэ ангиллын нэг нь л байгаа юм гэж ойлгох нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Арлын Их Хурлын 38 дугаар тойргийн депутат Д.Чойжамц:— Манай уламжлалын ерөнхий гэдгийг шашныхаа үүднээс ч гэх юм уу, ардынхаа уламжлалын үүднээс хэлбэ гэж бодож байна. Тэгэхлээр Үндсэн хуулийг бол ерөнхий гэж үзэж болох юм байгаа юм.

6.

Яагаад гэвэл ерөнхий цотроо олон салбар байдаг. Салбарууд нь ерөнхийгөө болж байсан нөхцөлд бол ерөнхий болж байдаг. Ямарваа нэгэн юм бол туйлын ерөнхий болдог нэг хэсэг бий, эүгээр жижиг цүнх гэлээ гэхэд ерөнхий болоод явчихдаг, хар цүнх, улаан цүнх, ногоон цүнх гээд жижиг хэсгүүдээс бүрдээд ердийнхөө бол ерөнхийлдөг. Тэгэхлээр ээрэг Үндсэн хуулийг ерөнхий гэж авч үээж болно. Яагаад гэвэл Францын Үндсэн хууль, Монголын Үндсэн хууль, Хятадын Үндсэн хууль ч гэх юм уу олон шинжээр нь авч үээж болно. Нэрээр нь хэлж болно. Энэ дээр бол оноосон уу, үгүй юу гэдэг дээр бол ярих ажил биш. Нэрэн дээр ярих ажил биш. Ерөнхий гэдэг дээр бол, ерөнхий байж болно. Зүгээр энд ямар нэр өгөх вэ гэдэг тал дээр нь авч үээх юм бол Үндсэн хуулинд оноосон нэр өгч болох юм. Жишээлбэл түрүүний хэлсэн Их засаг гэх юм уу ийм нэр өгч болох юм. Тэгэхлээр тэр нэр, ерөнхий гэдэг хоёрыг бол салгаж үзмээргүй юм шиг санагдаж байна. Тэгэхлээр ээрэг ерөнхий хуулиндаа бид нэр өгөх үү үгүй юу, Үндсэн хууль гэдэг энэ юндээ нэр өгөх үү гэдэг л ийм л ажил. Жишээ нь Монголын Үндсэн хуулинд Их засаг гэдэг нэр өгөх үү, эсвэл яах вэ гэдэг, ерөнхий нэрээрээ байх уу гэж. Энэ дээр бас одоо ерөнхий, юманд юу яадаг л даа. Монголын Үндсэн хуулинд Үндсэн хууль гээд нэр өгчихөж болно. Ерөнхий, Францын Үндсэн хууль гээд жижиглэдэг боловч Үндсэн хууль гэж нэр өгч болдог тал бий. Жишээлбэл нарнаас гарсан цацрагийг, нар ханын толгойд оччихжээ гэхэд тэрэн дээр нар байх албагүй, ханын толгойн дээр нар байх албагүй, тэр эх үүсвэр нь нар юм. Тийм учраас тэр харсан зүйлийг нь нар гээд л өгчихдөг ийм тал бий. Тэгэхлээр ээрэг ерөнхийгийн нэр тусгайдаа очдог тал бий. Яагаад гэвэл Чойжамц гэдэг бол хүн гэдэг нэрийг авч болдог, ерөнхий нэрийг Чойжамцад өгөөд, хүн гэж хэлж болдог ийм учир байдаг учраас Үндсэн хууль гэдэг нэр ч байж болох юм. Зүгээр бид бол тэр оноосон нэр гэдэг, ерөнхий нэрийгээ хутгамааргүй байна.

Ж. Уртнасан:— За баярлалаа. Тэгэхлээр бид! хооронд ^{бас энэ} зөвлөхийн группийг хэл бичгийн эрдэмтдийн групптэй холбоо бариуллаа. Тэгэх-

7.

лээр хэл бичгийн энэ нэр томъёоны комиссыг толгойлж байсан манай эрдэмтэн Чоймаа та бидэнд ийм зүйлийг сонордуулж байна. Үндсэн гэдэг, Үндсэн хууль гэдэг энэ үндсэн гэдэг уг бол оноосон нэр биш, тодотгол нэр шүү гэдгийг та бүхэн болгооно уу гэсэн ийм хариулт ирүүлж байна. За ингээд бид түрүүчийнхээ томъёоллоор ярилцвал яасан юм бэ? Үндсэн хууль оноосон нэртэй байна. Үндсэн хууль оноосон нэртэй байна гэдгээр санал хураалт явуулъя.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Д.Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Л.Хорлоо

1991.11.18
Кассет Ш-48
17.02-17.14

Ж.Уртнасан: "... оноосон нэртэй байна.гэсэн дээр санал хураалт явуулж байна.

Санал өгсөн нийт депутатуудын 58 хувь нь буку олонхи нь оноосон нэртэй байна гэж 231 хүн санал ирүүлсэн байна. 146 хүн татгалзаж, 23 хүн түдгэлзжээ.Үндсэн хууль олонхийн саналаар оноосон нэртэй байх нь ээ.Ийм тохиолдолд хажуугийн санал Их засаг гэдэг дээр санал хураалт явуулъя.Томьёоллоо хэлье.

Танхимаас:

Хурлын даргаа, уучлаарай нэг км асууж болох уу? Ерөөсөө үүнийг ойлголгүй бид коноп дарчихлаа шүү дээ.Та Үндсэн хууль гэдгийг тодотгол нь мэдэгдэхгүй, ерөнхий нь ч мэдэгдэхгүй юм хэлчихээд саналаа хураая гэхээр ерөөсөө үнэн юм гарахгүй. Тийм учраас та хэлээд өгөөч, Үндсэн гэдэг үг чинь ерөнхий юм уу? оноосон км уу гэдгийг ялгахгүй байж энэ дээр зөв санал гарна гэж ерөөсөө байхгүй.

Ж.Уртнасан: Оноосон нэр биш, тодотгол гэдгийг тайлбарласан шүү дээ.Оноосон нэр бишээ, үндсэн гэдэг тодотгол.

Танхимаас:

Оноосон нэртэй байх уу? ерөнхий нэртэй байх уу гэсэн болохоос биш тодотгол нэртэй байх уу? гэж та хэлсэнгүй шүү дээ. Дахин хураалгах нь зүйтэй байна.Ингэж хураалгах юм бол энэ хариуцлагын юман дээр бид ингэж хандаж огт боломгүй.Үг хэлэх ч боломж ч олдохгүй байна, санаа сэтгэлээ ч хэлж болохгүй байна, тэгээд ч нэг км яахаараа тэр нь ойлгомж муутай.Ойлгох гээд ойлгож болохгүй байна шүү дээ, тодотгол ч гэмээр, ерөнхий ч гэмээр, оноосон ч гэмээр ийм 3 тоо гараад байна.

Танхимаас:

Хурлын даргаа, хажуугийн санал үнэхээр хэлэлцэж байгаа юм бол уул Бага Хурлаас оруулж ирсэн үндсэн нэр нь Их цааз байгаа. Тэгвэл хажуугийн санал нь Үндсэн хууль, Их засаг гэдэг хоёр хажуугийн санал байх ёстой шүү дээ. Их хууль гурав байх ёстой.

Ж.Уртнасан: Уучлаарай, депутатууд аа, Их засаг гэдэг хажуугийн санал дээр санал хураалт явуулъя. Хэрэв маргаантай гэж үзвэл цөөнх саналаа хэлье. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Санал хураалт явуулъя. Томьёоллоо хэлье. Хуулийн оноосон нэрийг Их засаг гэнэ гэдэг хуучин томьёолол дээр санал хураалгаж байна.

274 дүгээр тойргийн депутат Л.Цог-Очир: гэж байх шиг байна.

Би хэд хэдэн хувилбараар санал хураалгах. Тэгэхээр санал хураалгаж байгаа аргыгаа тодорхой болгомоор байна. Жишээ нь, Их засаг гэдэг энэ хувилбар дээр санал хураалгахад зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн бүгдийг нь санал хураалгаж авах хэрэгтэй. Тэгэхгүй энэ хоёр, гурван хувилбарыг дотор нь хутгачихаад болж өгөхгүй байна.

Ж.Уртнасан: Машин дээр гарч байгаа шүү дээ.

Л.Цог-Очир: Тэгээд дараагаар нь Үндсэн хуулиар, энэ санал хураалгах хувилбаруудаа, хураалгах дарааллаа, эхэлж хувилбараа хэлээд зарлах хэрэгтэй байна. Тэгж байж хүмүүс ямар хувилбар дараа нь гарч ирэх гэж байна гэдгийг мэдсэний үндсэн дээр саналаа өгөх хэрэгтэй.

Ж.Уртнасан: Санал шүүмжлэл ярих асуудал чөлөөтэй үлдэж байгаа. Бид хэлэлцүүлэг үргэлжилж байна. Яараад яах вэ? одоо харин нэгэнт анхаарал төвлөрсөн дээр санал хураалтынхаа нэг хэсгийг дуусгаж гаръя. Үндсэн хуулийн энэ хэлэлцэж байгаа хуулийн төслийнхөө оноосон нэрийг Их засаг гэж нэрлэе гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

298 дүгээр тойргийн депутат Д.Тангад: Ингээд бүр тодорхой хэлж өгчихөөд, 3 нэр дээрээ гурвуулан дээр нь саналаа авна шүү. Тэгэхдээ хажуугийнхаа саналыг эхэлж авчихаад хамгийн сүүлд Их цааз дээрээ авна. Авахдаа ингээд дөрвүүлээ ийм ийм боллоо гэдэг тайлбар хийнэ шүү гэдгээ сайн хэлээд өгөөч ээ даргаа. Энэ чинь будилчихаад болж өгөхгүй байна шүү дээ. Тэндээс ч нэг хүн утасдаад тэр нэрийг нь тийм гэж хэлнэ гэнээ, ийм нэрийг нь ийм гэж хэлнэ гэнээ гээд байхаар чинь энэ танхимд сууж байгаа бид цөмөөрөө л шийдчихье. Заавал хэлбичгийн ухааны хүн түгээр шийдүүлэхгүй. Ерөөсөө энэ дээр ингээд энэ хуулийнхаа нэрийг 4 бол 4, 5 бол таваар нь зарлаад л дор дор нь хураагаад явчихаая ээ.

Танимаас:

Даргаа би жишээ нь хэдэн юман дээр санал өгөх вэ гэдгээ мэдэхгүй байна. Хичнээн юман дээр та санал хураах гэж байна вэ та? 4 дээр өгөх гэж байна уу? 3 дээр өгөх гэж байна уу? Би мэдэхгүй байна. Эхлээд та түүнийгээ хэлчихгүй юу? Ийм ийм нэрээр авъя гэж. Тэгэх юм бол бид сонголтоо хиймээр байна.

Ж.Уртнасан: Хэрвээ цөөнхийн саналыг оруулбал бид хэд хэдэн хувилбар гаргаж ирнэ. Тэгэхдээ бид үндсэн хоёр хувилбар дээрээ санал хураалт явуулмаар байна. Их засаг, хажуугийн саналууд олон депутатууд Үндсэн хууль гэдгээр санал хурааж өгөөч гэж байх шиг байна. Ийм учраас бид Бага Хурлын оруулж ирсэн төслийг үлдээгээд, эхлээд Их засаг гэж нэрлэе гэдгээр нэг санал хураалт явуулъя, Үндсэн хууль гэдэг нэрээр, энэ бол ерөнхий нэр гэдгийг оноосон нэр, тодотгосон нэр гээд гайхаад байх шиг байна. Тийм учраас үүнийг санал хураагаад шийдье. Бид эхлээд хажуугийн саналыг Их засаг гэдгээр санал хураалт явуулаад завсарлая.

? 399-р тойргийн депутат

Нэг санал хэлье. Бид өнөөдөр Үндсэн хууль хэлэлцэж байгаа. Их цааз нэртэйгээр үндсэн хуулийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр би таны эхэлж авах гэж байгаа саналыг энд хурааж өгөөч гэж хэлэх гэж байна.

Монгол улсын өнөөдөр хэлэлцэж байгаа Үндсэн хууль нь тодорхой нэр өгөх үү, өгөхгүй юу гэдэг дээр хурааж өгөөч. Ийм санал хурааж өгөөч ээ гэж танаасгүйж байна. Бид Үндсэн хуулиа хэлэлцэж байж, үндсэн хуулин дээр санал хураалгая гэвэл зөвшөөрөхгүй байна. Энэ бол утгагүй ийм санал хэрэг байхгүй. Тэгэхээр Үндсэн хуулиа хэлэлцэж байгаад, хэлэлцэж байгаа үндсэн хуулиндаа, тодорхой нэртэй батлах уу? эсвэл тодорхой нэргүй, юугаар нь батлах юм уу? Тийм учраас энэ үндсэн хуулин дээрээ нэр өгөх үү, үгүй юу гэдэг дээрээ хурааж өгөөч гэсэн ийм л саналыг би оруулж байна.

Ж. Уртнасан: Уучлаарай, Үндсэн хууль гэдгийг чинь оноосон нэр гэж үзэхгүй, тодотгол нэр шүү гэдгийг тайлбар тавиад байна шүү дээ, манай ажлын хэсэг.

Тийм учраас хажуугийн санал, Их засаг гэдэг дээр санал хураалт явуулъя. Үндсэн санал Их цааз хэвээрээ байгаа гэдгийг та бүгдэд хэлмээр байна.

25 дугаар тойргийн депутат Энэбиш: Энд манайхан даргыгаа шуугиж байгаад самгардуулаад, болохгүй байна. Тэгэхдээ дарга өөрөө ингэсэн шүү дээ, эхлээд Үндсэн хууль гэдгийг оноосон нэр гэж үзээд гурав дээр нь гурвуулан дээр нь санал хурааа гэж хэлчихээд, тэгээд дараа нь Чоймаа ийм юм хэллээ шүү гэж хэлчихээд, тэгээд оноосон нэр гэдэг дээр хоёр байнаа гэхээр энэ улсууд чинь будилчихаад байна.

Тэгэхээр ингэж болохгүй л дээ. Одоо бол яах ёстой вэ гэвэл Үндсэн хуулиа ямар ч байсан, оноосон нэр гэж орхиод, тэгээд түрүүн тэр Их хууль гэдгийг бас одоо ингэж бужигнаад байвал юу ч үгүй тарах нь байна шүү дээ. Өчнөөн өдөр юу ч байхгүй, хоцорчихоод, цаана чинь амьдрал, ажил болохоо байж байна шүү дээ. Тэгээд учраа олохгүй ингэж шуугилдаад байдаг. Их хууль гэдгийг нь аваад, та ингээд 4 үндэслэлээ хэлээд ийм ийм дарааллаар хураана, хүмүүсүүд үүнээсээ сонгосныгоо хэлнэ шүү дээ. Түүнээс тэр Чоймоо бид нарыг төлөөлж тэгж байж болохгүй. Өөрөө тэгж хэлсэн юмаа эргүүлчихээр энэ дээр чинь хүний

тоо будилж гараад ингээд бужигнаад байх үндэс болоод байна шүү дээ.

Депутат /нэр, тойргоо хэлээгүй/

Одоо энэ чинь тодорхой байна шүү дээ. 4 санал гарч байна шүү дээ. Зарим нь Их цааз гэе, зарим нь Үндсэн хууль гэж байна, зарим Их засаг гэж байна, зарим нь Их хууль гэж байна. Энэ 4 дээрээ л санал хураая. Яг нэрийг нь заагаад, зөвөл оноосон уу? ерөнхий юу гээд ингэж бүрхэгдүүлж, гуйвуулж, хүний санаа үймүүлж байх хэрэг байхгүй байна шүү дээ. Энэ дөрөв дээрээ дараалан саналаа хураачихъя, тэгээд хүмүүсүүд өөрсдөө сонгож аваг л даа. Энэ дөрвөөс.

Ж.Уртнасан: За баярлалаа.

399 дүгээр тойргийн депутат Л.Чилхаажав:

Санал хураахын өмнө нэг км-ан дээр тогтох хэрэгтэй байна л даа. Зарчмын асуудал мөн үү, үгүй юу гэдэг дээр бид шилэх хэрэгтэй юм. Бид үүнийг зарчмын асуудал гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл ерөнхий хэлэлцүүлгийн явцад зөвхөн зарчмын асуудлаар ярина гэсэн. Үг хэлсэн ихэнх депутатуудын бараг 100 хувь нь зөвхөн энэ асуудлаар л ярьсан. Ийм учраас би зарчмын асуудал гэж бодож байна. Зарчмын асуудал бол гуравны хоёроор олонхи болох ёстой. Түрүүчийн санал дээр үндсэн хууль ч олонхи болоогүй, Их засаг ч олонхи болоогүй. Иймээс үндсэн хувилбар Их цаазаараа үлдцээ гэж ийм журмаар бид цаашаа явах ёстой. Тэгэхгүй бол бид хажуугийнх нь энэ, юуных нь энэ гээд болохгүй. Гуравны хоёроор зарчмын асуудлыг шийдэх ёстой.

Ж.Уртнасан: Үгүй л дээ. Анхны хэлэлцүүлэг олонхийн саналаар шийдээд, тохиролцоонд хүрээд байгаа шүү дээ.

Л.Чилхаажав: Үгүй, үгүй, зарчмын асуудлаар ерөнхий санал шүүмжлэл явуулна гэж бид нар тохирсон бие дээ. Тэгээд зарчмын асуудлаар санал шүүмжлэл явуулсан. Ихэнх хүмүүс энэ асуудлаар

санал шүүмжлэл хэлсэн.Ингэхээр үүнийг би зарчмын асуудал гэж ойлгож байгаа.

Ж.Уртнасан: Анхны хэлэлцүүлэг шүү дээ.

315 дугаар тойргийн депутат Бат-Эрдэнэ: Тэгэхээр бид нар ёстой Дашбалбарын хэлдгээр ерөөсөө найруулсан жүжиг рүү ормооргүй байна.Оноосон нэр, тодотгол нэр ч гэх ч шиг бид хий ингэж будилсаар байтал өдрөө барлаа шүү дээ.Тэгэхээр үндсэндээ хуулийн нэрээр чинь 4 үндсэн санал гараадбайна шүү дээ.Улсын Бага Хурлаас оруулж байгаа санал бол Их цааз, хажуугийн гурван санал бол Их хууль, Үндсэн хууль, Их засаг гэсэн 3 хажуугийн санал гарч ирж байна.Тэгэхээр энэ дөрвийгөө санал хураалгах дэс дарааллыг нь тогтоод, дөрвүүлэн дээр нь санал хураалгаад, тэдгээд хэрвээ олонхийн санал авч чацдаггүй юм бол хамгийн олон санал авсан хоёрыг нь үлдээж хураалгаад, тэгээд дийлэнх олонхийн санал авсныг нь хуулийнхаа нэр болгоод тогтчихмоор байна шүү дээ. Тэгэхгүй болохоор чинь болохгүй байна шүү дээ.Тодотгол, үндсэн нэр гээд ингээд будилсаар байтал бид чинь жинхэнэ жүжиг байна шүү дээ.Ерөөсөө оруулсан саналаа тулгаж батлуулах гэсэн жүжиг байна шүү дээ.

Ж.Уртнасан: За баярлалаа.

9-р тойргийн депутат С.Зориг.


Би ганцхан юм сануулаатхая.Сая Энэбиш дарга ярилаа.Чоймоо юу яриад байгаа юм бэ гэж.Тэгэхээр түүхийн нэг жишээ хэлье л дээ.Та нар мэднэ байх,Жардано Бруног шатаасан тийм ээ,гал дээр.Яагаад шатаасан юм бэ гэхээр дэлхий нарыг тойрдог байсан юмаа гэдгийг шинжлэх ухааны үүднээс нээсэн байгаа.

7.

Чоймаа бол хэл шинжлэлийн ухааны хүн.Тийм учраас тэнд энэ оноосон нэр бишээ гэж.Та нар яаж байна вэ гэхээр олонхийн саналаар шинжлэх ухааны дүгнэлтийг үгүйсгэнэ гэсэн үг шүү дээ.Тэгэхээр одоо Чоймааг шатаах хэрэгтэй байна шүү дээ. Яагаад гэхээр буруу дүгнэлт гаргасан.

Ж.Уртнасан: Завсарлага 20 минут.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭНЭГ

424-р тойргийн депутат Бадамсүрэн: -Өнөөдрийн бидний энэ хуралдааны үйл ажиллагааг бол ард түмэн ч ойлгохгүй, сүүлдээ еерсдөө ч ойлгохоо байлаа.Тийм учраас Их хурлын даргад хүсэхэд бол хурлаа дэгтэйхэн шиг жаахан асуудлаа хэлэлцүүлэхдээ системтэй явуулмаар байна.Энэ дээр юу гэж хэлэх гэж байна вэ гэхлээр Та өнөөдөр урьд нь ярьж байсан, оноосон нэр гэж Чимид гуай томъёолсон.Ингээд оноосон нэр гэж бүх юмыг будлиулчихлаа.Тэгэхлээр нэгэнт өдрийн нэг өдөр будилсан юм, оноосон нэр гэдэг дээрээ бид оноосон нэр өгнө гэдэг дээр тогтчихлоо. 2-рт, эрдэмтдийн хэлснээр Үндсэн хууль гэдэг бол оноосон нэр биш, тодотгол нэр гээд еерээр хэлбэл энэ оноосон нэрэнд авч үлдэхгүй нь ээ гэж, тэгэхлээр би ямар санал хэлэх гэж байна гэвэл, нэгэнт тогтсон, оноосон нэр дээрээ санал авъя.Ийм учраас аль нэгий нь орхихгүйгээр оноосон нэрэн дээр бол ингэж гарлаа шүү дээ.Их засаг I-рт, 2-рт Их хууль, III-рт **Эх хууль** энэ 3 дээрээ санал авчихъя.Дараа нь депутат Очирхүүгийн хэлснээр Үндсэн хувилбар болох Их цааз байна, ингээд энүүнтэйгээ, энэ дээрээ санал авчихъя, ингээд гараад ирэх юм биш үү гэж бодож байна.

32-р тойргийн депутат Мандах: - Одоо ингээд ер нь явц дунд бид нэлээн будиллаа.Цаашдаа ч их будилах байх. Тийм учраас хурлын дарга, орлогч нар ерөөсөө нэг санал аваад, еерсдийнхөө толгой руу шууд /**промлерёвк** / хийх гээд томъёолол хэлээд тэрэн дээр үймээд байна.Ийм учраас бүх хүмүүс саналаа цэгцтэй хэлэг ээ, нэгэнт хэлсэн санал дээр хурлын нэг орлогч нь байдаг юм уу, ахлаад, энд чинь бага хурлын боловсруулсан хүмүүс байж байна, тэхээр цаад талд нь аппарат байж байна.За энэ саналыг тоъёолол гаргахаар хойш нь тогтъя гэж хэлээд энэ хүмүүс зөвлөөд, хэл зүйн талаас нь хууль зүйн талаас нь зөвлөөд тэгээд томъёололоо тогтоод за хүмүүсчөглөө, та бүгдийг гаргасан санал дээр ийм томъёолол гаргаад иржээ, за энэ дээр саналдаа хураая гэж тогтъя. Тэгвэл улсууд үймэхгүй, тэгвэл тэр

үндэстэй болно, ганцхан нэр дээр бид иймэрхүү байдлаар будилж, олон янз хувирч байгаа км чинь цаана нь бүхэл бүтэн заалтын хувьд өөрчлөхөд энийг ганц хурал удирдаж байгаа хүн энүүгээр толгойдоо бүх томъёоллыг боловсруулж аваад санал хураалгана гэдэг бол яг л түрүүчийнх шиг болоогүй байхад санал хураалгачихлаа, болоон хойно ингэлээ гэсэн будлиан болно. Магадгүй Зоригийн хэлснээр ёстой нэгийгээ шатаах ч км болно. Тийм биш, энийгээ тогтё. Одоо тэгээд түрүүчийн санал хураалгүй миний бодол бол саянхаа нэр дээр тогтсон томъёолол гаргаж ирээд тэр бүх хүмүүс зөвлөөд ийм л томъёолол гарч ирж байна, энэ дээр санал хурааа гэж гаргаад ирмээр байна. Ингэж л хэлэх гэсэн км.

404-р тойргийн депутат Л.Хээшиг: -Учраа олохгүйгээр санал өгөөд байна. Юуны өмнө эхлээд санал авахынхаа өмнө ямар ямар зүйл дээр санал авах гэж байна гэдгийг эхлээд бүгдий нь сонсож байж өгмөөр байна. Жишээлбэл сая завсарлахын өмнө Их засаг, Их цааз гэдэг дээр авъя гэсэн. Гэтэл зарим хүн Үндсэн хуулийг оруулж авъя гэсэн, ямар ч байсан 3-уу, дөрөв уу, ямар зүйл дээр санал авах гэж байна гэдгийг мэдэж байж саналаа өгмөөр байна. Нөгөө талаар ойлгохдоо энэний өмнө Үндсэн хуулийг оноосон нэр үү, үгүй юу гэдэг дээр санал аваад, оноосон нэрээр санал авах уу, үгүй юу гэдгийг үзээд оноосон нэрээр санал авна гээд шийдчих шиг болсон. Тэгсэн бол үндсэн хууль гэж санал авахгүй болов уу гэж бодож байна. Нөгөө талаар энэ саналыг олонхийн саналаар шийдэх км уу, гуравны 2-ын саналаар шийдэх км уу гэдгээ ч мэдээгүй байна.

257-р тойргийн депутат Ч.Цэрэндагва: -Тэгэхээр энэ санал хураалттай холбоотой горимын саналыг Их хурлын удирдлага, эрхэм депутатуудын сонорт хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ Үндсэн хууль маань оноосон нэр үү, үгүй юу гээд онолын маргаан хиймээргүй байна. Өнөөдөр бид Үндсэн хуулиа хэлэлцэж байгаа гэдгийг эсэргүүцэх нэг ч хүн байхгүй байхаа гэж миний хувьд ойлгож байна. Тийм учраас өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа

Үндсэн хуулийг тухайлсан, оноосон нэр өгөх үү үгүй юу гэдэг дээр бид ярилцаж байна. Энэ дээр санал хураагаад хэрвээ үндсэн хуульд оноосон нэр өгөхгүй, гэж тогтвол энэ хууль Үндсэн хууль нэртэйгээ л үлдэж таарна. Оноосон нэр өгнө гээд тогтох юм бол дараагийн асуудал бол Үндсэн хууль гэдэг асуудал дээр хураагдахгүй, Их цааз, Эх хууль, Их Засаг хууль, гэсэн ийм 3 санал гарлаа л даа, сая, энэ 3 дээрээ санал хураагаад энэ 3-ынхаа аль нэгээр л шийдэж таарах байх. Энийг хураахдаа аль бага оноо анхнагадгүй гэдэг талаас нь хураавал тэр улсууд дараагаар нь үлдсэн дээр нь бас өөрийнхөө саналыг нэмэрлэж хэлэхэд илүү болов уу. Тухайлбал Их хууль гэж хэлж байна, Их хууль гэдэг дээр санал хураагаад, энэ дээр санал өгөх улсууд олонхи болж чадаагүй бол дараагийн 2-ын аль нэг рүүгээ санал нь гүйгдэж орох жишээтэй, сонгож авах жишээтэй, ийм байдлаар явбал бид эцсийн шийдэн хүрэх байх гэж ингэж бодож байна. Тийм учраас ахиад Үндсэн хууль гэдэг энэ хуулиндаа оноосон нэр өгөх үү, үгүй юу гэдэг дээрээ санал хурааж, 2 тийш нь болгоод, оноосон нэр өгөх юм бол саяынхаа 3 дээр санал хураагаад дуусгамаар байна. Хураасан боловч хүмүүс ойлгоц муутай өглөө гэж бодож байна. л даа. Зарим хүмүүс бол Үндсэн хууль оноосон нэрээ тийм учраас би оноосон нэр өгнө гэдэг ойлголтоор кино дарсан юм шиг байна.

260 дугаар тойргийн депутат Ж.Буд: —Би нэг горимын санал гаргая гэж бодлоо. Тэгэхээр энэ бид нэлээн ойлгогч шиг боллоо. Нэлээн шуугилдлаа. Эцсийн эцэст бол бид мэргэн оюн ухаандаа нэлээн тунгаасан байх. Миний бодлоор бол одоо тэр, тэр ч үндсэн санал, энэ ч туслах нь гээд маргаад баймааргүй байна. Ерөөсөө 4 саналаа 4 санал байгаа, энэ 4-өө цувуулаад бүгдээрэнд нь санал авчихмаар байна. Тэгэхгүй бол ийм маргаан гарчихаж болзошгүй юм шиг санагдаж байна. Ерөөсөө Үндсэн хуулиа хасчихаад наад 3 санал дээр нь хураах юм бол нөгөө 3 санал нь тус бүртээ олигтой биеэ даасан тийм оноогоо авч чадахгүй байгаа, анх оруулж ирсэн саналаар бол болж болзошгүй ийм тактикийн юм байх шиг байна. Тэгээд ний нуугүй үнэнийг хэлэхэд өнөөдөр ард түмэн хүлээж авах, тэгэхдээ шинэчлэлт, өөрчлөлтөнд эохих хэмжээгээр хувь нэмрээ үзүүлэх, ийм нэг тодорхой саналыг мэргэн оюн ухаандаа тунгаасан байх аа манай депутатууд, ийм учраас ерөөсөө их, бага, шинэ хуучин,

хойно, урд гэхгүйгээр ерөөсөө 4 саналаа 4-үүлэнгий нь хуваагаад эцэст нь одоо гарсан 2 санал, хэн олонхи хувийг эзэлсэн 2 саналаа нэг хураагаад ингээд шийдчихье. Ийм санал оруулж байна.

84-р тойргийн депутат Н.Самат: -Дарга аа, та еөрөө будилчихлаа даа. Уг нь бид нар хэл зүйн ойлголт яриагүй шүү дээ энэ дээр, та Чоймоо гуайн оруулж ирсэн саян саналыг уншаад төөрөгдөлд орууллаа. Бид нар хэл зүйн юм огт яриагүй. Бид ойлголтыг хүрээнд ярьж байгаа шүү дээ. Энэ нэг систем байх нь ээ, энэ ерөнхий энэ бол оноосон нэр. Тэрнээс бид нар хууль гэдэг нь нэр уг, тэрний тодотгол нь үндсэн гэж яриагүй. Тэгж ярих юм бол Их цааз гэдгийг бас тэгж задалж үзэх хэрэгтэй. Цааз гэдэг нь нэр уг байна, Их гэдэг нь тодотгол. Ерөөсөө энэ бол ямар ч утгагүй, юм болчихоод байна. Зүгээр депутатуудын гаргасан саналуудыг харж байхад бид нар одоо ерөнхий, оноосон гэдгийг болимоор байна. Бид нар эцсийн эцэст бол хэрэг дээрээ энэ нэг барьж байгаа төслийн нэрийн тухай л ярьж байгаа юм байна шүү дээ. Үндсэн хууль гэж байна, тэр бол Их цааз гэж нэртэй байна гэж асуудлыг тавивал ба жаахан төөрөөд байх шиг байна. Тийм учраас энэ төслөө юу гэж нэрлэх вэ гэдгийг ярьъя. Тэгвэл миний санал ямар байна гэхээр одоо энэ талар ямар ч санал ялгаагүй. Үндсэн хууль, их цааз, гэдэг байгаа саналуудыг бүгдий нь нэг хүн нэг л юманд санал өгөхөөр тохиролцоод тэгээд нэг удаа бүгдий нь нэг удаа хураалгаад үзье. Тэгээд хамгийн олон санал авсан 2-ыг шаталж ингэж юу яах саналтай байна.

Уртнасан: -Ойлголт жигдэрлээ гэж бодож байна, депутатууд аа, тэгэхээр бид бас олонхийн саналаар шийддэг сайхан зарчимтай

Товчхон тайлбар тавимаар байна. Санал хураадаг 3 хувилбар байдаг, тэр олон улсын парламент ч гэнэ үү, их хурлын ч гэнэ үү мөрддөг, тэр нь үндсэн саналыг орж ирсэн төслийг үлдээгээд

хажуугийн саналуудыг санал хураалт явуулаад, тэр олонхи болж чадахгүй бол үлдсэн санал үлддэг, нэг ерөнхий зарчим бий. Энийг бид тоохоо больё. Саналыг 2 хэсэгт хуваагаад санал хураалт явуулаад шалгаруулдаг 2 дахь санал бий. Энийг больё. Манай өнөөдрийн депутатуудын уур амьсгал Болат, Самат нарын санал бол шалгаруулах санал хураалт буюу танхимын уур амьсгалд автаж санал хураалт шалгаруулдаг ийм санал хураалт байдаг, тэр бол ерөнхий, оноосон гэдгээсээ болино, бид өрөөсөө энэ дээр тогтож байх шиг байна. Тэгэхээр тэр ерөнхий, оноосон гэдгээрээ толгойгоо үймүүлж маргахаа больё гэдэг дээр санал нэгдэж байна. Шалгаруулах санал хураалт явуулъя. Шалгаруулах санал хураалтын зарчим ийм юмаа нөхөд өө, энд бид нарт ирсэн нэрүүдийг нь бүгдийг нь ингээд санал хураалт явуулчихъя. Тэрнээс хамгийн олон үлдсэн 2-ыг шилж аваад дахин санал хураалт явуулаад шийддэг энэ зарчмаар явъя. Тэгэхээр би та бүхэнд хэлье. Түрүүн депутатууд хэлнэ лээ. Эхлээд санал хураах нэрээ бүгдийг нь уншаачээ гэж, одоо бид 5 удаа санал хураалт явуулах нь ээ. Нэрийн дээр. За бичээд аваарай. Хажуугийн саналуудаас эхэлж байна. Их засаг гэдгээр санал хураалт явуулна. Их хууль гэдгээр явуулах нь ээ. Эх хууль гэдгээр явуулна, Их цааз гэдэг үндсэн орж ирсэн төслөөрөө бас санал хураалт явуулъя. Үндсэн хууль гэдгээр явуулъя. Энэ 5 нэр дээр санал хураалт явуулаад, хамгийн олонхийн санал авсан 2 нэрийг үлдээгээд, дахин санал хураалт явуулаад ингээд эцэст нь шийдье. За тогтох уу, За баярлалаа, За тэгвэл санал хураалтанд бэлтгээрэй.

Ц.Элбэгдорж: – Үндсэн хууль гэдэг санал хамгийн сүүлд байгаа учраас энэ рүүгээ гүйж Үндсэн хууль гэдэг санал авах нь ойлгомжтой шүү дээ. Ийм байдлаар жоохон хүүхэд хуурч байгаа юм шиг юм хийх шаардлагагүй. Хажуугийн саналаа хураагаад, хажуугийн санал нь цийлэнх олонхио авахгүй бол энэ Их цаазын төсөлд байгаа Их цааз гэдэг энэ нэр л үлдэх ёстой. Ийм л байдлаар явах ёстой.

–Уртнасан:– Уучлаарай, тэгэх юм бол дараагийн хэлэлцүүлэг хүртэл энэ маргаан тасрахгүй. Бид шалгаруулах санал хураалтаа

явуулаад, тэгээд шийдье.

197-р тойргийн депутат Шура:

-Шалгаруулах саналыг ингэж явуулдаггүй. Ерөөсөө шалгаруулах саналыг байна шүү дээ та ингээд бүгдээрэнгий нь ингээд санал хураалгачихдаг нь зөв өө, Саматын , тэгчихээд та хамгийн сүүлийн 2-ы нь авч үлдэх гэж байна шүү дээ, хамгийн эхэнд орж байгаа 2-ы нь , ингэхгүйгээр хамгийн сүүлд орохы нь хасаад дахиж нөмөөрийнгий нь хурааж явсаар байгаад хамгийн сүүлд 2 ийм түүвэр маягийн хураавал зөв болно.

/Танхимаас/

-Нэг хүн 1 санал өгдөг нь буруу, түрүүчийн Чимид гуайн хэлдгээр яг тулгаад 100 болгоно гэсэн шүү дээ, тэр чинь ерөөсөө буруу байхгүй юу.

Уртнасан: -Уучлаарай, уучлаарай, горимын саналыг сайн сонсож бай л цаа. Тухтай шийдье.

39-р тойргийн депутат Ламжав: -Түрүүний санал хураалт хэвээрээ байхад дахиад өөр юм руу ингээд бид нар ерөөсөө сүүлд нь юу л болох бол гэж би их айж байна. Энэ мэтээр л байгаад байх юм бол хөгийн юм болно шүү дээ. Шийдвэр гарчихсан л байдаг, нэг мэдэхэд, тэгээд л цааш нь өөр өөр юм яваад байдаг, ухаандаа түрүүний санал хураалт хүчингүй болоогүй байгаа шүү дээ, Үндсэн хууль гэдэг чинь одоо оноосон нэр олгоно гээд л 4 юу нь үлдэх юм биш үү. Тэр чинь хасагдчихаад байгаа шүү дээ. Үндсэн хууль чинь хураалтаас хасагдчихаад байгаа шүү дээ.

/Танхимаас/

-Тэгэхээр шалгаруулах саналыг чинь эсэргүүцсэн их олон хүн түрүү үг хэлсэн шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хууль гэдгий чинь ерөнхий нэр гэж үзээд оноосон нэр өгөх үү

үгүй юу гээд санал хураалт явуулсан тэр чинь хүчинтэй хэвээрээ байгаа. Тийм учраас ахиад бид нар шалгаруулах санал явууллаа ч гэсэн түрүүн санал хэлсэн маш олон хүн эргээд тэрнийг эсэргүүцнэ шүү дээ. Тийм учраас би эхлээд санал хураах зарчмаараа ахиад санал хураамаар байна. Өөрөөр хэлэх юм бол түрүү хураасан зарчмаараа санал хураая I-рт, 2-рт саяын таны хэлсэн шалгаруулах журмаар санал хураая гэдэг дээрээ санал хураагаад тэгээд тогтсон журмынхаа дагуу цаашлаад явъя. Ийм санал байна. Тэгэхгүй бол ахиад эсэргүүцнэ шүү дээ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа

Ш. БУРМАА

Ардын Их Хурлын 23 дугаар тойргийн депутат Ц.Энхбат:-
 Бид нарын маргаад байгаа юм ерөөсөө хоёр үндсэн юман дээр л маргаад байна шүү дээ. Үндсэн хууль гэдгээ ч үлдээе, Их цааз юм уу Их засаг гэдгээ үлдээе гэдэг дээрээ л маргаад байх шиг байх юм. Тэгэхээр Их цааз, Их засаг, Их хууль гэдэг дээрээ саналаа хураагаад тэгээд тэрнээс гарсан нэрнийхээ ард талд хаалтан дотор тэр Үндсэн хууль гэдгийгээ хийгээд тэгээд явчихвал яасан юм бэ? Хэрвээ энэнийг эсэргүүцэж байгаа бол Үндсэн хууль гэдгээ толгойг нь болгоод хаалтан дотор нь Их засгаа юм уу Их хуулиа хийчихгүй юу.

Ардын Их Хурлын 360 дугаар тойргийн депутат Д.Найдан:-
 Бид нар их цаг алдсан нь үнэн. Сая Ламжав депутатын хэлсэн ч үнэн. Түрүүчийнхээ баталчихаад сүүлээс нь дахиад санал хураагаад байгааг юу болдог бол гэдэг нь МҮ гэсэн үг вэ гэвэл бид нар мөрийнхөө хөтөлбөрийг сэргээж санацгаая. Энэ дээр хоёрдугаар бүлэгт нь тодорхой асуудал хэлэлцэх асуудлын дагуу ярьж байгаа. Тодорхой асуудлын 12 дугаар хуудасны дотор "д" дээр нь ингэж заасан байгаа. Зарчмын шинжтэй асуудал бүр дээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон депутатын гуравны хоёрын саналаар шийцвэрлэнэ гэсэн. Энэ ёсоор түрүүчийн санал хураалт явахад Үндсэн хууль гэсэн дээр үлдсэн санал 68 хувь байсан, тэр бол хэвээрээ байж байгаа. Гэтэл санал буудихын үед Үндсэн хуулийн нэрүүдийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлуулсан. Зарим нэрийн нь тайлбар хийж хаяад, зарим нэрийг нь тайлбар хийхгүй хаясан. Хэрвээ ерөнхий нэртэй Үндсэн хууль байдаггүй юм аа гэж үзэх юм бол Үндсэн хууль ч энэ нэр болж чадахгүй, Их цааз ч энэ нэр болж чадахгүй, яагаад гэвэл Үндсэн хууль гэдгийн хууль ерөнхий нэр, үндсэн тодотгол нэр юм бол Их цааз гэдгийн чинь цааз нь тодотгол нэр, үндсэн ерөнхий нэр, их гэдэг нь тодотгол нэр ээ. Ийм маягаар тайлбарлах юм бол тэр хоёр хуулийн нэр автоматаар хасаглаж байгаа. Тийм учраас бид нар эргэж горимдоо орохдоо тэр шалгаруулах

зарчмаараа явах нь зүйтэй гэж бодож байна.

Ардын Их Хурлын 22 дугаар тойргийн депутат Д. Дшаням:

-Би нэг санал хэллэе. Тэр Шураагийн саналыг бас бодмоор юм байна. Энэ санал хураалтаа шалгаруулахдаа яагаад гэвэл Их хууль гэсэн чинь санал өгсөн улсууд чинь хойноосоо хасагцаад байвал урьдахь саналдаа дахиж нэмэрлэх тийм боломж нээгдэнэ шүү дээ. Тэгэхгүй бол шууд бүгдийг нь аваад таныхаар яачих юм бол тэр чинь өөр ч болчих гээд байна. Шураагийн тэрэнд бас нэг бодох юм байна гэж бодоод тэр саналыг дэмжиж байна би.

Ж. Уртнасан: -Уучлаарай нөхөд өө. Бид бас хэлэлцэж бие биенээ ойлгох хэрэгтэй болж байгаа юм шиг байна. Тэгэхээр Найдан депутатын хэлж байгааг би үндсэндээ зөвшөөрч байгаа юм. Үндсэн хууль гэдгийг бид будилсан. Оноосон нэр гэх юм уу, ерөнхий нэр гэх юм уу гэдэг дээр будицад, оноосон нэр гэдэг уруу манай ихэнх депутатууд ойлгож энэ санал хураалтын шалгаруулах хэсэгт оруулж ирж байна гэж ийм томъёололтой байгаа шүү. Тийм учраас бид одоо санал хураалтанд ер нь жигдэрч байгаа байх гэж бодож байна. Шалгаруулах санал хураалтаа явуулчихъя. Үлдсэн хоёр дээр нь дахин санал хураалт хураагаад л ингээд шийцье. Энэ дээрээ тогтмоор байна.

За саналаа хураая. Шалгаруулах санал хураалтанд та бүгдийг бэлэн болсон болов уу гэж бодож байна. Шалгаруулах санал хураалтанд. Нэг хүн, хамгийн гол та бидний анхаарах юм нэг хүн нэг дээр л санал өгнө шүү. Тийм ээ. Таван нэрээ тогтсон. Өөрөөр хэлбэл бидний дахин нэг лавлаж авах юм байгаа юм. Зарим депутатууд Үндсэн хууль гэдэг нэрийг бид нар оруулах уу үгүй юу гэдэг дээр эргэлзээд байх шиг байна. Энэ Үндсэн хууль гэдгийг түрүүчийн оруулсан олонхи 68 хувь бол энэ бол бас оноосон нэр гэж үзэж байна гэж бид бодож байгаа. Энэ дээр бид андуураагүй бие. Ингээд бид санал хураалтанд оруулж байна. За санал хураалтаа таван нэрээ дахиад хэлчихье. Томъёоллоор явна шүү. : Их цааз, Их хууль, Эх хууль, Үндсэн хууль, Их засаг энэ тав. Эхлээд энэ Их засаг. Хоёр дахь нь Их хууль,

3.

одоо Их засгаар хураалаа.Хуулийн төслийн нэр Их засаг.Анхаараарай санал хураалт явж байна.

За 47 хувь, 42 хувь, II хувьтай гарлаа.

Одоо хоёр дахь томъёолол оруулж байна.Их хууль."и"-гээр. Анхаараарай санал хураалт явуулж байна.

За 3 дахь томъёолол орж байна.Эх хууль."э"-гээр. Анхаараарай санал хураалт явж байна.

За 4 дэх хажуугийн санал.Одоо Үндсэн хууль.Санал хураалт явж байна.

За одоо 5 дахь нэр.

Ардын Их Хурлын 427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж:

-Их цаазаар санал хурааж болохгүй ээ.Энэ бол үндсэн санал байхгүй юу. Аль нь ч гуравны хоёрыг авсангүй шүү дээ.Одоо Их цааз гэдэг нэр үлдэнэ.Тэгэх км бол алиныгаа тулгуур барьж хэлэлцэх км бэ.Энэ чинь утгагүй болчихно шүү дээ.Их цаазаар санал хураалт болохгүй.Энд ердөөсөө ойлгомжгүй км болчихоод байна шүү дээ.Аль нь тулгуур санал.Оруулж байгаа хуулийнхаа үндсэн төслөөр хэзээ санал хурааж байсан км бэ?Үндсэн төслөөр санал хурааж болохгүй шүү дээ.

Ж.Уртнасан:-Уучлаарай нөхөд өө.Болно.

Төслийн нэрийг Их цааз гэснээр санал хураалт явуулж байна.

За хоёр дахь шатны санал хураалтанд ороход бэлэн байгаа болов уу гэж бодож байна.Та бидэнд хамгийн олон санал авч үлдсэн хоёр нэр Их засаг, Үндсэн хууль хоёр үлдэж байна.

4.

Танхимаас:

—Энэ болохгүй, энэ санал хураалт. Энэ ингээд зөвшөөрсөн саналыг бүтцийг нь тоолоод үзэх км бол 500 гараад явчихаж байна. Тэгээд нэг хүн давхардаж өгч байна. Энэ бол хүчингүй саналууд байгаа шүү.


Ж.Уртнасан:—Уучлаарай, зарим депутатууд үнэхээр хоёр санал өгчихсөн тал байх шиг байна. Тэгэхээр энэ бол илэрхий байна. Их засаг, Үндсэн хууль хоёр дээр санал хураалт явуулах уу үгүй юу гэдэг санал хураалт явуулъя. Тэгээд л шийдчихье. Дараагийн шатанд дахин шалгаруулалт хийх хэрэггүй, хоёрхон км үлдлээ гэж үзэж болж байна уу? За баярдалаа. За тэгвэл Их засаг, Үндсэн хууль хоёр үлдлээ. Одоо битгий будлиарай. Ерөөсөө нэгэн дээр нь санал өгөхийг хичээгээрэй. За одоо хоёр дахь шатны санал хураалт. Хуулийнхаа төслийг Их засаг гэж нэрлэе.

Санал хураалт явагдаж байна. За энэ хуулийг Их засаг гэж нэрлэе гэсэн дүн гарлаа.

Одоо хоёр дахь хувилбарын санал хураалт явуулъя. Хуулийн төслийг Үндсэн хууль гэж нэрлэе.

Санал хураалт явагдаж байна. Баярдалаа. Бид их цаг алдаж буцилсан ч гэсэн хууль маань нэртэй болох шиг боллоо. Их засаг гэдэг дээр олонхи нь байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙДСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

1991.11.18.
Кассет № III-51
18.06-18.20

Ж.Уртнасан -Бид цаашаа явахад бэлэн болж байна. Сая бид санал хураалт явуулаад шалгаруулаад, хоёр дахь шатны санал хураалт явуулаад Их засаг гэсэн нэрийг сонгож авлаа. Бид одоо Их засаг гэсэн нэрээ батлчихъя. Их засаг гэсэн нэрийг батлая.

Танхимаас: -2 дээр зөвшөөрч өгөөч, санал байна.

Танхимаас: -Хурлын даргаа, цөөнхөд санал байна.

Ж.Уртнасан -Санал хураалтын дараа, цөөнх нь үгээ хэлдэг шүү дээ. Тэр зарчмаараа явъя.

Танхимаас -Бид сая цөөнх болчихлоо шүү дээ, тэхээр саналаа хэлмээр байна.

Ж.Уртнасан -Саналаа батлчихъя, дараа нь үгээ хэлье.

О.Дашбалбар/10-р тойрог/ -Уртнасан даргаа, санал батлаад уг хэлнэ гэж та юу яриад байна вэ? Цөөнхийн саналыг сонсоно гэхихээд цөөнхийн саналыг сонсохгүй байна шүү дээ. Их засаг гэсэн хуулийг батлах уу, батлахгүй юу гэдгээ цөөнхийн саналыг сонсож байж шийднэ шүү дээ. Сонсохгүйгээр батлана гэж юу байсан юм бэ.

Ж.Уртнасан -Сүүлчийн хэлэлцүүлэг гэж бас нэг хэлэлцүүлэг бий шүү дээ, депутат аа!

О.Дашбалбар/10-р тойрог/-Тэгж ярих юм бол та нар анхнаасаа зохион байгуулсан луйвар, жүжиг, найрууллагаа хийсээр байгаад ийм болгож байна шүү дээ. Үндсэн хууль гэдэг дээр анх 60 хэдэн хувийн санал авчихаад, хурааж, хурааж байгаад би түрүүнд хэлсэн шүү дээ, тавгатай хоол, хундага архианаас үзэл бодлоо худалдаж байна гэж, ийм маягаар явбал үүнд учир, утга алга байна. Ямар ч байсан дахин санал хураахыг хүсч байна.

Ж. Уртнасан -Ямар томъёоллоор санал хураалгахыг хүсч байна вэ? Томъёоллыг өөрчлөж болохгүй шүү дээ. Бид нэгэнт нэгдсэн зарчимтай шүү дээ.

Д. Жарварал 104-р тойргийн депутат -Цөөнхийн саналыг сонсож байж саналаа хураагаад байдаг түрүүчийнхээ журмаар бид хэлээдхье, эцэст нь батлагдана биз дээ. Батлагдсан хойно нь саналыг сонсоно гэдэг нь утгагүй асуудал гэж бодож байна.

Тэхээр би саналаа хэлье. Ямар ч байсан Үндсэн хууль, Их засаг гэсэн хоёр шалгаруулалтын нэр гараад, дэгд батласан ёсоор санал гуравны хоёрыг авч чадахгүй байна. Түрүүнд Үндсэн хууль авсан юм, 68 хувийг авсан шүү дээ. Тэхээр би үүн дээр хувийн саналаа хэлье. Их засаг гэсэн нэрээр нэрлээд, хаалтан дотор Үндсэн хууль гэж тавья гэсэн саналтай байна.

О. Дашбалбар -Энэ саналыг би дэмжиж байна. Их засаг гэж нэрлээд хаалтан дотор Үндсэн хууль гэж байх юм бол болж байна. Гэхдээ гуравны хоёрын саналыг энэ нь авч чадаагүй гэдгийг мөн тэмдэглэх хэрэгтэй.

Д. Энхбаатар/178-р тойрг./ -Буруу хэлж байна. Тэхээр хоёр юм ярьчихаад, олон, цөөнх болно уу гэхээс биш, дөрөв, таван зүйлээс шалгаруулалт явуулчихаад цөөнх болно гэж байхгүй шүү дээ. Шалгаруулалт явуулаад нэг юм гарч ирж байна шүү дээ. Тэхээр энд цөөнхийн асуудал байх ёсгүй гэж бодож байна. Гуравны хоёрын тухайд бол бид нар энэ нь зарчмын асуудал мөн үү, үгүй юу гэдэг дээр анх ярилцахдаа санал хураагаагүй учраас үүнийг зарчмын асуудал гэж үзэвгүй байгаа учраас гуравны хоёр байх шаардлагагүй юм.

Ж. Уртнасан -Тиймээ ойлгож байна.

Д. Дэмбэрэл 243-р тойргийн депутат -Тэхээр үүн дээр надад ийм санал байна. Үндсэн хууль гэж нэрлэхийг Их засаг гэдэг нь давамгайлж байгаа юм байна. Гэхдээ Их засаг, Их цааз хоёр төсөө-

тэй юм. Яагаад гэвэл Үндсэн хуулийн уг агуулгандaa энэ тодорхой оноож байгаа нэр тохирохгүй байгаа юм. Үгүй бол хуулийн нөхдүүд Их цааз гэдгийг туйлшруулж авчирч, нэг ийм малгай өмсгөөд байна. Үгүй бол төрийн талыг нь томруулахын тулд Их засаг гэж томруулаад байна. Гэтэл Үндсэн хууль маань цаанаа, би Бага Хурлын нөхдийн танилцуулсан зарчмын үндсэн асуудлыг засаг, иргэн хоёр ижил ирхтэй гэж байна. Тэхээр засагийн талын нэрийг авчирч тавьчихаад, иргэний талын асуудлыг дарангуйлаад байгаа учраас энэ хуулийн нэр нь багадаад байгаа юм. Үндсэн агуулгийг нь тодорхойлохгүй байна. Энэ хуулинд нэр өгөхдөө оноосон нэр биш, оносон нэр өгөх ёстой. Тэгвэл Үндсэн хуулийн агуулга нь энэ нэр нь онохгүй байгаа гэж үзэж байгаа учраас би өөрийн үгээ хэлж байгаа зүйлээ, бид ер нь Үндсэн хуульдаа оносон нэр өгөхийн тулд аль болохоор Үндсэн хуулийн бүхэл агуулгыг авсан ийм нэрийг энд өгөх ёстой. Бид цаашаа иргэний нийгэм байгуулья. Хэрэв иргэнээ хүндэтгээ гэж байгаа бол заавал дотроос нь нэг үгийг сугалаж авчраад, түүнийг нь тэр иргэний эрх эдлүүлэх гэж байгаа Үндсэн ардчилсан баримт зарчмаасаа ухарч сөргүүлсэн нэр өгөх нь ач холбогдолгүй гэж үзэж байна. Тийм учраас Их засаг Үндсэн хуулийн нэрэнд тохирсонгүй, харин Үндсэн хууль гэвэл эрх биш бүх агуулгаар нь зөв нэрлэгдэж гарах байлаа гэдгийг тэмдэглэж хэлэх байна. Тийм учраас цөөнхийн саналыг дахин 3 хүртэл хураалгаж байх зарчмын дагуу энэ саналыг дахин нэг хураалгана уу гэсэн саналтай байна.

Н.Жанцан 273-р тойргийн депутат -Тэхээр шалгаруулалт явуулаад Үндсэн хууль, Их засаг гэсэн хоёр томъёолол үлдээд, үүний цөөнх нь Үндсэн хууль гэдэг томъёолол^{болдоо} гэсэн агуулгаар би цөөнхөд багтаж үг хэлж байна.

Үүн дээр би Их засаг гэсэн томъёоллыг шинжлэх ухааны үүднээс аваад үзсэн ч гэсэн, хууль зүйн агуулгынхаа үүднээс аваад үзсэн ч гэсэн зохимжгүй болжээ гэдгийг би гурван үндсэн зүйл дээр томъёолохыг хүсэж байна.

4.

Нэгдүгээрт Их засаг гэдэг хууль Монгол улсад байсан юм уу, үгүй юу гэдэг нь хууль цаазын түүх судлаачдын хэмжээнд өнөөдөртөө тогтоогүй байгаа юм. Тэхээр Их засаг хууль юм уу, Их засгийн хууль юм уу, эсвэл Чингис хаан Яссагай Чингис хаанаа гэсэн хууль байна. Энэ нь Чингисийн ёс гэдэг хууль юм уу гэдэг нь шинжлэх ухааны үүднээс аль нь юм бэ гэдгийг өнөөдөр тогтоогүй байгаа юм. Тийм учраас бид шинжлэх ухааны үндэстэй тогтоогүй байгаа зүйл дээр шоо хаяад шууд Их засаг хууль гээ гэвэл шинжлэх ухааныг үгүйсгэсэн асуудал болж байгаа юм нэг талаас. Нөгөө талаас Их засаг гэдэг хууль бол Монгол улсыг хаант засагтай байх үед дагаж мөрдөж байсан хууль учраас хэзээ нэгэн цагт Монгол улс хаант засагтай болохыг үгүйсгэхгүй тийм үед энэ хуулийг нэрлэхийг би үгүйсгэхгүй ээ. Тийм учраас зохимжийнхоо хувьд өнөөдөр Монгол улс Парламентын засаглалтай болох гэж байгаа бол хаант засгийн үеийн Их засаг гэж байсан юм уу, Их засгийн ч гэж байсан юм уу, ёс ч гэж байсан юм уу, томъёолол нь тогтоогүй нэрийг энд авч болохгүй гэж үзэж байна.

Хоёрдугаарт Их засаг хууль нь уг хуушийн агуулгыг тусгаж чадахгүй байгаа юм. Яагаад гэвэл энэ нь зөвхөн засаглалуудын томъёоллыг авч байгаа биш, энд хүний эрхийн тухай асуудал, Монгол улсын аюулгүй байдлын тухай асуудал г.м.-ийн өдий, төдий асуудлыг авч хэлэлцэж байгаа учраас энд зөвхөн засаглалын хууль хууль биш Их засаг гэсэн томъёолол нийцэхгүй байгаа юм.

Гуравдугаарт Үндсэн хууль гэдэг нь нэг талаас оноосон нэр, нөгөө талаас дэлхийн жишигийг аваад үзвэл АНУ-ын Үндсэн хууль, ЗХУ-ын Үндсэн хууль, Францын Үндсэн хууль, Японы Үндсэн хууль гэж байдаг болохоос биш, тэдгээр улсуудад оноосон тийм хууль гэж байхгүй. Хэрвээ үүнийг Их засаг хууль гээд өгчихвөл Монгол улс Үндсэн хуульгүй улс юм гэж ойлгох тохиолдол гарна. Тийм учраас Үндсэн хууль гэдэг нь угаасаа Үндсэн хуулийн оноосон нэр, тодорхой нэр Үндсэн хууль учраас үүнээс өөр нэр томъёо байх нь аль ч талаасаа болохгүй гэдгийг та нөхөд ойлгох ёстой гэж үзэж байна.

5.

Ж. Барамсай 420-р тойргийн депутат -Би хүмүүсийн ярьсан яриаг анхааралтай сонсож суулаа. Хүмүүс хачин их маргаж байна. Би юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл түрүүчийн маргаан шиг ярихаа больё. Цөөнх нь үгээ хэлж байх шиг байна. Өөрөөр хэлбэл БНМАУ-ын ч байна уу, Монгол улсын ч байна уу, Их засаг гэж байна. Тэхээр хэрэв бид Монгол улс гээд улсынхаа нэрийг батлалчихвал Монгол улсын Их засаг гээд, Монгол улсын Их засаг бол Монгол улсын Үндсэн хууль мөн гэсэн үг бичвэл энэ нь дүндээ дүн болно.

Ч. Тэрбуян 406-р тойргийн депутат / -Би цөөнх юм.

Би цөөнхдөө хандаж үг хэлбэ. Бидний маргаан лавираад асуудлаа шийдэх чадахгүй байна. Явж явж Үндсэн хууль нь байна уу, Их засаг байна уу, нэрэндээ бэл бол нь хуулийн агуулгаандаа чухал ач холбогдолтой юм. Тийм учраас хоёр талаасаа буулт хийе. Дашбалбар депутатын саналыг аваад, Их засаг гэдгийн ард хаалтан дотор Үндсэн хууль гэгчхээд энэ хуулиа гаргая, одоо маргахаа больё.

Н. Адъяажав 228-р тойргийн депутат -Санал дахин хураагдахаар боллоо л доо. Яагаад гэвэл энэ зарчмын асуудал байх ёстой. Гуравны хоёрын саналыг авч чадсангүй. Тийм учраас би шинэ хувилбар гаргаж ирье гэж бодож байна. Их засаг хэмээх Үндсэн хууль гэж нэрлэвэл яасан юм бэ?

Т. Ядамсүрэн 71-р тойргийн депутат -Надад ийм санал байна. Тэхээр хууль маань онож чадсангүй гэж хэлж байна гэж үзэж байна. Яагаад гэвэл Их цааз, Их засаг гэдэг хоёр хууль нь Монголын Үндсэн хуулийн агуулгыг хадгалаж чадаагүй гэж хэлнэ. Яагаад гэвэл эдгээр хууль нь төрийн зохион байгуулалтыг цэгцтэй тогтоосон юм байгаагүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ нь ямар хэм хэмжээг зохицуулж байсан вэ гэвэл Эрүүгийн болон Иргэний хуулийн хэм хэмжээг зохицуулж байсан ийм хууль байсан Тийм учраас энэ хууль нь энэ агуулгыг хадгалаж чадахгүй байна гэж гэж үзэж байна.

1924 оны анхны Үндсэн хууль нь төрийн дээд удирдлага, тогтолцлыг яаж байгуулах вэ гэдгийг дэлхийн олон улсын төвшинд боловсруулсан хууль юм. Тэр ёсоо бид өнөөдөр төр засгаа бариад, буруу ч бай, зөв ч бай 70 жил болсон. Тэхээр энэ утгаар нь үзэхэд манай хууль нь хоцрогдсон биш, 24 оны хуулийн агуулга бол олон улсын төвшинд харгалзаж үзсэн хууль гэж үзэж байгаа учраас би үүнийг татгалзаж байгаа юм. Тийм учраас ийм нөхцөл байдлыг харж үзээд, цөөнхийн саналыг дахин хураахыг хүсэж байна.

И.Баларч 293-р тойргийн депутат —Их засаг гэдэг нэр нь өөрөө Их цааз гэдгээсээ агуулгын хувьд муудчихлаа. Энэ санал хураалт юу харуулж байна вэ гэхээр бидний дотор тойргоо төлөөлж, өөрийн гэсэн саналтай хүмүүс бага, ер нь уур амьсгалаас л будаа идэж, нааш, цааш найгаж, дайвдаг хүмүүс олон байна гэдэг нь харагдаж байна. Их засаг гэдэг үг нь Их цаазаасаа дордсныг онолын талаар Жанцан тайлбарлалаа. Би практикийн тал дээр ганцхан үг хэлэхэд өнөөдөр манай ард түмэн Үндсэн хуулийг ямар ч байсан Үндсэн хууль гэдгээр нь ойлгож байгаа юм. Ард түмэн өнөөдөр засаг, төр хоёроо ялгахгүй байгаа шүү дээ ихэнх тохиодолд. Дээр нь гуравдагч засаг гараад ирнэ. Энэ нь бүр ойлгомжгүй гэсэн үг юм. Тийм учраас бид өнөөдөр тохиролцоонд хүрч чадахгүй ээ. Нэгэнт өнөөдрийн хөдөлмөрийн их үр дүнд ямар ч байсан залуучууд маань их амжилт олж, хүчингүй ч гэлээ гэсэн Их засаг гэдгийг оруулж ирлээ. Тийм учраас бид үүнийг Их засаг гэдгээр нь хаалтан дотор Үндсэн хууль гэснээр хоёрдугаар хэлэлцүүлэгт үлдээе гэсэн саналтай байна. Маргаад яахав, бидэнд цаг хэрэгтэй, бид түүхийн өмнө хариуцлага хүлээж байна. Үүнийхээ дараагийн асуудалд оръя гэж бодож байна. Хоёрдугаар хэлэлцүүлэгт энэ чигээр нь оруулъя. Одоо санал хураагаад нэмэр болохгүй.

Л.Батжаргал 296-р тойргийн депутат —Тэхээр бид нэрээ олж чадсангүй. Ерөнхий хэлбэрийн хувьд өөрчлөх гэж өөрчлөж байна. Манай өсвөрийн залуу үеийнхний эх оронч сэтгэлгээн дээр үндэслэсэн өөрчлөлтийг зөв олж чадаагүй, ер нь өөрчлөнө

7.

гэдэг нь зөв юм. Тэхдээ олж чадаагүй нь харамсалтай. Энд нэг уур амьсгал, Бадарч гуай хэллээ, бид шинжлэх ухааны үндэслэлгүй, хувилбарласан, хуулирсан байдал харагдаж байна нөхөр зохиолч Дашбалбараас эхлээд, сайхан асуулт дэвшүүлж байсан, одоо аялдан дагалдаад, бүх зүйл үндэслэлгүй болоод байна. Үүн дээрээ дүгнэлт хийгээд, бид тодорхой байх уу, ерөнхий байх уу гэдгээ үндэслэж ерөнхий нэртэй Үндсэн хууль гэдгээ ХАТУУ БАРЬД , шинжлэх ухааны үндэслэлээ олж, сүүд, туг, соёмбо энэ бүхнээ аажимд нь хөгжилд нь өөрчлөө гэсэн санал байна.

Ж. Авхиа I4I-р тойргийн депутат -Бид нэлээд...

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ц. БАЯРМАА

Бичээч С. Туул

1991.XI.18.
Кассет № 52
18.20-18.36.

141 дугаар тойргийн депутат Ш.Авхиа: -Бид нэлээн их маргаж, багагүй цаг алдсан мөртлөө туйлын зохимж муутай нэр гаргаж ирлээ гэж бодож байна.Лагаад гэвэл, Засаг гэдэг бол оросоор "власть" гэсэн ийм агуулгатай уг км аа.Энэ бол захирах, захирагдах, ер нь дарангуйлах ч утга агуулга бол энд байгаа км.Энэ бол иргэний ардчилсан нийгэм байгуулах зарчим, хуулийг хүндэтгэх зарчим, төр, иргэн хоёр адилхан бие биенийхээ өмнө хариуцлага хүлээх зарчимд харшилж байна гэж бодож байна.Ийм учраас Үндсэн хуулийн агуулгыг бол үнэхээр илэрхийлж чадахгүй байна.Энэ бол их хариуцлагатай асуудал.Энэ асуудлыг бид 50 хувийн саналаар биш гуравны хоёрын саналаар шийдэх ёстой.Энийг манай дэгд заасан ёсоор би зарчмын асуудал гэж бодож байна.Ийм учраас дахин санал хураалгах нь зүйтэй.Энийг хоёрны гуравны саналаар шийдэх нь зүйтэй гэж бодож байна.

Ер ньманай депутатууд сайн ухаарч бодож үзэх хэрэгтэй байна.

415 дугаар тойргийн депутат Н.Ганбямба: -Тэгэхээр энэ Их засгийн талын саналын үндэслэл жаахан бүрхэг байна гэсэн ийм бодол төрж байна.Тэгэхээр өнөөдрийн, түүхчдийн тулд ялангуяа эрх зүйн талаас нь Их засаг гэж ийм хууль байжээ гэсэн нотолгоо өнөөдөртөө гараагүй км шиг байна, нэг талаас.

Нөгөө талаас одоогийн тогтсон км нь юу гэхээр Их засаг гэсэн хуулийн эмхтгэл байсан гэсэн ийм км дээр түүхчид тогтсон км шиг байна, эрүүгийн хууль, янз бүрийн км.Ийм учраас би энд анхны хэлэлцүүлэг дээр дахин санал авахуулах саналтай байна.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ: -Би цөөнх болж саналаа хэлж байна.Тэгэхээр нэг ийм км байна.Бид ер нь юмыг еөрчлөхийн тулд өөрчилмөөргүй байна.

Үндсэн хуулийн энэ нэрний тухайд бол манай соёмбо, туг далбаннаас шал өөр км, улсын нэрнээс ч өөр км.Тэрнийг харин

өөрчлөх талаар бид ярих ёстой. Би тэрэн дээр санал зарим талаараа нэгдэж байгаа хүн.

Бид ер нь сэтгэлийн хөөрлөөр зарим нэгэн нэр гаргаж ирээд өнөөдөр, одоо яг энэ цаг минутад зарим талаараа мухардалд хүрч байна шүү дээ. Тэгэхээр ер нь юу гэж нэрлэлээ, хаанаас ч харавч, юу гэж сэтгэсэн ерөөсөө Үндсэн хууль хэвээрээ байна шүү дээ. Тэгэхээр Үндсэн хууль гэдэг энэ цөөнхийн санал дээр санал хураалгаж өгөөч гэж хэлмээр байна.

280 дугаар тойргийн депутат Ш.Цэндбаяр: -Тэгэхээр энд бол 66 хувийн саналаар Үндсэн хууль манай энэ хэлэлцэж байгаа гол хуулийн нэр болж түрүүн нэгэнт нотлогдсон. 68 хувиар. Гэхдээ бид дэлхий нийтэд улс орноо, Монгол улсаа өөрчлөгдөж байна гэдгийг харуулахын тулд бид нэрээ өөрчилж байгаа юм биш ээ. Тэр нэр, жишээ нь, зарим залуучуудын ярьдгаар эрка, мишка, дашка гэдэг шиг үндсэн нэр нь цаанаа агуулгаараа үлдэж л таарна. Ийм учраас бид бол Үндсэн хууль гэдэг нэртэйгээ дэлхий нийтэд нэрээ тогтох юм бол энэ монгол түмэн гэдэг чинь ерөөсөө тогтвортой, нэг нэрээ хадгалж чаддаг, олон хувирч буцдаггүй гэж улам нэр хүндтэй байх болов уу. Тийм учраас Үндсэн хууль гэдэг нэрээрээ дахин санал хураалгахыг хүсч байна.

танхимаас:

-Цөөнхийн саналаа бид хүндэтгэж сонсоод тэгээд хоёр дахь санал явуулаад гуравны хоёрын санал авч чадсангүй. Тэгэхээр эхний гуравны хоёрын санал авсан 68 хувиараа асуудал шийдэгдчихжээ. Одоо тэгэхээр маргах юм байхгүй, дараагийнхаа ажилд орох нь зүйтэй гэсэн саналтай байна.

302 дугаар тойргийн депутат Ц.Шагдарпүрэв:

-Уучлаарай, эрхэм депутатууд, уг хэлэх боломж олдолгүй өчнөөн хоносон юм. Тэгээд уг нь нутгаас гарахдаа Үндсэн хуулиа хэлэлцэнэ гэж гарсан юм байгаа. Тэгээд ирээд хэлэлцүүлээд нэрийг авсан чинь өв уламжлалаа дагана гэгчхээд монголын

түүхэнд байгаагүй, баримт баталгаагүй нэр өгчихөөд тэгээд бид чинь очиж юу гэж хэлэх вэ? Олны санал сэтгэгдэлд хөтлөгдөөд ийм нэр өгчихөөд ирлээ, миний нэр нэрээр авсан хуудас сонинд гарах байх гэж очилтой нь биш ээ.

Тэгэхээр энд бид нэг юм бодмоор байна.Ерөөсөө Үндсэн хууль гээд хэлчихээр яагаад байгаа юм бэ? Монгол уг биш л гэнэ, оросжсон уг л гэнэ.Энд бас эргэж бодмоор юм байна. Бид ерөөсөө өв уламжлалаа үзнэ, харна гэж байна.Тэр чинь заавал 1200 оных нь өв уламжлал болдог, зан заншил, ёс суртахуун болдог.Энэ хооронд байгаа энэ түүхийн үе чинь яахаараа энүүнд хамаарч болдоггүй юм бэ? Бид чинь сайн нэртэй ч бай, муу нэртэй ч бай, энэ чинь нэгэнт монгол зан заншил, ёсоор амьдарч ирсэн ард түмний үр хүүхэд мөн юм байгаа биз дээ. Тэгэхээр энэ дээр жаахан тогтож хандмаар байна.Сүүлд нь улсынхаа Үндсэн хуулийн нэрийг хууль ёсны болгох гэж юм хайж сүйд болох вий дээ.Энэ дээр эргэж харж үзээч ээ гээд бусад нөхөдтэй санал нэг байгаагаа хэлээд дахин санал хураахыг хүсч байна.

360 дугаар тойргийн депутат Д.Найлан: -Саян хэлэлцсэн асуудлаар одоогийн санал хураах асуудлыг эарчмын хувьд зөвшөөрч байна.Юу гэж зөвшөөрч байна вэ гэвэл, Үндсэн хууль гэсэн нөхдүүд цөөнх боллоо гэж зөвшөөрч байгаа юм биш, харин Их засаг гэдгийг тайлбарлаа гэсэн нөхдүүд, 51 болсон гуравныхаа хоёрт хүрээгүй, тэрнийхээ төлөө дахиад нэг санал өгье гэсэн түрүүчийн саналыг нэгдүгээрт дэмжиж байна.

Хоёрдугаарт, Их засгийн төлөө санал өгсөн нөхдүүд дахиад тэрнийхээ төлөө тайлбар хэлэх нь зүйтэй гэж бодож байна.Юу гэвэл, энэ хууль чинь яруу тод биш байна.Үндсэн хууль гэхэд хэн ч хараад ойлгодог юм байна, Их засаг гэвэл хойно нь хаалтан дотор Үндсэн хууль гээд ингэж бичиж байх ямар хэрэг байна вэ? Ард түмэнд ойлгомжтой, энэ Үндсэн хууль юм байна гээд ингээд ойлгогдвол яасан юм бэ? Их засгийг чинь бид нар Үндсэн хуулиа Их засаг гээд гаргавал дараачийн хуулийгаа бага засаг гэж гарах уу, энд чинь бас жаахан хуулийнхаа

нэрийг илэрхийлж чадахгүй байгаатай холбоотой байгаа бус уу.

Шинжлэх ухааны баталгааны хувьд энэ баталгаагүй байгаа гэдгийг бусад нөхөд ярьж байна. Ийм учраас одоогийн санал хураалт бол Их засгийгаа дахиж гуравны хоёр болгож чадаж байна уу гэдгийн төлөө санал хураалгах нь зүйтэй гэж бодож байна.

340 дүгээр тойргийн депутат Б.Сумъяа: —Энэ дээр би хамгийн урьдаар юу цохож хэлмээр байна вэ гэвэл түрүүч би бас хэлж байсан. Ер нь бололцоотой зүйл дээр бол уян хатан хандаж, харилцан зөвшилд хүрч байх нь одоо бидний энэ тогтох гэж байгаа юугаа урагш нь ахиулах л хэрэгтэй юм шиг санагдаж байгаа юм.

Ийм учраас би ямар нэгэн санал дээр хөдөлшгүй хатуу зогсоод байя гэж бодохгүй байгаа юм. Ер нь яг үнэнээр ярих юм бол өнөөдрийн Үндсэн хууль /юу ч гэж нэртэй байсан хамаагүй/ тэрнийхээ нэрийг бид XII зуун юмуу, XIII, XIV зуунаас эрнэ гэдэг маань ер нь утгагүй зүйл байгаа юм. Тэр чинь бол Үндсэн хууль биш шүү дээ. Тэр бол би эхээс төрөхөөс өмнө ямар нэртэй байсан юм бэ гэж асуусантай адил байгаа юм, хэрэг дээрээ бол.

Гэхдээ ихэнх хүмүүс Их засаг гэж нэрлэж болох юм гэж байна. Эгүүнд ямар үндэслэлтэй байна вэ гэвэл, бид манай хууль эрхийн хамгийн анхны бичмэл дурсгал бол Их засаг юм гэж үзээд тэрний чинь өнөөдөр олддоогүй гэж байна. Тэр чинь монгол хэл дээр хуулбар нь олддоогүй болохоос биш тэр үед, XIII, XIV зууны үед байсан нэртэй том түүхчид

өгсүүлээд Монгол орноор явж байсан жуулчид бүгд биччихсэн байгаа шүү дээ. Тэр байсан гэдэг бол хөдөлшгүй баримт. Ганцхан тэр нь монгол хэл дээр одоо болтол олддоогүй байгаа гэж байгаа болохоос биш. Хэрвээ уламжлалаа харья гэвэл, хууль эрхийн хамгийн анхны бичиг бол дурсгалынхаа авья гэж байгаа бол Их засаг гэж байж болох юм гэж бодож байгаа юм. Би бол анхнаасаа Үндсэн хууль гэж байхад болохгүй юм байхгүй. Нагаад вэ гэхээр, зарим улсууд орчуулгын гэж байна.

Хэрвээ орчуулгын гэдэг юмнаас татгалзах юм бол бид энд иргэний нийгэм, хүнлэг ардчилсан нийгэм, зах зээл, тэр хэрэглэж байгаа соёл иргэншил бүх юмнаас татгалзах хэрэгтэй болно. Тэр орчуулгадаа ерөөсөө биш.

Үндсэн хууль бол хэлмэгдлийн юу болсон гэж байна. Тэр нэрэндээ биш л дээ. Тэр Үндсэн хуулийг чинь түрүүн хүмүүсүүд хэлсэн, зөрчсөнөөс болсон. Үндсэн хуулиа зөрчсөнөөс болсон нэгдүгээрт, хоёрдугаарт, Үндсэн хууль бол зөвхөн цэвэр тунхаглалын чанартай, түүнийг баталгаажуулсан заалт байхгүй болсноос болж Үндсэн хууль зөрчигдсэн. Тэгэхээр ийм асуулт гарна шүү дээ. Хэрвээ нэрнээс болсон юм бид тэр үед нь 1924 оны Үндсэн хуулиа бид Их засаг юмуу Их цааз гээд нэрлэсэн бол хэлмэгдэл гарахгүй байсан уу гэдэг асуудал гарна л даа. Тэгэхээр энэ бол логик багатай юм. Гэлээ ч гэсэн бид харилцан зөвшилц хүрэхийн тулд би Их засаг гэж болох юм гэж бодож байгаа юм л даа.

Ер нь цаашдаа их олон асуудал дээр бид нар санал хураана, санал өгнө. Тэрэн дээр олонхийн саналыг ч харгалзаж үзэх хэрэгтэй, түүний зэрэгцээгээр нотолгоонуудыг аль зэрэг оновчтой болохыг харгалзаж үзэх ёстой юм байгаа. Түрүүн яриад байгаа шүү дээ. 500 сонгогчид саналаа өгсөн гэж. Энэ бол нэг л харгалзаж үзэх үндэслэгээ болохоос биш эцсийн үндэслэгээ биш.

Гол нь бид нар тэр нотолгоонуудыг уралдуулж байж тэрний дотороос аль нь няцаагдашгүй жинхэнэ үнэн зөв нотолгоо байна гэдэгт л тулгуурлах ёстой гэж бодогдож байгаа юм. Тэгээд үзэх юм бол бид энд Үндсэн хууль, түрүүний хүмүүсүүдийн хэлснийг харгалзаж үзэх ёстой санал гэж бодож байна. Үндсэн хууль гэдэг бол ямар нэгэн хэмжээгээр бидний хэлмэгдэх үетэй холбоотой. Ийм учраас ямар нэгэн хэмжээгээр сэдсэн гэдгийг бид хүлээгээд авч болъё гэж бодъё. Их цааз, энэ бол манай ард түмэн чинь нэг хамгийн гол онцлог нь юу гэхээр билэгдлийг эрхэмд үздэг ард түмэн шүү дээ. Ийм учраас тэр "цааз" гэдгийг чинь ард түмэн ерөөсөө хүлээж авахгүй байгаа юм. Тийм учраас тэрнийг бас сэдсэн үзэж тооцож байя. Тэгээд би өөрийн

анхны Үндсэн хууль гэдэг нэрээ болиод Их засаг гэдгийн уламжлалаа хараад авъя тэгэхэд аль аль талдаа нэг их онцгой, эсрэг үзэл гаргахгүй гэж ийм юманд яасан юм байгаа. Тэгэхээр би энийг яагаад хэлж байна вэ гэхээр дахиж санал хураахыг зөвшөөрч байна.

Ер нь харилцан зөвшилд хүрч байх, нэгдүгээрт. Хоёрдугаарт, зөвхөн тооны үзүүлэлтийг биш, тэр нотолгоонуудын оновчтой байдлыг харгалзаж үзэж шийдэж байвал ямар вэ гэдгийг депутатууд бас анхааралдаа авна гэж хүсэх гэсэн юм.

95 дугаар тойргийн депутат Т.Төмөрбаатар:

-Саянн депутатын хэлсэн үгтэй санал нэгтэй байна. Манай энэ хэлэлцэж байгаа хуулинд үнэхээр нотолгоогүй маргаантай зүйл маш их байгаа. Ер нь өөрчлөхийн тулд өөрчлөх...

Тэгэхээр бид нар өнөөдөр залхуурсхийгээд гэдэг юмуу, ер нь ажлаа явуулах гэж байгаа нь энэ гээд аль нь ч сайн мэдэгдэхгүй юмыг түргэхэн шиг баталчихаад гарвал маргааш эргээд задрах аюултай байна. Тийм учраас би ч гэсэн Их засаг гэдэг үгийг ойлгохгүй байгаа. Засаг, засаглалын асуудлыг би төрийн байгууллагад ажиллаж байсны хувьд ойлгохдоо төрийн байгууллага талаас нь ойлгодог хүн. Энэ хуулийн нэр юмуу, аль эсвэл хууль дээр тогтож байгаа засаглалын асуудал юмуу гэдгийг мэдэхгүй байгаа. Тэгэхээр энийг эргээд бас чиг мэргэжлийн, тэр битгий хэл бараг энэ хууль зүйгээр докторын зэрэг хамгаалсан улсууд ч гэсэн ийм асуудал байхгүй талаар нотолгоо гаргаж ирж байна. Ийм учраас энэ асуудлыг задгай орхих саналтай байна. Бид бүрэн төгс юм хийхийн тулд.

Үнэхээр засаглал гэж тийм хууль байсан ч юмуу, үгүй ч юмуу, ингэж нэрлэснээр ямар ч ашигтай юм, Үндсэн хууль гэж нэрлэснээсээ юугаараа ашигтай юм гэдгийг нотлохгүйгээр энэ асуудлыг одоо санал хурааж олонхийн саналаар хүч түрж тогтлоо гээд үр дүн бага гарах юм биш үү. Тийм учраас

задгай үлдээ. Бас мөн зохих хэмжээний хугацаанд эрдэмтдийнхээ саналыг энэ хоёр дээр уралдуулъя. Тэгээд аль еөдтэй нь баталъя гэсэн ийм л саналтай байна.

86 дугаар тойргийн депутат С.Харжаубай: -Тэгэхээр ийм байна нөхөд минь ээ. Би энэ хоёр талын аль алинтай нь маргалдая, тэгье гэж байгаа юм биш. Гэхдээ би саналаа Их засагт өгсөн. Зуучлах үүрэг гүйцэтгэе гэж бодож байна.

Уучлаарай, нэг юм ойлгуулах хэрэгтэй байна л даа, та бүхэнд. Та бүхэн надад итгэж үзээч ээ. Энд ийм асуудал байгаа юм. Монголчууд, ХХ зууны монголчууд бид еерсдийгөө еерсдөө эрээд олохгүй байна. Муны төлөө бид маргалдаж байна. Өөрсдийгөө еерсдөө олохгүй байна, нөхөд минь. Олох гээд маргалдаж байна. Нахаараа ийм хэмжээнд бид хүрсэн юм бэ? Монголчууд маань яагаад ийм хэмжээнд хүрсэн юм бэ гэдэг чинь их сонин байна шүү дээ.

Их Чингисийн юу гэжээ, тэрнээс хойш бидний жинхэнэ төр үзэл бодол болох шашин маань орж иржээ. Эхлээд бурхны шашныг авчирсан, дараа нь шарын шашныг авлаа. Дараагаар нь янз бүрийн изм орж ирлээ. Энүүнээс болж жинхэнэ төр монгол уламжлалаасаа их л хоцорчээ. Тэгэхээр та бүхэн минь уучлаарай, бид нэгэнт уламжлалаа сэргээх гэж байгаа шүү дээ. Хэрэв уламжлалаа үнэхээр сэргээе гэвэл Их засаг гэдэг нэрээ хүлээн зөвшөөрөөч ээ. Гэтлэл бид нэг үгэн дээр ч гэсэн өөрийгөө еерсдөө бид олж байгаа хэрэг гэж би ингэж бодож байна. Нахаараа ингэж хэлж байна вэ гэвэл энэ маань ийм байгаа юм. Ерөөсөө Их засаг гэдэг, одоо та бүхэн ойлгож байгаа. Төртэй адилхан болчихлоо гэж байна. Энэ төр биш ээ. Тухайн үед анх удаа гарч ирсэн нэр томъёо төр биш шүү. Их засаг хууль. Энэ маань сүүлдээ энэ үг маань утга нь шилжээд шилжмэл утга аваад төр нь Их засгийн хэмжээнд ийм утга авсан байна л даа. Тэгэхээр энийг, одоохондоо бид будилж болох юм. Гэхдээ бидний хүүхдүүд, бид энэ хуулиа зөвшөөрсний дараагаар нэр томъёогоо зөвшөөрсний дараагаар энд теерехгүй болно. Нөгөө талаар энэ танхимд сууж байгаа 430 депутатаас гадна энэ хуулийн нэр ямараар нэрлэгдэх вэ гэдгийг дэлхийн мон-

голчууд харж байгаа шүү. Дэлхийд 9 төрлийн монгол хүн байна. 9 төрлийн монгол үндэстэн байна. Та бүхэн мэдэх байх. Энэ бүгд энийг харж байна. Монгол, дагуур, ар өвөр халх ингээд байж байна. дараагаар нь ойрад монгол, тэрний эавсраас халимаг, бүр монгол хэлээ мартсан дуншаа пава гэж байж байна. Монголчууд мөн адилхан мартсан. Одоо нэг өөрсдийгөө өөрсдөө олъё монголчууд минь. Та нар нэг эвлэж үзээч ээ, ойлгооч ээ. Энийг хэлэх гэсэн юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУУА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан -5 дугаар микрофон.

180 дугаар тойргийн депутат Жумдаанбаатар

-Тэгэхлээр энэ хуулийн хувьд, нэрний хувьд бол сайн ойлгосонгүй. Олонх нь ялчихлаа. Би цөөнхийн талаас нь санал өгч байгаа юм. Энэ нэрэн дээр ингэх хэрэгтэй. Электронин багажинд дарсан дарснаараа үлдэх юм байгаа юм. Сүүлд нь бид нар сонгогчиддоо хариутай очих юм байгаа юм. Би бол Их цаазт үндсэн оноосон нэр лүү Их цааз оногдож байгаа. Сонгогчид үүнийг нэлэнхүйдээ хүлээж авахгүй тал байгаа юм. Эсвэл Үндсэн хууль-тайгаа үлдэх ийм л юм байсан л даа. Их хууль гэсэн санал авсан, тэрнийг хүлээж авсангүй. Тэгэхлээр тэр электронин багажинд ямар хүмүүс ингэсэн, дараа нь бид нар хариу өгөх юмтай байх хэрэгтэй болж байна. Тэгээд энэ Их засаг хуулиа сайн тайлбарлаж ойлгуулахгүй бол ард түмэн яаж хүлээж авах бол доо гэдгийг энд бас ярьчихъя.

Ж.Уртнасан -2 дугаар микрофон. Цөөнхийн саналыг сонсоё.

39 дүгээр тойргийн депутат Ламжав -Тэгэхлээр би нуу гэж хэлэх гэж байна вэ гэхлээр зарим депутатуудын амнаас энэ 24 оны Үндсэн хууль бол их сайхан тунхаглаж барьсан юмнууд байсан. Тэр нь биелэгдээгүй гэж ярьж байгаа явдал байна. Би үүнийг зарчмын хувьд чухамхүү монголд улс төрийн харгислал хийх энэ бүх онолын үндсийг тавьсан хамгийн анхны үндсэн хууль. Түрүүн депутатууд ярьсан. Энэ хуулийг үндэслэж 40 мянган хүнийг бүртгэлд бүртгэгдсэнийг хэлж байгаа шүү дээ. 40 мянган хүний амь насыг бүрэлгэсэн, эрдэмтдийн бүрэн бус тооцоогоор 100 мянган хүн гэж ярьж байна. Өсгөж ярьж байгаа хүмүүс ч юмуу ер нь нилээн сэтгэл хөдлөлөөр ярьж байгаа хүмүүсийн 300 мянган хүний тухай асуудал яригдаж байна. Тэгэхлээр би нуу хэлэх гэж байна вэ гэхлээр энэ Үндсэн хууль бол биелүүлбэл их сайхан хууль байсан юмаа. Даанч гажижчихсан учраас гэж ярьж байгаа энэ хүмүүсийг би ерөвдөж байна үнэндээ. Би дараа хэлнэ. Улсын нэрэн дээр бас маргаан гарах байх. Манай ерөнхий сайд Амар гуай чухамхүү 24 оны Үндсэн хуулийн үндсэн дээр тэрнээсээ болоод тэрний өмнө

хуулийн ямар ч хамгаалалтгүй хүнд байдалд ороод хэлсэн уг нь байгаа. Би тэрнийг дараа та бүхэнд уншиж өгнө. Тийм учраас Үндсэн хуулийг гэдэг нэрийг ёс бэлэгдлийн талаас аваад үзсэн ч гэсэн тэр тийм нэрээр нэрлэхийг үнэхээр өрөвдөлтэй зүйл гэж бодож байна. Би бүр цөөнх нь.

Ж. Уртнасан -8 дугаар микрофон.

109 дүгээр тойргийн депутат Лхагвасүрэн -Тэгэхлээр би бодож байна. Ардын Их Хурлын хуралдаан бол эрдэмтдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэдэг хуралдаан биш байх аа. Энэ дээрээс үндэслээд бид оновчтой нэр үндсэн хуульдаа өгч чадсангүй ээ. Өөрөөр хэлбэл засаг хууль гэдэг нэр томъёо бүрэн тогтоогүй байгааг бид АИХ-ныхаа хуралдаанаар тогтоож өгснөөрөө эрдэмтдээ нилээн эвгүй байдалд оруулаад яах вэ. Энэ үүднээс үзэхэд ямар нэгэн хэмжээнд, хэзээ нэгэн цагт эргэж хэлэлцэгдэх ийм асуудал болох нээ. Бид аль болохоор удаан хугацаатай хууль боловсруулж гаргая гэдэг үүднээс үзэх юм бол энэ нэр томъёоноос татгалзмаар байна.

Ерөнхий, нийтлэг зохицолцоонд хүрэх ганц зам маань хал балгүйгээрээ Үндсэн хууль л байна. Ийм учраас дахиж санал хурааж өгөөч ээ.

Дашбалбар -За би саналаа хэлье. Үндсэн хууль, Их засаг хууль гэдгийг аль нь харгис вэ гэдгийг яриад байна. Үгэнд нь харгис байхгүй гэдгийг би түрүүний хэлээд байгаа. Хэрвээ Их засаг гэдэг хуулийг аваад үзэх юм бол Их засаг гэдэг хуулийн маань олонх заалтын тэн хагас нь хүн алах заалт байгаа шүү. Дандаа цаазаар авах заалт байгаа. Ийм учраас би ингэж бодож байна. Их засаг гэдэг бол үнэхээр яг үндсэн утгаараа бол Үндсэн хууль биш яг засаглалын, эрүүгийн ийм хууль байгаа. Хэрвээ би Их засаглал гэдэг хууль тогтох юм бол 2 сая монголчуудын нэг саяных нь толгойг авах хууль гарах юм байна аа гэж үзэж байна.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

332 дугаар тойргийн депутат Бааст - Бидэнд ер нь маргалдаад байх юм байгаа юм уу. Энэ асуудлыг цааш нь үргэлжлүүлж л хэлэлцэх

шаардлагатай байна. Хэрвээ бид АИХ-ынхаа, өөрсдийнхөө баталсан дэгэндээ захирагдаж чаддаг юм бол 12 дугаар зүйлийн 3-ын "д"-д заасан журмыг бид баримтлах ёстой. Энэ дээр заахдаа зарчмын шинжтэй асуудал бүр дээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон депутатуудын 3-ны 2-ийн саналаар шийдвэрлэнэ гэсэн байгаа. Энэ дээр батлуулах гээд шамдаад байхын ч хэрэг алга. Дахин энэ асуудлаа энэ хоёр нэрэн дээр тодорхой хэлэлцэж байж өөрөөр хэлбэл 67-гоос дээш хувийн санал авч байж энэ хуулийн нэр батлагдах ёстой. Ямар ч нэрээр батлагд. Гэтэл өнөөдөр 51 хувь болгочихоод дэгээ зөрчөөд бид үүнийгээ батлуулах гээд дайраад байдаг маань ердөө түрүүч нь 68 хувь авчихсан байдаг, дараад нь 51 хувь болоод ирэхлээр зэрэг үүнийг батлуулах гээд дайраад байдаг ямар шалтгаан байгаа юм бэ. Тийм учраас энэ дэгэндээ захирагдаж цаашдаа бид нар хуулийнхаа нэрийг дахин санал хураалт явуулж 3-ны 2-оос санал авахаас нааш энэ нэрийг баталж болохгүй гэж бодож байна.

Ж. Уртнасан -Хоёрхон хүн байна. 6 , дараа нь 7 дугаар микрофон хэлээрэй. Цөөнхийн үг сонсож байгаа шүү.

389 дүгээр тойргийн депутат Бат-Очир -Ер нь аливаа нэр томъёо бол мөн чанар нь түүхэн үедээ хадгалалдаг байх. Нэр томъёоны хувьд бол өөрчлөгдөх байх аа тухайн үеэ дагаж гэж дүгнэж бодож байна л даа. Хүүхдэд Чингис гэж нэр өгснөөр тэр хүүхэд Чингис болохгүй ээ. Бас үүнийг анхаарах хэрэгтэй байна. Дараа нь бол энэ хуулинд Их засаг гэж нэр өгөөд дараагийн салбарлаж гарах хуулиуд нь чухам ямар нэртэй байх юм бэ гэдэг асуудал бас гарч ирж байна. гэж үзэж байна. Дашбалбарын түрүүний ярьсан саналыг эвшееремгүй байна. Ер нь Их цааз гэж хуулиндаа нэр өгчихөөд хаалтан дотор Үндсэн хууль гэж байх юм бол Бат-Очир гэж өнөөдөр хүн байж байгаад өөр аймагт очоод хоёрдахь авгайгаа авахад Бат-Очир гэдэг нэрээ орхиод Дашбалбар гэдэг нэртэй болох юмуу гэж. Энэ бол таарахгүй байна гэж бодож байна. Хаалтан дотор орох үгийг миний хувьд эвшееремгүй байна. Ингээд ахин санал хураахыг хүсч байна.

344 дүгээр тойргийн депутат Сүхбаатар -Би Их засаг гэдэг

нэрийн хувьд цөөнх болсон юм. Энэ учрыг товчхон тайлбарлахыг бодож байна.

Их засаг гэдгийг байсныг одоогоор нотлогдоогүй байгаа. Мөн түүнчлэн судлаачид энэ талаар тодорхой судалгаа гаргаж ирээгүй байгаа. Ер нь ерөнхийдөө бол түүхийн сурвалжид ийм нэр байдаг гэсэн ийм юм явагдаж байгаа. Монголын нууц товчоонд засаг гэдэг үг бий, засаглах гэдэг үг бий. Юун дээр бол Их засаг гэдэг хууль байна гэсэн юм бол Монголын нууц товчоонд байхгүй байгаа. Ийм учраас бид өнөөдөр энэ талаар монгол хүн бол өнөөдөр ер нь энэ Их засаг гэдэг хуулийг огт үзээгүй, огт хараагүй, гар дээрээ тавиагүй гэж үзэж байгаа. Энэ байдлыг харгалзан үзээд бид нар цаашдаа энэ засаг гэдэг үгээр нь бодож байгаад бид Их засаг гэдэг хуулиа засаг хуваарилах, онолын хууль болгочих вий гэж дараа нь жаахан эмзэглээд байгаа юмаа. Тийм учраас үүн дээр бас анхаарч үзээсэй гэж бодож байна.

Ж. Уртнасан - Хууль оруулсан байгууллага яриг ээ.

396 дугаар тойргийн депутат Чимид - Тэгэхлээр нэг км ярих-лаар гуйвж явчихаад, тэр гуйвсан юм нь сонинд гарчихаад тэгээд нөгөө муу Чимид дээр тохогдоод байгаа юм. Би Чингисийн үед хууль байгаагүй гэж хэлээгүй. Засаг хууль байгаагүй гэж хэлээгүй. Тэр хуулийн чинь нэр нь тодорхой биш байна, монголч эрдэмтэд засгийн хууль гэж бичсэн байна. Орос дээр Их засаг гэж великий яса гэж бичсэн байна. Би өөрөө англи хэл мэддэггүй хүн. Англи хэл мэддэг, англи хэлний мэргэжилтэй, хуулийн ангид явж байсан, дээд сургуулийн багш хүнээр орчуулуулж үзсэн. Тэрийг /англи үг/ яса байна аа. Яса гэдэг үгийг нь хөөгөөд байхлаар цааз гэдэг уйгар үгээ гэж ийм дүгнэлт тэнд байна аа. Би үгийн гарлыг хэлсэн болохоос биш мөн чанар өрөөсөө хэлээгүй. Эцэст нь дээр нэг км нэмээд хэлэхэд феодалын, альч нийгэмд үндсэн хууль байгаагүй юм. Тийм учраас феодалын хууль үндсэн хууль байгаагүй гэж ярих нь өрөөсөө утга байхгүй. Харин хаант засгаа яаж хамгаалж байсан юм бэ, ноёд түшмэдээ яаж хамгаалж байсан юм бэ, отог хошуугаа яаж зохион байгуулж

байсан юм бэ, хааныг эсэргүүцээд яаж шийтгэж байсан юм бэ, ийм учраас тэр утгаараа дандаа шийтгэлтэй, торгуультай, цалин пунлүү хасдаг тэр утгаар нь аваачаад мушгиад байх юмаа. Феодалын нийгэмд үндсэн хууль байсан гэдгийг нотолж чадах хүн байхгүй байх гэж бодож байна. Тэгэхлээр тэр, зүгээр би үгийн гарлын тухай ярьж байхад тэр үеийн хуульд дүйлгэх гэлээ гээд ингээд яриад байх юм. Цаазлана гэснээр ~~цаах~~ чихгүй, засаг гэснээр аваад хаячихгүй. Хуулин дотор юу зааж вэ гэдгээр л болно. Тэгвэл энэ хууль дотор ерөөсөө үндсэндээ манай улсын бүрэн эрхт байдал, төрийн байгууллагын систем, тэдгээрийн хоорондын эрх хэмжээний асуудал, иргэний, хүний эрхийн асуудал, тэр, иргэн хоёрын харилцааны асуудал ийм л юмыг заах учиртай. Үүнд тохируулж нэр өгөх учиртай гэж би хэлмээр байна.

Ж. Уртнасан - За баярлалаа депутатууд аа. Цөөнхийн саналыг сонслоо. Бид цөөнхийг хүндэтгэж олонхийн саналаар шийддэг.

Б. Чимид - Бага хурлын нэр байж байгаа шүү дээ. Олонхийн саналаар баталсан. Би еерөө бол саналаа юугаар өгнө еө.

тулгадаг, хөтөлдөг, зүтгүүлдэг гээд байгаа учраас би энд юм хэлэхгүй зөвхөн тайлбар хэлж байна.

Ж. Уртнасан - Цөөнхийн саналыг, цөөнхийн тайлбарыг сонслоо. Бид санал хураалгахдаа томъёоллыг өөрчилж хураалгаж болохгүй ээ. Тийм учраас томъёоллыг дахиж хэлье. Энэ саналаа батлуулах саналтай байна. Их засаг, Үндсэн хууль хоёр үлдсэнийг дахин та нарт сануулъя. Их засаг гэдэг дээр дахин санал явуулахад цөөнхийн санал шийдвэрлэгдэнэ гэж ингэж ойлгож байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

- Бямбаа гуай тэгэж гуравдахь хувилбар гаргаж ирж хураалгаж болохгүй л дээ. Бид Их засаг, Үндсэн хууль хоёр дээр л санал хураалт, Их засаг дээр л санал хураалт явуулчихад тэгээд гараад ирнэ шүү дээ. Нэг хүн нэг л саналд орох учраас.

За хүлээгээрэй.

163 дугаар тойргийн депутат -Мижид -Цеенхийн санал сонс-
чихоод тэрүүгээр нь явуулахгүй бол эргээд будлианд орчихно.
Дахиж хэрүүл хийхээ больё.Цеенхийн саналаар явуулаач.

И.Уртнасан -Цеенхийн саналыг хүндэтгэж Үндсэн хууль
гэж нэрлээ гэдэг дээр санал хураалт явуулъя гэж байгаа хэрэг
үү.За баярлалаа.Томьёоллоо бид доод талаас нь эхэллээ шүү.
Ойлгомжтой байгаа биз.Хуулийн төслөө Үндсэн хууль гэж нэрлээ
гэдэг санал хураалт явуулж байна.

Санал өгсөн 397 депутатын 60 хувь нь буюу 238 хүн Үндсэн
хууль гэж нэрлээ гэж байна.145 хүн буюу 37 хувь нь татгал-
заж,14 хүн буюу 4 хувь нь түдгэлзлээ.Дүн ийм байна.
Одоо дахиад цеенхийн саналыг сонсох уу.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Баяндүүрэн

/Д.БАЯНДҮҮРЭН/

Бичээч Д.Энэбиш

Улаанхүү:

Депутатууд аа. Хэд хоног хуралдаанд сууж жаахан ажиглалаа. Тэгэхээр нэг ийм сонин юм ажиглагдаж байна. Энэ хуулийг хэн оруулж хэлэлцүүлж байгаа юм бэ гэдэг бол тодорхойгүй болсон байна. Тэгэхээр энэ дээр хуулийг хэн хэлэлцүүлж байгаа нь тодорхойгүй гэдэг юу хэлэх гэж байгаа юм бэ гэхээр энийг Улсын Бага Хурал Ардын Их Хуралд өргөн барьсан байгаа. Улсын Бага Хурал гэдэг хэн бэ гээд үзэхээр Улсын Бага Хурал бол Ардын Их Хурлаас байгуулсан нэгэн байгууллага бишээ. Энэ бол ард түмний сонгуулиар тэгш эрхтэйгээр байгуулагдсан.

Бид Үндсэн хуулийнхаа нэмэлтийг уншмаар байна депутатууд аа.

Улсын Бага Хурал гэдэг бол бүх нийтийн сонгуулиар тэгш эрхтэй байгуулагдсан ийм байгууллага байж байгаа. Та бүгд ямар эрх байгаа вэ гэхдээр зарим доторхи гишүүдийг нь өөрчилж болохоос биш тухайн Улсын Бага Хурлыг юу яаж болохгүй. Тийм учраас энэ хоёр тэгш эрхтэй байгууллага байж байхад энэ байгууллага хуулиа оруулж ирчихээд байхад энийг авч хэлэлцэхгүйгээр өөрсдөө яаж байгаа. Тэгвэл өөрсдөө аваад хэлэлцэе. Хууль санаачлагч нь хэн юм бэ. Энд байгаа 430 депутат уу. Та нар Улсын Бага Хурлыг хар. 53 хүн 53-уулаа нэг нэг юм ярих юм бол яаж хууль гарах вэ. Тэнд санаачлагч гэж нэг объект байх ёстой. Гэтэл өнөөдөр та нар 430-уулаа объект болчихоод, субъект болчихоод ингээд явж байна. Тэр хууль санаачлагч нь болчихсон. Ингээд замбараагүй болох юм бол 53 хүн тэнд 53-уулаа яриад байвал яаж замбараагүй байдаг вэ тэрэнтэй адилхан та нар 430 хүн 430 тийш чангаагаад байна шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт ингээд харахад Улсын Бага Хурлаас оруулж ирсэн хуулийг Улсын Бага Хурал хуулиа хамгаалж болохгүй бид нар 430-уулаа эндээ яриад шийднэ гэсэн учраас өөр зүгрүү явж байна. Энд Улсын Бага Хурлын эсрэг уур амьсгал байгаа учраас яагаад өөр зүгрүү явж байна вэ гэвэл өөр хажуугийн санал гарч ирэхээр тэр санал дээр яриад Улсын Бага Хурлаас орж ирээгүй бол өөр ямар ч байсан яахав гээд Их Засаг гэдэг рүү яваад өгч энэ ажиглагдаж байна. Нөгөнт энд хэлэлцүүлж байгаа Үндсэн хууль, Улсын

нэрийг хуучнаар нь байлгах гэсэн энэ бүх хуучин үзэл санаа нь явахгүй гэдгийг мэдэж байгаа учраас тэгвэл улсын Бага Хурлаас хууль санаачлагчаас оруулж ирж байгаа юм биш бол өөр юу ч байсан яахав гэдэг ийм хариуцлагагүй уур амьсгал энд байна гэж үзэж байна. Тийм учраас эхлээд миний үзэж байгаагаар Улсын Бага Хурал эхлээд бол энд байлдаад хуулиа өөрөө хамгаалах энэ эрхээ олж авах хэрэгтэй. Ингэсний дараа хуулиа хэлэлцэхгүй бол 430 хүн хууль хэлэлцээд явахгүй ээ.

Би тойрог байхгүй. Улсын Бага Хурлын гишүүн Улаанхүү.

283 дугаар тойргийн депутат Ш. Шагдарсүрэн: Би нэг ганц зүйлийг хэлье гэж бодож байна.

Бид дэгээ батлахдаа бас ярьцгаасан. Нэлээд ярьцгаасан. Дэгэн дээр хатуу чанга юмнууд орохвий, бас уян хатан янз бүрийн юм гарна. Тийм учраас бас жаахан уян хатан талыг баримтлаарай. Их хориг тавихыг бодож байна шүү гэсэн зүйлүүдийг ярьж байсан. Би ч бас хэлж байсан. Тэгэхээр бидний тэр оруулсан хязгаарлалт бол одоо чөдөр болж эхэлж байна гэж ингэж ойлгож байна. Хамгийн түрүүний энэ асуудал дээр гарч ирж байна. Тэгэхээр би бол хуулиндаа ямар нэр өгөх вэ гэдэг бол зарчмын асуудал гэж үзэж байна. Тэгэхээр зарчмын асуудлыг 75 хувийн саналаар батлах ёстой. Гуравны хоёроор батлах ёстой. Энэ бол дэгэн дээрээ байж байгаа зүйл. Би дэгийг зөрчөөгүй, зөрчиж ч яриагүй, зөрчих ч ёсгүй гэж үзэж байна. Ийм учраас энэ бол 75 хувийн саналаар явах ёстой. Сая бол 60 хувийн санал авлаа. Ийм учраас хүчин төгөлдөр биш байгаа гэдгийг би бас депутатууд ойлгоосой гэж бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт би нэг зүйлийг хэлье. Хоёрдугаарт бид бол үнэхээр цаг их үрлээ. Ер нь анхнаасаа бас буруу, зөв явж байгаа гэдэг бол ойлгомжтой байна. Бас хоёрдугаар зүйл дээр. Их цааз буюу Үндсэн хуулиа ямар, хэдэн хоногийн хэмжээнд, 21 хоногийн хэдэн хоногт нь багтаах вэ гэж цагийн хэмжээг тавьж өгөөгүй ингээд задгай тавьснаас өнөөдөр 7 хоног болоход нэрээ тогтож чадаагүй явж байна. Гуравны нэг хоног нь өнгөрсөн. Бүтэн 7 хонож байна. Ийм учраас би ямар санал хэлэх гэж байна вэ гэвэл

бид үнэхээр ингээд суугаад байхад үнэхээр ард түмэн гээд яриад байдаг, олон түмэн ч гэж ярьж байгаа тэд нар бол ингээд суугаад маргалдаад байх нь бол хохирноо, ашиг сонирхол хохирч байгаа байх гэж бодож байна. Ийм учраас миний санал бол өнөөдрөөс эхлээд цагаа сунгаад шөнөжин хуралдах хэрэгтэй болж байна. Ингэж байх дуусгахгүй болбол бид хэдэн сар ч хуралдаж мэдэхээр байна шүү даргаа. Ийм санал оруулж байна.

137 дугаар тойргийн депутат Г.Вааран: Бид ер нь урагшаа явашгүйээ. Энэ байдлаараа бол бид энэ хуралдаанаараа Үндсэн хуулиа баталж чадахгүй нь. Тэгэхлээр энэ хугацаанд одоо улсын нэр, Үндсэн хуулийн нэр, төрийн сүлд, далбаа энэ дөрвөөрөө одоо энэ хуралдааны хугацаанд бүх нийтийн санал, асуулга явуулъя. Хэрвээ чадахгүй бол хойшлуулаад хэлэлцэхээс өөр аргагүй байна. За одоо энэ асуудлаа орхиод бид энэ Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайлан, бусад асуудлаа одоо хэлэлцэхгүй бол үнэхээр энэ асуудал шийдэгдэхэд үнэхээр хүнд байна. Ийм саналтай байна.

14 дүгээр тойргийн депутат С.Лхагвасүрэн: Бид үнэндээ дотроо юм бодохгүй бол болохгүй нээ. Долоо хоног хуралдлаа. Нэлээн мөнгө зараад, одоо энд нэг ч асуудал шийдэхгүй байна гэдэг чинь утгагүй байна шүү дээ. Үнэхээр бид чинь шинэ хууль батлах гэж байдаг. Тэгээд хуучнаар нь зүтгүүлнэ, зарим нь шинээр нь зүтгүүлнэ гээд ингэж маргалдсаар байтал одоо энэ чинь болохоо байх нээ. Би хувьдаа бодож байна. Иймэрхүү маягтай байвал ердөөсөө энэ хурлаа орхиод 7 хоног идсэн хоолныхоо мөнгийг төлөөд явах саналтай байна.

24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар: Бид санал хураалтын тухайд гээд эхлээд бол нэлээн тийм тодорхойгүй бужигнаж байгаад санал хураачихсан. Дараа нь бол шалгаруулах санал хураалт явагдсан. Ингээд бид нар Их засаг, Үндсэн хууль гэсэн хоёр нэрийг л үлдээж авсан. Шалгаруулан сонгуулалтаар. Ингээд энүүгээр бид нар одоо хоёр удаа санал хураалаа. Эхний удаад нь Их засаг нь 51 хувь болсон, дараагийн удаад нь Үндсэн хууль нь 60 хувь болсон. Ингэхээр бид нар манай хуралдааны дэг ёсоор бол

хэрвээ бид депутатууд хүсэх юм бол гуравдахь удаагийн санал хураалтыг явуулж болно. Нэгдүгээрт энэ байна.

Хоёрдугаарт бид саяны депутат Шагдарсүрэнгийн саналыг бол дэмжиж байна. Өөрөөр хэлбэл бид 21 хоногоосоо 7-г нь авчихлаа. Арын ажил болохоо болилоо. Тэгээд өнөөдөр сунгаж хуралдаж гэсэн саналыг оруулж байна.

297 дугаар тойргийн депутат Д. Тангад: Би нэг түрүүн ерөнхий санал шүүмжлэл явахад ярьсан. Би нээрээ үнэхээр санаа зовж байна. Бид ер нь энэ шинэ төрийн тогтолцооныхоо энэ тулгуур хуулийг баталж чадах юмуу, үгүй юу. Үнэхээр санаа зовж байна. Яагаад гэвэл олон хүмүүсүүд, санал гаргаж байгаа депутатууд хуучин тогтолцооны бүх юмыг хэвээр хадгалж үлдэхийг одоо оролдоод байх юмаа. Ерөнхийлөгч маань одоо шинэ Монголын шинэ нөхцөлд бид ажиллаж, амьдарч байна гэж яриад байдаг, тэгээд одоо шинэ юм юу байнаа. Одоо хуучнаа хэвээр нь байлгахыг л оролдоод байх юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид амаараа ярьж байгаа зүйлээ өрөөсөө ажил хэрэг болгодоггүй, ам, ажил хоёр маань үнэхээр их зөрөөтэй байна. Бид ярихдаа хүн бүгд ярьж байгаа. Үндэснийхээ зан заншил, түүх, соёлыг сэргээе, уламжлалыг бататгая, түүхийн сургамжийг авъя гээд яриад байдаг. Үгүй энэ чинь нэгдсэн Монгол улсыг чинь байгуулсан хүн чинь эзэн богд Чингис шүү дээ. Энийг бид бүгдээрээ мэддэг, зөвшөөрдөг. Тийм ч учраас эзэн богд Чингис хаан маань таалал төгсөж байгаа өдрөө хэлсэн гэдэг. Энэ 1227 оны 8 дугаар сарын 25-ны өдөр болсон юм шиг байгаа юм. Би амьд явсан хугацаандаа ямар сайн үйл хийсэн бэ, ямар муу үйл хийсэн бэ гэж өөрийнхөө шадар туслах, түшмэдүүдээс асуусан байгаа юм. Тэгэхэд нь сайн үйлс хийсэнд нь хамгийн түрүүн хэлсэн байгаа юм. Таны хамгийн сайн үйлс бол Их засаг хууль гэж хэлсэн байгаа юм. Тэгээд энэ чухал Их засаг хуулийг бид одоо уламжилж авъя гэхээр татгалзаад байдаг чинь ямар учиртай юм бэ. Яагаад болдоггүй юм бэ. Бид түүхийнхээ сурвалжийг яагаад хүлээж авдаггүй юм бэ. Энэ дээр л би гайхаад байна. Ийм учраас за яахав та нар инээж болно, хүнийг дооглож болно. Хуучнаар нь үлдээхийг үнэхээр эр-

мэлзээд байгаа бол яахав энэ эрхбичиг учир нь олноо биз дээ. Бид, ард түмэн маань энэнийг зөв ойлгох байхаа, ялгаж зөв ойлгож чадна шүү, зөв ойлгож чадна. Тийм учраас депутатууд минь сайн бодвол яасан юм бэ гэж хэлэх гэсэн юм.

За өнөөдрийн хувьд депутатууд бас хурлын хуралдах цагийг сунгая гэсэн санал ирүүлж байна. Бодууштай санал байх. Тэгэхдээ өнөөдрийн хувьд дэгээ барья гэж бодож байна. Одоо манай хуралдаанд ирсэн хөдөлмөрчдийн санал хүсэлтийн тоймоос...

Танхимаас:

Хурлын даргаа горимын санал байна.

Н. Олзончимэд:

Санал байна. Тэгэхдээ би хурлыг хурдлуулах тухай санал хэлмээр байна. Өөрөөр хэлбэл би ярьмаар юм их байна. Гэхдээ ганцхан санал хэлье. Депутатын гэнэ үү, орон нутгийн гэнэ үү, намуудын гэнэ үү маш олон бүлэг ажиллаж байгаа. Энд, би тэгж ойлгож байгаа. Одоо Уртнасан дарга та хурал завсарлуулаад энэ бүлгүүд ажиллаад, саналаа нэгтгээд байгаа байх. Саналууд үндсэндээ хоёр хуваагдлаа шүү дээ. Алин дээр нь саналаа өгөх вэ гэдэг саналаа нэгтгэж ирэх ийм бололцоо өгөөчээ. Тэгээд л дараагаар нь саналаа өгөг. Ийм л саналтай байна.

Танхимаас: Хурлын даргаа. Тэгэхээр энэ дэгийн Улаанхүү депутат яриад байна шүү дээ. Дэгийн I2-ын E-д заасан гэж яриад байна. I2-ын E-д чинь бүлэг, зүйл тус бүрээр хэлэлцсэн үед хэрэглэх дэгээ. Тэгэхээр бүлэг, зүйлдээ бид ороогүй, одоо зөвхөн нэр хэлэлцэж байгаа. Энэ нэрийг хэлэлцэх үед бол хуралдааныг ердийн нөгөө дэгээрээ явна. Тэр дэгэнд ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж байгаа, гурав дахин санал хураана гэж байгаа. Бид энэ дэгээ бариад гурав дахин саналаа хураалаа. Одоо ердийн олонхоор асуудал шийдвэрлэгдсэн гэж үзмээр байна.

2 дугаар тойргийн депутат С. Батмөнх:

9 дүгээр тойргийн депутат С. Зориг: Тэр депутатууд энэ Их цааз гэдэг үгний эсрэг явж байгаад хоёр алдаа хийчихлээ. Энэ

юу гэхээр Их засгийн хууль, Их засгийн бичиг гэдгийг та нар Их засаг гээд сонсчихжээ. Тийм учраас Их засаг гэдэг тийм хууль байдаг юм гэдэг ойлголттой яриад байх шиг байна. Түрүүн тайлбарлахад Их засгийн хууль буюу Их засгийн бичиг гэж хоёр түүхэн сурвалж бичгээс гаргаж ярьсан. Тэрийг үгүйсгээгүй. Зүгээр нэгэнт батлах юм бол Их Засгийн хууль гэдэг юмуу, Их засгийн бичиг гэдгээр нь батлаачээ. Тэгэхгүй бол гуйвуулчихгаад байна түүхээ.

Хоёрдугаарт тэр Үндсэн хууль гэж батлавал би энд нэг юм ойлгохоо болчихлоо. Үндсэн хууль гээд бид нар баталчих юм бол Үндсэн хууль чинь оноосон нэр болчихно. Тэгэхээр дараа нь тэр чинь нэмэлтийн хуулиуд гарна. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлтийн хууль гэдэг чинь одоо Үндсэн хууль гэдэг ерөнхий ойлголтондоо орохоо больчихгоод байна. Үндсэн хууль гэдэг ерөнхий ойлголтоо өөр үгээр томъёолох болж байна. Тэгэхээр өөр үгийг нь юу гэдэг юм бэ тулгуур гэвэл өөргийм шинэ үг зохиох даалгаврыг нь хэл шинжлэлийнхэндээ өгөхөөс өөр аргагүй болох нь байна. Тийм биздээ. Үндсэн хууль чинь оноосон нэр болчихсон юм чинь. Нэмэлтийн олон хууль гарна шүү дээ. Тэр чинь тэр үндсэн хууль ердөө хамаарахгүй нэмэлтийн хуулиар явчихна шүү дээ.

Үндсэн хууль бол та нар оноосон нэр өгчихсөн байгаа шүү дээ. Нэмэлтийн хуулийг чинь тусдаа хууль байна шүү дээ. Тэрэнд ордог нэг салбар.

Хоёрдугаар тойргийн депутат С. Батмөнх: Тэгэхээр эрхэм депутатууд анхаарахгүй юу. Бид үнэхээр маргаад байвал эхлэл, төгсгөлгүй юм болох нээ. Тэгэхээр бид одоо яах вэ гэвэл надад ийм санал байна. Одоо бүгдээрээ Ерөнхийлөгчийн үгийг сонсоё, юу бодож байгаа, энэ талаар гэж ийм саналтай байна.

Надад нэг санал байна.

ЗI дүгээр тойргийн депутат Д. Дожоодорж: Одоо маргалдах хэрэггүй гэж бодож байна. Юм бол тодорхой боллоо. Саналыг бол цаашид хураана. Энэ Үндсэн хууль гэдэг дээр бол яагаад ч зөвшөөрөхгүй, сүүлд нь би зөвшөөрөхгүйгээ маш үндэслэлтэйгээр ярина.

Хэрвээ ийм санал гарах юм бол.Одоо энийг саналыг хураагаад цаашаа цөөнхийн санал шүүмжлэл явна.Улсын Бага Хурал нэг цаг хүртэл, хоёр цаг хүртэл хуралддаг.Өнөөдөр энэ нэрийг тогтохоос нааш эндээс гарахгүй, заавал хурдан шийдэж таарна.Ийм л саналыг дэвшүүлбэ.Ерөөсөө л.Бид одоо энэ чинь хичнээн өдөр хуралдаад ганц нэргүй сууж болохгүй.Заавал нэрийг тогтож энэ заалаас гарна.Тэгж байж бид эндээс сална шүү.

Уртнасан: Уучлаарай депутатууд аа.Ерөнхийлөгчийнхөө үгийг сонсоё гэдэг энэ саналыг дэмжиж байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



ЭНХТҮЯА

Бичээч

В.ОГИН

Ж.Уртнасан:-Ерөнхийлөгчийн үгийг сонсоё гэсэн энэ саналыг дэмжиж байна.Ерөнхийлөгч уг хэлэх болов уу гэж найдаж байна.

БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат:-Тэгэхлээр Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, Улсын Бага Хуралд одоо хэлэлцэж байгаа энэ Үндсэн хуулийн төслийг оруулахдаа Үндсэн хууль гэж нэрлээ гэдэг санал оруулсан.Улсын Бага Хурал энэнийг хэлэлцээд Их цааз гэдэг нэртэйгээр оруулья гэж шийдсэн. Тэгэхлээр би Бага Хурлын тэр шийдвэрийг зүйтэй болсон байх аа гэж зөвшөөрсөн.Тэр ямар учраас зүйтэй болов оо гэхлээр ер нь Үндсэн хууль, одоо бол ингээд Үндсэн хууль гэсэн нэрдээ энэ бол энэ хуулийн нэр.БНМАУ-ын Үндсэн хууль.Тохосон ч гэнэ үү, оноосон ч гэнэ үү, ямар ч атугай энэ бол нэртэй хууль.Тэгэхлээр энэ хуулийн агуулгыг бид үндсээр нь өөрчилсөн.Тийм учраас энэ хуулийг Үндсэн хууль гэдэг тэр нэрийг нь өөрчилье гэдэг зарчим энэнээс үүцэж гараад тэгээд энэний нэрийг өөрчлөх нь зүйтэй юм аа гэж би ойлгож байгаа юм аа.Тэгж хүлээн зөвшөөрсөн.Чухам ямар нэр байх вэ гэдэг асуудал бол та бүхний олж нэрлэх, Улсын Бага Хурлаас оруулсан нэрийг биш байна аа, олон түмэн бол энэнийг нэг их хүлээж авахгүй байна аа, тийм учраас энэ өөр нэрээр, энэ хуулиа нэрлээ, хуулиндаа нэр өгье гэдэг санаа бол зөв юм уу гэж би болсон юм аа.Тэгэхээр Үндсэн хууль ямар ч нэртэй байсан, ямар ч улсаа, тусгаар тогтносон улс бол Үндсэн хуультай байх ёстой.Тийм юм.Тэгэхлээр юу ч гэж нэрлэлээ гэсэн Үндсэн хууль бол Үндсэн хуулиараа үлдэнэ.Доторхи нь.Нэр нь . Тийм учраас та бүхний одоо энэ яриад байгаа зүйл дээр үндэслээд Их засаг гэдэг нэртэй, тэгээд Үндсэн хууль гэдгийг нь хаалтанг хийгээд, одоо бусад орнуудад тийм юм байж л байгаа шүү дээ. Заавал цуурайх гэж байгаа биш, юмаа ойлгомжтой болгохын тулд конституция гээд тэгээд доод талд нь основный закон гээд л тавьса байцаг шүү дээ.Тэгэхээр бид хуулиа тэгж нэрлээд, Үндсэн хууль гэх нь байж байхад, хаалтан дотор.Энэ бол Монгол улсын Үндсэн хууль юм шүү гэдгийгээ гадна, дотнын, хүний өөрийн хүмүүсүүдэд мэдэгдүүлэх зорилгоор ингээд биччихэц болохгүй юм угүй юм биш үү

гэж ингэж бодож сууна нэг хэсэг нь.

Ер нь горимын чанартай нэг санаа бодогдож л сууна. Тэгэхээр энэ депутатуудын хэлсэн саналыг ер нь заавал хэлэлцүүлээд тэгээд шийдчихдэг байх зарчим зөв байгаа юм аа. Тэгэхгүй санал хэлээд байдаг, тэр нь тэгээд анзаарагдахгүй, авагдахгүй ийм байж болохгүй, тэр чинь депутатын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Тэрнийг хүндэтгэх хэрэгтэй. Тавьсан санал болгоныг л заавал зөвшөөрвөл санал хураадаг, зөвшөөрөхөөргүй байвал урд талаас хаагаад санал хураахгүй байж болохгүй юм аа. Би түрүүнд тэр одоо хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх асуудал дээр депутатууд ярих нь зүйтэй байсан болгов уу гэж бодож сууна. Тэгэхдээ энэ 24 оны Үндсэн хуулиас болоод тэр хууль буруу байснаас болоод хэлмэгдэл гарсан, тийм учраас хүндэтгээ гэвэл энэ нэг янзын ойлголт. Зүгээр ер нь одоо хэлмэгдэгсдийгээ тэр хэдэн арван мянган хүний амь насыг бүрэлгэсэн тэр амь насаа алдсан хүмүүсүүдийн гэгээн дурсгалыг босч хүндэтгээ гэвэл энэ нэг өөр асуудал. Энэ хоёр дахь хэсгээр нь бол болохгүй юм ерөөсөө байхгүй. Бид өмнөхийнхөө өмнө буруугаа ч хүлээх хэрэгтэй, зөв сайн сайхныг нь ч алдаршуулах хэрэгтэй. Тэгж байж бид уламжлал, урд түүх, өнгөрсөн түүхийнхээ өмнө бас одоо тэрнийгээ хүндэтгэх, хүлээх хариуцлага гэж энэнийг ойлгох болов уу. Тийм учраас би депутат нөхөр Билэгсайханы саналыг энэ хоёр дахь хэсгээр нь ойлгож хүлээж аваад, одоо та бүхэн шийдчихэд бас болохгүй юмгүй юм шиг бодож сууна. Тэгээд энэ чинь нэг ийм юм болоод байгаа шүү. Би цаашдаа, сая тэр сонин энэ тэр дээр тэргүүн дуугай гэдэг цол хайрласан байна лээ. Тэгэхээр та бүхэн энэ дэгээ ярихдаа ер нь одоо дугаргах уу байх уу гэж ихээхэн ярилаа. Тэгээд ер нь сүүлдээ дугарахгүй болж таарсан. Тэгэхдээ энэ хууль хэвээрээ байгаа учраас Үндсэн хуулийн

✓ Нэмэлтийн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулиуд өнөөдөр хэвээрээ байгаа учраас нэг талаас, нөгөө талаас энэ хуулийг Бага Хурлын даалгавраар боловсруулах ажлыг учирцаж зохион байгуулж тэгээд иймэрхүү хууль хийлээ, энэнийхээ гол үзэл баримтлал, өөрчлөх болсон шалтаг, шалтгаан, зарим гол зүйлүүд дээр тогтож илтгэх ийм зөвшөөрлийг Бага Хурал надад өгсөн. Их Хурал тэрнийг

3.

зөвшөөрөөц тэгээд надаар илтгүүлсэн. Тэр утгаараа би бас энэ хуулийг хэлэлцүүлэх нэг, үүнд оролцогч байх учиртай. Цаашдаа бол хуулийн тоцорхой зүйл ангиудаар хэрэв шаардлага гарвал санаа бодлоо ярина. Хамгийн гол нь ингээд хэлэхлээр та бүхнийг () нөгөө ухуулан таниулах, татах, санал бодолд нь нөлөөлөх ийм буруу ойлголт уруу орчих болов уу гэж ихээхэн болгоомжилж сууна. Ер нь энэ асуудлын талаар бол та бүхэн бас нэг сайн болоол талаасаа шийдчих нь зүйтэй. Би энэнийг тэг гэж хэлж болшгүй. Тийм ёс зүйн ч болшгүй, энэ ер нь Их Хурлын уур амьсгалын одоогийн байж байгаа байцыг бодоход тэгж хэлж болшгүй нь ээ. Тийм учраас би саянхаа л цундач санааг хэлчихье.

Ж. Уртнасан: Санал хураалт явуулъя. Эрхэм депутатууд аа. Энэ хуулийг боловсруулахад ихээхэн идэвх зүтгэлээ гаргасан Бага Хурлын дөрвөн гишүүн уг хэлэх гээд зогсож байх юм. Яах вэ? Миний бодоход бид өнөөдрийн хувьд дэгээ баримаар байна. Яагаад гэвэл хэрвээ хуралдааныг үргэлжлүүлэн хуралдъя гэвэл нэгдүгээрт та бүгдийн хоол ундыг бас зохицуулах энэ талаар ажлын группэд үүрэг өгөх учиртай болно. Өнөөдрийн хувьд хуралдааныг сунгахад үнэхээр учир лутагдалтай болов уу гэж бодож байна. Мэдээж хэрэг бид хуралдаж сунгаж таарна. Өнөөдрийн хувьд дэгээ баримаар байна. Санал хураагаад, энэ хөдөлмөрчдөөс ирсэн саналаа сонсоод өнөөдрийнхөө хуралдааныг өндөрлөвөл яасан юм бэ? Эрхэм гишүүдээс уучлал гуйя. Маргааш өглөө та бүхэн үгээ хэлж болохгүй болов уу?

-Өнөөдөр хэлэх ёстой үгийг маргааш хэлж болдог юм уу? Өнөөдөр, чухам одоо хэлэх үгийг маргааш хэлж болохгүй шүү дээ. Болохгүй ээ.

Ж. Уртнасан: Бид тэгээд дэгээ зөрчөөд суугаад байх уу? Дэгээ баримаар байна.

-Их Хурлын дарга аа дэгээс чухал юм байж болох биш үү? Энэ бол дэгээс чухал, жинхэнэ үзэл бодлын уралдаан явагдаж байна гэж санаж байна. Яагаад болиуштай байдаг юм. Хоёрхон минут

ярья. Би яримгаар байна. Танхимын соёлыг хүндэтгэж би ярьж эхэлмээргүй байна. Би зөвшөөрөл авмаар байна.

Ж.Уртнасан:— Дэгээ баримаар байна. Саналаа хураая. Тэгээд одоо...

— Дарга аа! Алиныг нь дэгээ зөрчиж байна гэж үзэх юм бэ?

Ж.Уртнасан:— Үг хэлэх хүмүүсийн тоо улам олширч байна. Бид дэгээ баримаар байна.

— Их Хурлын дарга аа, тухайн асуудал дээр, тухайн агшинд энэ дэг барина гэдэг бол ам барихтай адилхан байна. Надад тэгж санагдаж байна. Бид нар 15 минут зөрчвөл болно. 16 дахь дээрээс нь эхлээд дэг барих ёстой гэж тохиролцоогүй шүү дээ. Надад хэлмээр нэг болохгүй юм байдаг аа цаа. Тийм юм байна надад.

Ж.Уртнасан:— Тэр үед нь хэлэхгүй ясан юм бэ? Цаг өнгөрлөө дэгээ баримаар байна.

— Энэ хэлэлцүүлэг анхнаасаа буруу явагдаж байгаа учраас эхлээд хэн хууль хэлэлцүүлж байгаа, тэрийгээ тохирчихоод, тэгээл хэлэлцүүлэгтээ ормоор байна шүү дээ. Энэ маягаараа хууль явахгүй, энэнийгээ тохирч авах хэрэгтэй байна.

— Чухамхүү Жанцан хуульчийн, түрүүн доктор гэж хэлж байх шиг байна лээ зарим хүн. Жанцан докторын гурван зүйл үндэслэлийн нэг зүйл дээр нь, хоёр дахь зүйл дээр нь би тогтож яримгаар байна. Хоёрдугаарт гэвэл энд сууж байгаа энэ дөрвөн зуун хүний нэгдмэл оюун ухаан гэдэг чинь тэр чигээрээ бүтээлч оюун ухаан, өөрөөр хэлбэл энд дөрвөн зуун хүнээс бүрдсэн зохиолч сууж байна гэж хэлэх гэж байна. Яагаад тэгж байна гэвэл тэр

өмнө байсан байгаагүй, тэрүүгээр хэмжигдэх биш юу хэрэгтэй байна, юу гэдэг үг, эсвэл бүлэг үг цогц тавих ёстой байна уу? тэрнийг бид нар ярьж тавих ёстой. Тэр түүхэнд байсан байгаагүй буюу

авч үзэх ёстой зүйлийн нэг гэж би санаж байна.

Их засаг гэж хэлэх юм бол Монгол улс Үндсэн хуульгүй болно гэдэг чинь тийм худлаа ятгалга, их эвгүй зүйл бол ерөөсөө байж болохгүй. Үгүй энэ чинь Бага Хурал гэдгийг чинь парламент гэж орчуулдаг юм байхчивлээ. Тэгээд Их засаг гэж хэлчихээд дараа нь конституция юм уу основный закон гэж орчуулж яагаад болдоггүй юм, болно шүү дээ. Энэ танхим чинь өөрөө тэгж нэрээ оноогоод л Дашбалбар энд сууж байна. Балбарын хичнээн сайхан шүлгүүдийг Балбарын өөрийнх нь төлбөр доторхи үзэл бодлын уралдааны үр дүнд шигшигдэж нэг санаа нь гарч ирж байгаа. Нэг тал байна. Тэр тал өргөн байна. Тэнд үнэг явж байна гэдэг ийм үнэн юм байдаг. Байз л цаа, би хэлье. Тэгтэл тэр ертөнц дээр байгаа юмнуудыг нийлүүлээд нэг яруу найрагч өргөн талд үнэг шогшино, үснийх нь сайханд нүгэл шогшино гэсэн тэр хүний бүтээл. Тэрлүгээ нэгэн ажил танхим өөрөө бүтээл гаргах ёстой. Заавал тэндээс хуулна, эндээс орчуулна гэж гол төлөв хүмүүсүүд ингэж ярьж байгаад би маш их эргэлзэж байна.

Баяр

Ж. Уртнасан:— Үг хэлэхгүй, тайлбар хэлье гэсэн байна. Тайлбар сонсох уу?

Ардын Их Хурлын I дүгээр тойргийн депутат С. Баяр:— Лавлагаа хэлье гэж бодсон юм л цаа. Би энэ хуралдаанд Их Хурлын депутатын хувьд сууж байгаа юм. Төслийг хэлэлцэхэд комиссын гишүүний хувьд ч Бага Хурлын гишүүний хувьд ч өөрийнхөө хэмжээнд оролцлоо. Саяны Ерөнхийлөгчийн хэлсэн зүйлд нэг ташаа зүйл орсныг залруулах шаардлагатай гэж бодож байна. Улсын Бага Хурлын IV чуулганд оруулсан төслийн нэр бол Монгол улсын Үндсэн хууль хаалтан дотор Их цааз гэж орж ирсэн байгаа юм л цаа. Ерөнхийлөгч маань андуураад буруу хэлчих шиг боллоо. Нэг ийм л лавлагаа хэлэх гэсэн юм. Цаашид шаардлагатай бол би маш товчхон хоёр санал хэлчихмээр байна. Тэгэхлээр өнөөдөр бид энэ баримт бичгийг юу гэж нэрлэсэн ч

энэ бол төсөл нь төсөл. Энэнийг чухам юу гэж нэрлэх вэ гэдэг дээр бид зөвхөн хавтсан дээрээ явж байгаа. Энэ ном маань дотроо 38 хуудастай. 38 хуудсандаа орохоосоо өмнө өнөөдөр бид хавтсан дээрээ бид өнөөдөр нэг дэх долоо хоногоо барлаа. Манай улс орон чинь тийм их баян орон, улс биш шиг санаглаад байх юм. 430 депутатуудыг ингээд хуралдуулаад, нэрэн дээр нь, хос үгэн дээр чухам яах вэ гэдэг. Тэгэхлээр миний тодорхой горимын санал байна. Нэгэнт хоёр удаа санал хураасан. Бид дэгээ баталсан. Одоо гурав дахь удаагаа санал хураагаад тэрүүгээр нь үлцээ. Эхний хэлэлцүүлгийн хэмжээ¹⁴. Бидэнд цааш нь ярих сэдэв гарна. Их засаг гэдгийг наана, цаанаас нь шүүх хэрэгтэй болох байх. Ингээд хоёр дахь хэлэлцүүлэг дээрээ бид энэ дээр шууд саналаа хураахал бэлэн болчихсон улс байх болов уу гэж санаж байна. Ингээд гурав дахь удаагаа хураачихъя.

Нэг санал юу вэ гэхлээр Их засаг гээд хаалтан дотор Үндсэн хууль гэж энэ бол болмооргүй байна. Яагаад гэвэл монгол үгийг монгол үгээр орчуулж тайлбарладаг энэ юу бол үнэхээр манайд зохимжгүй юм л даа. Зөвлөлтийнхэн бол конституция гээд гаднын шинэ үг оруулж ирчихээд тэрийгээ тайлбарлах үүднээс основный закон гэж тэр үгийг нь, гаднын үгийг тайлж байсан юм л даа. Хаанаас нь ч хөөсөн Их засаг гэдэг бол энэ гаднын үг биш, энэнийгээ тайлах үндсэн дээр Үндсэн хууль гэж байснаас өрөөсөө шууд Үндсэн хууль байх нь зүйтэй. Тийм завхарсан, монгол хэлээ монгол хэл уруугаа хөрвүүлж орчуулдаг ийм хувилбарыг гаргамааргүй байна шүү нөхдүүд. Энэ дээр санал хураалгаагүй байна л даа. Зүгээр нэгэнт энэ дээр санал гарсан учраас энэ дээр бодогдсон бодлоо хэлье.

Улсын Бага Хурлын гишүүн Гү. Лхагважав:

-Их Хурлын эрхэм дарга аа би өрөөсөө хоёрхон минут л үг хэлчихье. Би юу гэж хэлэх гэж байна гэхлээр. Миний урдаас байна шүү дээ. Харин ийм эсэргүүцэл тулгарах тусмаа баярлаж байна. Яагаад гэвэл та бүхэн тулгар цаазаа ийм сайхан тулгатай сайн хэлэлцэж байгаад чинь баярлаж байгаа учраас хоёрхон үг хэлье гэж бодож байна. Үндсэн хууль гэдэг сайхан монгол үгээ би

үзэн ядахгүй. Энэ сайхан монгол уг бол ямар ч монгол хүний амнаас гарч сонсогдсон монгол л уг. Тэрэн шиг сайхан уг байхгүй. Тэгэхдээ яагаад Үндсэн хууль гэхлээрээ бид нар өнөөдөр энэн дээр эргэж харах шаардлага бий болчихвоо гэхлээр ийм хэдэн км бодогдоод байна. Саяхан олон улсын бага хурал болсон. Манай Үндсэн хуулийн төсөл ямархуу байдалд байна вэ та нар хараадахаач гээд манай парламентын бүлгэмийн зохиосон тэр хуралд хүрэлцэн ирсэн гадаад дотоодын маш өндөр мэдлэгтэй, мэргэжилтэй хүмүүсүүд манай хуулийг үзэж судалчихаад энд саналаа авчраад ярихад нь монгол, англи хоёр хэл дээр тэр хэлэлцүүлэг явагдсан. Англи хэл дээр ярьсан бүх хүн гэдэг уг хэрэглэж байна лээ. Тэгэхлээр би их баярласан. Үндсэн хууль гэж нэг ч хүн гадаад хэл дээр ярьж чадахгүй байна лээ. "У" үсэг монголд л байх болов уу. Энэ янз бүрийн сүүлд манайд орж ирсэн энэ нэр томъёоноос илүү ах юм байна, бид чинь үнэхээр том гүрний, үнэхээр том улсуудын үр сад юм байна гэдэг дээр үнэхээр баярласан. Үндсэн хууль гэдэг ойлголт 1924 онд орж ирсэн. Тэрэн дээр хоёр төслийн тухай асуудал ч байгаа. Үндсэн хуулиа эргээд харъя. Манайх 24, 40, 60 гурван Үндсэн хуультай. ЗХУ-д 18, 24, 36. Яг тэр тухай тухайн шатных нь юмыг хийж яваад хийгээд ирсэн. Тэгээд Үндсэн хууль гэж орчуулахдаа, би өнөөдөр энэнийг тодорхой ганцхан зүйл дээр тогтож ярья гэж бодож байна. Үндсэн хууль гэж бид нар орчуулахдаа англи болон орос хэлний ярианы, англи хэлэн дээр бол Үндсэн хуулийг ярьдаг, бас үндсэн хууль гэж. Тэгэхдээ хоёр хүн хоорондоо гээд амьдралын хооронд ярьж явахдаа ярьж байдаг. Үндсэн хууль гэдэг ойлголтыг анх Аристотель гаргасан. Аристотель гаргахад **политая** гэдэг уг байсан. Тэр уг ямар утга байсан гэхлээр тэр барья гэдэг утгаар байсан. Дараа нь тэр уг Грек, Роман тэр хэллэгт орж ирэхдээ конституцио гэдэг уг байхдаа төрөө хамтарч барья гэсэн. Өнөөдрийн Үндсэн хууль яг тэр санааг гаргаж байгаа. 38 хуудастай та бүхний барьж байгаа төсөл, 38-хан хуудастай та бүхний барьж байгаа төслийн дөнгөж аравхан **хуудсанд** нь төрийн тогтолцооноос бусад юм нь байж байгаа. Бусад 28 хуудсанд нь зөвхөн төрийн тогтолцооны асуудал байж байна. Энэнийг Үндсэн хууль гээд нэрлэчихэж болно.

Тэгэхээр хүн төрөлхтөнд бас Үндсэн сайхан хуулиудтай орон байна. Энэ чинь Шинэ Зеланд, Пакистан, Үндсэн хуулиндаа Ерөнхийлөгчийн хэд алхаад ширээндээ очиж суухуу гэгдгийг нь хүртэл тодорхойлчихсон тийм орнууд байж байна. Бидний энэ хуулинд бол тэрнийг бичиж чадахгүй. Тэгэхлээр хуулиудын үндэс энэ мөн үү гэхлээр бас эргэлзэх юм гарч ирж байна. Хэрвээ энэ хуулиудын эх нь, эцэг нь юм бол энэнээс урган гарч ирэх бүх хуулиудын эх нь, эцэг нь байхаар тийм сайхан баримт бичиг байгаасай гэж ингэж бодогдож байна. Эрх чөлөөнүүдийн тухай асуудал ярьж байна. Энэ дээр бүтдээрээ бий. 60 оны Үндсэн хуулин дээр бүтдээрээ бий. Дипломат ажилтны хувьд би 60 оны Үндсэн хуулийг хамгаалж явсан. Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцож байхдаа хамгаалж явахад манай Үндсэн хуулинд сайхан заачихсан мөртлөө хэрэгждэггүй, нүүр улайлгадаг юм олон байсан. Тэгэхлээр өнөөдрийн энэ Үндсэн хуулинд үнэхээр тэр эрх чөлөөгөө баталгаатай, нотолгоотой хийж өгөхөөр байх юм бол бидний хийж байгаа гавъяа нь тэр гэж бодож байна.

Манайх бол Их цааз ч юм уу, Их засаг ч юм уу ийм сайхан нэр өгчихвэл, би юүгээрээ баярхах гээд байна гэхлээр 74 оноос дэлхийн 160 орны 80 нь шинэ хууль хийсэн буюу хуулиа шинэчилсэн. Манай хууль бол Их цааз гээд нэрлэчихвэл 1640 он тийшээ явах нь, Их засаг юм уу, бусад засгийн засаг гэсэн энэ нэртэйгээ авах юм бол Чингисийн маань үе, тэрний урагшаа явах нь гэж ингэж бодож байна. Ард түмнүүдийн хувьд, ард түмний нэрийн өмнөөс гэдэг үг бол айхтар үг шүү. Урьд нь бид нарыг, бүтцийг хэлмэгдүүлэхдээ ард түмний нэрийн өмнөөс толгойг чинь авлаа шүү гэж авч ирсэн шүү гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Д. Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Л.Хорлоо

1991.11.18
Кассет № III-56
19.25-19.30

Ж.Уртнасан: Ингээд одоо завсарлах цаг хэтэрч байна.
Санал хураалт явуулъя.

66 дугаар тойргийн депутат Г.Дхагважав:

Тэгэхээр би энэ хурал дээр 6-7 хоног суулаа. Ерөнхийгий нь мэдлээ. Манай Бага Хурал дээр ч гэсэн ийм уур амьсгал байдаг. Тэгэхээр би энэ Ерөнхийлөгч болон Их Хурлын дарга, хүндэт депутатууддаа өөрийнхөө хувийн бодлын юмыг хэлье гэсэн юм. Түүнээс би энэ хуулийн талаар юм ярихгүй. Манай эх орны амьдрал өнөөдөр ямар байна вэ гэдгийг та бүгд мэдэж байгаа. Өнөөдөр бид 25 сая малтай, монгол орон гэжэд бараг хоосон хонох дээр хүрч байгаа. Тэгвэл өнөөдөр 400 гаруй депутатууд маань энд ирчихээд 7-8 хоног юу хийж байна вэ? Ганц хоёрхон үгний төлөө л маргалдаж байна. Хойтохоо бодохгүй байна. Цаана чинь мичин жил ирчихээд, түрүүчийн гаээр нь зуд болчихоод, мэдээ ирж байна. Тэгвэл өнөөдөр монголын 25 сая мал ямар юман дээр хүрч байна вэ гэвэл, хутга, сүх хоёр дээр хүрчихсэн байна гэж ярьж байна. Үүнийгээ бодож байж хуулиа яримаар байна. Түүнээс 1200, 1300 жилийн өмнөх юм яриад ч яах вэ? одоогоос 30-40 жилд болох юмыг яриад ч хэрэггүй байна. Ер нь энэ мал байхгүй бол монгол орон юугаар томъёолох вэ? Тэгвэл бид сэтгэлийг өөршигээ ч юм уу, ямар нэгэн юмаар юу яаж байгаад өмч хувьчлалын хууль гэдгийг ноднин гаргасан. Өөрөөр хэлбэл нөхөр Ганболд, эдийн засагчдын зөвлөлгөөн дээр өмч хувьчлах талаар ярьж байгаад, зад татаад тавьчихсан. Одоо монгол хүн хууль ч биелүүлдэггүй, хуульгүй юмаа гаргасан. Одоо бид тэгээд хууль гаргачихаад яах юм бэ? Сүүлд нь гадна, дотноос өдий төдий юм гуйж аваад, тэр өрөө дарах гэж газар нутгаа худалдах болж байна уу? Үүн дээр бид бодмоор байна. Тэгэхгүй бол бид энэ дээр хууль гаргана гэж яриад хэрэггүй. Би үүнийг л хэлэх гэсэн юм. Ерөнхийлөгч маань энэ жил яасан юм бэ? Би ерөнхийлөгчийг нэг юм хэлье гэж бодож байна. Энэ танхимд нэгдлийн холбооны ҮШ их хурал хуралдаад л алтны тухай бухимдаад л, Ганболд энэ дээр яасан, эндээс баахан төлөөлөгчид тэвдээд ярьсан. Ерөнхийлөгч

1991.11.18

Кассет № Ш-56

19.25-19.30

Ж.Уртнасан: Ингээд одоо завсарлах цаг хэтэрч байна. Санал хураалт явуулъя.

66 дугаар тойргийн депутат Г.Лхагважав:

Тэгэхээр би энэ хурал дээр 6-7 хоног суулаа. Ерөнхийгй нь мэдлээ. Манай Бага Хурал дээр ч гэсэн ийм уур амьсгал байдаг. Тэгэхээр би энэ Ерөнхийлөгч болон Их Хурлын дарга, хүндэт депутатууддаа өөрийнхөө хувийн бодлын юмыг хэлье гэсэн юм. Түүнээс би энэ хуулийн талаар юм ярихгүй. Манай эх орны амьдрал өнөөдөр ямар байна вэ гэдгийг та бүгд мэдэж байгаа. Өнөөдөр бид 25 сая малтай, монгол орон гэжэд бараг хоосон хонох дээр хүрч байгаа. Тэгвэл өнөөдөр 400 гаруй депутатууд маань энд ирчихээд 7-8 хоног юу хийж байна вэ? Ганц хоёрхон үгний төлөө л маргалдаж байна. Хойтохоо бодохгүй байна. Цаана чинь мичин жил ирчихээд, түрүүчийн газар нь зуд болчихоод, мэдээ ирж байна. Тэгвэл өнөөдөр монголын 25 сая мал ямар юман дээр хүрч байна вэ гэвэл, хутга, сүх хоёр дээр хүрчихсэн байна гэж ярьж байна. Үүнийгээ бодож байж хуулиа яриаар байна. Түүнээс 1200, 1300 жилийн өмнөх юм яриад ч яах вэ? одоогоос 30-40 жилд болох юмыг яриад ч хэрэггүй байна. Ер нь энэ мал байхгүй бол монгол орон юугаар томъёолох вэ? Тэгвэл бид сэтгэлийг өөршигээ ч юм уу, ямар нэгэн юмаар юу яаж байгаад өмч хувьчлалын хууль гэдгийг ноднин гаргасан. Өөрөөр хэлбэл нөхөр Ганболд, эдийн засагчдын зөвлөлгөөн дээр өмч хувьчлах талаар ярьж байгаад, зад татаад тавьчихсан. Одоо монгол хун хууль ч биелүүлдэггүй, хуульгүй юмаа гаргасан. Одоо бид тэгээд хууль гаргачихаад яах юм бэ? Сүүлд ньгадна, дотноос өдий төдий юм гуйж аваад, тэр өрөө дарах гэж газар нутгаа худалдах болж байна уу? Үүн дээр бид бодмоор байна. Тэгэхгүй бол бид энэ дээр хууль гаргана гэж яриад хэрэггүй. Би үүнийг л хэлэх гэсэн юм. Ерөнхийлөгч маань энэ жил яасан юм бэ? Би ерөнхийлөгчийг нэг юм хэлье гэж бодож байна. Энэ танхимд нэгдлийн холбооны VIII их хурал хуралдаад л алтны тухай бухимдаад л, Ганболд энэ дээр яасан, эндээс баахан төлөөлөгчид тэвдээд ярьсан. Ерөнхийлөгч

босоод сайхан тайвшруулсан.Ээ, алт гэдэг чинь өр нь манайх юмтай хүн шүү.Гадаадын банкинд хадгалуулчихвал юмтай гэдгээ харуулж байгаа юм шүү гээд байсан.Нөгөө дэх нь хэдэн танхай банди нар нь мөрийнд аваачаад өгчихсөн байна шүү дээ.Одоо хоосон, байхгүй.Одоо тэгвэл мал чинь байхгүй боллоо.Малаа байхгүй болгочихвол бид юугаараа амь зуух юм бэ? Одоо тэр танхай улсууд чинь одоо тэр хэдэн малыг чинь хядаад дуусч байна гэж байна.Ийм учраас хэрэггүй юмаар маргаад бид хэрэг алгаа. Хэрэгтэй юман дээрээ маргая.Энэ хуулийг баталбал баталъя, батлахгүй бол болиод, Засгийн газар, Бага Хурлынхаа хуулийг яагаад, энэ Засгийн газар чинь ажиллаж чадвал чадахыг нь үзээд, чадахгүй бол тараагаад хөдөө тийшээ явъя.Өөр юм байхгүй.

Ж.Уртнасан:Уучлаарай, одоо бид сунжирч байна.Одоо дэгээ баръя.Одоо санал хураалтаа явуулъя.Бид ядаж ганц нэртэйгээ салбал өнөөдөр бас хэлэх үгтэй баймаар байна.Санал хураалтанд бэлтгэнэ үү.З дахь удаагаа санал хураалгаж өгөхийг хүссэн, томъёоллыг өөрчлөхгүй байна.Хуулийн нэрийг Их засаг гэж нэрлэе гэдэг дээр санал хураалт явуулж байна.Анхаараарай, хуулийн нэрийг Их засаг гэж нэрлэе.

47, 47 хувьтай байна.Өнөөдрийн хувьд энэ асуудлыг арга буку бид нээлттэй орхихоос арга алга.Энд ирж байгаа саналууд, жишээ нь, бүлгүүд хуралдаж саналаа нэгтгэе гэсэн ийм саналууд ирж байна.Энэ бүлгүүд хуралдаж саналаа нэгтгэх нь их зүйтэй болов уу.Бид цагийг дэндүү их алдаж байгаадаа харамсаж байна. Хэлэлцүүлэг явж байгаа боловч бид дэндүү удаан явж байна. Энд МАХН-ын гишүүн дэмжигчид депутатууд үлдээрэй гэсэн зарлал ирсэн байна.

Уучлаарай, бас нэг санал хураалт явуулах эсэх талаар шийдвэрлэмээр байна.Депутат Билэгсайхан, Элбэгдорж нарын гаргасан Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх саналыг дэмжиж байна.Уг саналыг хэлэлцүүлж өгнө үү гэсэн ^{бүлгийн} МҮДН-ын санал ирлээ.

3.

Маргааш болтол нээлттэй орхих уу? За баярлалаа маргааш санал хураалтаар эхэлнэ. За баярлалаа. Өнөөдөр завсарлага.

Танхимаас:

Даргаа, үүнийг чинь өнөөдөр шийдчихээд, маргааш өглөө ирээд яах вэ гэдгээ ярих ёстой байсан шүү дээ. Маргааш бас баажан яриа гарах нь байна шүү дээ, өглөө жишээлбэл.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Ц.ЧУЛУУНЦЭЦЭГ